



ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүл

Цуврал 3 (99)

Улаанбаатар хот  
2024 он

Сэтгүүлд нийтэлсэн бүтээл нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх Сэтгүүлийн редакц болон зохиогчид хадгалагдана.

Эх бэлтгэгч, дизайнер: Б.Заяа

Хэвлэсэн газар: "Тоонот принт" ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 279  
ISSN:2226-9185  
Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс  
эрхлэн гаргав. Жилд 5 дугаар гарна.

Хаяг: Эко Интернэйшнл Трэйд Тауэр 9 давхар,  
1 дүгээр хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар  
хот  
Утас: +(976)-11-315735  
Факс: 315735  
Вэб хуудас: [www.nli.gov.mn](http://www.nli.gov.mn)  
Цахим хаяг: [lawjournal@legalinstitute.mn](mailto:lawjournal@legalinstitute.mn)

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

- Ерөнхий эрхлэгч: **Х.Эрдэм-Ундрах** Хууль зүйн ухааны доктор (*Dr.jur.*),  
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
- Эрхлэгч: **М.Түвшинжаргал** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D*)  
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга
- Гишүүд:
- С.Нарангэрэл** Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (*Sc.D*),  
МУИС-ийн эмерит профессор
- Ц.Сарантуяа** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (*Sc.D*), профессор
- Г.Банзрагч** Хууль зүйн ухааны доктор, УДШ-ийн шүүгч
- Н.Баярмаа** Хууль зүйн ухааны доктор, УДШ-ийн шүүгч
- Э.Батбаяр** Хууль зүйн ухааны доктор, профессор, ДХИС-ийн  
ШШГАС-ийн Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны  
тэнхимийн эрхлэгч
- Д.Сүнжид** Хууль зүйн ухааны доктор (*Dr.jur.*), дэд профессор  
ХЭҮК-ын дарга
- С.Болормаа** МУИС-ийн ХЗС-ийн Практик сургалтын төвийн  
эрхлэгч, хууль зүйн ухааны доктор (*Ph.D*), дэд профессор
- Б.Буяншиг** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D*), МУИС-ийн ХЗС-ийн  
Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор
- Ц.Давхарбаяр** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D*), дэд профессор,  
Шүүхийн сахилгын хорооны дарга
- Г.Давааням** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D*), МУИС-ийн ХЗС-ийн  
Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор
- Д.Зүмбэрэлхам** Хууль зүйн ухааны доктор, профессор,  
ШЕЗ-ийн гишүүн
- Г.Нарантуяа** Хууль зүйн ухааны доктор, ХЭҮК-ын гишүүн
- С.Сүхбаатар** Хууль зүйн ухааны доктор
- Б.Улаанбаатар** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D*), дэд профессор,  
МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- М.Уянга** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D*), дэд профессор МУИС-ийн  
ХЗС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
- Ц.Цогт** Хууль зүйн ухааны доктор (*LL.D*), УДШ-ийн шүүгч
- Д.Эрдэнэчимэг** Хууль зүйн ухааны доктор, дэд профессор,  
УДШ-ийн дэргэдэх Шүүхийн Академийн захирал
- Ж.Эрхэсхулан** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D*), дэд профессор,  
МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- Д.Янжинхорлоо** Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн  
Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор
- Анна Тумурова** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D*), ОХУ-ын Буриадын  
Улсын их сургуулийн Төр, эрх зүйн онол, түүхийн тэнхимийн профессор

**Накамура Масаки** Хууль зүйн ухааны доктор (Ph.D), Япон Улсын Нагоягийн их сургуулийн Эдийн засгийн сургуулийн дэд профессор

**Ким Габ Сок** Хууль зүйн ухааны доктор, Жүнбү Их сургуулийн Цагдаагийн сургуулийн профессор

**Пак Жеон Вон** Хууль зүйн ухааны доктор (Ph.D), БНСУ-ын Кукмины их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор

**Сарпеков Р.К.** БНКаЗУ-ын Хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн хүрээлэнгийн захирал, БНКаЗУ-ын Гавьяат ажилтан

**Том Гинсбург** Хууль зүйн ухааны доктор (Ph.D), АНУ-ын Чикагогийн их сургуулийн профессор

Хариуцлагатай нарийн  
бичгийн дарга:

**М.Энхжин** Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан

**Тус дугаарын өгүүллийг хянасан:**

Ц.Сарантуяа

Х.Эрдэм-Ундрах

Д.Сүнжид

Э.Батбаяр

Б.Буянхишиг

Г.Давааням

Д.Зүмбэрэллхам

Д.Эрдэнэчимэг

Ж.Эрхэсхулан



## EDITORIAL BOARD

### EDITOR-IN-CHIEF

**ERDEM-UNDRAKH** Khurelbaatar *Doctor of Jurisprudence, Director,  
The National Legal Institute of Mongolia*

### MANAGING EDITOR

**TUVSHINJARGAL** Moyoer *Doctor of Law (Ph.D), Academic Secretary  
The National Legal Institute of Mongolia*

### MEMBERS

**NARANGEREL** Sodovsuren *Member of the Academy of Sciences, Science  
Doctor of Law (Sc.D), Emeritus Professor,  
National University of Mongolia*

**SARANTUYA** Tserenbaltav *Science Doctor of Law (Sc.D), Professor, School  
of Law, National University of Mongolia*

**BANZRAGCH** Gochoo *Doctor of Jurisprudence (Dr.jur.), Justice, The  
Supreme Court of Mongolia*

**BAYARMAA** Nyamdoov *Doctor of Law (LL.D), Justice, The Supreme  
Court of Mongolia*

**BATBAYAR** Enkhee *(Ph.D), Professor, Department Head, Court Order  
Enforcement College, University of Internal  
Affairs of Mongolia*

**SUNJID** Dugar *Doctor of Jurisprudence (Dr.jur.), Commissioner,  
The National Human Rights Commission of  
Mongolia*

**BOLORMAA** Soloon *(Ph.D), Associate Professor, Head of Legal Clinic  
Center, School of Law, National University of  
Mongolia*

**BUYANKHISHIG** Bat-Erdene *(Ph.D), Associate professor, Private Law  
Department, School of Law, National University  
of Mongolia*

**DAVKHARBAYAR** Tseveensuren *Doctor of Law (Ph.D), Chairperson, The Judicial  
Disciplinary Committee of Mongolia*

**DAVAANYAM** Gankhuyag *(Ph.D), Associate professor, School of Law,  
National University of Mongolia*

**ERDENECHIMEG** Dashpuntsag *(Ph.D), Associate professor, Director, Judicial  
Academy of Mongolia*

**ERKHESKHULAN** Jambaajultem *Doctor of Law (Ph.D), Head of the Public Law  
Department, School of Law, National University  
of Mongolia*

**NARANTUYA** Ganbat *(Ph.D), Commissioner, The National Human  
Rights Commission of Mongolia*

**SUKHBAATAR** Sumiya *Doctor of Law (LL.D)*

**TSOGT** Tsend *Doctor of Law (LL.D), Justice, The Supreme  
Court of Mongolia*

**ULAANBAATAR** Byambajav *Doctor of Law (Ph.D), Head of the Private Law  
Department, School of Law, National University  
of Mongolia*

<b>UYANGA Myagmar</b>	<i>Doctor of Law (Ph.D), Academic Secretary, School of Law, National University of Mongolia</i>
<b>YANJINKHORLOO Dambadarjaa</b>	<i>(Ph.D), Associate professor, Private Law Department, School of Law, National University of Mongolia</i>
<b>ZUMBERELLKHAM Dorjdamba</b>	<i>Doctor of Law (Ph.D), Chairman, The Judicial General Council of Mongolia</i>
<b>ANNA TUMUROVA</b>	<i>Doctor of Law (Ph.D), Professor, Buryat State University, Russian Federation</i>
<b>MASAKI NAKAMURA</b>	<i>Doctor of Law (Ph.D), Professor, Nagoya University of Economics, Japan</i>
<b>GIM, GAB-SEOK</b>	<i>(Ph.D), Professor, Department of Police, Joongbu University</i>
<b>PARK JEON WONG</b>	<i>Doctor of Law (Ph.D), College of Law and Graduate School of Legal Affairs, Kookmin University, Republic of Korea</i>
<b>RAMAZAN K.SARPEKOV</b>	<i>Doctor of Law (Ph.D), Director, The Institute of Legislation and Legal Information, Republic of Kazakhstan</i>
<b>TOM GINSBURG</b>	<i>Doctor of Law (Ph.D), Professor, The University of Chicago, USA</i>

**STAFF:**

<b>ENKHJIN Munbish</b>	<i>Researcher, The National Legal Institute of Mongolia</i>
------------------------	---

**The papers of the series reviewed by:**

Sarantuya.Ts  
Erdem-Undrakh.Kh  
Sunjid.D  
Batsbyar.E  
Buyankhishig.B  
Davaanyam.G  
Zumberellkham.D  
Erkheskhulan.J  
Erdenechimeg.D

State Registration Number:279  
ISSN: 2226-9185  
The National Legal Institute publishes  
Mongolian Journal of Law five times  
per year.

Address: 9th floor, Eco International Trade Tower  
building, 1st khoroo, Sukhbaatar district,  
Ulaanbaatar, Mongolia  
Phone:+(976)-11-315735  
Fax: 315735  
Website: [www.nli.gov.mn](http://www.nli.gov.mn)  
E-mail: [lawjournal@legalinstitute.mn](mailto:lawjournal@legalinstitute.mn)

# АГУУЛГА

## ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

**Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийн ач холбогдол** 12  
*Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ч.Энхбаатар*

**Прокурорын эсэргүүцлийн хууль зүйн агуулга, мөн чанар, төрөл, хэлбэр, онцлог** 24  
*Ахмад прокурор, хууль зүйн магистр Т.Батсүх*

## ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

**Шударга шүүхээр шүүлгэх эрх эрүүгийн процессийн эрх зүйд хэрэгжих нь** 35  
*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант Х.Болормаа*  
*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант, судлаач Д.Даваажаргал*

**Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын хэрэгжилт дэх шүүхийн хяналт** 51  
*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант, хуульч, өмгөөлөгч Б.Анирмаа*  
*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5-р түвшний оюутан Б.Билэгдэмбэрэл*

**Бүтээгдэхүүний загварын патентын эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлох асуудалд** 67  
*ДХИС-ийн докторант Б.Одгэрэл*

## ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ, ҮР ДҮН

**Хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны зохион байгуулалт: харьцуулалт** 76  
*Судлаач, МУИС-ийн Хууль зүйн сургууль болон Лондонгийн Күийн Мэри их сургуулийн магистр Ж.Сайнхишиг*

**Гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг гадаад улсаас Монгол Улсад буцаах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь** 86  
*Баянгол дүүргийн прокурорын газрын Хяналтын прокурор, Хууль цаазын дэд зөвлөх, хууль зүйн магистр Г.Ган-Эрдэнэ*

**Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ, түүний эрх зүйн зохицуулалт** 95  
*МХХ-ны Эрүүгийн эрх зүйн хорооны тэргүүн, хуульч өмгөөлөгч О.Баярбаясгалан*

**Хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчмын эрүүгийн эрх зүй дэх хэрэглээ: харьцуулсан судалгаа** 108  
*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант Э.Отгонбаатар*

**Прокурорын дүгнэлтээр үүсэх зөрчлийн хэрэг нь захиргааны байгууллага хоорондын маргааны шинжтэй** 119  
*МУИС-ийн хууль зүйн сургуулийн магистрант, УДШ-ийн дэргэдэх Шүүхийн академийн Захиргааны эрх зүйн секторын судлаач О.Тэнхлүүн*

**Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд нотолгооны стандартыг тусгайлан авч үзэх асуудал** 129  
*УДШ-ийн дэргэдэх Шүүхийн академийн Эрүүгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан З.Янжинлхам*

**18 хүртэлх насны хүүхдийн бусдад учруулсан хохирлын улмаас үүдэх эцэг, эхийн  
гэм хорын хариуцлагын асуудал** **142**  
*Хууль зүйн магистр Б.Хэрлэнчимэг*

**ШИНЭ ЭРДЭМТНИЙ ИНДЭР** **159**  
*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хууль зүйн ухааны  
доктор Б.Нинжин (Ph.D)*

**МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ**  
*Мэдээ* **160**

# CONTENT

---

---

## LEGAL THINKING: VIEWS AND REFLECTIONS

- The importance of the first constitution of Mongolia** 12  
*Enkhbaatar.Ch Sc.D. National Academy of Governance*
- The legal content of the prosecutor's objection, nature, type, form, feature** 24  
*Batsukh.T (LL.M) Senior Prosecutor, Master of Laws*

## IMPLEMENTATION AND EFFICIENCY OF LAW

- Implementation of the right to a fair trial in the Law on criminal procedure** 35  
*Bolormaa.Kh Ph.D. candidate, Senior lecturer, School of Law, NUM*  
*Davaajargal.D researcher, Master's student, School of Law, NUM*
- Judicial review on the implementation of the principle of legitimate expectation** 51  
*Anirmaa.B lawyer, Master's student, School of Law, NUM*  
*Bilegdemberel.B Bachelor's student, School of Law, NUM*
- The issue of determining the scope of protection of a design patent right** 67  
*Odgerel.B Ph.D. candidate of the University of Internal Affairs*

## LEGAL RESEARCH OVERVIEW

- Organizational models of legislative drafting: A comparison** 76  
*Sainkhishig.J, (LL.M) NUM, Queen Mary University of London*
- Property obtained due to crime: The Law of Return from foreign countries to Mongolia, making the organization educational** 86  
*Gan-Erdene.G (LL.M) Bayangol District Prosecutor's Office, Supervising Prosecutor, Law Enforcement Deputy Counselor, Master of Laws*
- Forced measures for confiscation of assets and income: Legal regulation** 95  
*Bayarbayasgalan.O Head of the Criminal Law Committee of the Mongolian Bar Association, lawyer and advocate*
- The application of the principle of non-retroactivity in criminal Law: A Comparative study** 108  
*Otgonbaatar.E Master's student, School of Law, NUM*
- A violation case arising from the prosecutor's conclusion is characterized as an interagency dispute** 119  
*Tenkhlun.O, Master's student, School of Law, NUM (Researcher, Administrative Law sector, Judicial Academy under the Supreme Court of Mongolia)*
- The standard of proof in simplified criminal procedure** 129  
*Yanjinkham.Z Researcher at the criminal Law sector of Judicial Academy of Mongolia.*
- Parental tort liability for damages caused by minors under 18 years old** 142  
*Kherlenchimeg.B (LL.M), Research Assistant*

**NEW SCHOLARS IN THE FIELD**

**159**

*B.Ninjin (Ph.D), Senior Lecturer, the Department of Private Law, School of Law, NUM*

**NOTES**

*News*

**160**

## ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Уншигч та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна.

2003 оноос хойш Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс тасралтгүй эрхлэн гаргаж буй хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2024 оны 3 дугаар улирлын 99 дэх цувралаар эрхэм уншигч та бүхэнтэйгээ дахин уулзаж байгаадаа баяртай байна.

Тус дугаарт үндсэн хуулийн эрх зүй, эрүүгийн эрх зүй, захиргааны эрх зүй, хүний эрх, эрх чөлөөний тухай хууль зүйн

салбарын нэр хүндтэй судлаачид болоод шинэ залуу судлаачдын олон өгүүлэл багтлаа.

Энэ дугаарын “Эрх зүйн сэтгэлгээ: үзэл бодол, эргэцүүлэл” буланд хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ч.Энхбаатарын 1924 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үндсэн хууль буюу анхдугаар үндсэн хуулиар Монгол Улсад хүний эрх, эрх чөлөө, тэгш эрхийн үзэл санааг анх тунхагласан тухай өгүүлсэн “Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийн ач холбогдол” өгүүлэл багтсан бөгөөд анхдугаар үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ой тохиож буй энэ цаг үед манай сэтгүүлээр ийнхүү нийтийн хүртээл болж байна.

Сэтгүүлийн “Эрх зүйн судалгаа, тойм, үр дүн” булангаас Англи, Ирланд, АНУ тэргүүтэй парламент ёсны баялаг түүхт, өндөр хөгжсөн орнуудын хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны зохион байгуулалтын сайн жишгийг өөрийн орны өнөөгийн эрх зүйн байдалтай үнэлэн харьцуулсан судалгаа, хүүхдийн бусдад учруулсан хохирлын улмаас үүдэх эцэг, эхийн гэм хорын хариуцлагын зохицуулалт нь иргэний эрх зүйн гэм буруугийн зарчимд суурилан хэрхэн шийдвэрлэгдэж буй тухай хуулийн практик дахь хэрэгжилтийг өргөн хүрээнд авч үзэж судалсан өгүүлэл зэрэг залуу судлаачдын шинэлэг сэдэвт өгүүллүүдтэй танилцах боломжтой.

Сэтгүүлийн үйл ажиллагааг ямагт дэмжин ажилладаг хууль зүйн салбарын эрдэмтэн багш, хуульч, судлаач, шүүгч, прокурор та бүхэнд гүн талархал илэрхийлэхийн зэрэгцээ цаашдын эрдмийн их үйлсэд нь өндөр амжилт хүсэн ерөөе.

Эцэст нь тус дугаарт нийтлэгдсэн бүтээлүүд нь уншигч Та бүхний хууль зүйн салбарын онол, практикийн мэдлэгийг улам аривжуулна гэдэгт итгэж байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,

ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР

Х.ЭРДЭМ-УНДРАХ (Dr.jur.)

## МОНГОЛ УЛСЫН АНХДУГААР ҮНДСЭН ХУУЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ



**Ч.Энхбаатар**

*Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор*

### **ТОВЧЛОЛ:**

2024 онд БНМАУ-ын анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан энэхүү өгүүллийн эхэнд Үндсэн хуулийн төслийг боловсруулж баталсан үйл явцыг тоймлож, улмаар түүний ач холбогдлыг тодорхойлохыг зорьсон. Үндсэн хуулийн төслийг боловсруулах бэлтгэл ажил нэлээд эртнээс эхэлсэн боловч ихээхэн адармаатай, амар хялбаргүй ажил байсан нь түүнийг боловсруулж ирсэн үйл явцаас харагддаг. Анхны комисс 1922 оноос ажилласан боловч амжилт олоогүй. Харин 1924 оны 5 дугаар сарын 20-нд Богд гэгээн таалал төгссөн нь хэмжээт цаазат хаант засгийг халж, бүгд найрамдах засгийг тогтоох бодлого, зорилгыг хангах аятайхан боломжийг бүрдүүлжээ. Хичээнгүй сайд Цэрэндоржоор ахлуулсан комиссын богино хугацаанд боловсруулсан Үндсэн хуулийн төслийг Анхдугаар Их Хурал хэлэлцээд 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталсан юм. 1924 оны Үндсэн хууль нь үзэл баримтлалын хувьд социалист хэв маягийн Үндсэн хууль байсан. Харин ач холбогдлыг тодорхойлох хэд хэдэн үндэслэл байна. Анхдугаар Үндсэн хууль төр улсынхаа тусгаар тогтнолыг дэлхий дахинд зарлан тунхаглаад, Монголын түүхэнд анх удаа хаант ёсыг халж, бүгд найрамдах улсын байгуулал, улс төрийн шинэ тогтолцоог хуульчлан баталгаажуулсан нь энэ Үндсэн хуулийн үлэмж их гавьяа мөн. Энэхүү Үндсэн хуулийн ачаар Монгол Улсын харьяат иргэд тэгш эрхтэй байх, эх орондоо эрх эдэлж чөлөөтэй амьдрахыг анхлан мэдэрсэн юм.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Үндсэн хууль, тусгаар тогтнол, бүрэн эрх, хөдөлмөрчдийн хурал, хаант засаг, бүгд найрамдах хэлбэр



## I. ОРШИЛ

2024 онд тохиож байгаа түүхэн тэмдэглэлт үйл явдлын нэг нь БНМАУ-ын анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ой юм. Энэхүү Үндсэн хууль нь Монголын төр, эрх зүйн түүхэнд сод байрыг эзэлдэг. Нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд, өнөө цагт дэлхийн улсууд хууль зүйн хамгийн дээд хүчин чадалтай, төрт ёс, хууль ёс, хэв журмын үндсийг тунхаглан бэхжүүлсэн Үндсэн хуультай байх нь түгээмэл үзэгдэл билээ. Харин ардын хувьсгалын өмнө дорно зүгийн үлэмж хоцрогдсон колони орны нэг байсан Монгол орон алс тэртээ 1924 онд Үндсэн хуулиа баталснаараа Азийн 49 улсаас арван нэгд жагссан нь өөрөө яах аргагүй монголчууд бидний бахархах гайхамшигт үйлс мөн.<sup>1</sup> Өмнөх үеийн үзэл сурталжсан түүхэнд 1924 оны Үндсэн хуулийг ихээхэн эерэгээр үнэлж дүгнэж ирсэн билээ. Энэхүү Үндсэн хууль нь ардын хувьсгалын ялалтын үр дүнг улс төр, хууль зүйн талаас нь бататган бэхжүүлэх<sup>2</sup> нийгмийн амьдралыг ардчилж, хөдөлмөрчин ард түмний эрх ашгийн үүднээс хувьсгалт ёсоор өөрчлөн байгуулах зорилгоос урган гарсан нэн чухал арга хэмжээний нэг байсан<sup>3</sup> гэж тодорхойлж байв. Харин өнөө цагт эрдэмтэн, судлаачид анхдугаар Үндсэн хуулийг социалист хэв маягийн Үндсэн хуулийн ангилалд хамааруулж, улсынхаа зорилгыг нийгэм журмын (социалист) чиг баримжаагаар тунхагласан<sup>4</sup>, төрийн төв, орон нутгийн байгууллагын тогтолцоог Зөвлөлүүдийн үзэл санааг удирдлага болгон тодорхойлсон, хүн амаа анги ялгаварлаж, төрийн эрх мэдэл хуваарилах зарчим, ардчилал, хүний жам ёсны эрх зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэт зүйлсийг үгүйсгэсэн, ингэснээрээ Монгол Улсад төрийн хатуу төвлөрсөн удирдлага, нэг намын ноёрхолт улс төрийн дэглэм тогтоход үйлчилсэн, энэ нь яваандаа даамжирч их хэлмэгдүүлэлтэд хүргэсэн гэж үзэх хандлага байна. Мэдээж, аливаа Үндсэн хууль цаг үеийнхээ бүтээгдэхүүн байдаг учраас “төрөлхийн толбо”-оо тээх нь жам. Иймд түүхэн үнэнийг эрхэмлэхийн үүднээс анхдугаар Үндсэн хуулийн ач холбогдлыг уг баримт бичгийг боловсруулж батлах цаг үеийн түүхэн урьдач нөхцөл байдлыг харгалзан, үзэл баримтлал бүрэлдэхэд нөлөөлсөн улс төр, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийг тодорхойлсны үндсэн дээр бодит үнэлгээ өгөх нь зүйд нийцнэ. Энэхүү бэсрэг өгүүллийн эхэнд анхдугаар Үндсэн хуулийн төслийг боловсруулж, баталсан үйл явцыг тоймлож, улмаар түүний ач холбогдлыг тодорхойлох болно.

## II. АНХДУГААР ҮНДСЭН ХУУЛИЙГ БОЛОВСРУУЛЖ, УЛМААР БАТАЛСАН ТҮҮХЭН ҮЙЛ ЯВЦ

Хувьсгалт ололтоо бататгаж, бүгд найрамдах байгууллыг тогтоох үйл хэргийг хууль зүйн талаас бэхжүүлэх нь эрх баригчдын эн тэргүүний зорилт байсныг Үндсэн хуулийн төслийг боловсруулах бэлтгэл ажил нэлээд эртнээс эхэлсэн нь гэрчилдэг. Бүр 1921 оны 3 дугаар сарын 13-нд Ардын түр Засгийн газрыг байгуулах тухай тогтоолд “...Монгол Ардын Төлөөлөгчдийн Их Хурлыг зарлан хуралдуулж үүрд байх Засгийн газрыг байгуулж улсын Үндсэн цааз дүрмийг тогтоолгосугай” гэжээ.<sup>5</sup> Гэхдээ тулгар улсын үндсэн шинж төрх,

<sup>1</sup> Азийн орнуудаас Шри-Ланк 1833 онд, Армени 1863 онд, Турк (Оттоманы эзэнт гүрэн) 1876 онд, Япон 1889 онд, Филиппин 1899 онд, Иран 1906 онд, Хятад (Дундад иргэн улс) 1911 онд, Сири 1920 онд, Гүрж 1921 онд, Афганистан 1923 онд анхныхаа Үндсэн хуулийг тус тус батлан тунхаглаж байсан. <https://www.constituteproject.org/countries/Asia>

<sup>2</sup> Э.Авирмэд, Д.Лувсаншарав, Р.Махвал, Г.Иш. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төр, эрх зүйн үндэс, УБ., 1966 он, 22-23 дахь тал; БНМАУ-ын төрийн эрх зүй [хамтын бүтээл], УБ., 1988 он, 33-34 дэх тал.

<sup>3</sup> Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль: улс төр-эрх зүйн тайлбар. Улсын хэвлэлийн газар, УБ., 1988 он, 10 дахь тал.

<sup>4</sup> 1924 оны Үндсэн хуульд: “Бүх дэлхийн жинхэнэ ард түмний зорилго нь одоогийн эзэрхэг хөрөнгөтний байдлыг үндсээр нь устгаж, нийгэм журамт ба эв хамт ёс журмыг эрмэлзэх тул засгийн бодлогыг түүнтэй нийцүүлэх явуулах” гэх зэргээр заасан. Тайлбар: Нийгэм журамт ёс- Социализм, Эв хамт ёс- Коммунизм.

<sup>5</sup> Монгол Ардын бүгд найрамдах засаг тогтоон явуулсан нь. Улсын хэвлэлийн газар, УБ., 1970 он, хууд. 7. Түүнчлэн хувьсгалын эхний жилүүдэд батлагдсан бөгөөд нийгэм, төрийн байгууламжийн аль нэг талыг бэхжүүлэх, төрийн байгууллагуудын шинэ тогтолцоо, иргэдийн эрх, эрх чөлөөг бэхжүүлэхэд чиглэгдсэн “Монгол Улсын ардын Засгийн газрын Хурлын түр зуурын дүрэм” (1921.09.12), “Улсын түр цагийн хурлын дүрэм” (1921.09.20), “Тангарагийн гэрээ” (1921.11.01), “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм” (1921.03.05) зэрэг цөөнгүй дүрэм, тогтоол нь анхдугаар Үндсэн хуулийг боловсруулж батлах бэлтгэл шат болсон юм.

нийгэм-эдийн засаг, төр засгийн байгуулалтыг тогтоон бататгасан Үндсэн хуулийг бүтээх нь ихээхэн адармаатай, амаргүй ажил байсан нь түүнийг боловсруулж ирсэн үйл явцаас харагддаг.

Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажил анхлан Засгийн газрын 1922 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор Шүүх явдлын яамны тэргүүн сайд Магсаржав хурц тэргүүтэй, бүрэлдэхүүнд нь Ж.Цэвээн, Бат-Очир зэрэг номын хүмүүс орсон тусгай комисс байгуулснаар албан ёсоор эхэлсэн бөгөөд<sup>6</sup> уг комисст Үндсэн хуулийн төслийг гурван сарын дотор хянан зохиолгож гүйцэтгүүлэхээр тогтоожээ.<sup>7</sup> Тус комисст Ардын засгийн газрын 1922 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 39 дүгээр хурлаас “...Үндсэн хуулийг ардын эрхт хэмжээт цаазат Англи мэт улсын хуулиас товчлон авч эдүгээгийн явуулан буй засгийн байдалд нийцүүлэн зохиовол зохино” гэсэн удирдамж өгсний дагуу<sup>8</sup> барууны ардчилсан гэх Герман, Швед, Австри, Бельги, Голланд, Япон зэрэг орны Үндсэн хууль ба Үндсэн хуулийн чанартай актууд, түүнчлэн хөрөнгөтөн орны Үндсэн хуулийн хөгжлийн тухай судалгааны бичиг зохиолыг дөнгөж байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнгийн оролцоотойгоор орчуулах, судлах ажил хийж байсан гэж түүхчид тэмдэглэжээ.<sup>9</sup>

Орчуулга, судалгаанд ихээхэн цаг зарцуулсан учраас тус комисс Засгийн газраас тогтоосон хугацаанд багтаан Үндсэн хуулийн төслийг боловсруулах бололцоо байгаагүйг харгалзан ажиллах хугацааг гурван сараар сунгаж, улмаар ажлаа зөвхөн барууны орнуудын хүрээгээр хязгаарласан гэж буруутган уг комиссыг 1922 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн тогтоолоор татан буулгаж, уул үүргийг Засгийн газрын хууль цааз эмхлэх хэлтэст хариуцуулжээ.<sup>10</sup> Үндсэн хууль боловсруулах үйл явц ийнхүү удааширч, яваандаа зогсонги байдалд орсон нь цаанаа өөр учир шалтгаантай байсан нь тодорхой.<sup>11</sup> Бүр 1920-1921 онд тухайн үед гарч байсан зарим хэвлэлд нийтлэгдсэн “Ардын засгийн үндсэн журам”, “Монгол Улсын шинэ ард олны эрхийн төвийн ба нутгийн засгийн янз төлөв” өгүүлэл хийгээд “Монгол ардын хэргийг түр ерөнхийлөн захирах газар” байгуулсан тухай тогтоол, тунхаглал зэрэг гол гол баримт бичигт Үндсэн хууль бүгд найрамдах байгуулал тогтоох тухай санааг дэвшүүлж байжээ.<sup>12</sup> Гэхдээ энэ нь шууд хэрэгжээгүй, хэрэгжих боломж, нөхцөл ч хувьсгалын эхний жилүүдэд төдийлөн бүрдээгүй байсан. Учир нь Монголын сүүлчийн хаан, амьд бурхан гэж ард түмэндээ бишрэгдсэн Богд гэгээн амьд сэрүүн байсан үед тус улсад бүгд найрамдах засгийг тогтоох тухай асуудлыг шийдвэрлэхэд нэн бэрхтэй байсан нь ойлгомжтой.

Харин 1924 оны 5 дугаар сарын 20-нд Богд гэгээн таалал төгссөн нь хэмжээт цаазат хаант засгийг халж, бүгд найрамдах засгийг тогтоох зорилгыг хангахад аятайхан боломжийг бүрдүүлжээ.<sup>13</sup> Тус улсад бүгд найрамдах засаг тогтоох тухай шийдвэрүүд ар араасаа цувран гарсан бөгөөд үүнд МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1924 оны 6

<sup>6</sup> Жалан-Аажав С. Ардын төрийн хууль тогтоох үйл ажиллагаа (1921-1940). Улаанбаатар хот., 1967 он, 72 дахь тал

<sup>7</sup> БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхтгэл, УБ., 1970 он, 54 дэх тал.

<sup>8</sup> УТТА. 1-1-72.

<sup>9</sup> Түүхч Д.Даш “Судар бичгийн хүрээлэн олон улсын Үндсэн хуулиас орчуулж байсан нь ердийн нэг хөрвүүлэх зорилгоор биш, харин анхдугаар Үндсэн хуулийг бэлтгэн боловсруулах ажилтай холбогдож байсан бололтой” гэж тэмдэглэсэн байдаг. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Анхдугаар Их Хурал. УБ., 1984 он. 341-342 дахь тал. Энэ дашрамд тэмдэглэхэд, эдгээр орчуулгууд тухайлбал Австри, Герман, Бельги зэрэг улсын Үндсэн хуулийн орчуулгууд хараахан олдоогүй бөгөөд гагцхүү зарим судлаачдын бүтээлд тэмдэглэгдсэн байдаг.

<sup>10</sup> УТТА. 1-1-72. (АЗГ-ын 1922 оны 56 дугаар хурлын тогтоол).

<sup>11</sup> Магсар хурц тэргүүтэй комиссыг олигтой үр дүн гаргаагүй гэж буруутгаж татан буулгасан нь зөвхөн шалтаг байсан бололтой. Учир нь тус комисс удирдамжид заагдсан үүргээ биелүүлж, 1923 онд 6 бүлэг, 26 зүйлтэй “Монголын хэмжээт засагтай ард улсын Үндсэн хууль” нэртэй төслийг бэлэн болгосон байдаг. Монгол Улсын түүх (хамтын бүтээл), “МУИС пресс” хэвлэлийн газар, 2017 он, 395 дахь тал. Харин үндсэн шалтгаан нь тус комиссын төсөл Монголд хэмжээт эрхт хаант засгийг хадгалах чиглэлийг баримталсанд оршиж байв.

<sup>12</sup> Амарсанаа Ж., Батсайхан О. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг. УБ., 2004 он, XXII дахь тал.

<sup>13</sup> Богд гэгээн таалал төгсөнгүүт түүний хойт дүрийг тодруулах тухай асуудал яригдсан бөгөөд энэ нь сүсэг бишрэлийн хажуугаар засаг төрийн тухай асуудал байсан тул олон түмний сүсэг бишрэл, улс төрийн тухайн нөхцөл байдлыг харгалзан хэдийгээр Богдын хойт дүрийг тодруулахаас шууд татгалзаагүй боловч хойш тавьж, харин бүгд найрамдах засаг тогтоох ажлыг ихээхэн яаравчилжээ.

дугаар сарын 3-ны өдрийн хурлаас гаргасан шийдвэр, түүнийг мөн оны 6 дугаар сарын 7-нд баталж, "...одоо ардын эрхтэй улсын ёсонд нийцүүлэн... Бүгд Найрамдах Ард Улсын засгийг явуулбаас зүйтэй болох ба Да цзун тун хэмээх их ерөнхий даргыг сонгохгүй, улсын дээд эрхийг улсын их хурлын дүрмийн ёсоор тус хуралд хадгалах..." гэсэн МАХН-ын Төв Хорооны бүгд хурлын тогтоол, энэхүү шийдвэрийг сайшаан баталсан Ардын засгийн газрын 18 дугаар хурлын тогтоол<sup>14</sup> зэргийг нэрлэж болно. Эдгээр улс төрийн үйл явцын оргил нь Ардын засгийн газрын 1924 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 39 дүгээр хурлын тогтоолоор Үндсэн хууль боловсруулах шинэ комисс байгуулсан үйл явдал болов.<sup>15</sup>



Зүүн гараас: П.В.Всесвятский, Хатагбаатар Магсаржав, Элбэгдорж Ринчино, Б.Цэрэндорж, А.Амар, С.Нацов нар

Ерөнхий сайд Б.Цэрэндорж тэргүүтэй комисс ажилдаа дараах чиглэлийг баримталсан байдаг. Үүнд, нэгдүгээрт, МАХН-ын III их хурлаас улсаа капиталист бус замаар хөгжүүлэх зорилтыг намын жанжин шугам болгож, түүнийг хангах гол тулгуур хүч нь жинхэнэ ядуу, дунд ард болно гэсэн заалтыг онол, улс төрийн удирдамж болгосон; хоёрдугаарт, Ардын засгийн газар ба Богд гэгээний хооронд байгуулсан “Тангарагийн гэрээ” болон

“Улсын түр цагийн хурлын дүрэм”, “Монгол улсын засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний тухай дүрэм”, “Бүгд Найрамдах засаг тогтоон явуулах тухай Ардын засгийн газрын тогтоол” зэрэг Үндсэн хуулийн чанартай актуудыг харгалзан үзсэн; гуравдугаарт, 1924 онд ЗХУ-аас уригдан ирсэн хуульч мэргэжилтэн П.В.Всесвятский болон Коминтерний төлөөлөгч Э.Ринчино, Т.Рыскулов<sup>16</sup> нарын шууд нөлөөгөөр хувьсгалт Монголын Үндсэн хуулийн голлох эх загвараар зөвлөлтийн Үндсэн хуулийг сонгожээ.<sup>17</sup> Тус комисс Үндсэн хуулийн төслийг богино хугацаанд боловсруулж Монгол Улсын Анхдугаар Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Их Хурал хоёр өдрийн турш төслийг зүйл бүрээр ширхэгчлэн хэлэлцэж, жар гаруй төлөөлөгч Үндсэн хуулийн төслийн талаар санал дүгнэлтээ хэлсэн ба эдгээр саналын үндсэн дээр зохих засвар оруулж, 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 16 цаг 17 минутад 14 дүгээр тогтоолоор Үндсэн хуулийг баталсан юм. Ийнхүү Монгол Улс түүхэндээ анх удаа Үндсэн хууль хэмээх улсын гол хуультай болсон билээ.<sup>18</sup> БНМАУ-ын

<sup>14</sup> Ардын засгаас 1921-24 онд авсан хувьсгалт арга хэмжээнүүд, УБ., 1954 он, 88 дахь тал.

<sup>15</sup> “Үндсэн хууль зохиох ба Улсын Их Хурлын бэлтгэл ажлын тухай” Засгийн газрын 1924 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 39 дүгээр хурлын тогтоолын 15 дугаар зүйл: “Тус улсын Үндсэн хуулийг зохиох ба засгийн газрын дүрмийг шинэчилж даруйхан төлөвлүүлэн Улсын Их Хуралд батлуулах явдлыг хэлэлцээд үүнд тусгай комисс томиж эл зүйлийг эрхбиш долоо хоногийн дотор гүйцэтгүүлэн ирүүлэх явдлыг Засгийн газраас гүйцэтгүүлэхээр тогтов” (БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхтгэл УБ., 1972 он, 96 дахь тал)

<sup>16</sup> Уг төслийг хэлэлцэхэд Коминтерний төлөөлөгчид Улсын Их Хурлын төлөөлөгч нартай зэрэгцэн 20 гаруй удаа үг хэлж тайлбарлаж, санал оруулж батлуулан бас хянан найруулах комисст орж ажилласан байна. БНМАУ-ын Анхдугаар Их Хуралд анхдугаар Үндсэн хуулийн төслийн талаар ерөнхий сайд Б.Цэрэндоржийн тавьсан илтгэл, уул төслийг хэлэлцэж баталсан тухай тэмдэглэлээс үзвэл Арван гуравдугаар хуралдаанд (1924 оны 11 дүгээр сарын 25-нд) Коминтерний төлөөлөгч Рыскулов: Энэхүү Үндсэн хуулийг төлөвлөхөд би мөн туслалцсан гээд төлөөлөгчдийн зарим асуултанд хариулж байсан юм. Ж.Амарсанаа, О.Батсайхан. *Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг*. УБ., 2004 он, 53 дахь тал.

<sup>17</sup> Хэрэв анхны комиссын бүрэлдэхүүнд голдуу эрдэмтэн мэргэд орж байсан бол хичээнгүй сайд Б.Цэрэндоржийн ахалсан комисст дөрвөн хүнээс гурав нь оросын буриад нар байжээ (Элбэгдорж Ринчино, Цэвээн Жамсранов, Гомбобаддамжав). Б.Батбаяр (Баабар). *XX зууны Монгол. Нүүдэл, суудал. Олз гарз*. УБ., 1996 он, 343-344 дэх тал.

<sup>18</sup> БНМАУ-ын анхдугаар Үндсэн хууль нь бүгд 6 бүлэг, 50 зүйлээс бүрдэж байв. Үүнд: Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлэгт Монголын жинхэнэ ардын эрх чөлөөг илтгэн тунхаглах тухай, Хоёрдугаар бүлэг нь Улсын дээд эрх барих газрын (Улсын Их Хурал, Улсын Бага Хурал, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид, Засгийн газар, Эдийн засгийн зөвлөл) тухай, Гуравдугаар бүлэг нь Орон нутгийн захиргааны тухай, Дөрөвдүгээр бүлэг нь Сонгох, сонгогдох эрхийн тухай, Тавдугаар бүлэг нь Улсын орлого, зарлагын эрхийн тухай, Зургадугаар бүлэг нь Улсын тамга ба сүлд тэмдэг, туг далбаа гурвын тухай тус тус заасан байна.

анхдугаар Үндсэн хууль 1921-1924 онуудад тус орны улс төр, нийгэм эдийн засаг, ангиудын хүчний харьцаанд гарсан хувьсгалт өөрчлөлтүүд болон ардчилсан ёс журмуудыг хууль цаазын үүднээс дүгнэж, ардын бүгд найрамдах байгууллыг төрийн захиргааны хэлбэр болгон хуульчлан бэхжүүлжээ.

БНМАУ-ын Анхдугаар их хурлаар тус улсын Үндсэн хуулийг баталсан нь Монголын ард түмний өнгөрсөн үед байгаагүй улс төрийн том үйл явдал болов.

### III. 1924 ОНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Анхдугаар Үндсэн хуулийн үзэл баримтлалын цөм нь үндэсний ардчилсан үзэл болж байв. Түүний ач холбогдлыг дараах чиглэлээр тодорхойлж байна. Үүнд:

**а) Монгол Улсын тусгаар тогтнолыг дэлхий даяар зарлан тунхагласан нь.** Монголд 1921 онд ялсан ардын хувьсгал тусгаар тогтнолоо сэргээн тогтоох шинэ замыг нээж өгсөн билээ. Ардын засгийн газраас эхний өдрөөс эхлэн улсынхаа тусгаар тогтнолыг нийтэд зарлаж, аливаа улс түмэнтэй энх тайван, найрамдалт харилцаа тогтоох тухай саналаа илэрхийлж байв. Тухайлбал, “Монгол Улсыг тусгаар тогтносон тухай гадаад олон улсуудад тунхагласан бичиг”-т “...Манай ардын засгийн газраас ер Дундад улстай<sup>19</sup> өшөө хорсголыг агуулан байлдах дайлах хэргийг явуулах саналгүй боловч, Хятадын сузернитетийг<sup>20</sup> дахин хүлээж хэрхэвч чадахгүй, гагцхүү одоогийн байгуулсан ардын эрхтэй хэмжээт засгийг өөрсдөө эзэрхэн явуулж ...үүнээс хойш олон улстай нэгэн адилаар худалдаа нэвтрүүлнэ гэж дараа удаагаар батлан ирүүлсэн явдлыг хамтад илэрхийлэн гаргав” гэжээ.<sup>21</sup> Мөн “Улсын түр цагийн хурлыг байгуулах бичиг ба дүрэм”-д “Эдүгээ бол манай гадаад Монгол нэгэнт дэлхий дахины олон улстай адил улс байгуулсан тул, мөнхүү хурал байгуулан хэлэлцэж, түмэн ардын тус ашгийг бадруулан өнө үүрдийн дагаж журамлах хууль дүрмийг тогтоох нийтээр эрдэм соёлд гэгээрэн, эртнээс уламжлан ирсэн язгуур үндсийг бататган бадруулах чухал цаг” ирснийг тэмдэглэжээ.<sup>22</sup> Ялангуяа Үндсэн хууль хэлэлцэгдэж байсан цаг үе нь манай хоёр хөрш орон Монголын статусын асуудлыг монголчуудын оролцоогүйгээр шийдвэрлэх оролдлого хийж байсан үетэй давхцсан нь Монгол Улс тусгаар тогтносон, бүрэн эрхт улсын статусаа дэлхий нийтийн сонорт нэн яаралтай хүргэх явдлыг үлэмж чухал зорилго болгов.<sup>23</sup> Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд: “Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн Эрхт Ард Улс гэж улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн, улсын аливаа хэргийг Улсын Их Хурал ба мөн Хурлаар сонгогдсон Засгийн Газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүсэглэн дагавал зохино” гэж заажээ. Гэхдээ тунхаглах нь нэг асуудал, хүлээн зөвшөөрүүлэх нь өөр асуудал. Монгол Улс тусгаар тогтнолоо асар их үнээр, үе үеийнхний тууштай тэмцэл, улс төрийн, дипломат, цэргийн, хууль зүйн цогц

<sup>19</sup> Дундад улс- Хятад улс.

<sup>20</sup> Сузернитет- аль нэг улсын эрхшээлд байх.

<sup>21</sup> Ардын Засгийн Газраас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд, УБ., 1954 он, 145-147 дахь тал.

<sup>22</sup> БНМАУ ТТА Лавлах номын сан, 1921.

<sup>23</sup> Зөвлөлт Холбоот Улс, Дундад Иргэн Улс(Хятад)-ын хооронд 1924 оны тавдугаар сарын 31-нд байгуулсан “ЗСБНХУ ба Дундад Иргэн Улсын хооронд асуудлыг зохицуулах ерөнхий зарчмуудын тухай хэлэлцээр”-ийн 5 дугаар зүйлд: “ЗСБНХУ нь Гадаад Монголыг Дундад Иргэн Улсын бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрч Хятадын суверенитетийг хүндэтгэнэ. ЗСБНХУ нь Гадаад Монголоос Орос улсын цэргийг татан авах тухай, тодруулбал эдгээр цэргийг татах цаад талын хугацаа болон ЗСБНХУ-ын хил хязгаарыг аюулгүй байлгах үүднээс авбал зохих арга хэмжээний тухай асуудлыг энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан Бага хурлаар шийдвэрлэмэгц ЗСБНХУ-ын засгийн газар өөрийн цэргийг Гадаад Монголоос гаргах болно” гэж заажээ. Орос, Хятадын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхэтгэл. УБ., 2001 он. 149-150 дахь тал.

арга хэмжээний үр дүнд олж авч, баталгаажуулсан.<sup>24</sup> Иймд БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн түүхэн гавьяа нь БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхийг анх удаа Үндсэн хуулийн түвшинд тунхаглан бэхжүүлсэнд оршино.

**б) Хэмжээт цаазат хаант засгаас Бүгд найрамдах засагт шилжээнийг тунхагласан нь.** Төрийн эрхэнд гарсан хувьсгалчдын хувьд улс орноо цаашид хэрхэн яаж хөгжүүлэх замаа сонгох нэн чухал асуудалтай тулгарсан билээ. Үүний гол гогцоо нь засаглалын асуудал, тодруулбал цаашдаа хаант засгийн хэлбэрээ хадгалах уу, аль эсхүл бүгд найрамдах хэлбэрт шилжих үү гэсэн асуудал байв. Энэ талаар эрх баригчдын дунд нэгдсэн ойлголцол байгаагүй. Зарим улс төрч хуучнаар явах нь зүйтэй гэж үзэж байсан<sup>25</sup> бол дийлэнх нь төрийн удирдлагын хаант хэлбэрийг эгнэгт халж, илүү дэвшилттэй бүгд найрамдах ёсыг тогтоох тал дээр хатуу зогссон. Гэхдээ дээр тэмдэглэсэнчлэн Монголын хүн амын дийлэнх сүсэгтэн байсан бөгөөд шашны нөлөөнд гүнзгий автсан, хаанаар өргөмжлөгдсөн шашны тэргүүн Богд гэгээнийг тахин шүтэж байсан нөхцөлд хаант засгаас татгалзах нь туйлын адармаатай зорилт байсан учраас мухардалд орсон бөгөөд гагцхүү Богд хаан жанч халсан нь Монголын засаглалын хэлбэрийг өөрчлөх асуудлыг гацаанаас гаргасныг түүхэн үйл явдлын өрнөл нотолдог. Ерөнхийлөгчгүй, Бүгд найрамдах улсын төрийн байгуулалтыг тус оронд тогтоон явуулах тухай Ардын засгийн газрын 1924 оны зургадугаар сарын 13-ны өдрийн тогтоолыг үндэс болгосон заалт анхдугаар Үндсэн хуулийн оршилд орсноор Монгол Улс Азидаа дөрөв дэх бүгд найрамдах улс болсон билээ.<sup>26</sup> Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлд: “БНМАУ-ын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах бөгөөд мөн Хурлын чөлөө цагт Улсын Бага Хуралд хадгалуулах, ба бас мөн Хурлын чөлөө цагт Бага Хурлын Тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино” гэж зохицуулжээ. Анхдугаар Үндсэн хуулиар тус улсад бүгд найрамдах засаг тогтоосон нь үлэмж ач холбогдолтой алхам болсон юм.

**с) Бүх шатны Хурлууд нь төрийн улс төрийн үндэс болсныг хуульчлан бэхжүүлсэн нь.** Дороос дээр хүртэл бүх шатны Хурлууд тус улсын улс төрийн үндэс болсныг Үндсэн хуулиар хуульчлан бататгажээ. Эдгээр Хурлууд ардын төрийн улс төрийн үндэс, ардын төрийн тогтнох хэлбэр болсон нь нэгдүгээрт, нийт улс орны хэмжээнд төлөөлөгчдийн байгууллагын нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, төв ба орон нутагт төрийн бүх эрхийг гартаа авсан; хоёрдугаарт, төрийн гүйцэтгэн захирах бүх байгууллагын эх үндэс болж, ард түмний нэрийн өмнөөс тэдгээрийн үйл ажиллагааг хянан шалгаж удирдан чиглүүлж байхаар заасан. Ингэснээр Монголын түүхэнд анх удаа төрийн байгууллагуудын өмнөхөөс давуу тогтолцоог Үндсэн хуулийн түвшинд бэхжүүлжээ. Харин сайны хажуугаар саар гэгчээр, энэхүү тогтолцоо нь хэт төвлөрсөн шинжтэй байсан нь түүнийг шүүмжлэх гол үндэслэл болдог. Гэхдээ үүний бурууг ганц Үндсэн хуульд тохох нь учир дутагдалтай. Үнэн хэрэгтээ 1924 оны Үндсэн хуульд төрийн эрх барих ба төрийн захиргааны байгууллагуудын эрх

<sup>24</sup> Монголд ардын хувьсгал ялсны дараахнаас ардын засгийн газар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бусад улсаар, ялангуяа хөрш зэргэлдээ улсаар хүлээн зөвшөөрүүлэх оролдлого хийсэн юм. Хэрэв Дундад Иргэн Улс [Хятад] Гадаад Монголыг өөрийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэсэн байр суурин дээр баттай зогсож байсан бол ЗХУ нь БНМАУ-тай Засгийн газрын түвшинд олон тооны гэрээ, хэлэлцээр байгуулж, төрөл бүрийн туслалцаа үзүүлж байсан боловч тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрөөгүй хэвээр байв. Үүний шалтгаан нь БНМАУ-аас болж Дундад Иргэн Улстай тогтоосон харилцаанд сэв суулгахыг ЗХУ хүсээгүйтэй холбоотой. Харин дайны хүнд жилүүдэд БНМАУ хойд хөршөө дэмжиж, чадан ядан туслаж, үнэнч холбоотон гэдгээ харуулсан учраас Дундад Иргэн Улстай 1945 оны наймдугаар сард найрамдал, холбооны гэрээ байгуулахдаа БНМАУ-ын тусгаар тогтнолын асуудлыг Монголын ард түмэнд даатгуулж, бүх нийтийн санал асуулгаар шийдвэрлүүлэх болзлыг тавьсан юм. Энэхүү бүх нийтийн санал асуулгад оролцсон саналын эрх бүхий иргэд бүгдээрээ улсынхаа тусгаар тогтнолын төлөө саналаа өгснийг харгалзан Хятадын засгийн газраас 1946 оны нэгдүгээр сард БНМАУ-ын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн ноот бичгийг ирүүлжээ. Үүний дараахан ЗХУ мөн БНМАУ-ын тусгаар тогтнолыг албан ёсоор зөвшөөрч, улмаар Ази, Европын олон орон энэ жишгийг дагасан бөгөөд хожим 1961 онд БНМАУ НҮБ-д элсэж, алтан соёмбот далбаагаа Нью-Йоркийн тэнгэрт мандуулсан юм.

<sup>25</sup> Үндсэн хуулийн анхны хоёр төсөл боловсруулсан Д.Бодоо, Ж.Цэвээн аль аль нь Монгол улс төрийн байгуулал, засаглалын хэлбэрийн хувьд хэмжээт эрхт хаант улс байхаар төсөөлж байсан нь тэдний тус тусдаа боловсруулсан төслөөс харагддаг. Ц.Батбаяр, Д.Лүндээнжанцан. Хэмжээт цаазатаас бүгд найрамдах засагт шилжсэн нь: анхдугаар Үндсэн хууль. “Мөнхийн үсэг” хэвлэлийн газар, УБ., 2023 он, 145 дахь тал.

<sup>26</sup> Азийн нийт 48 орноос 35 нь бүгд найрамдах улс бол 13 улс хаант засагтай. Анх бүгд найрамдах улсын хэлбэрийг Хятад улс 1912 онд, Сири 1920 онд, Турк улс 1922 онд тус тус сонгож байсан. Харин Энэтхэг, Вьетнам, Солонгос, Индонез, Египет, Пакистан, Ирак зэрэг улс дөнгөж 1940-1950-иад онд бүгд найрамдах улсуудын эгнээнд шилжсэн билээ.



хэмжээ, харилцах зарчмуудыг нарийвчлан тодорхойлоогүй бөгөөд эдгээр асуудлыг Нутгийн захиргааны дүрэмд заасан ёсоор гүйцэтгэн явуулах тухай заасан байдаг (Үндсэн хуулийн 33 дугаар зүйл). Харин нутгийн засаг захиргааны хууль тогтоомжид нутгийн Хурлууд цөм дээрээсээ доошоо шатлан захирагдах төвлөрсөн удирдлагын зарчмын үндсэн дээр зохион байгуулагдахаар зохицуулсан юм.

**д) Монголын ард иргэдийн тэгш эрх, эрх чөлөөг тунхагласан нь.** Урьд нь феодалуудын эрхшээлд, ямар ч эрх мэдэлгүй байсан албат, хамжлага, шавь нар Ардын хувьсгалын ачаар Монголын иргэн гэсэн хүндэт алдрыг олж авсныг баталгаажуулсан төдийгүй, анх удаа аливаа хэргэм зэргийг устгаж, тус улсын харьяат аливаа хүн адил тэгш эрхтэй байх, тэдгээрээс эдлэх нийгэм, улс төрийн өргөн эрх, эрх чөлөөг тунхаглан бэхжүүлсэн нь анхдугаар Үндсэн хуулийн үлэмж дэвшилттэй тал байсан юм. Үндсэн хуулийн тэргүүн бүлгийн 3 дугаар зүйлд “улс төрийн бүх хэргийг ард түмнээс удирдан гүйцэтгэх явдлыг хүндэтгэх ба ... улсын үндсийг батагахад гол болгон явуулбал зохих зүйлүүд”-ийн дотор тус улсын харьяат ард түмний шүтэх итгэх эрх чөлөөг бүрнээ хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ үүний тулд төрөөс шашныг тусгаарласныг хууль ёсоор баталж, шүтэх бишрэх явдал нь хүн бүрийн хувийн дүр сүсгээс болно гэж заажээ. Мөн иргэдэд шүүмжлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, нийтээр хуралдах, цэнгэлдэх ба баяр ёслол үйлдэх, аливаа эвлэл хоршоо зэргийг байгуулах, элдэв ухааны эрдэмд үнэ төлбөргүй сурч боловсрох эрхүүдийг хүндэтгэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд нь улсаас дэмжихээр тогтоосон нь энэ Үндсэн хуулийн нэгэн онцлог гэж хэлж болно. Тухайлбал, шүүмжлэх эрхийг хэрэгжүүлэхэд улсаас аливаа хэвлэх, нийтлэх явдлыг бүртгэн гүйцэтгүүлэх, хуран цуглах, жагсаж цэнгэхэд улсаас хэрэгцээт орон байшин, элдэв хэрэглэл зэргийг бэлтгэн гүйцэтгүүлэх, эвлэл, хоршоо байгуулах бол элдэв тусламж үзүүлэх гэх зэргээр тухайн эрх бүрийг хүндэтгэх, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай элдэв дэмжлэг, тусалцаа үзүүлэх үүргийг төр өөр дээрээ хүлээсэн байна. Энэ бүхэн тус улсад иргэдийн эрх, эрх чөлөөг зөвхөн тунхаглаад зогсохгүй, хэрэгжих баталгаатай болгох анхны оролдлого байв. Түүнчлэн яс угсаа, шашин шүтлэг, эрэгтэй, эмэгтэй гэж ялгаварлахгүйгээр харьяат ард иргэнд нэгэн адил тэгш эрх эдлүүлэхээр тунхаглажээ. Үүний зэрэгцээ Үндсэн хуулиар иргэдийн хүлээх үүргийг шууд заагаагүй боловч тус улсын иргэд Үндсэн хуулийг сахин биелүүлэх, цэргийн алба хааж, Эх орноо баглан хамгаалахад оролцох тухай санаа тусгагджээ.<sup>27</sup>

**е) Тус улсад сонгуульт ёс журмыг бэхжүүлсэн нь.** Аливаа улсын шинж чанар нь юуны урьд тэдгээр орны засаг захиргааны байгуулалтын сонгуулийн систем, ард иргэдийн эрх үүрэг аль хэр өргөн бөгөөд чөлөөтэй байгаагаар тодорхойлогддог. Ардын Засгийн газраас 1923 оны гуравдугаар сарын 22-ны өдөр баталсан “Нутгийн захиргааны дүрэм”-ээр нутгийн өөрөө удирдах байгууллагыг сонгуулиар байгуулах журмыг тогтоосноор тус улсад сонгуулийн тогтолцоо анх бүрэлджээ.<sup>28</sup> Монгол Улсын сонгуулийн тогтолцооны цаашдын хөгжилд анхдугаар Үндсэн хууль чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Үндсэн хуульд “Сонгох, сонгогдох эрхийн тухай” тусгай бүлэг орж, түүндээ ардчилсан сонгуулийн тогтолцооны гол агуулгыг тодорхойлсон билээ. Уг бүлэгт, тус улсын харьяат эрэгтэй, эмэгтэй<sup>29</sup> хэн боловч сонгууль явагдах өдөр 18 нас хүрэгч нь Улсын Их Хурал, орон нутгийн хурлуудад төлөөлөгчийг сонгох, төлөөлөгчдөөр өөрсдөө сонгогдох эрхтэй гэж заасан бөгөөд тэр зүйлдээ тодруулан “(нэг) өөрийн хүчийг үнэлэх буюу хувийн ажил хийж амьдрагчид, (хоёр) ардын хувьсгалт цэрэг” гэж онцлон тэмдэглэсэн юм (Үндсэн хуулийн 34 дүгээр

<sup>27</sup> Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйл, Гуравдугаар зүйлийн Тав.

<sup>28</sup> Уг дүрмээр иргэд саналаа ил гаргах журмыг тогтоосны дээр олон шатлалт сонгуулийг тогтоожээ. Өөрөөр хэлбэл, иргэд зөвхөн доод шатны Хурлыг шууд сонгож, үүний дараа тэдгээр Хурлууд өөрийн дээд шатны Хурлуудыг шатлан сонгох журмыг тогтоосон байна. *Орон нутагт ардчилсан засаг захиргааны байгууллагуудыг байгуулсан нь*. Улсын хэвлэлийн газар, 1958 он, 8-15 дахь тал.

<sup>29</sup> Монгол улс 1924 онд анхдугаар Үндсэн хуулиа батлахдаа эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан Азийн анхны улс болж байсан. Тэгвэл Азиас дэлхийн тэргүүлэгч орны тоонд багтдаг БНХАУ, Энэтхэг, Япон, Өмнөд Солонгос дөнгөж 1940-өөд онд эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийг хүлээн зөвшөөрч байсан юм.

зүйл). Урьд хөдөлмөрөөрөө амьдрагчид, цэргүүд, эмэгтэйчүүд ямар ч эрх чөлөөгүй байсан бол энэ бүхнийг эцэс болгож энэ цагаас төрийн хэрэгт тэгш эрхт гишүүн нь болон оролцох болсныг ийнхүү илтгэжээ. Тухайн үед олон оронд боловсрол, суурьшил, хүйс, эд хөрөнгө, цэргийн албан хаагч эсэх зэргийг харгалзан иргэдийнхээ сонгох, сонгогдох эрхэд олон тооны хязгаарлалтыг тогтоодог байсан бол анхдугаар Үндсэн хуульд Монголын нийт хүн амын дотроос таван бүлэг иргэний сонгох, сонгогдох эрхийг хасахаар заажээ. Хэрэв сэтгэл мэдрэлийн өвчтэй гэдэг нь эмнэлгийн зохих байгууллагаас шинжлэн тогтоогдсон болон эд хөрөнгө хулгайлах, завших хэргээр ял шийтгүүлсэн этгээдийн сонгуулийн эрхийг хассан нь сонгуулийн ардчилсан зарчимтай нийцэж байсан бол “...ямагт ашгийг эрмэлзэн бусдыг зарж мөлжин амьдрагчид, ямагт бусдыг хөлслөн зарах ба хөрөнгө орлого зэргийн үржлээр амьдрагч жинхэнэ худалдааны ба мөнгө хүүлэгчид, урьдын ван, гүн, хутагт хувилгаад, жич орон хийдэд үргэлж суух санваартан лам нар”-ын сонгох, сонгогдох эрх буюу хэрэг дээрээ улс төрийн бүх эрхийг хассан нь энэ Үндсэн хуулийн ангич шинж чанарын илэрхийлэл байв.<sup>30</sup> Энэ дашрамд тэмдэглэхэд, аливаа хувьсгалын зорилго нь нэгэнт унагаагдсан улс төрийн хүчнийг улс төрд эргэн орж ирэх бололцоо, нүх сүвийг хаахад чиглэгддэгийг ХХ зуунд нийгмийн гарал, нийгмийн байдал, улс төрийн шинжээр хэсэг бүлэг иргэдийнхээ сонгох, сонгогдох эрхийг хасч байсан Ангол, Вьетнам, Румын, ЗХУ, Хятад зэрэг улсын жишээг нэрлэж болох боловч энэхүү практик нь ардчилсан ёс, зарчимд хэрхэвч нийцэхгүй гэдэг нь тодорхой.<sup>31</sup> Нөгөөтэйгүүр, зарим эрдэмтэн, судлаач Үндсэн хуулийн энэ заалт яваандаа олон мянган хүнийг хэлмэгдүүлсэн аймшигт үр дагаварт хүргэсэн гэж дүгнэсэнтэй<sup>32</sup> дараах үндэслэлээр бүрэн зөвшөөрөх боломжгүй байна. Үүнд: Нэгдүгээрт, Монголд явагдсан их хэлмэгдүүлэлт олон шалтгаантай байсан бөгөөд үндсэн шалтгаан нь эрх баригч намын болон төрийн удирдлагын түвшинд өрнөсөн улс төрийн ширүүн тэмцлийн үр дагавар байв. Хэрэв Үндсэн хуулийн энэхүү заалт хар, шар феодал, мөнгө хүүлэгч, бусдын хөдөлмөрийг мөлжигчдийн эсрэг чиглэж байсан бол улс төрийн хэлмэгдүүлэлтийн он жилүүдэд |1937 оноос хойш| хэлмэгдүүлэлтэд өртөгсдийн дийлэнх нь нийгмийн бүх давхрааны төлөөлөл, тухайлбал лам нараас гадна нам, төр, цэргийн, олон нийтийн болон аж ахуйн байгууллагын удирдах, гүйцэтгэх ажилтнууд, жирийн иргэд байв.<sup>33</sup> Хоёрдугаарт, сул ван, гүн, тайж нар болон түшмэдэд тэдгээрийн нэлээд хэсгийн хөрөнгө хүч, ахуй байдал, нийгмийн амьдралд эзлэх байр суурь нь ард ангийхаас төдийлөн ялгаваргүй байсан, мөн ардын төрийн бодлогод

<sup>30</sup> Төр үеийн Засгийн газраас гаргасан 1924 оны Үндсэн хуулийн албан ёсны тайлбарт: “...нэгдүгээр, хоёрдугаар ангид дурдсан хүмүүс болоос ард түмний ашиг тусыг өчүүхэн ч хайхрахгүй, дан ганц өөрсдийн хувийн ашиг завшааныг эрхэмлэн ямагт бусдыг мөлжин хохируулагчид болох...” гээд “...нэгдүгээр ангийн хүмүүс Монголд байхгүй ч хойшид гарч ирвэл үгүй болгоход бэрх. Хоёрдугаар ангийн хүмүүс хааяа үзэгдсээр буй, гуравдагч ангид дурдсан ван, гүн, хутагт хувилгаад бол ард түмнийг хэсэг, бүлгээр нь боолчлон дарлаж ирсэн учраас тэдэнд, бас төрөөс шашныг тусгаарласан тул лам нарт сонгох, сонгогдох эрх олгох нь үл зохилдоно” гэх зэргээр тайлбарлажээ. Амарсанаа Ж., Батсайхан О. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг, 2004 он, 63-96 дахь тал. ю

<sup>31</sup> В.Е.Чиркин. *Конституционное право зарубежных стран*. Москва, “Юристь”, 2005 он, 230 дахь тал.

<sup>32</sup> Ж.Бямбадорж. *Монгол Улсын сонгуулийн тогтолцоо: Онол, арга зүй, цаашдын төлөв*. “Адмон”, УБ., 2023 он, 11дэх тал; Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг |Эмхэтгэсэн Ж.Амарсанаа, О.Батсайхан|. 2004, XXIV дахь тал.

<sup>33</sup> Түүхч нарын үздэгээр, баруунтан хэмээн цоллогдсон үндэсний ардчилсан хөгжлийн чиг шугамыг баримтлагчид, тэдгээрийн дотор анхдугаар Үндсэн хуулийг боловсруулж батлахад гар биеэр оролцсон Хичээнгүй сайд Б.Цэрэндорж, Ерөнхий сайд А.Амар, эрдэмтэн Ж.Цэвээн нарыг 1924-1928 оны хооронд улс төрийн тавцангаас зайлуулан, 1928 оны арванхоёрдугаар сард хуралдсан МАН-ын VII их хурлаас нам, төрийн удирдлагад гарч ирсэн хатуу шугам баримтлагч зүүнтүүдээс ноёд болон шашны мяндагтны хөрөнгө хураах, сүм хийдийн хөрөнгө, барилга, жасын бүх хөрөнгөнд ноогдуулдаг татварыг өсгөх, уламжлалт шашин, соёл руу бүдүүлгээр дайрах зэрэг нугалаа, завхрал хэрээс хэтэрч, бүх нийтийн дургуйцал, бослогод хүргэсэн явдал хэлмэгдүүлэлтийн эхлэлийг тавьсан. *Монгол Улсын түүх* (хамтын бүтээл), УБ., “Адмон принт”, 2017 он, 398-401 дэх тал. Цаашлаад 1937 оны наймдугаар сард ЗХУ-ын Батлан хамгаалах, дотоодын хэргийн ардын комиссарын орлогч М.П.Фриновский П.Гэндэнгийн мөрдөн байцаалтын мэдүүлэг, “хуйвалдаан”-д оролцсон гэх 115 хүний нэрсийн жагсаалтыг авчирснаар дайчлан баривчлах ажиллагаа эхэлж, улс төрийн хэлмэгдүүлэлт гаарсан юм. Мөн тэнд, 408-410. Үүний уршгаар 1937-1939 онд хууль ёсыг ноцтой гажуудуулж, нам, улс, олон нийт, аж ахуйн байгууллагын удирдах ажилтан олон хүнийг хилс хэлмэгдүүлжээ. М.Санждорж. *Ардын төрийн түүх*. УБ., “ШУА-ийн хэвлэл”, 1974 он, 223 дахь тал. Хэрэв 1932 оноос 1937 оныг хүртэлх таван жилд 1730 хүн шийтгэгдэж, нэг хүрэхгүй хувь нь цааздуулсан бол 1937 онд байгуулагдсан Онцгой бүрэн эрхт комиссын шийдвэрээр 1937-1940 онд 27 мянга шахам хүн ял сонссоноос 20 мянга гаруй хүн буюу 77 хувь нь цаазаар авах ялаар шийтгүүлжээ. *Монгол Улсын түүх*. “Адмон”, УБ., 1999 он, 136 дахь тал.

нааштай хандаж байсныг харгалзан сонгуулийн эрх эдлүүлжээ.<sup>34</sup> Тухайлбал, 1929 оны гуравдугаар сард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан тогтоолоор батлагдсан “Үндсэн хуулиар сонгуулийн эрх нь хасагдсан хүмүүсийн тухай заавар”-т хэний сонгуулийн эрхийг хасаж, хэнийхийг сэргээж болох тухай заажээ.<sup>35</sup>

Үндсэн хуулиар тус орны эдийн засгийн үндсийг бэхжүүлсэн нь. Эрдэмтэн, судлаачдын үзсэнээр, уг хууль улсын эдийн засгийн суурь, улсын төсвийн орлого, зарлагыг тодорхойлсноороо төрийн эдийн засаг, санхүүгийн үндсийг анхлан тогтоосон.<sup>36</sup> Үүний тулд гадаад худалдаан дээр улсын онц эрхийг зарлан тогтоохын хамт санхүү эдийн засгийн бодлогыг улсаас эрхлэн удирдах явдлыг тогтоожээ. Энэ тухайд Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 4-т: “Улсын аж ахуйн ба эдийн засгийн бодлогыг чухал болгон тус улсаас эрхлэн удирдах ба мөн гадаадтай харилцах худалдааг улсын онц эрх болгон авах нь ардын эрхийг мандуулах, мөн ардын эрхт засгийг бататгах чухал нөхцөл болох тул цөм улсаас эрхэлбэл зохино” гэжээ. Энэ нь тус орны эдийн засгийн амьдралыг удирдах хэргийг төрийн үүрэг болохыг Үндсэн хуулиар бататгасан явдал болов. Мөн тус орны нутаг дахь газар ба уурхай, ой мод, ус ба тэдгээрийн баялгийг ардын мэдэлд бүрэн шилжүүлж энэ тухайд хувьдаа өмчлөх явдал байж болохгүйг заажээ. Энэ заалт нь улсын тусгаар тогтнолын эдийн засгийн үндсийг хамгаалахад чиглэгдэж байв.

Бүс нутагтаа түүчээлсэн нь. Монгол улс төрийн гол хууль болох бичмэл Үндсэн хуулийг баталсан Азийн арван нэг дэх орон болжээ. Түүнчлэн Азийн улсууд дотроос хаант засгаас бүгд найрамдах засаглалд шилжсэн дөрөв дэх улс, эмэгтэйчүүдэд сонгуулийн эрх олгосон анхны улс болсон бол тус улсын харьяат аливаа хүн адил тэгш эрхтэй байх, ялангуяа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг тунхаглаж, жирийн иргэд, өөрийн хөдөлмөрөөр амьдрагчид, цэргүүдээс эдлэх эрх, эрх чөлөөг тогтоон бэхжүүлсэнээрээ тивдээ тэргүүлэгч орны нэг болсон юм.

#### IV. ДҮГНЭЛТ

1924 оны Үндсэн хууль нь улс орны хөгжилд ололт, амжилтын зэрэгцээ сөрөг үр дүн, гажуудлыг авчирсан нь түүхэн үнэн юм. Энэ хууль нэг талаас үзэл баримтлалын хувьд үндэсний ардчилсан үзэлд суурилж байсан боловч, нөгөө талаас ангич мөн чанартай байсан бөгөөд “зөвлөлтжүүлэх” бодлогын нөлөөнд автаж, нийгмийг эсрэг тэсрэг ангиудад хуваан талцуулах эрх зүйн үндэс болж өгсөнд түүний гол дутагдал оршино. Тийм ч учраас энэ Үндсэн хуулийг социалист хэв маягийн Үндсэн хуулийн ангилалд хамааруулдаг. Энэхүү зөрчилт байдал нь түүнийг боловсруулах комисст нэг талаас Хичээнгүй сайд Б.Цэрэндорж, эрдэмтэн Ж.Цэвээн зэрэг үндэсний ардчилсан хөгжил, сэргэн мандалт, эв нэгдэл, ардын эрхт ёсыг баримтлагчид, нөгөө талаас Элбэгдорж Ринчино, Т.Рыскулов зэрэг ангич хатуу байр суурийг баримтлагчид орсонтой холбоотой. Яваандаа үндэсний ардчилсан хөгжлийн чиг шугамыг баримтлагчид нам, төрийн удирдлагаас зайлуулагдаж, ардчилсан хувьсгалт өөрчлөлтийг социалист чиглэлд оруулахыг эрмэлзсэн хэт хатуу байр суурь баримтлагчдын үзэл төрийн бодлогод зонхилж эхэлнээр улс төрийн практик Үндсэн хуулийн үзэл баримтлалаас хазайсан билээ.

Хэдий тийм боловч, 1924 оны Үндсэн хуулийн ач холбогдол нь түүний сөрөг талыг хол илүү давах бөгөөд энэ баримт бичиг Монголын түүхэнд арилшгүй тод ул мөрөө тамгалан үлдээсэн гэхэд хэтрүүлэг болохгүй.

Колонийн дөнгөөс салаад удаагүй, хүн амын дийлэнх нь бичиг үсэггүй, сүсэг бишрэлд гүн автсан, Үндсэн хуулыг ёсны ямар ч уламжлалгүй Азийн үлэмж хоцрогдсон Монгол

<sup>34</sup> М.Санждорж. *Ардын төрийн түүх*. УБ., “ШУА-ийн хэвлэл”, 1974 он, 158 дахь тал.

<sup>35</sup> Ж.Бямбадорж. *Монгол Улсын сонгуулийн тогтолцоо: Онол, арга зүй, цаашдын төлөв*. “Адмон принт” УБ., 2023 он, 13-14 дэх тал.

<sup>36</sup> Б.Чинид. Уншаад төрсөн бодол, хадгалж явдаг сэтгэл [редакторын тодотгол] Амарсанаа Ж., Батсайхан О. *БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн тайлбар*, 2004 он, хууд. XXIII.



орон туурга тусгаар төр улсаа дээд хуулиараа дэлхий дахинд зарлан тунхаглаж, Монголын төрийн түүхнээ анх удаа хаант ёсыг халж, бүгд найрамдах улсын байгуулалд шилжсэнийг бататгаж, ардаар овоглосон улс төрийн шинэ тогтолцоог хуульчлан баталгаажуулж, төр, захиргааны шинэ тогтолцоо, орчин үеийн эрх зүйн үндэс суурийг тавьсан, мөн эдийн засгийн үндсийг бэхжүүлэх, нийгэм, улс төр, эдийн засгийн бүхий л салбарт хөгжил дэвшил гарахад зохих эх үүсвэрийг бүрдүүлсэн нь анхдугаар Үндсэн хуулийн үлэмж гавьяа мөн.

Энэхүү Үндсэн хуулийн ачаар урьд нь ямар ч эрх чөлөөгүй байсан Монголын ард иргэд эх орондоо тэгш эрхтэй байх, хүний дайтай амьдрах, эрх чөлөөтэй байхын амтыг анхлан мэдэрсэн юм. Түүнчлэн эрх, эрх чөлөөгөө эдлэх зарим баталгааг тэдэнд уг хуулиар тогтоох анхны оролдлого хийжээ.

## ЭХ СУРВАЛЖ

1. Амарсанаа Ж., Батсайхан О. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг. 2004 он.
2. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг. Эмхэтгэсэн Ж.Амарсанаа, О.Батсайхан. 2004 он.
3. Ардын Засгийн Газраас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. 1954 он.
4. Б.Батбаяр (Баабар). XX зууны Монгол. Нүүдэл, суудал. Олз гарз. 1996 он.
5. Б.Чимид. Уншаад төрсөн бодол, хадгалж явдаг сэтгэл. редакторын тодотгол. Амарсанаа Ж., Батсайхан О. БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн тайлбар, 2004 он.
6. БНМАУ-ын төрийн эрх зүй хамтын бүтээл, 1988 он.
7. БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхэтгэл. 1972 он.
8. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Анхдугаар Их Хурал. 1984 он.
9. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль: улс төр-эрх зүйн тайлбар. Улсын хэвлэлийн газар. 1988 он.
10. Ж.Амарсанаа, О.Батсайхан. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг. 2004 он.
11. Ж.Бямбадорж. Монгол Улсын сонгуулийн тогтолцоо: Онол, арга зүй, цаашдын төлөв. 2023 он.
12. Жалан-Аажав С. Ардын төрийн хууль тогтоох үйл ажиллагаа (1921-1940). 1967 он.
13. М.Санждорж. Ардын төрийн түүх. 1974 он.
14. Монгол Ардын бүгд найрамдах засаг тогтоон явуулсан нь. 1970 он.
15. Монгол Улсын түүх (хамтын бүтээл). 2017 он.
16. Орон нутагт ардчилсан засаг захиргааны байгууллагуудыг байгуулсан нь. Улсын хэвлэлийн газар, 1958 он.
17. Орос, Хятадын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхэтгэл. УБ., 2001 он.
18. Ц.Батбаяр, Д.Лүндээнжанцан. Хэмжээт цаазатаас бүгд найрамдах засагт шилжсэн нь: анхдугаар Үндсэн хууль. 2023 он.
19. Э.Авирмэд, Д.Лувсаншарав, Р.Махвал, Г.Иш. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төр, эрх зүйн үндэс, 1966 он.
20. В.Е.Чиркин. Конституционное право зарубежных стран. Москва, “Юрист”, 2005 он.

## THE IMPORTANCE OF THE FIRST CONSTITUTION OF MONGOLIA

*Enkhbaatar.Ch*

*Sc.D. National Academy of Governance*

### **ABSTRACT:**

2024 marks the 100th anniversary of adopting the first constitution of the Mongolian People's Republic. At the beginning of this article, it is intended to outline the process by which the draft constitution was drafted and adopted, thereby determining its significance. Preparations for the drafting of the Constitution began quite a long time ago, but it was a rather quaint and not easy task, which is reflected in its development. The first commission worked from 1922 but without success. But the death of Bogd Gegeen in 1924, on 20th May, made it possible to achieve the policy and goals of abolishing the theocratic monarchist regime and establishing a republic. The commission, headed by the Diligent minister Tserendorj, prepared a draft constitution in a short time and submitted it to the first State Great Khural (Congress), which approved it on November 26, 1924. The Constitution of 1924 was conceptually a socialist-style Constitution. However, there are several grounds for determining the significance of the Constitution. The great merit of this Constitution is that the first constitution declared the independent state of Mongolia to the world, abolished the monarchy for the first time in the history of the Mongolian state, and legalized the establishment of the Republic and the new political system. Due to this Constitution, Mongolian nationals were able, for the first time, to experience equality, freedom, and human rights in their homeland.

### **KEYWORDS:**

Constitution, independence, political powers, Staff Consultation Session, monarchy, republic

## ПРОКУРОРЫН ЭСЭРГҮҮЦЛИЙН ХУУЛЬ ЗҮЙН АГУУЛГА, МӨН ЧАНАР, ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ОНЦЛОГ



**Т.Батсүх**

*Ахмад прокурор, хууль зүйн магистр*

### ТОВЧЛОЛ:

Прокурор нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцохдоо шүүхийн хүчинтэй<sup>1</sup> шийдвэр хуульд нийцээгүй, хэргийн оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн бол дээд шатны шүүхэд прокурорын эсэргүүцэл бичиж хуульд нийцүүлэх буюу зөвтгүүлэх онцлог эрх хэмжээг эдэлдэг. Прокурорын эсэргүүцэл хэмээх эрх зүйн баримт бичгийн онолын үндэслэл, хууль зүйн агуулга, практик ач холбогдлын талаарх ойлголтыг прокурорын хяналтын эрх зүйн онолын түвшинд илүү тодорхой болгож эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулах, эсэргүүцлийн талаарх эрүүгийн процессийн хуульд дахь зарим зохицуулалатыг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхэд энэ өгүүллийн зорилго оршино.

Прокурорын эсэргүүцлийн эрх зүйн онолын судалгаа тун хомс<sup>2</sup>, магистр, докторын бүтээл байхгүй, нэг сэдэвт ном товхимол бичээгүй нь энэхүү сэдвийг сонгон судалхад түлхэц өгсөн юм. Прокурор нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогчийн хувьд хуульд нийцээгүй шүүхийн шийдвэрийг хүчин төгөлдөр болохоос өмнө хуульд нийцүүлэх талаар дээд шатны шүүхэд бичгээр эсэргүүцэл гаргаж зөвтгүүлдэг. Прокурорын энэхүү эрх хэмжээг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар олгож зохицуулдаг. Энэ агуулгаараа эсэргүүцэл нь анхан шатны шүүхийн шийтгэх, цагаатгах тогтоолыг хуулийн хүчин төгөлдөр болох эсэхэд шууд нөлөөлдөг. Харин яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах шатанд шүүгчийн захирамжид прокурор эсэргүүцэл бичиж байгаа нь эсэргүүцлийн үндсэн агуулгад хэр нийцэж байгаа нь эргэлзээтэй, практикт эрүүгийн процесс ажиллагааны шуурхай байдалд сөргөөр нөлөөлж хүндрэл учруулж байна. Өөрөөр хэлбэл прокурор шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс гаргасан шүүгчийн шийдвэрт эсэргүүцэл бичих үү, эсхүл шүүх хуралдаанаас гарсан шүүхийн шийдвэрт бичих үү гэдэг нь процессийн эрх зүйн онолын хүрээнд маргаан дагуулахаар асуудал юм. Түүнчлэн прокурорын хяналтын танилцах, хянах ажиллагааны ялгаа, онцлогыг эсэргүүцэл бичих асуудалтай уялдуулан гаргахыг зорилоо. Өгүүллийг бичихдээ эх сурвалжаас түүхэн мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх, бусад улс орны хуулиас харьцуулах, анализ дүгнэлт хийх зэрэг аргыг өргөн ашигласан болно.

<sup>1</sup> Шүүхийн шийдвэр буюу шүүгчийн захирамж, шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоол нь уншиж сонсгомогц хүчинтэй байна.

<sup>2</sup> Монгол Улсын Хууль зүйн сэдэвт ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалтад байхгүй, Б. Цэрэнбалтвар нарын Прокурорын хяналт 2009 номд товч дурдагдсан байна.

**ТҮЛХҮҮР ҮГС:**

Шүүх эрх мэдэл, шүүхийн шийтгэх тогтоол, шүүгчийн захирамж, прокурорын хяналт, прокурорын эсэргүүцэл, эсэргүүцлийн төрөл, хэлбэр.

**I. ОРШИЛ**

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1930 оны 8 сарын 24-ний өдрийн 25 дугаар хурлын тогтоолоор баталсан “Улсын прокуроруудын дүрэм”-ийн Найм дахь хэсгийн 8 дахь заалтад “Доод шүүх таслах газруудаас гаргасан аливаа хэргийн тогтоолд хууль дүрэмд үл нийлэлцэх зүйл байх ахул үл зөвшөөрөн дээд эрх барих шүүх таслах газраа мэдүүлэх<sup>3</sup>,...” гэж шүүхийн шийдвэрт прокурор эсэргүүцэл бичих эрх хэмжээг хууль тогтоох байгууллага анх удаа журамлан тогтоосон байна. Энэ нь прокурорын эсэргүүцлийн эрх зүйн эх үндсийг тавьсан ач холбогдолтой эх сурвалж болсон төдийгүй хөгжлийн тодорхой үе шатыг дамжин өнөөг хүртэл улам боловсронгуй болж хэрэгжсээр ирсэн юм. Анхны энэ заалтаар анхан болон давж заалдах шатны<sup>4</sup> /нэгдүгээр ангийн ба хоёрдугаар ангийн шүүх таслах газар гэж нэрлэж байв/ шүүхүүдийн шийдвэр хуульд нийцээгүй бол эсэргүүцэл бичихээр ерөнхий агуулгатай заасан бол “Аймгуудын прокуроруудыг байгуулсан уг зорилго ба тэдгээрийн эрх үүрэг хийгээд уул үүргэнд багталцах хэрэг ажлыг хэрхэн гүйцэтгэх тухай заавар дүрэм”-ийн Тавдугаар бүлгийн Хорин долоо дахь хэсгийн 7-д “Аливаа хэргийг шийтгэн тасалсан тогтоолуудад хууль дүрмийг буруугаар хэрэглэсэн буюу хэргийн байдал чанарт үл нийцсэн ба жич ангийн шугамыг<sup>5</sup> шууд зөрчсөн зэрэг үл зохилдох зүйлүүд байвал даруй дээд ангийн шүүх таслах газар заалдан мэдүүлэх<sup>6</sup>.” хэмээн прокурор шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд эдлэх нэг эрх хэмжээ байхаар тусгасан нь илүү тодорхой болсон. Өөрөөр хэлбэл шүүхийн шийтгэх тогтоол гаргахдаа хууль буруу хэрэглэсэн, хэргийн бодит байдалд нийцээгүй, эсхүл хүний эрхийг зөрчсөн, шударга ёсонд харшилсан бол прокурор эсэргүүцэл бичих өнөөгийн хууль зүйн агуулга, хэрэглээ, шаардлагыг бүрэн илэрхийлсэн байна.

Прокурор эсэргүүцлийг зөвхөн шүүхийн шийдвэрт төдийгүй байгууллага, албан тушаалтны хууль зөрчсөн шийдвэрт мөн адил бичиж зөвтгүүлэх эрх хэмжээг дээрх дүрмээр<sup>7</sup> анхлан зохицуулсан бөгөөд энэ нь прокурорын байгууллагын үйл ажиллагааны үндсийг тодорхойлсон удаа дараагийн дүрэм<sup>8</sup>, хуулиуд<sup>9</sup> болон эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад<sup>10</sup> уламжлагдан зохицуулагдаж ирсэн байдаг.

<sup>3</sup> Монгол Улсын Прокурорын байгууллагын хууль тогтоомжийн түүхэн эх сурвалж эмхтгэл УБ. 2020 он. 29 дэх тал

<sup>4</sup> “Доод шатны шүүн таслах газруудаас...” гэнээс үзэхэд хэдийгээр анхан болон давж заалдах шатны шүүх гэж тодорхойлоогүй ч хоёр шатны шүүхийн шийдвэрт эсэргүүцэл гаргах эрх хэмжээ гэж ойлгох боломжтой байна.

<sup>5</sup> Социалист нийгмийн ангич чанар буюу ажилчин, малчин зэрэг жирийн харц ард /иргэдийн/-ын эрх ашигт нийцээгүй бол гэсэн санаагаар тусгажээ.

<sup>6</sup> Монгол Улсын Прокурорын байгууллагын хууль тогтоомжийн түүхэн эх сурвалж эмхтгэл УБ. 2020 он. 38 дахь тал

<sup>7</sup> Мөн дүрмийн гуравдугаар бүлгийн долоо дахь хэсгийн 4-д “Аливаа орон нутгийн эрх барих газруудаас шийтгэн гаргасан тогтоол буюу тушаал хууль дүрэмд үл нийцсэн зүйл байваас үл зөвшөөрөн зохих газарт мэдэгдэх...” гэжээ.

<sup>8</sup> БНМАУ-ын Шүүх таслах газар, прокурор нар хийгээд байцаагч нарын газруудын дүрмийн Дөчин наймдугаар зүйлд “Аймгийн захиргааны тогтоолуудыг харьяат аймгийн прокуророос үл зөвшөөрөн протест гаргах...” гэж, Монгол Ард улсын хувьсгалт цэргийн прокуроруудын дүрмийн Ес дэх заалтад “Монгол ардын хувьсгалт цэргийн албан тушаалтны байлдааны тушаалаас бусад хуулийг зөрчсөн тогтоол, тушаалуудад эсэргүүцэл, протестийг гаргах” гэж, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс 1941 онд баталсан БНМАУ-ын Прокурорын дүрмийн Арвандөрөвдүгээр зүйлд “... албан газар ба олон нийтийн байгууллагаас Засгийн дээд эрхийг барих газруудаас гаргасан тогтоол тушаал ба хууль дүрмүүдийг зөрчсөн тогтоол тушаалуудыг гаргах бол эсэргүүцлийг бичих” гэжээ. 1957 онд баталсан БНМАУ-ын Прокурорын хяналтын дүрмийн 13 дугаар зүйлд “... прокурорууд нь хуульд нийцээгүй тушаал, заавар, шийдвэр, захирамж, тогтоолын зэрэг актуудын талаар түүнийг гаргасан газарт нь буюу эсхүл түүний дээд байгууллагад эсэргүүцэл бичнэ.” гэж заасан.

<sup>9</sup> 1976 онд баталсан Прокурорын хяналтын хуулийн 19 дүгээр зүйлд “... прокурор хууль тогтоомж зөрчиж гаргасан эрхийн актыг өөрчлүүлэх буюу хүчингүй болгуулахаар эсэргүүцэл бичиж, түүнийг уг эрхийн акт гаргасан байгууллага буюу шаардлагатай гэж үзвэл дээд шатны байгууллагад явуулна” гэж илүү тодорхой байдлаар заасан.

<sup>10</sup> Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 1994 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр мөн хуулийн 209 дүгээр зүйлийн 18 дахь заалт, 2022 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 193 дугаар зүйлийн 193.1.24 дэх заалт. Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009 он/ УБ. 2012 он. 342, 430 дахь тал.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан прокурорын байгууллагын чиг үүргийн шинэ үзэл баримтлалын дагуу боловсруулан 1993 онд баталсан Прокурорын байгууллагын тухай хуулиар өмнөх социалист нийгмийн үеийн бүх байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагааг хуульд нийцсэн эсэхэд тавьдаг “срөнхий хяналт” гэх чиг үүрэг байхгүй болсонтой холбоотой зөвхөн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын захиргаанаас хэрэг бүртгэх, мөрдөн байцаах талаар гаргасан, ял эдлүүлэх байгууллагаас ял эдлүүлэх талаар гаргасан тушаал шийдвэр тус тус хуульд нийцэж байгаа эсэхийг хянаж, хууль бус тушаал, шийдвэрт эсэргүүцэл бичих эрхийг тусгасан<sup>11</sup> байна.

2002 онд баталсан Прокурорын байгууллагын тухай хууль, 2017 онд баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар прокурор шүүхийн шийдвэрт эсэргүүцэл бичих эрх хэмжээг хуульчилсан ба бусад байгууллагын албан тушаалтны шийдвэрт эсэргүүцэл бичих талаарх өмнөх хуулиудын зохицуулалтыг халжээ.

## II. ПРОКУРОРЫН ЭСЭРГҮҮЦЛИЙН ХУУЛЬ ЗҮЙН АГУУЛГА, АЧ ХОБОГДОЛ

Прокурор нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцдог албан тушаалтны хувьд шүүхийн шийдвэр/шүүгчийн захирамж, тогтоол, магадлал/ хуульд нийцээгүй, оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн үндэслэлээр үл зөвшөөрч дээд шатны шүүхэд хандаж бичгээр мэдэгдэх буюу эсэргүүцэл гаргадаг. Эсэргүүцэл<sup>12</sup> гэх үг Монгол хэлний тайлбар тольд “аливаа зүйлийг үл зөвшөөрснөө илэрхийлсэн мэдэгдэл” хэмээн тодорхойлжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.1 дүгээр зүйлд улсын яллагч, дээд шатны прокурор шүүхийн шийдвэрт эсэргүүцэл бичих эрхтэй гэж заасан нь прокурор шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогчийн хувьд эдэлдэг нэг төрлийн эрх хэмжээг тодорхойлсон чухал зохицуулалт юм. Прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцож яллах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шүүгдэгчид ял оногдуулахад баримтлах Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалт, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, хорих байгууллагын нөхцөл, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, тэнсэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх, хохирол, иргэний нэхэмжлэлийг хэрхэн шийдэх талаархи дүгнэлтээ шүүхэд гаргадаг<sup>13</sup>. Өөрөөр хэлбэл прокурор улсын яллагчийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд эдлэх эрх хэмжээ нь ДҮГНЭЛТ гаргах хэлбэрээр илэрдэг.

Харин эсэргүүцэл нь тухайн шүүх хуралдаанд оролцсон улсын яллагч-прокурор, эсхүл дээд шатны прокурор шүүхийн шийдвэрийг /шүүгчийн захирамж, шийтгэх болон цагаатгах тогтоол, магадлал, тогтоол/ хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хянаж үзээд эс зөвшөөрч байгаагаа илэрхийлдэг эрх хэмжээ юм.

Эндээс үзэхэд эсэргүүцэл нь улсын яллагчийн яллах чиг үүргээ хэрэгжүүлэхэд эдэлдэг эрх хэмжээ гэж зарим судлаачид явцуу хүрээнд тодорхойлж байгаа<sup>14</sup> нь ташаа бөгөөд прокурор шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогчийн хувьд эдэлдэг хяналтын бүрэн эрхийн нэг бие даасан төрөл мөн. Шүүхийн шийдвэрийг прокурор гардан хүлээн авч танилцаж хуульд нийцсэн эсэхийг хянасны үндсэн дээр үл зөвшөөрч байгаагаа дээд шатны шүүхэд мэдэгдэж буй эрх зүйн баримт бичгийг эсэргүүцэл гэнэ гэсэн тодорхойлолт өгч болохоор байна. Энд прокурор нь шүүхийн шийдвэрийг хянах эрх хэмжээг эдэлж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцож байгааг анхаарахгүй өнгөрч<sup>15</sup> болохгүй юм.

<sup>11</sup> Монгол Улсын Прокурорын байгууллагын хууль тогтоомжийн түүхэн эх сурвалж эмхтгэл УБ. 2020 он. 142-143 дахь тал

<sup>12</sup> Орос хэлээр “протест” гэх бөгөөд возражение, неодобрение гэх үгтэй ойролцоо утгатай. Энэ нь үл зөвшөөрөх, татгалзах, эсэргүүцэх, хориг, тээг, дэмжихгүй байх гэсэн санааг илэрхийлдэг байна.

<sup>13</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.7 дугаар зүйл. <https://Legalinfo.mn/mn/detail/12694>. /сүүлд үзсэн 2023-05-25/

<sup>14</sup> Б. Цэрэнбалтаг, Б. Амарбаясгалан. Прокурорын хяналт. УБ. 2009 он. 149 дэх тал

<sup>15</sup> Прокурорын хяналтын чиглэлээр бичсэн ном, гарын авлага, судалгааны өгүүлэлд “прокурор шүүхийн шийдвэрийг хянах” гэсэн ухагдуун, нэр томъёог огт хэрэглэдэггүй ба практик хэрэглээнд ч ийм ойлголтгүй байдаг нь шүүхийн шийдвэрийг зөвхөн дээд шатны шүүх хянах тухай эрх зүйн онолтой холбоотой.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.2 дугаар зүйл, 40.1 дүгээр зүйлд прокурор анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг гардаж авснаас хойш эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор эсэргүүцэл гаргахаар заасан нь тухайн шийдвэрүүдийг хянах хугацааг тодорхойлсон гэж үзнэ. Прокурор нь шүүхийн шийдвэрийг хянах эрх хэмжээ нь прокурорын үйл ажиллагаа эрх хэмжээг тогтоосон үе үеийн дүрэм, хуулиудаар зохицуулагдаж ирсэн түүхэн уламжлалтай байдаг. Тухайлбал, 1930 онд баталсан “Аймгуудын прокуроруудыг байгуулсан уг зорилго ба тэдгээрийн эрх үүрэг хийгээд уул үүргэнд багталцах хэрэг ажлыг хэрхэн гүйцэтгэх тухай заавар дүрэм”-ийн Хорин зургаа дахь зүйлийн 2-т “Шүүн таслах газруудаас гаргасан эрүүгийн ба иргэний хэргийн тогтоолууд нь зүйтэй болсон эсэхийг хянах”, 1931 онд баталсан “БНМАУ-ын Шүүх таслах газар, прокурор нар хийгээд байцаагч нарын газруудын дүрэм”-ийн Дөчин тавдугаар зүйлд “Бүх улсын доторх ардын шүүх таслах газруудад шийтгэн тасалсан аливаа зарим хэргүүдийг хянах байцаах эрхийг баримтлан ирүүлэн хянан үзнэ.”, 1957 онд баталсан БНМАУ-ын Прокурорын хяналтын дүрмийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүхийн байгууллагын тогтоол, магадлал, шийдвэр нь хуульд нийцсэн, үндэстэй болж байгаа эсэхэд хяналт тавих” гэж, 1976 онд баталсан Прокурорын хяналтын тухай хуулийн /анхны хууль/ 34 дүгээр зүйлд “... зохих шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүгчийн тогтоолын хууль ёсны болон үндэслэлтэй эсэхэд хяналт тавина” гэж<sup>16</sup> тус тус прокурор шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлтэй эсэхийг хянах эрх зүйн үндсийг тодорхойлж байжээ.

ОХУ-ын прокурорын байгууллагад ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа зарим прокурор эрдэмтэн, судлаачдын хамтын бүтээлд<sup>17</sup>: “прокурор нь эрүү, иргэний болон бусад хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хоёр үндсэн чиг үүрэгтэй оролцдог. Нэгдүгээрт: эрүү, иргэн, арбитрын шүүн таслах ажиллагаанд тэгш эрхтэй талууд болж шууд оролцоно. Хоёрдугаарт: Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, шийтгэх тогтоолын хууль зүйн үндэслэлд хяналт тавих чиг үүрэгтэй ба шүүхийн тухайн шийдвэр нь хууль зөрчсөн /хуульд нийцээгүй/ гэж үзвэл эсэргүүцэл бичих эрхийг хэрэгжүүлэх байдлаар илэрнэ. Энэ нь хүний эрх, эрх чөлөөг хангах, хуулиар хамгаалагдсан төр, нийтийн эрх ашиг сонирхлыг хамгаалах, хууль дээд хүчинтэй байх, хуулийг дээдлэх зарчмыг хэрэгжүүлэх зэрэг нэн чухал зорилгыг хангана” гэжээ. Энэхүү дүгнэлт нь манай улсын шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын оролцож буй эрх хэмжээ, чиг үүрэгтэй ижил, агуулга ач холбогдлын хувьд адил байна.

Шүүхэд эрүүгийн хэргийг анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор төрийн өмнөөс улсын яллагчаар буюу яллах чиг үүргийг хэрэгжүүлэн мэтгэлцэгч нэг тал болж тэгш эрхтэй оролцдог. Харин прокурор нь шүүхийн шийдвэрийг хүлээн авч тодорхой хугацааны дотор хянаж тухайн хэргийн хувьд эрүүгийн /иргэн, захиргааны хэрэгт гомдол/ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шийдвэр нь хуульд нийцээгүй гэж үзсэн тохиолдолд эсэргүүцэл бичих эрх хэмжээг хэрэгжүүлэх асуудал хөндөгддөг. Эсэргүүцэл бичих нь шүүх шийдвэрээ гаргасны дараа буюу тухайн шийдвэрийн хууль зүйн үндэслэлтэй эсэхийг хянах явцад үүсдэг процесс ажиллагаа учраас зөвхөн улсын яллагчийн яллах чиг үүргээ хэрэгжүүлэхэд эдэлдэг эрх хэмжээ гэж үзэх нь өрөөсгөл бөгөөд харин прокурор шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогчийн хувьд эдэлж буй нэг өвөрмөц эрх хэмжээ гэж өргөн хүрээнд үзвэл зүйд нийцнэ. Учир нь шүүхийн шийдвэрийг хуульд нийцээгүй гэж үзвэл улсын яллагчаас гадна дээд шатны прокурор /шүүх хуралдаанд оролцоогүй боловч/ эсэргүүцэл бичих эрх хэмжээтэй байдаг. Тухайлбал, зөвхөн хэргийг хэрэгсэхгүй болгож шүүгдэгчийг цагаатгасан, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, хэргийн зүйлчлэлийг өөрчилсөн тохиолдолд л бичих төдийгүй Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, хууль зүйн

<sup>16</sup> Монгол Улсын Прокурорын байгууллагын хууль тогтоомжийн түүхэн эх сурвалж. УБ.2020 он. 39, 60, 101, 125 дахь тал

<sup>17</sup> Прокурорский надзор. Учебник. Под общей редакцией профессора Ю. Е. Винокурова. Москва. 2001г. 254 дэх тал



үндэслэлтэй дүгнэлт хийсэн эсэх, эрүүгийн процессийн хуулийг ноцтой зөрчсөн эсэхийг хянаж, хэрэв алдаатай гэж үзвэл зөвтгүүлэх зорилгоор дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй байна. Энэ нь шүүхийн шийтгэх, цагаатгах тогтоолыг /магадлал/ хянасны үндсэн дээр хэрэгждэг прокурорын эрх хэмжээ бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг онцлог хэлбэр мөн.

Эндээс үзвэл эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор нь нэгд: улсын яллагчаар төрийн нэрийн өмнөөс оролцох, хоёрт: шүүхийн шийдвэр хуульд нийцсэн эсэхийг хянах гэсэн хоёр үндсэн эрх хэмжээг эдэлдэг байна.

Прокурорын эсэргүүцлийн зорилт, хууль зүйн ач холбогдол нь Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хууль дээдлэх ёс, шударга ёсны, хэргийн бодит байдлыг тогтоох, хүний халдашгүй байх эрхийг хангах, гэм буруугүйд тооцох, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зэрэг эрүүгийн эрх зүйн тулгуур зарчмуудын хэрэгжилтийг хангуулахад оршино. Прокурор эсэргүүцэл бичиж Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөв нэг мөр хэрэглэх жишгийг улсын хэмжээнд тогтооход чухал үүрэг гүйцэтгэнэ. Тухайлбал, Эрүүгийн хуулийг хэрэглэж эхэлсэн 2017 оноос 2018 оны хооронд мөн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн болон 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн зохицуулалтыг шүүгдэгчид хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээнд давхар хэрэглэдэг, зарим шүүх аль нэгийг нь журамладаг байсан хууль хэрэглээний тогтворгүй байдлыг арилгахад прокурорууд эсэргүүцэл бичиж давж заалдах, хяналтын шатаар шийдвэрлүүлэн нэг жишигт хүргэсэн юм. Энэ мэт хууль хэрэглээний нэгдсэн жишиг тогтооход прокурорын эсэргүүцэл чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үүгээр түүний хууль зүйн ач холбогдол, үр нөлөөг бас тодорхойлж болно.

Прокурорын эсэргүүцэл нь прокурорын үйлдэж буй бусад эрх зүйн баримт бичгүүдээс /тогтоол, зөвшөөрөл, мэдэгдэл, шаардлага, даалгавар, дүгнэлт г.м/ хууль зүйн агуулгын хувьд илүү хүчин чадалтай биш бөгөөд прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд үйлдэгдэг эрх зүйн актын нэг төрөл юм. Шүүхийн шийдвэрийг шууд хүчингүй болгох, өөрчлөлт оруулах хүчин чадалтай акт биш учраас бусад актуудаас илүү хүчинтэй<sup>18</sup> гэж үзэх үндэслэлгүй.

### Ш.ПРОКУРОРЫН ЭСЭРГҮҮЦЛИЙН ОНЦЛОГ АНГИЛАЛ

Прокурор нь шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоолын хууль ёсны эсэхэд тавих хяналтын нэг онцлог нь тухайн тогтоол хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө хэрэгждэгт оршино. Энэ нь прокурор шүүхийн тогтоолыг хүлээн авснаас хойш тодорхой хугацааны дотор<sup>19</sup> хянаж хуульд нийцээгүй буюу Эрүүгийн хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, нотлох баримтыг дутуу, буруу үнэлсэн, хэргийн зүйлчлэл өөрчилсөн, үндэслэлгүйгээр эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлсэн, хүндрүүлсэн, чөлөөлсөн буюу шүүхийн тогтоолд заасан үндэслэл нь хэргийн бодит байдалтай нийцээгүй, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчсөн зэрэг үндэслэл тогтоогдвол эсэргүүцэл бичих хэлбэрээр хэрэгждэг хяналтын ажлын нэг өвөрмөц төрөл юм.

Эндээс үзэхэд прокурорын эсэргүүцлийн онцлог нь а/ шүүхийн тогтоол, захирамж хүчин төгөлдөр болохоос өмнө бичигдэх, б/ шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш тодорхой хугацааны дотор /14 хоногийн дотор/ бичигдэх, в/ хууль бус, үндэслэлгүй шүүхийн шийдвэрт заавал бичигдэх<sup>20</sup>, г/ анхан шатны шүүхийн шийдвэрийг түдгэлзүүлэх

<sup>18</sup> Б. Цэрэнбалтав, Б. Амарбаясгалан. Прокурорын хяналт. УБ. 2009 он. 149, Прокурорын ном. Гарын авлага. УБ. 2002 он. 193 дахь тал

<sup>19</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 40.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгүүдэд зохицуулсан.

<sup>20</sup> Эсэргүүцэл бичих нь прокурорын үндсэн эрх төдийгүй хууль зөрчсөн, үндэслэлгүй шүүхийн шийдвэр бүрт бичигдэх ёстой. Энэ нь хүний эрх, болон төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, хууль ёсыг хэрэгжүүлэх эрүүгийн процессийн эрх зүйн зорилт, зарчимтай нягт уялдаатай институт юм.



үндэс болох ба давж заалдах шатны шүүхийн магадлалыг түдгэлзүүлэх үндэс болохгүй байх, д/ давж заалдсан, хяналтын журмаар гаргасан эсэргүүцлээс татгалзах<sup>21</sup> буюу буцаан авах эрхтэй байх явдал юм. Эсэргүүцлийн онцлогыг ингэж тодорхой болгож өгснөөр оюутан, судлаачид, залуу хуульчдад прокурорын хяналтын эрх зүйн мэдлэг мэдээллийг цэгцтэй ойлгомжтой болгох ач холбогдолтой.

Аливаа эрх зүйн зохицуулалтад хамаарах хууль зүйн ойлголтуудыг шинжлэх ухааны үүднээс ангилан төрөлжүүлэх нь тэдгээрийн хууль зүйн үр дагавар, зорилго, мөн чанар, онцлог, бүтэц бүрдүүлбэрийг танин мэдэх онолын болон хууль хэрэглээний практик ач холбогдолтой байдаг. Иймээс прокурорын эсэргүүцлийг ангилал нь түүний мөн чанарыг зөв ойлгож практикт хэрэглэхэд зохих ач холбогдолтой. Энэ үүднээс эсэргүүцлийг дараах шалгуур, шинжээр нь ангилан төрөлжүүлж болно. Үүнд:

Прокурорын эсэргүүцлийг аль шатны шүүхийн шийдвэрт бичигдэж байгаагаар нь: а/ анхан шатны шүүхийн шийдвэрт бичих эсэргүүцэл, б/ давж заалдах шатны шүүхийн шийдвэрт бичих эсэргүүцэл гэж ангилж болох бөгөөд эдгээр нь хоорондоо хууль зүйн үндэслэлээрээ ялгаатай болохыг эрүүгийн процессийн хуулийн зохицуулалтаас<sup>22</sup> харагдана.

Агуулга, мөн чанараар нь: а/ хууль буруу хэрэглэсэн (хууль хэрэглээний алдааг арилгах, Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн) шийдвэрт бичих эсэргүүцэл, б/ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг зөрчсөн шийдвэрт бичих эсэргүүцэл, в/ шүүхийн шийдвэр хэргийн бодит байдалд нийцээгүй гэж үзэж бичих эсэргүүцэл, г/ шүүгчийн шийдвэртэй санал нийлээгүй гэж үзэж бичих эсэргүүцэл хэмээн ангилан тус бүрийн онцлогт тохирсон хууль зүйн үндэслэлийг сонгож бичих ёстой байдаг.

Хууль зүйн үр дагавар, зорилгын онцлогоор нь: а/ шүүхэд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хангуулах явцад гаргасан шүүгчийн шийдвэрт /захирамж/ бичих эсэргүүцэл, б/ хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн шийдвэрт /шийтгэх, цагаатгах тогтоол, магадлал/ бичих эсэргүүцэл гэж ангилж болно. Үүнийг яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах шатанд шүүгчийн гаргасан шийдвэрт бичих эсэргүүцэл, хэргийг анхан болон давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн шийдвэрт бичих эсэргүүцэл хэмээн нэрлэж болох бөгөөд тэдгээрийн онцлог, мөн чанарт нь нийцүүлэн хууль зүйн үндэслэлийг оновчтой тодорхойлж бичнэ.

Шүүхийн шийдвэрийн агуулгын онцлогоор нь: а/ хэргийг прокурорт буцаасан шийдвэрт бичих эсэргүүцэл, б/ цагаатгах тогтоолд бичих эсэргүүцэл, в/ хэргийн зүйлчлэлийг өөрчилсөн шийдвэрт бичих эсэргүүцэл, г/ шийтгэх тогтоолоор зарим шүүгдэгчийг шийтгэсэн, цагаатгасан шийдвэрт бичих эсэргүүцэл гэж ангилж болно.

Эсэргүүцлийг ийнхүү ангилж төрөлжүүлэх нь эрх зүйн боловсрол эзэмшиж буй оюутан, залуу прокурор, судлаач, хуульчдад танин мэдэхүйн болон эсэргүүцлийн агуулга, мөн чанарыг ойлгож практикт хэрэглэхэд ач холбогдолтой юм.

#### IV. ЭСЭРГҮҮЦЭЛ БИЧИХ ХУГАЦАА, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш эсэргүүцэл бичих хугацаа улс орон бүрт харилцан адилгүй байх бөгөөд Кыргызстан улс, Гүрж улсад шүүхийн шийтгэх тогтоолыг гардуулан өгснөөс хойш 30 хоногийн<sup>23</sup> дотор, харин Казахстан, ОХУ-д гардаж авснаас хойш 15 хоногийн<sup>24</sup> дотор давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргадаг байна.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.2 дугаар зүйлд прокурор, дээд шатны прокурор анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш, эсхүл ... хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор давж заалдах эсэргүүцлээ шийдвэр гаргасан

<sup>21</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.5 дугаар зүйл, 40.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг.

<sup>22</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 38.1 дүгээр зүйл., 40.1 дүгээр зүйлийг үзэх.

<sup>23</sup> Кыргызстан Улсын Эрүүгийн процессийн хуулийн 400 дугаар зүйл, Гүрж улсын эрүүгийн процессийн хуулийн 293 дугаар зүйлийг үз.

<sup>24</sup> Казахстан Улсын Эрүүгийн процессийн хуулийн 418, ОХУ-ын Эрүүгийн процессийн хуулийн 389 дугаар зүйл.

анхан шатны шүүхэд бичгээр гаргана гэж заасан. Давж заалдах журмаар гомдол, эсэргүүцэл гаргах хугацааг хуулиар тогтоож өгөх нь шүүхийн хууль зөрчсөн болон үндэслэлгүй шийдвэрийг богино хугацаанд зөвтгүүлж хэргийн оролцогчийн /шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч/ эрхийг сэргээх, хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хууль хэрэглээний зөв нэгдсэн жишиг тогтооход чиглэсэн хууль зүйн өндөр ач холбогдолтой процесс юм. Хүний эрх үүргийг үүсгэх, дуусгавар болгох, сэргээх зэрэг хууль зүйн үр дагаварыг бий болгодог учраас эрх зүйн шинжлэх ухаанд хугацааг өргөн хэрэглэх бөгөөд тухайн харилцааг зохицуулсан хуулиар тогтоож өгдөг. Энэ нь тухайн хуулиар зохицуулж буй нийгмийн харилцааны мөн чанар, онцлогтой нягт уялдаатай бөгөөд хуулийн зорилтыг хангахад чиглэсэн байдаг.

Давж заалдах болон хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргах хугацааг ийнхүү хуулиар тогтоосон нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, зорилттой холбоотой буюу хүний эрхийг богино хугацаанд шуурхай сэргээн тогтооход чиглэсэн байна. Хугацаа тогтоосноор хууль зөрчсөн шүүхийн шийтгэх, цагаатгах тогтоол, захирамж хүчин төгөлдөр болж хүний эрх, ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх нэн тэргүүн ач холбогдолтой бөгөөд хугацаа тогтоосны хууль зүйн үр дагавар үүгээр тодорхойлогдоно. Тийм учраас анхан шатны шүүхийн шийдвэрт гомдол, эсэргүүцэл гаргасан бол шүүхийн шийдвэрийн биелэлт түдгэлзэнэ гэж хуулиар зохицуулсан.<sup>25</sup>

## V. ЭСЭРГҮҮЦЭЛ БИЧИХ ХЭМЖЭЭ ХЯЗГААР

Шүүхийн шийдвэрт бүхэлд нь болон хэсэгчлэн, эсхүл аль заалтыг зөвшөөрөхгүй байгаа талаар эсэргүүцэл бичдэг. Мөн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулахаар эсхүл өөрчлөлт оруулахаар бичиж байна. Эдгээр нь хоорондоо эрх зүйн ямар үр дагаварыг бий болгохоос хамаарч ялгаатай байдаг. Манай улсын эрүүгийн процессийн хуульд энэ талаар тодорхой заалт байхгүй боловч прокурор, шүүхийн жишигт /практикт/ нэгэнтээ хэрэгжүүлж ирсэн байна.

Хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгасан шүүхийн тогтоол, эсхүл процессийн ноцтой зөрчил гаргасан, хэргийн зүйлчлэлийг болон оногдуулах ялыг хэт хөнгөрүүлсэн буюу хэргийн бодит байдалтай нийцээгүй бол, эсхүл хэргийг мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаасан шүүгчийн захирамжид бүхэлд нь эсэргүүцэл бичих нь түгээмэл байна. Харин хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зүйл заалтыг журамлаагүй орхигдуулсан зэрэг үндэслэлээр шүүхийн шийдвэрт хэсэгчилэн, эсхүл шийтгэх, цагаатгах тогтоолын аль нэг заалтыг зөвшөөрөөгүй бол түүнд өөрчлөлт оруулахаар эсэргүүцэл бичнэ. Тухайлбал, 2023 оны жилийн эцсийн мэдээгээр улсын хэмжээнд прокурор хэргийг мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаасан шүүгчийн захирамжид давж заалдах шатны шүүхэд нийт 271 эсэргүүцэл бичсэн, цагаатгах тогтоолд 78 эсэргүүцэл, хэргийн зүйлчлэл өөрчлөгдсөн хэрэгт 28, шийтгэх тогтоолоор цагаатгасан хэрэгт 31, хууль буруу хэрэглэсэн, процессийн хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр 165 эсэргүүцэл бичсэн. 2024 оны эхний хагас жилийн байдлаар прокурор хэргийг мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаасан шүүгчийн захирамжид давж заалдах шатны шүүхэд нийт 209 эсэргүүцэл бичсэн, цагаатгах тогтоолд 58 эсэргүүцэл, хэргийн зүйлчлэл өөрчлөгдсөн хэрэгт 20, шийтгэх тогтоолоор цагаатгасан хэрэгт 19, хууль буруу хэрэглэсэн, процессийн хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр 143 эсэргүүцэл бичсэн байна<sup>26</sup>.

<sup>25</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт таслан сэргийлэх арга хэмжээний талаар тодруулан тусгаагүйгээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шийтгэх тогтоолын заалт нэгэн адил түдгэлзэхээр ойлгогддог. Казахстан Улсын Эрүүгийн процессийн хуулийн 421 дүгээр зүйлд "... шүүхийн шийтгэх тогтоолын таслан сэргийлэх арга хэмжээ авснаас бусад заалтын биелэлтийг түдгэлзүүлнэ" гэж заасан нь оновчтой юм.

<sup>26</sup> Улсын Ерөнхий прокурорын газрын 2023 оны бүтэн жилийн, 2024 оны эхний хагас жилийн мэдээ.

## VI. ДҮГНЭЛТ, САНАЛ

Үндсэн хуульд заасан шударга шүүхээр шийдвэрлүүлэх иргэний эрхийг хамгаалж, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох хууль дээдлэх, шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэхэд прокурорын эсэргүүцэл бичих эрх нягт уялдаатай нь дээрхээс тодорхой харагдана. Хуулийг нэг мөр хэрэглэх, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь прокурорын үйл ажиллагааны зарчим бөгөөд шүүхийн хууль зөрчсөн шийдвэрийг хуульд нийцүүлэхээр эсэргүүцэл гаргаж эдгээр зарчмын хэрэгжилтийг хангуулдаг болох нь энэ судалгааны үр дүнд тодорхой болж байна.

Дээр дурдсанаас нэгтгэн дүгнэвэл эсэргүүцэл нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг өвөрмөц хэлбэр, шүүхийн шийдвэрийг /захирамж, шийтгэх, цагаатгах тогтоол, магадлал/ хянасны үндсэн дээр хэрэгждэг прокурорын эрх хэмжээ, прокурорын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд үйлдэгддэг эрх зүйн актын нэг төрөл гэсэн прокурорын хяналтын эрх зүйн шинжлэх ухааны ойлголтуудыг бий болгож байна. Мөн эсэргүүцэл нь анхан шатны шүүхийн шийтгэх, цагаатгах тогтоолыг хуулийн хүчин төгөлдөр болох эсэхэд шууд нөлөөлдөг өвөрмөц онцлогтой<sup>27</sup> байна.

Судалгааны үр дүнд прокурорын эсэргүүцлийн эрх зүйн онолын тодорхойлолт өгч, төрөлжүүлэн ангилж, эсэргүүцэл бичих хугацаа, түүний ач холбогдол, хэмжээ хязгаарыг анх удаа шинжлэх ухааны үүднээс тайлбарлах зорилгодоо хүрсэн гэж үзэж байна.

Энэхүү өгүүллийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор эс зөвшөөрвөл ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих... эрхтэй” гэж зааснаар яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах шатанд шүүгчийн гаргасан “шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрдөн шалгах ажиллагааг хийлгэх”-ээр хэргийг прокурорт буцаасан захирамжид эсэргүүцэл бичих тохиолдол нилээд байдаг. Тухайлбал, 2023 онд улсын хэмжээнд давж заалдах шатны шүүхэд прокурорын бичсэн нийт 573 эсэргүүцлийн 47,2 хувийг дээрх үндэслэлээр бичсэн эсэргүүцэл эзэлсэн байна. Энэ үндэслэлээр бичигдсэн эсэргүүцлийн бараг тэн хагас нь /45,3%/ биелээгүй буюу давж заалдах шатны шүүх хэрэгсэхгүй болгосон байна. Мөн хяналтын шатны шүүхэд гаргасан эсэргүүцлийг хүлээн аваагүй байна. 2024 оны эхний хагас жилд улсын хэмжээнд бичсэн нийт 449 эсэргүүцлийн 209 буюу 46,5%-ийг дээрх үндэслэлээр бичсэн байх ба үүнээс 31,1% нь билээгүй байна. Үүнтэй холбоотойгоор давж заалдах, хяналтын шатны шүүхээр прокурорын эсэргүүцлийг хэлэлцэх хүртэл доод тал нь 2-3 сарын хугацаа өнгөрч хэргийн оролцогчийн эрх зөрчих<sup>28</sup> явдал гарах эрсдэлтэй байна. Жишээ нь: Хархорин сум дундын прокурорын газраас яллагдагч Г-д холбогдох хэрэгт 2024-03-07-ны өдөр яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн, шүүх хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр 2024-03-22-ны өдөр шүүгчийн захирамжаар хэргийг прокурорт буцаасан, хэргийг прокурор 2024-03-25-ны өдөр хүлээн авч дээд шатны прокурор 2024-04-01-ний өдөр давж заалдах эсэргүүцэл гаргасан, давж заалдах шатны шүүх хэргийг 2024-04-12-ны өдөр хэлэлцэж эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгосон, магадлалыг прокурорын газарт 2024-04-22-ны өдөр хүлээн авч 2024-04-24-ний өдөр хяналтын шатанд эсэргүүцэл бичсэн, хяналтын шатны шүүх эсэргүүцлийг хэлэлцэхээс 2024-06-05-нд татгалзсан тухай албан бичиг үйлдсэнийг 2024-06-20-нд прокурорын газарт ирүүлсэн ба хэргийг 2024-07-03-нд прокурор хүлээн авч 2024-07-09-ний өдөр зүйлчлэлийг хүндрүүлэн дахин яллах дүгнэлт үйлджээ. Эндээс үзэхэд анх яллах дүгнэлт үйлдсэн өдрөөс хойш 4 сарын дараа хэргийг

<sup>27</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д “... эсэргүүцэл бичих хугацаа дуусмагц анхан шатны шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “... эсэргүүцэл гаргасан бол шүүхийн шийдвэрийн биелэлт түдгэлзэнэ”, 37.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... эсэргүүцэл гаргаагүй бол уг хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг гүйцэтгэнэ” гэж тус тус заасан нь прокурорын эсэргүүцлийн хууль зүйн үр дагаварын мөн чанарыг илэрхийлдэг.

<sup>28</sup> Яллагдагч хэргээ боломжит богино хугацаанд шийдвэрлүүлэх эрх, хохирогчийн эрхийг шуурхай сэргээх хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтын аль аль нь алдагдахад хүрч чирэгдэл үүсгэдэг.

дахин шүүхэд шилжүүлсэн ба яллагдагч энэ хугацаанд цагдан хоригдож байсан бөгөөд хэргээ боломжит богино хугацаанд шийдвэрлүүлэх эрх нь ноцтой зөрчигдсөөр ирсэн байна.

“Шүүх хуралдаан нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрөн шалгах ажиллагаа хийлгэх бол” гэсэн үндэслэл нь тухайн хэргийн нотлох ажиллагааны талаарх шүүх, прокурорын байр суурь зөрчилдсөнтэй холбоотой гарч ирдэг. Өөрөөр хэлбэл шүүгч хувь бодгаль хүний хувьд болон шүүгчийнхээ хувьд тухайн хэрэгт ямар ажиллагаа нэмж хийлгэх шаардлагатай талаар өөрийн дотоод итгэлээр үнэлж гаргасан шийдвэрт хэргийн нотлох ажиллагааг гардан<sup>29</sup> гүйцэтгэсэн прокурорын нотлох баримтын талаарх үнэлэмжтой зөрчилдсөн тохиолдолд эсэргүүцэл бичдэг бөгөөд ихэнхдээ биелдэггүй. Ингэснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширна. Иймээс нотлох ажиллагаатай холбоотой шүүгчийн гаргасан захирамжид прокурор эсэргүүцэл бичихгүй байх, харин үл зөвшөөрсөн тохиолдолд гомдол гаргадаг хэлбэрээр зохицуулалт хийх нь зохимжтой гэж үзэж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүхийн өмнөх шатанд шүүгчийн гаргасан шийдвэрт прокурор гомдол<sup>30</sup> гаргахаар зохицуулсан байдаг. Тухайлбал, албадан ирүүлэх, гэрч хохирогчийг хамгаалах, хамтран ажиллах этгээдээр тогтоох, зарим төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах, сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээ хийлгэх, эд хөрөнгө битүүмжлэх, хураан авсан, битүүмжилсэн эд хөрөнгийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт прокурор эсэргүүцэл бичихгүй, харин гомдол гаргадаг.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллагдагчийг шүүхэд шилжүүлэх эсэх асуудлыг хэлэлцэж хэрэгт нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийх шаардлагатай гэж үзсэн шүүхийн шийдвэр нь гэм буруугийн болон эрүүгийн хариуцлагын талаар хэлэлцэхгүй тул шүүхийн өмнөх шатны ажиллагааны талаар гаргасан шийдвэр гэж үзнэ. Энэ шатанд гаргасан шүүхийн шийдвэрт дээрх мөрдөн шалгах ажиллагааны явцад гаргасан шийдвэрийн нэгэн адил эсэргүүцэл бичихгүй харин тухайн шатны шүүхэд гомдол гаргаж анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч, эсхүл ерөнхий шүүгчийн гаргасан шийдвэрт гомдол гаргасан бол бусад 3 хүртэл шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр ажлын 3 хоногийн дотор шийдвэрлэдэг байхаар зохицуулах нь хохирогчийн эрхийг шуурхай сэргээх, яллагдагчийн хэргээ богино хугацаанд шийдвэрлүүлэх эрхийг хангахад чухал ач холбогдолтой болно. Нөгөө талаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал хэмнэгдэж, шуурхай байдалд эрс эерэг өөрчлөлт гарна. Үүний дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “эсэргүүцэл бичих” гэснийг хасах нь зүйтэй юм. Энэхүү өөрчлөлтийг оруулснаар мөрдөн шалгах ажиллагааны чанар сайжирч нотлох ажиллагааны доголдолтой байдлаас шалтгаалан хэргийг удаа дараа прокурорт буцаах, эсхүл тухайн асуудлаар прокурор давж заалдах, хяналтын шатанд дахин дахин эсэргүүцэл гаргаж урт хугацаанд<sup>31</sup> хэргийг шийдвэрлэхгүйд хүрдэг одоогийн сөрөг жишгийг таслан зогсооно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг “Анхан шатны шүүхийн шийтгэх, цагаатгах тогтоолд гомдол, эсэргүүцэл гаргасан бол

<sup>29</sup> Хэрэгт хяналт тавьж буй прокурор нь мөрдөн шалгах ажиллагааг бүхэлд нь удирдан чиглүүлж нотлох баримтын хангалттай, хүрэлцээтэй байдалд тухай бүр үнэлэлт дүгнэлт өгч шаардлагатай бол мөрдөгчид даалгавар буюу заалт бичиж нөхөн гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулдаг.

<sup>30</sup> ОХУ болон хамтын нөхөрлөлийн улсуудын эрүүгийн процессийн хуулиар гомдол буюу “ходатайство” гаргадаг нь манай улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.8 дугаар зүйлд заасан шүүхийн шийдвэрт гомдол гаргах журамтай агаар нэг байдаг. Үүнээс ОХУ-д анхан шатны шүүхээр хэргийг хянан шийдвэрлэж гаргасан шийтгэх, цагаатгах тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалд “протест” буюу эсэргүүцэл бичдэг.

<sup>31</sup> Анхан шатны шүүхийн тогтоолыг прокурор гардан авснаас хойш 14 хоногийн хамгийн сүүлийн өдөрт нь эсэргүүцэл бичсэн тохиолдолд хариу тайлбар гаргах 7 хоногийн хугацаа тоологдох ба уг хугацаа дуусмагц давж заалдах шатны шүүхэд хэргийг хүргүүлдэг. Давж заалдах шатны шүүхэд хэрэг хүрч хүлээн авах хугацаа нийтдээ 25 хоногт багтаах байдаг. Үүний дараа давж заалдах шатны шүүх 30 хоногт, нэмэлт 30 хоног буюу нийтдээ 60 хоногт шийдэх боломжтой. Дээрх 25 хоногтойгоо нийлээд 85 хоног буюу 2 сар 25 хоног өнгөрнө. Давж заалдах шатны шүүх магадлалыг уншиж сонгосноос хойш 15 хоногийн дотор бичгээр үйлдэнэ. Хэргийн оролцогчдоод шуудангаар хүргүүлэхэд дахиад 5 хоногоос доошгүй хугацаа өнгөрнө. Үүнийг дараа прокурор магадлалыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хяналтын шатанд эсэргүүцэл бичвэл нийтдээ 35 хоног өнгөрнө. Ингээд хяналтын шатны шүүхэд хэргийг хүргүүлэх хүртэл хамгийн багадаа 14 /хариу тайлбар гаргах 7 хоног, шуудангаар хүргүүлэхэд 7 хоног/ хоног өнгөрнө. Хяналтын шатны шүүхэд хэрэг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэж хэргийг прокурорт ирүүлэх хүртэл доод тал нь 14 хоног өнгөрч ирдэг. Нийтдээ 178 хоног өнгөрч хэрэг прокурорт ирэх магадлалтай байдаг нь дэндүү нүсэр бөгөөд өндөр зардалтай ажиллагаа юм.

шүүхийн шийдвэрийн таслан сэргийлэх арга хэмжээ авсанаас бусад заалтын биелэлт түдгэлзэнэ.” гэж өөрчлөн найруулж хуулийн хийдлийг арилгах.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол...” гэснийг “...шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл давж заалдах гомдол...” гэж нэмэлт оруулах саналтай байна. Одоогийн зохицуулалтаар шүүхийн шийдвэрийг зөвшөөрсөн ч, эс зөвшөөрсөн ч давж заалдах эрхтэй мэт ойлголтыг оролцогчдод төрүүлэхээр байна.

Мөн хуулийн 38.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг “2. Давж заалдах гомдол, эсэргүүцэлд анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчилэн хүчингүй болгуулах, эсхүл аль заалтад ямар өөрчлөлт оруулах талаар тухайн хэрэгт авагдсан нотлох баримт, анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн хэргийн үйл баримтын хүрээнд хуулийн үндэслэл бүхий, тодорхой дурдсан байна.” гэж шинэчлэн нэмэх. /дараагийн дугааруудыг өөрчлөх/ Энэ нь давж заалдах гомдол, эсэргүүцлийн хэмжээ хязгаарыг тодорхой болгож, оролцогчийн хариуцлагыг өндөржүүлэхэд ач холбогдолтой юм.

Мөн хуулийн 38.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 38.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 38.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор, дээд шатны прокурор” гэснийг “Улсын яллагч, дээд шатны прокурор” гэж өөрчлөх нь мөн хуулийн 38.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалттай нийцнэ.

Мөн хуулийн 39.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “...цагаатгагдсан этгээд давж заалдах гомдол, эсэргүүцэл бичигдсэн эсэхийг харгалзахгүйгээр...” гэсэн нь бичвэр, найруулгын алдаатай байх тул “...цагаатгагдсан этгээд давж заалдах гомдол гаргасан, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичсэн эсэхийг харгалзахгүйгээр...” гэж өөрчлөн найруулах нь ойлгомжтой болно.

Дээрх саналыг хэрэгжүүлж хуульд оруулбал прокурорын эсэргүүцлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим тодорхой бус зөвхөн практикаар авч ирсэн ойлголтууд цэгцтэй, ойлгомжтой, тодорхой болж хуулийн зохицуулалт улам боловсронгуй болно гэдэгт итгэлтэй байна. Нөгөө талаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд гаргасан шүүгчийн шийдвэрт прокурор эсэргүүцэл бичихгүй байх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байх зорилгод нийцэх төдийгүй эрүүгийн процесс ажиллагааны оролцогчдын эрхийг хангахад практикийн олон талын ач холбогдолтой гэж үзэж байна.

**ЭХ СУРВАЛЖ****Хууль:**

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он.
2. БНКаЗУ-ын Эрүүгийн процессийн төрөлжсөн хууль 2014 он
3. ОХУ-ын Эрүүгийн процессийн төрөлжсөн хууль 2001 он
4. Кыргызстан улсын Эрүүгийн процессийн төрөлжсөн хууль 2021 он
5. Гүрж улсын Эрүүгийн процессийн хууль 2011 он

**Ном, сурах бичиг:**

1. Монгол Улсын Прокурорын байгууллагын хууль тогтоомжийн түүхэн эх сурвалж эмхтгэл УБ. 2020 он.
2. Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009 он/ УБ. 2012 он
3. Б. Цэрэнбалтав, Б. Амарбаясгалан. Прокурорын хяналт. УБ. 2009 он
4. Прокурорский надзор. Учебник. Под общей редакцией профессора Ю.Е.Винокурова. Москва. 2001г
5. Прокурорын ном. Гарын авлага. УБ. 2002 он .
6. С. Нарангэрэл. Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. УБ. 2021 он

**THE LEGAL CONTENT OF THE PROSECUTOR'S OBJECTION, NATURE, TYPE, FORM, FEATURE*****Batsukh. T****(LL.M) Senior Prosecutor, Master of Laws***ABSTRACT:**

When participating in the exercise of judicial authority, the prosecutor has the special right to make the court's decision by the law or to justify it by writing a protest to the higher court if the valid decision of the court is not by the law or seriously violates the rights of the participant in the case. This article aims to make understanding the theoretical basis, legal content, and practical importance of the legal document called the prosecutor's objection more clear at the level of the legal theory of the prosecutor's control and bring it into the circulation of academic research.

**KEYWORDS:**

The judiciary, court's sentence, judge's order, prosecutor's control, prosecutor's objection, type and form of objection.



## ШУДАРГА ШҮҮХЭЭР ШҮҮЛГЭХ ЭРХ ЭРҮҮГИЙН ПРОЦЕССИЙН ЭРХ ЗҮЙД ХЭРЭГЖИХ НЬ



*Х.Болормаа*

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант,*



*Д.Даваажаргал*

*Судлаач, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант*

### **ТОВЧЛОЛ:**

Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээнүүдийн холбогдох заалтуудад болон манай улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэний шударгаар шүүлгэх эрхийг тунхагласан бөгөөд уг эрхийн баталгаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлд тусгалаа олсон юм. Шударгаар шүүлгэх тухай ойлголт нь хэргийг шударга бөгөөд нээлттэй шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх баталгааг агуулдаг. Хэргийг шударгаар шийдвэрлэсэн эсэх нь аль нэг оролцогчоос, ямар нэг сэдлээр хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд болон шууд бус нөлөөлөл, дарамт шахалт, оролцоо үгүй байдлаар илэрхийлэгдэнэ. Шударгаар шүүлгэх эрх нь хүний үндсэн эрхийн нэг төрөл бөгөөд уул эрх нь “Шударга ёс”, “Хүний эрх”, “The rule of law” гэх ойлголтуудтай салшгүй холбоотой ойлголт тул хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, тэгш эрх, шударга ёсыг чандлан сахиулах нь уг эрхийг хэрэгжүүлэх суурь үндэс юм.

Шударгаар шүүлгэх эрхийн талаар судалсан эрдэм шинжилгээний ажлуудыг авч үзвэл:

- Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс эрхийн ойлголт талаас нь тайлбарласан Г.Совд, Н.Жамцан, Ж.Амарсанаа, С.Жанцан нарын “Монгол Улсын Үндсэн хууль”-ын тайлбар /2000/, Н.Лүндэндорж “Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар /2022/”,

- Үндсэн эрх болох талаас нь Ц.Сарантуяа “Үндсэн эрх болон хүний эрх: Харьцуулалт, онолын эргэцүүлэл” эрдэм шинжилгээний өгүүлэл, Д.Баярсайхан “Хүний эрхийн онолын сэтгэлгээ, уламжлал, шинэчлэлийн асуудал” эрдэм шинжилгээний өгүүлэл, Х.Сэлэнгэ “Цэвэр эрх зүйн онол” эрдэм шинжилгээний өгүүлэл, В.Оюумаа, М.Уянга нарын “Олон улсын эрх зүй дэх “Хүний эрх” ба “Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй” /Харьцуулсан судалгаа/” эрдэм шинжилгээний өгүүлэл,

- Уг эрхийн ойлголтын талаар болон хэрэгжилтийн талаар Эмнести интернэшнлээс гаргасан “Шударгаар шүүлгэх эрх: Гарын авлага”, Нээлттэй нийгэм форумас явуулсан “Эрүүгийн хууль дахь шударга ёсны зарчмын хэрэгжилт” бодлогын судалгааны тайлан /2020/ болон “Парламент-Судалгааны эмхэтгэл /2021/”, “Чухал сэдэв- Хэлэлцүүлгийн тэмдэглэл /2022/”, Монгол Улсын Их Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгээс гаргасан “Үндсэн хууль манай сургуульд- НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар болон сургалтын хөтөлбөр”,

- Харьцуулсан эрх зүйн хүрээнд Ш.Цогтоо “Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй- Харьцуулсан судалгаа /2018/”, Д.Баярсайхан “Гадаад орнуудын эрүүгийн процесс /2015/”, Ж.Эрхэсхулан “Шүүн шийдвэрлэх ажиллагаан дахь алдаа (Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд)” эрдэм шинжилгээний өгүүлэл,

- Бакалаврын болон магистрын судалгааны ажлын хүрээнд 2017 онд Үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр Б.Бат-Анугийн бичсэн “Шударга шүүхээр шүүлгэх эрхийн хамгаалалт” сэдэвтэй бакалаврын судалгааны ажил зэрэг бүтээлүүд нь тус тус бичигдэж байсан байна.

Эндээс дүгнэвэл, Шударга шүүхээр шүүлгэх эрх”-ийн талаар бичигдсэн эрдэм шинжилгээний ажлууд нь ихэнхдээ Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс авч үзэн тайлбарласан агуулгатай байх бөгөөд “Шударга шүүхээр шүүлгэх” эрхийг эрүүгийн процессийн эрх зүйн үүднээс авч үзэн, уг эрхийн хэрэгжилтийг нарийвчлан судалсан судалгааны бүтээл хараахан гараагүй байна. Иймд уг бүтээлээрээ дамжуулан “Шударга шүүхээр шүүлгэх” эрхийг эрүүгийн процессийн эрх зүйн үүднээс авч үзэн, уг эрхийн хэрэгжилтийг нарийвчлан судлахыг хичээлээ.

### ТҮЛХҮҮР ҮГС:

Эрүүгийн процессийн эрх зүй, Шударга шүүхээр шүүлгэх эрх, Хүний эрх, эрх чөлөө, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

## I. ОРШИЛ

### Шударгаар шүүхээр шүүлгэх эрхийн тухай ойлголт

Хүний эрхийн үзэл санаа “Justice”-шударга ёс, “Equal”-тэгш эрх, “Liberty”-эрх чөлөө гэсэн ойлголтуудтай зэрэгцэн хэрэглэгдэх болсон үеэс улс төрийн үнэт зүйл болсон гэж үздэг<sup>1</sup>. Иймд “Right to a fair trial” буюу “Шударга шүүхээр шүүлгэх эрх” нь хүний үндсэн эрхийн<sup>2</sup> нэг төрөл тул түүний үүсэл түүхийг авч үзэхдээ “Шударга ёс”, “Хүний эрх”, “The rule of law” гэх ойлголтуудын талаар зайлшгүй хөндөх шаардлагатай билээ. Иймд эдгээрийн холбоо хамаарлыг авч үзье...

### A. Шударга ёс ба шударга шүүхээр шүүлгэх эрх

“Шударга байх /Jus/”, “Шударга ёс /Justitia/” гэсэн ойлголтуудын гарал үүсэл нь латин хэлний *Jus*, *Justitia* буюу “үнэн зөв, шударга ёс” гэсэн утгыг илэрхийлж иржээ. Шударга ёсны тухай ойлголтын танин мэдэхүйн үндэслэл нь Грекийн нэрт сэтгэгч Платон, Аристотель нарын үзэл номлолд тусгалаа олсон байдаг. Платон “Шударга байх гэдэг нь хамгийн энгийнээр хэлбэл хэн ч бусдын юмыг авахгүй, мөн өөрийнхөө юмыг алдахгүй байх явдал” гэсэн нь бий. Мөн тэрээр өөрийн “Диалоги” зохиолдоо “Шударга ёс гэдэг нь хүний оюун санаагаа удирдах чадвар, эмх цэгцтэй байлган нэр төр, алдар хүндээ хүндэтгэх, өөртөө шударга гэж үзсэн зүйлээ сонгох, хуульд амьдралаа захируулан нийтээр тэгш эрхтэй амьдрах, хуулийн өмнө гэм буруугаа хүлээх чадвар юм” хэмээн үзэж байжээ. Тэрээр “Хүчирхэг эрх мэдэлтэй шилдэг төртэй, хамгийн тогтвортой, ухаалаг хуультай байх нь шударга ёсны дээд оргил юм” хэмээн сургаж байв.

Харин “Бусдад хохирол учруулахгүйгээр өөрийгөө болон өөрийн үйлдлээ хариуцах явдал нь шударга ёс” гэж Ульпиан хэлсэн бол “Хаана эрх зүй тогтооно, тэнд шударга ёс ноёлно”, “Хуулиудаас шударга ёс үүсэхгүй, харин шударга ёсноос хуулиуд үүснэ” гэж Павла, Цицерон нар номлосон. Үүнээс *шударга ёс нь хүний эрх, эрх чөлөөтэй салшгүй холбоотой жам ёсны эрх зүйн чухал үнэт зүйлс* болох нь харагддаг. Үүний дараах Дж.Локк, И.Кант

<sup>1</sup> Баярсайхан Д. Хүний эрхийн онолын сэтгэлгээ, уламжлал, шинэчлэлийн асуудал. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2000. №1. 14 дэх тал

<sup>2</sup> Basic norm- Энэ талаар Х.Сэлэнгэ (Ph.D) багш “Цэвэр эрх зүйн онол” өгүүлдэд бичихдээ <<Кельзены үзлээр “эрх зүй нь “Үндсэн хэм хэмжээ”-ний тусламжтайгаар шаталсан логик бүтэц бүхий нэгдмэл тогтолцоонд оршиж байдаг. Өөрөөр хэлбэл, эрх зүйн нэгдмэл, шаталсан тогтолцоотой байх үндэс нь хүн төрөлхтөний оюун санаагаар үнэн болох нь нотлогдсон “Үндсэн хэм хэмжээ” /Grundnorm, Basic Norm/ юм>> хэмээн байна.



нарын дэвшүүлж байсан хязгаарлагдсан эрх чөлөөний ухамсарлагдсан зайлшгүй байдал нь шударга ёсны зүй тогтолт шинж нь болдог. Тэдний үзлээр “Ямар ч хүний эдлэх эрх, эрх чөлөө нь бусдын эрхээр хязгаарлагдана. Хэн боловч өөрийн хүсэл сонирхол, эрх чөлөөг эдлэхдээ бусад хүний эрхэнд халдахгүй, түүнийг хөндөхгүй байх” тухай сургасан билээ. Мөн Ж.Роулс шударга ёс нь тэгш эрхийг үгүйсгэн зөвшөөрөх ялгагдах зарчмуудыг өөртөө агуулж, эрх чөлөөт боломжийн хязгаарлагдах хийгээд нөхөгдөх шаардлага, хэм хэмжээг тусган харьцангуй тогтвортой үнэлэмж, үнэт зүйлс болж оршдог гэжээ.

Түүхэн хөгжлийн янз бүрийн цаг үед шударга ёсны шалгуур, үнэт зүйлс өөрчлөгдөн шинэчлэгдэж, хөгжсөөр иржээ. Гэхдээ шударга ёс нь эрх чөлөө, тэгш эрх, ёс суртахуунтай холбогдож, үнэт зүйлсийн зөв зохистой байдлыг агуулдгаараа эрх зүйтэй илүү хамааралтай, түүний салшгүй эд эс нь болсон байна<sup>3</sup>.

Эндээс дүгнэвэл шударга ёс бол олон хүчин зүйлийг багтаасан их гүн гүнзгий утга бүхий ойлголт болох нь харагдаж байна. Тухайлбал, ялыг хэрэв энэ нь хууль бус, хэрэв иргэд хуулийн өмнө эрх тэгш байхыг зөрчсөн, хэрэв ял хэтэрхий хатуу зэрэг байвал шударга гэж үзэхгүй. Иймд шударга шүүхээр шүүлгэх эрхийг хэрэгжүүлэхэд шударга ёсны талаарх үзэл баримтлал зайлшгүй чухлаар тавигдах юм. Гэвч дан ганц шударга ёсны талаарх үзэл баримтлал нь уг эрхийн баталгаа болж чадахгүй. Учир нь *шударга шүүхээр шүүлгэх эрх нь хүний үндсэн эрхийн нэг төрөл тул хүний эрхийн талаарх ойлголт болон түүнийг хамгаалах механизм байх шаардлагатай* юм.

#### Б. “Хүний эрх” ба шударга шүүхээр шүүлгэх эрх

“Human right” гэсэн ойлголт хүн бүрд хамаатай үндсэн эрх гэсэн агуулгыг илэрхийлж 1776 оны Виржиний Үндсэн хууль болон Эрхийн тухай тунхагт анх удаа тусгалаа олж байсан бол хүний эрхийн ойлголтын танин мэдэхүйн анхны эх үндэс нь МЭӨ V зууны үед эртний Грекийн софистуудын боловсруулсан “байгалиас заяасан жам ёсны буюу заяамал эрхийн сургаал”-аас эхлэлтэй. Энэ сургаал нь МЭӨ III зууны үеийн Ромын хуульчдын жам ёсны эрх зүйн (jus naturale) номлолоор баяжин, улмаар 1215 оны Английн **magna carta** буюу “Эрх чөлөөний Харти” хэмээх баримт бичигт эрх зүйн институт болж тусгагдсан түүхтэй<sup>4</sup>.

Ийнхүү шударга шүүхээр шүүлгэх эрхийн талаар анхлан “Эрх чөлөөний Харти” буюу “Магна Харти”-ийн 39 дүгээр зүйлээр “Эрх чөлөөт иргэн хэнийг ч хуулиас гадуур, шүүхийн шийдвэргүйгээр хорьж цагдаж болохгүй, хэнийг ч улс орноос нь хөөх, нэр харьяаллыг нь хасаж болохгүй, хэнийг ч эзэмших болон бусад эрхээс салгаж болохгүй”<sup>5</sup> гэсэн санааг тусгаж байжээ. Хууль, шүүхийн өмнө бүх хүн арьсны өнгө, үндэс угсаа үл хамааран эрх тэгш байх, эрэгтэй эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байх гэсэн тэгш эрхийн зарчмыг ихэнх улсын Үндсэн хуульд дурдсан байна. Хожуу үеийн Үндсэн хуульд тэгш эрхийн аспектиудын жагсаалт илүү өргөн болж ирсэн байдаг. Хуулийн өмнө тэгш байх гэдэг нь албан тушаал, нийгмийн байдал, хувь хүний бусад шинж чанараас үл хамааран хууль бүгдэд адил үйлчилж, хууль зөрчсөн нөхцөлд бүх хүн адилхан хариуцлага хүлээх ёстой гэсэн үг юм<sup>6</sup>.

Ер нь олон улсын хэм хэмжээнд шударгаар шүүлгэх эрхийг хэрэгжүүлэх нь шударга шүүхийн үйл ажиллагааны баталгаа болдог хэдий ч илүү өргөн хүрээтэй байдаг. Үүнд үндэсний шүүн таслах ажиллагаа нь олон улсын хэм хэмжээтэй тохирч байгаа эсэх багтана<sup>7</sup>. Шударга шүүх гэх ойлголтоор Үндсэн хуульд заасан журмын дагуу байгуулагдан

<sup>3</sup> Нээлттэй нийгэм форум. “Эрүүгийн хууль дахь шударга ёсны зарчмын хэрэгжилт” бодлогын судалгааны тайлан, 2020, [https://forum.mn/uploads/site/1126/res\\_mat/2020/Criminalcode.pdf](https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/Criminalcode.pdf)

<sup>4</sup> Баярсайхан Д. Хүний эрхийн онолын сэтгэлгээ, уламжлал, шинэчлэлийн асуудал. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2000. №1. 13 дахь тал

<sup>5</sup> R.C. van Caenegem. (2014). A note on chapter 39 of Magna Carta. [https://www.researchgate.net/publication/317450368\\_A\\_note\\_on\\_chapter\\_39\\_of\\_Magna\\_Carta](https://www.researchgate.net/publication/317450368_A_note_on_chapter_39_of_Magna_Carta)

<sup>6</sup> Цогтоо Ш. Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй- Харьцуулсан судалгаа. УБ., 2018, 180 дахь тал

<sup>7</sup> Эмнести интернэшнл. Шударгаар шүүлгэх эрх: Гарын авлага. УБ., 2010

үйл ажиллагаандаа хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх журмыг хэрэглэдэг ердийн болон төрөлжсөн шүүх бүрийг ойлгох бөгөөд уг ойлголт нь хуульд заасан журмын ёсоор байгуулагдсан шүүхийг дотор нь шударга, шударга бус гэж ангилан ялгахын нэр биш юм. Шударга шүүхээр шүүлгэх эрхийг хэрэгжүүлэхэд удирдлага болгож буй тухайн хэм хэмжээнүүд нь “Хууль дээдлэх ёс /The rule of law/”-ны хэлбэрийн болон агуулгын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэх асуудал үүсэх бөгөөд үүнээс улбаалан уг эрх хэрэгжих болон хамгаалагдах баталгаа нь бодитоор хангагдах эсэх нь хамаарна.

### **В. “The rule of law” ба шударга шүүхээр шүүлгэх эрх**

Хууль зүйн аливаа үйл баримтад эрх зүйн үнэлгээ өгөхдөө (1) хааны зарлиг, (2) парламентаас тогтоосон хууль, (3) шүүхийн шийдвэрийн аль нь тэргүүлэх шинж чанартай талаар дундад зуунд маргаан өрнөж, түүний үр дүнд “The rule of law/ Үүнийг Монгол хэлнээ “эрх зүйт төр”, “хууль дээдлэх ёс”, “эрх зүйд захирагдах ёс” хэмээн орчуулан хэрэглэж байна/” гэсэн ойлголт үүссэн гэдэг. Хууль дээдлэх ёс нь Англи - Америкт анх үүссэн ойлголт боловч энэ нь эрх зүйт төр (Rechtsstaat) гэсэн эх газрын Европын ойлголттой төстэй утгаар хэрэглэгдэх нь түгээмэл болсон<sup>8</sup>.

Хууль дээдлэх ёс нь хүнээр засаглах ёс (The rule of person) болон хуулиар засаглах ёс (The rule by law) хоёроос ялгаатай. Хүнээр засагдах ёс нь дур зорго, авлига, тогтворгүй байдал гэсэн утгаар ойлгогддоогоороо хууль дээдлэх ёсноос ялгаатай. Хууль дээдлэх ёсыг ойлгох үзэл баримтлалуудыг ерөнхийд нь хэлбэрийн болон агуулгын хэмээн хоёр төрөлд хувааж болно. Хууль дээдлэх ёсны хэлбэрийн үзэл баримтлал нь хуулийн дагуу амьдралаа төлөвлөх боломжийг хүмүүст олгох замаар хүний нэр төр (human dignity) болон бие даасан байдлыг хүндэлдэг. Өөрөөр хэлбэл, хүмүүс хуулиар зөвшөөрсөн бүхнийг хийх эрх чөлөөг ядаж эдэлдэг. *Хууль дээдлэх ёсны агуулгын үзэл баримтлал нь хууль хэлбэрийн зарчмууд төдийгүй хувь хүний үндсэн эрхийг хүндэлж байх ёстой гэсэн шаардлагыг тавьдаг* бөгөөд үүгээрээ хэлбэрийн талаас ялгаатай.

Улс төрийн онолын нэртэй төлөөлөгч Жозеф Раз /1954 оны 10-р сарын 24-нд Чехийн Братиславд төрсөн/ хууль дээдлэх ёсны ойлголтыг агуулгын болон процедур талаас нь хослуулан:

1. Хууль амьдралд нийцсэн байхын хамт үйлчлэх ирээдүйтэй байх,
2. Хууль тогтвортой байж, хэрэглэгчдийг түүнд үйл ажиллагаагаа зохицуулах боломж олгож байх,
3. Хуулийг хэрэгжүүлэх журам, процедур нь тодорхой байх,
4. Шүүхийн хараат бус байдал баталгаажсан байх,
5. Шударга ёсны зарчмуудыг мөрдлөг болгох,
6. Шүүхийн хяналтын эрх мэдэл нь бусад зарчмуудаа хэрэгжихүйц байдлыг бий болгосон байх,
7. **Хүн бүр шүүхэд хандах, шударгаар шүүлгэх эрхтэй байх,**
8. Хууль хэрэгжүүлэх, хамгаалах байгууллага хуулийг гажуудуулахгүй байх зэрэг зарчмуудыг агуулна гэж үзсэн байна<sup>9</sup>.

Олон улсын барын холбоо хууль дээдлэх ёсны суурь зарчимд дараах зарчмуудыг хамааруулан үзсэн байна:

1. Хараат бус шүүх;
2. **Шударга, нээлттэй шүүхээр шүүлгэх эрх;**
3. Ял шийтгэл гэм бурууд нь тохирсон байх;
4. Эрх зүйн мэргэжил хүчтэй, бие даасан байх;
5. Өмгөөлөгч үйлчлүүлэгчийн хоорондын итгэлцлийн харилцааг нарийн чанд хамгаалах;

<sup>8</sup> Мөнхсайхан О. Хууль дээдлэх ёс ба Монгол. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2020. №4 (52). 14 дэх тал

<sup>9</sup> Лүндэндорж Н. Төрийн онол. УБ., 2020, 186-187 дахь тал

6. хуулийн өмнө бүгд эрх тэгш байх зэргүүд болно.

Мөн “The World Justice Project /цаашид “WJP” гэх/” буюу “Дэлхийн шударга ёсны төсөл”-өөс хууль дээдлэх ёсыг:

1. Засгийн газар, түүний байгууллага, ажилтнууд хуулийн өмнө хариуцлага хүлээж байх,
2. Хууль тодорхой, нийтлэгдсэн, тогтвортой, хүний суурь эрхийг хамгаалсан байх,
3. Хуулиар тогтоосон процесс нь шударга, үр нөлөөтэй байх,
4. Хууль ёсыг хамгаалж, сахиулагчид нь өндөр мэдлэг, ёс зүйтэй, хараат бусаар ажиллах тал бүрийн бололцоо бүрдсэн байх зэргийг онцолсон байна<sup>10</sup>.

Өдгөө эрх зүйд захирагдах ёсны /The rule of law/ процедурын талын стандартыг “Due process of law” буюу “Эрх зүйн байх ёстой шударга процесс” гэж нэрлэдэг. Энэ стандартыг анх 1215 онд Магна Хартид үндэслэж, цаашид АНУ-ын Үндсэн хуулийн 5.14 дүгээр зүйлийн нэмэлтээр баяжуулж, Францын 1789 оны “Хүний болон иргэний эрхийн тунхаг”-аар хөгжүүлсэн байна.

“WJP”-ээс дэлхийн улс орнуудыг “Хязгаарлагдмал гүйцэтгэх эрх мэдэл, Хээл хахуульгүй байх, Хуулиуд нь тодорхой, нийтлэгдсэн, тогтвортой байх, Дэг журам ба аюулгүй байдал, Суурь эрх, Нээлттэй засаг төр, Албадлагын зохицуулалт, Иргэний шүүн таслах ажиллагаа, Үр нөлөө бүхий эрүүгийн шүүн таслах ажиллагаа, Албан бус шүүн таслах ажиллагаа” гэсэн 10 бүлэг үзүүлэлтүүдээр “Rule of law” буюу хууль дээдлэх ёсны хэрэгжилтийг хэмжин жагсаахад Монгол Улс нь 140 улсаас 2021 оны байдлаар 61-д, 2022 оны байдлаар 62-т жагссан байна. Уг үзүүлэлтийн сүүлийн 7 жилийг харвал манай улс нь 2015 онд 102 орноос 47-д жагсаж байсан байна<sup>11</sup>. Дээрх 10 үзүүлэлтийн нэг болох “Суурь эрх” гэсэн бүлэг үзүүлэлт нь дотроо дараах 8 үзүүлэлтийн хамруулдаг. Үүнд:

1. Эрх тэгш байх ёс үр нөлөөтэй баталгаажсан байх,
2. Хувь хүний амьдрах, аюулгүй байх эрх үр нөлөөтэй баталгаажсан байх,
3. Эрх зүйн байх ёстой шударга процессууд үр нөлөөтэй баталгаажсан байх,
4. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө үр нөлөөтэй баталгаажсан байх,
5. Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө нь үр нөлөөтэй баталгаажсан байх,
6. Хувийн эрхийн халдашгүй байдал үр нөлөөтэй баталгаажсан байх,
7. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө үр нөлөөтэй баталгаажсан байх,
8. Хөдөлмөрлөх суурь эрх үр нөлөөтэй баталгаажсан байх зэргүүдийг хамруулдаг байна<sup>12</sup>.

## II. ШУДАРГА ШҮҮХЭЭР ШҮҮЛГЭХ ЭРХИЙН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ

“Шударга шүүхээр шүүлгэх эрх”-ийн талаарх ойлголт нь хүний үндсэн эрхийн нэг төрөл тул Үндсэн хуулийн эрх зүйтэй салшгүй холбоотой. Эх газрын системийн орнуудад хууль дээдлэх явдлыг эрх зүйн гол баримтлал болгосон байдгаас үүдэн эрүүгийн процессийн эрх зүйн тулгуур зарчмийг ихэнхдээ Үндсэн хуульд тусгалаа олж томъёологдсон байдаг. Иймд эрүүгийн процессийг хэрэгжүүлэхийн тулд хүний үндсэн эрх, эрх чөлөөг хөндөх, хязгаарлах явдал зайлшгүй гардаг бөгөөд энэ нь чухам ямар нөхцөл, үндэслэл бий болсон үед ямар хэмжээ хязгаарт зөвшөөрөгдөх учиртайг гагцхүү Үндсэн хуульд тодорхойлсон тэр хүрээнд зохицуулсан байдаг. Үүний зэрэгцээ шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг Үндсэн хуульд заасан байхаас гадна гэмт хэрэгтэй тэмцэх болон хүний халдашгүй

<sup>10</sup> Лүндэндорж Н. Төрийн онол. УБ., 2020, 188-189 дэх тал

<sup>11</sup> World Justice Project 2022. The rule of law index. <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/global/2022/Mongolia/>

<sup>12</sup> Лүндэндорж Н. Төрийн онол. УБ., 2020, 191-192 дахь тал

эрхийг хангуулах нь төрийн үүрэг болох тухай томъёолсон зэрэг нь Үндсэн хуулийн эрх зүйн зайлшгүй холбогдох хамаарал, онцлогийг тодорхойлж өгдөг<sup>13</sup>.

Манай улсын хувьд Үндсэн хуулийнхаа арван зургаадугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх эрх, эрх чөлөөг тунхаглан хуульчилсан билээ. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн холбогдох бүлгийг “Хүний эрх, эрх чөлөө” гэж нэрлэхдээ тус бүлэгт заасан эрхүүдийг дан ганц Монгол Улсын иргэн эдлэхгүй, харин Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн нэг дэх хэсэгт заасан, Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр эдэлнэ гэсэн санааг агуулсан юм<sup>14</sup>.

“Шударга шүүхээр шүүлгэх эрх”-ийн талаарх зохицуулалт нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, **шударга шүүхээр шүүлгэх**, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэж буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд халдаан хэрэглэхийг хориглоно” хэмээн хүний үндсэн эрхийн нэг төрөл болох “Шударгаар шүүлгэх эрх”-ийн талаар хуульчилжээ. Энэ заалт бол иргэдийн хувийн халдашгүй эрхийн эрүү, иргэний эрх зүйн болон байцаан шийтгэх ажиллагааны үндсэн баталгаа бөгөөд иргэд уг эрх нь зөрчигдсөн хэмээн үзвэл эрхээ хуулиар хамгаалуулахын тулд шүүхэд гомдол гаргах эрхтэй. Учир нь эрүү, иргэний болон төрөлжсөн шүүхийн гол зорилго бол ардчилсан Үндсэн хуулийн баталгаа болох хүний эрхийг зөрчигдөхөөс хамгаалах баталгаа нь болж байдаг оршино.

Шударга шүүхийн гол үндсэн зарчим бол харьяалах хэрэг, маргаанаа алагчлалгүйгээр хэний ч нөлөөнд авталгүйгээр, зөвхөн бодитой нотлох баримтад үндэслэн, хуульд нийцүүлэн ямар нэг харьяалал, хууль бус нөлөөлөл, сэтгэл хөдлөл, дарамт шахалт, сүрдүүлэгт автагдалгүй, ямар ч шалтгаантай байсан хэний ч талаас хөндлөнгийн шууд, шууд бус ямар нэг оролцоогүй шударга шийдвэрлэх явдал юм. Энэхүү үндсэн зарчмын тулгуур асуудал нь алагчлалгүй ажиллах, шударга шийдвэрлэх хоёр юм. **Шударга шийдвэрлэх гэдэг нь хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэхдээ хүн бүрийн үйлдсэн хэрэг зөрчлийн хор хохирлын байдал, үйлдлийн арга, гэм буруугийн хэлбэр, хэргийн хүнд хөнгөний байдал, хэрэг хийсэн, зөрчил гаргасан этгээдийн хувийн байдлын онцлогт тохируулан хуулийн хүрээнд хүлээлгэх хариуцлагыг хүн бүрд ялгамжтай шийдвэрлэхийг хэлнэ**<sup>15</sup>.

“Шударга шүүхээр шүүлгэх эрх”-ийн тухай ойлголт нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд хэрхэн тусгагдсан талаар авч үзэхийн тулд “Эрүүгийн хууль” болон “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-д уг эрхийн талаарх ойлголт хэрхэн тусгагдсан талаар судлан авч үзэх шаардлагатай билээ. Учир нь эрүүгийн процесс нь хүний эрхийг хамгаалах төдийгүй хүний эрхийг хязгаарлах, халдахад хүргэх үр дагаврыг агуулдгаараа тодорхой хориглолт, зохицуулалт бүхий эрх зүйн зарчмуудыг онцлог юм. Түүнчлэн эрүүгийн эрх зүйн зарчмууд нь эрүүгийн процессийн эрх зүйтэй шууд хамааралтай байдаг. Учир нь материаллаг эрх зүйн үзэл санаа нь практик дээр гагцхүү процессийн эрх зүйгээр л дамжин хэрэгжилтээ олж, илэрдэг тул уг 2 салбар эрх зүй нь хоорондоо нягт уялдаа холбоотой байдаг билээ. Иймд уг эрхийн суурь үзэл санаа нь эрх зүйн зарчим, түүн дотроо эрүүгийн эрх зүйн зарчмуудад хэрхэн тусгагдсан талаар судлан

<sup>13</sup> Баярсайхан Д. Эрүүгийн процессийн эрх зүй. УБ., 2020, 25-26 дахь тал

<sup>14</sup> Сарантуяа Ц. Үндсэн эрх болон хүний эрх: Харьцуулалт, онолын эргэцүүлэл. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2000. №1. 19-20 дахь тал

<sup>15</sup> Совд Г нар. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000, 116 дахь тал

авч үзсэний үр дүнд эрүүгийн процессийн эрх зүйд уг материаллаг эрх зүйд тусгагдсан үзэл санаа нь хэрхэн илрэн гарч буйд дүн шинжилгээ хийх боломжтой болох юм.

Эрх зүйн зарчим бол хууль тогтоох болон хэрэглэх үйл ажиллагаанд заавал хэрэглэгдэх **суурь үзэл баримтлал** юм. Өөрөөр хэлбэл тухайн салбар эрх зүйн үзэл баримтлал нь зарчмуудаар нь дамжин илэрхийлэгдэж байдаг бөгөөд тэрхүү үзэл баримтлал нь эрүүгийн эрх зүйн онолоор боловсрогдох бөгөөд Эрүүгийн хуулиар бэхжүүлснээр бодит хэлбэрийг олдог. Иймд эрүүгийн эрх зүйд шударга шүүхээр шүүлгэх эрхийн үзэл баримтлал хэрхэн тусгагдсан талаар авч үзэхийн тулд эхлээд эрүүгийн эрх зүйн зарчмуудын талаар судлан мэдэх шаардлагатай юм.

Манай Улсын шинээр дагаж мөрдүүлсэн “Эрүүгийн хууль”-д, түүнийг хэрэгжүүлэгчдээс баримтлах зарчмуудын тоог эрс цөөлж, “Монгол Улсын Үндсэн хууль”-ын тулгуур зарчмууд буюу эрх зүйн аль ч салбарыг ялгалгүй түгээмэл үйлчилдэг **хууль ёсны** болон **шударга ёсны**, мөн хүний эрх, эрх чөлөөг хөндөхтэй холбоотой харилцааг зохицуулдаг нэг бус салбар эрх зүйг хамран үйлчилдэг **гэм буруугийн зарчмуудыг** удирдлага болгохоор хэвээр үлдээсэн аж<sup>16</sup>. Тодруулбал:

Монгол Улсын 2002 болон 2015 оны эрүүгийн хуулиудыг харьцуулан авч үзвэл 2002 оны “Эрүүгийн хууль”-д заасан “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим”, “Энэрэнгүй ёсны зарчим”, “Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчим”, “Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим”-ыг 2015 оны “Эрүүгийн хууль”-д хасаж хуульчилсан байх ба энэ нь эрх зүйн хэм хэмжээний хяналтын үүднээс үзвэл тодорхой асуудал үүсэхээр байна. Тухайлбал: Майкл Розенфелдийнхээр “Бичмэл Үндсэн хууль нь үнэндээ хуулийн хүчин чадалтай болох бөгөөд төрийн эрх мэдлийг хязгаарласан, үндсэн эрхийг хамгаалсан түүний заалтууд нь тухайн Үндсэн хуулийн дэглэмээр бий болгосон хууль дээдлэх ёсны салшгүй хэсгийг бүрдүүлэх боломжтой”<sup>17</sup> гэжээ.

Эрх зүйн хэм хэмжээний хяналт нь эрх зүйн акт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шийдвэрлэдгээрээ Үндсэн хууль хамгийн дээд хүчин чадалтай баримт бичиг гэдгийг дахин нотолдог онцлогтой<sup>18</sup>. Гэтэл “Хүн бүр хууль, шүүхийн өмнө хүн эрх тэгш байх” зарчмыг хассанаараа “Монгол Улсын Үндсэн хууль”-ын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэх заалтыг, “Энэрэнгүй ёсны зарчим”-ийг хассанаараа “Монгол Улсын Үндсэн хууль”-ын 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт заасан “... Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэх заалтуудын эсрэг үйлдэл болсон байна.

Эрүүгийн эрх зүйн зарчмууд өөр хоорондоо харилцан холбоотойгоор хэрэгждэг. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүний гэм бурууг тогтооход алдаа гаргавал хууль ёсны зарчмыг гажуудуулахад шударга ёсны зарчим алдагдаж, шударга ёс алдагдахад хууль ёсны зарчим бас зөрчигдөх сөрөг үр дагавартай<sup>19</sup>.

Иргэнийг өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглосон явдал бол иргэдийн эрүүл мэнд, эрх чөлөө, нэр төрийг төр, түүний албан тушаалтны /мөрдөн шалгах, шүүн таслах байгууллага, тэдгээрийн албан тушаалтан/ зүгээс үзүүлэх элдэв дарамт, шахалт, хүчирхийллээс хамгаалж, тэгснээрээ эрүү шүүлтийн ямар нэг хэлбэрийг шүүн таслах эрхийг хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд гаргуулахгүй байх нь шударга шүүхээр шүүлгэх эрхийн хууль зүйн баталгаа нь болдог. Аливаа хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэдгийг зөвхөн

<sup>16</sup> Доржпалам Х. Монгол Улсын эрүүгийн эрх зүй- Ерөнхий анги. УБ., 2019, 23 дахь тал

<sup>17</sup> Мөнхсайхан О. Хууль дээдлэх ёс: Ерөнхий хандлага ба Монгол. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2020. №4 (52). 16 дахь тал

<sup>18</sup> Бямбажаргал А. Эрх зүйн хэм хэмжээ орхигдуулсан буюу негатив хяналт ба Монгол Улсын жишиг. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2020. №3 (51). 337-338 дахь тал

<sup>19</sup> Доржпалам Х. Монгол Улсын эрүүгийн эрх зүй - Ерөнхий анги. УБ., 2019, 23 дахь тал



шүүхээр хянан шүүж хууль ёсоор нотолсон баримтад тулгуурлан шийдвэрлэх ёстой. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэдгийг шүүхээс тогтоосон таслан шийдвэрлэх тогтоол, хуулийн хүчин төгөлдөр болоогүй нөхцөлд хэнийг боловч гэмт хэрэгтэнд тооцож ял эдлүүлж болохгүй. Уг зарчмын гол агуулга нь хэн нэг этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон шүүхийн тогтоол хууль ёсоор хүчинтэй болсноор уг иргэн ял эдлэх үндэслэл бүрдэх бөгөөд улмаар түүний нэр төр, эд хөрөнгө болон хувийн эрх, эрх чөлөөнд нь хуулийн хязгаарлалтуудыг тогтоож, түүний хүсэл зоригоос шалтгаалахгүйгээр албадан заавал биелүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндэслэл бүрддэг билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ын тодорхой заалтууд нь Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” хэмээх эрхийг, 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “...шударга шүүхээр шүүлгэх эрхтэй...” гэх заалтуудыг зөрчсөн хэмээн үзэж дараах дүгнэлт болон тогтоолыг гаргасан байдаг. Эдгээрийн талаар товч авч үзвэл:

**А. “Монгол Улсын Үндсэн хууль”-ын Цэцийн 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтэд:**

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад “тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт “Монгол Улсын Үндсэн хууль”-д заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол;” гэж, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх хэрэглэх хууль нь “Монгол Улсын Үндсэн хууль”-д нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан Үндсэн хуулийн цэцэд үүссэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.” гэж тус тус заасан нь “Монгол Улсын Үндсэн хууль”-ын Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал ...-г хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “*Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна*” гэж заасныг зөрчсөн байна” хэмээн дүгнэсэн байна.

Цэцээс ийнхүү үзэхдээ “Үндсэн хуулийн цэцэд тухайн эрүүгийн хэргийн оролцогч, эсхүл огт хамааралгүй этгээдийн өргөдөл, мэдээллээр маргаан үүсгэн хянан шийдвэрлэх тохиолдолд хэргийг түдгэлзүүлэхээр байгаа нь хэргийн бусад оролцогчдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж, “Монгол Улсын Үндсэн хууль”-аар баталгаажсан *хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх боломжийг алдагдуулж, тэгш байдлыг хангах зарчмыг хөндсөн байна*<sup>20</sup>” гэсэн үндэслэлийг дэвшүүлсэн байна.

Ийнхүү цэцийн уг дүгнэлтээр “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад “тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт “Монгол Улсын Үндсэн хууль”-д заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол;” гэж, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх хэрэглэх хууль нь “Монгол Улсын Үндсэн хууль”-д нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан Үндсэн хуулийн цэцэд үүссэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.” гэж тус тус заасан нь “Монгол Улсын Үндсэн хууль”-ын Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал ...-г хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн байна хэмээн түдгэлзүүлсэнг Монгол Улсын Их Хурлын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 42 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрөх боломжгүй хэмээн

<sup>20</sup> Монгол Улсын ҮХЦ-ийн дүгнэлт №04: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2021.05.12/, <https://old.legalinfo.mn/law/details/16354?lawid=16354>

үзсэн байна<sup>21</sup>.

**Б. “Монгол Улсын Үндсэн хууль”-ын Цэцийн 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 07 дугаар тогтоолд:**

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт «Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.» гэж заасан нь “Монгол Улсын Үндсэн хууль”-ын Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн «Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.», 16 дугаар зүйлийн 14 дэх заалтын «... *шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...*», Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасныг зөрчсөн байна” хэмээн тогтоосон байна.

Цэцээс ийнхүү тогтоохдоо “Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх заалтад тусгасан *«шударга шүүхээр шүүлгэх эрх»*-ийн хүрээ нь олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн “шударгаар шүүлгэх эрх”-ийн агуулгатай дүйцэж байгаа бөгөөд шүүхийн өмнөх, түүнчлэн шүүх хуралдааны болон түүний дараах үе шатанд эдлэх цогц эрхийг илэрхийлсэн өргөн агуулгатай ойлголт болно. Тухайлбал, хуулийн дагуу байгуулагдсан, бүрэн эрх бүхий, алагчлалгүй шүүхээр хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрх төдий бус, шүүх хуралдаанаас өмнө эрх зүйн туслалцаа авах, өмгөөлөгчөө сонгох, ялласан, баривчилсан үндэслэлийг мэдэх, эрүү шүүлтэд өртөхгүй байх, хүнлэг нөхцөлд хоригдох, хэргийг цаг алдалгүй шийдвэрлүүлэх, нотлох баримт шалгуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд талууд эрх тэгш байж, тэгш боломжоор хангагдах, ялгаварлан гадуурхлаас ангид байх зэрэг нь дээрх эрхийн хүрээнд багтаж байна. Үүнээс үзэхэд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь “*Монгол Улсын Үндсэн хууль*”-ын *16 дугаар зүйлийн 14 дэх заалтад заасан хүний шардрга шүүхээр шүүлгэх эрхийг зөрчсөн шинжтэй байна*<sup>22</sup>” гэсэн үндэслэлийг дэвшүүлсэн байна.

Ийнхүү цэцийн уг тогтоолоор “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.” гэж заасан нь “Монгол Улсын Үндсэн хууль”-ын Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “...шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасныг зөрчсөн байна.” гэж заасныг зөрчсөн байна хэмээн түдгэлзүүлсийг Монгол Улсын Их Хурлын 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 80 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрч “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ын 33.3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг “Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй” хэмээн өөрчилсөн байна<sup>23</sup>.

<sup>21</sup> Монгол Улсын Их Хурлын тогтоол №42: Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай /2021.05.20/, <https://old.legalinfo.mn/law/details/16606?lawid=16606>

<sup>22</sup> Монгол Улсын ҮХЦ-ийн тогтоол №07: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2021.10.20/, <https://old.legalinfo.mn/law/details/17056?lawid=17056>

<sup>23</sup> Монгол Улсын Их Хурлын тогтоол №80: Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 07 дугаар дүгнэлтийн тухай /2021.10.28/, <https://old.legalinfo.mn/law/details/17027?lawid=17027>

Өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилгыг “Гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино” хэмээн тодорхойлсон байна.

Харин хэргийн үнэн бодит байдлыг зөв шударгаар тогтоох, иргэдийн зөрчигдсөн эрх, эрх чөлөөг сэргээн эдлүүлэх явдал бол шүүн шийдвэрлэх ажиллагааны зорилго юм. Шүүхийн шийдвэр тэр тусмаа “...шүүхийн шийтгэх тогтоол нь Монгол Улсын нэрийн өмнөөс гарч, хүний амьд явах эрх, эрх чөлөө, өмч хөрөнгөнд нь хуулиар халдаж, хууль эрх зүйн хэм хэмжээ тогтоож байдгаараа асар хүчтэй, нэн хариуцлагатай шийдвэр” тул шүүх алдах эрхгүй, энэ боломжийг хэн ч зөвшөөрөхгүй нь ойлгомжтой. Гэвч алдах эрхийг хүлээн зөвшөөрсний нотолгоо бол гомдол, нэхэмжлэл гаргах эрхүүд, давах болон хяналтын шатны тогтолцоо түүнчлэн хохирол нөхөн төлүүлэх зохицуулалт зэргүүд болно. Түүнчлэн болзошгүй алдаанаас зайлсхийх механизм бол нотлогдоогүй бол гэм буруугүй, эргэлзээг ашигтайгаар шийдвэрлэх журмууд болно<sup>24</sup>.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баталгаа гэдэгт эрүүгийн процесс хуулийн дагуу хэвийн, найдвартай, тогтвортой, явагдах бүх талын хүчин зүйлийн бүрэн хангагдсан хийгээд хангагдах нөхцөл байдлыг ойлгох ба түүний зориулалт, мөн чанар, агуулга талаас нь таван төрлөөр ялган ангилж болно. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баталгааг түүний зориулалт, мөн чанар, агуулга талаас нь а) хүний эрхийн баталгаа, б) хууль зүйн баталгаа, в) улс төрийн баталгаа, г) эдийн засгийн баталгаа, д) ёс суртахуун- соёлын баталгаа хэмээх төрлөөр ялган ангилдаг. Тэдгээрийн нэг нь “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүний эрхийн баталгаа” нь ихэнхдээ НҮБ-ын конвенц болон Үндсэн хуулийн хэм хэмжээгээр баталгаажиж хангагдсан байдаг. Олон улсын гэрээ, конвенц болон Үндсэн хуульд заасны дагуу хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, гэмт хэрэг үйлдсэн шүүхээр тогтоогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болох, шударга шүүхээр шүүлгэх, шүүхэд гомдол гаргах зэрэг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүний эрхийн баталгааны нэгэн илрэл нь юм.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” хэмээн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанаар шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг тогтоосны дараа гэм буруутай бол “Эрүүгийн хууль”-д заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх, гэм буруугүй бол цагаатгах асуудлыг хянан шийдвэрлэнэ” хэмээн заасан байдаг. Гэтэл өнөөгийн шүүхийн практикт дараах хоёр асуудал нийтлэг ажиглагдаж байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2.7 дахь “Урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн” гэсэн заалт нь “Ne bis in idem” буюу “нэг гэмт хэрэгт нэг л удаа ял шийтгүүлэх” зарчимтай зөрчих асуудал
2. Гэмт хэрэгт холбогдсон хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахын өмнө гэрчээр мэдүүлэг авах асуудал

Дээрх хоёр тохиолдол нь тухайн этгээдийн /шүүгдэгчийн/ “Шударга шүүхээр шүүлгэх эрх”-д хэр нийцэж байгаа эсэх нь асуудалтай юм. Тодруулбал: Өнөөгийн практикт Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон ял, албадлагын арга хэмжээ байх шаардлагатай. Уг агуулга нь ялын тогтолцооны бодлого, төрөл, ял оногдуулах

<sup>24</sup> Эрхэсхулан Ж. Шүүн шийдвэрлэх ажиллагаан дахь алдаа (Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд). “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2016. №1 (33). 213; 217 дахь тал



хэлбэр, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх, хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл зэрэг хэм хэмжээгээр илэрдэг. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүх болон шүүгчийн зүгээс сэтгэл хөдлөлдөө автахгүйгээр тухайн үйлдэгдсэн гэмт хэргийн хор аюул, шүүгдэгчийн хувийн байдал, ялыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь сайтар шинжлэн судалж, хэнийг ч алагчлахгүйгээр үйлдсэн хэрэгт нь тохирсон ялыг оноох нь шударга ёсны зарчим хэрэгжиж байгаагийн илрэл болдог. Монгол Улсын нэгдэн орсон “Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт” болон “Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын Дүрэм”-д бичигт тусгагдсан эрүүгийн хуулийн үндэс, суурь гол зарчмуудын нэг нь “*Ne bis in idem*” буюу “нэг гэмт хэрэгт нэг л удаа ял шийтгүүлэх зарчим” юм. Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын Дүрэмийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ямар ч хүнийг 5 дугаар зүйлд дурдсан гэмт хэрэг үйлдсэнтэй холбогдуулж шүүхээс нэгэнт гэм буруутайг нь нотолсон буюу цагаатгасан бол түүнд өөр шүүхээс ял оногдуулж болохгүй”, Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пактын 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн орны хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй” гэж зааснаар уг зарчмын агуулга тодорхойлогддог. Монгол Улс Олон Улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, дотоодын хууль тогтоомжийг олон улсын конвенцод нийцүүлэх шаардлагын хүрээнд уг зарчмын агуулгыг 2015 оны Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” хэмээн шударга ёсны зарчмын агуулгат оруулан шинэчлэн тусгасан юм.

Гэвч “Эрүүгийн хууль”-ын 12.1 дүгээр зүйл “Хүчиндэх” гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний 2.7-т “урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн”, мөн хуулийн 12.3 дугаар зүйл “Бэлгийн мөлжлөг” гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний 2.2-т “урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн” хэмээн тус тус оруулж ирснээрээ “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн зарчмын эсрэг хүнийг өмнө нь үйлдсэн гэмт хэргийнх нь төлөө дахин хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан болохыг харуулж байна. Ийнхүү уг хоёр гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд “урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн” гэсэн хүндрүүлэх бүрэлдэхүүн тусгасан нь хуулийн үзэл баримтлал, нэр томьёо, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмаас гажжээ. Үүний улмаас хүн нийгэмд онц аюултай гэмт хэрэгтэн, ялтай этгээд, урьд нь ял шийтгүүлсэн этгээд, хүчиндэгч гэх мэтээр дахин дуудагдах, хүний өмнө нь үйлдсэн гэмт хэргийн үр дагавраар эрүүгийн хариуцлагыг хүндрүүлж, эрх зүйн байдлыг дордуулж байна.

Иймд Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7-т “урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн” хэмээн заасан нь “*Ne bis in idem*” буюу “нэг гэмт хэрэгт нэг л удаа ял шийтгүүлэх” гэх зарчимтай зөрчилдөхөөс “Эрүүгийн хууль” болон “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-д тусгагдсан үзэл баримтлал, зарчмын хүрээнд шударгаар шүүлгэх гэсэн эрхтэй нь зөрчилдөж байх тул уг заалтыг хүчингүй болгох шаардлагатай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу яллагдагчаар татагдсан хүнээс өөрийнх нь эсрэг мэдүүлгийг албадан авахыг хориглосон байдаг. Мөн уг хуулийн 9.6 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн дагуу гэрч нь өөрийнх нь эсрэг буюу түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай болох талаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзан өмгөөлөгчийн хамтаар мэдүүлэг өгөх эрхтэй юм.

Гэтэл практик дээр гэмт хэрэгт холбогдсон тухайн хүнийг яллагдагчаар татагдахын өмнө гэрчээр мэдүүлэг авахад тухайн хүнд “өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй” болохыг нь сануулан хэрвээ мэдүүлгийн агуулга нь өөрийнхөө эсрэг буюу

түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай болох талаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзан өмгөөлөгчийн хамтаар мэдүүлэг өгөхийг хүсэх эрхтэй болохыг нь сануулалгүйгээр мэдүүлэг авах тохиолдлууд гарах болжээ. Улмаар уг гэрчээр авсан мэдүүлэгтээ үндэслэн тухайн хүнийг яллагдагчаар татаж буй тохиолдлууд гарсаар байгаа юм. Тодруулбал:

Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн зүгээс аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын хяналтад мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргүүдэд “Гэмт хэрэгт холбогдсон хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахын өмнө гэрчээр мэдүүлэг авсан тохиолдол”-ыг 2022 оны III дугаар улирлын байдлаар улсын хэмжээнд судалж, илэрсэн зөрчлийг арилгуулах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах зорилго бүхий судалгаа явагдсан юм. Уг судалгаанд миний бие оролцсон бөгөөд судлан авч үзсэн тухайн дүүргийн тус улиралд шийдвэрлэсэн хэргүүдийн тоо нь ойролцоогоор 2500 орчим хэрэг байснаас миний түүвэрлэн судалсан 70 орчим хэргийн 30 орчим хэрэг нь нь тухайн гэмт хэрэгт холбогдсон хүнээс яллагдагчаар татагдахын өмнө гэрчээр мэдүүлэг авсан тохиолдол байсан юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 7.1.1-д эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг яллагдагч гэнэ хэмээн маш тодорхой заасан. Мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлээд хэн нэгнийг яллагдагчаар татах гэж байгаа бол яллагдагчаар татах тогтоолтой танилцах хүртэл “сэжигтэн” гэж нэрлэнэ. Өөрөөр хэлбэл, хэрэг бүртгэлтээс мөрдөн байцаалтад шилжих зааг дээр яллагдагчаар татах хүнийг гэрч, хохирогч гэх мэт өөр оролцогчоор нэрлэхгүй зөвхөн сэжигтэн гэнэ.

“Сэжигтэн”-ийг дуудан ирүүлэх, баривчлах нь тухайн хүнийг гэмт хэрэгт буруутган, мөрдөн байцаалтыг эхлүүлж буйг мэдэгдэх үе шат юм. Өмнөх хуулийн хүрээнд байсан хүний эрхийг сэжиг таамгаар хязгаарлахыг таслан зогсоох зорилгоор сэжигтэн гэх нэршлийг эрүүгийн процессийн оролцогчоор тооцохоо больсон. Учир нь сэжигтэнд хугацаагүйгээр хилийн хориг тавих, баглан даалт, барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авах, хамгийн ноцтой нь хүнийг зүгээр л сэжиглээд 14 хоног хорьдог, 72 цагтайгаа нийлэх юм бол 17 хоног хорьж саагуулах нөхцөл бүрдсэн байсан. Тиймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31-р бүлэгт бүхэлд нь ямар тохиолдолд хүнийг сэжигтнээр дуудах, баривчлахыг нарийвчлан заасан. Гэтэл энэ бүлгийг хэрэглэхийн оронд хүнийг гэрчээр дуудаад өөрийнх нь эсрэг мэдүүлэг авч, улмаар яллагдагчаар татаж байна. Нэг ёсондоо сэжигтнээр оролцох ёстой хүнийг гэрчээр оролцуулсны улмаас “Монгол Улсын Үндсэн хууль”-д заасан гомдол гаргах эрх нь автоматаар хасагдаж байгаа буюу “гэрч” болсноор гомдол гаргах, мөрдөгч, прокуророос татгалзах, өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхгүй болж байна. Тэр ч бүү хэл ямар хэрэгт сэжиглэгдэж байгаагаа мэдэх эрхгүй. Мөн ар гэртэйгээ холбоо барих, өмгөөлөгчдөө мэдэгдэх боломжгүй. Харин сэжигтэн байх тохиолдолд эдгээр эрх нээлттэй<sup>25</sup>.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу сэжигтнээс, эсвэл гэрчээс мэдүүлэг авах үед өөрийнх нь эсрэг мэдүүлэг авах гэж байна гэж үзвэл тэмдэглүүлээд, өмгөөлөгчтэй үргэлжлүүлнэ гэсэн зохицуулалт хуульд туссан байдаг хэдий ч уг хуулийн зохицуулалт хөдөө орон нутагт хэрэгжих бодит боломжгүй байна. Түүнийг тод илрэл нь гэмт хэрэгт холбогдсон хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахын өмнө гэрчээр мэдүүлэг авч улмаар яллагдагчаар татсан тохиолдлууд юм. Иймд хүний эрхийн тэр тусмаа шударга шүүхээр шүүлгэх эрхийн зөрчилтэй уг буруу жишгийг халж, тийнхүү авсан мэдүүлгийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ын 16.1.1-ийн дагуу хууль бусаар бэхжүүлсэн нотлох баримтад тооцохгүй байхаар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-д тусгах шаардлагатай байна.

<sup>25</sup> Нээлттэй нийгэм форум. Чухал сэдэв- Хэлэлцүүлгийн тэмдэглэл, 2022, <https://forum.mn/product/257155>

### III. ДҮГНЭЛТ

Энэхүү өгүүллээрээ Эрүүгийн процессийн эрх зүйн үүднээс уг эрхийн ойлголт, хэрэгжилтийг судлан авч үзээд дараах дүгнэлтэд хүрлээ.

“Шударга шүүхээр шүүлгэх эрх” нь *хүний үндсэн эрхийн нэг төрөл тул хүний эрхийн талаарх ойлголт болон түүнийг хамгаалах механизм байх шаардлагатай* бөгөөд “Шударга ёс”, “Хүний эрх”, “The rule of law” гэх ойлголтуудтай зайлшгүй холбоотой ойлголт тул *хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, тэгш эрх, шударга ёсыг чандлан сахиулах* нь уг эрхийг хэрэгжүүлэх суурь үндэс юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь хүний эрхийг хамгаалахаас гадна хүний эрхийг хязгаарлах, халдахад хүргэх үр дагаврыг агуулдгаараа тодорхой хориглолт, зохицуулалт бүхий эрх зүйн зарчмуудыг шингээсэн байдаг. Иргэн бүр хэргээ шударга шүүхээр шүүлгүүлэх эрхтэй бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад хамгийн ихээр хөндөгдөн зөрчигдөж болзошгүй хүний эрхийн нэг төрөл нь “Шударга шүүхээр шүүлгэх эрх” билээ. Шударга шүүхээр шүүлгэх эрхийн хууль зүйн баталгаа нь хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, тэгш эрх, эрх чөлөө, шударга ёсыг чандлан сахиулснаар шүүн таслах эрхийг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд эрүү шүүлтийн ямар нэгэн хэлбэрийг гаргуулахгүй байх боломж бүрдэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт шударга шүүхээр шүүлгэх эрхийг хүний үндсэн эрхийн нэг төрөл болох талаас хуульчилсан бөгөөд манай улсын эрүүгийн процессийн эрх зүйн зохицуулалтын хувьд Үндсэн хуульд тусгагдаж, төрийн бодлогын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны зорилго, зорилтыг хангахад чиглэгдсэн эрүүгийн процессийн эрх зүйн зарчмууд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг олон улсын гэрээ, конвенцод тусгагдсан хэмжээ, зохицуулалттай нягт уялдаж байгаагаас харах боломжтой юм.

Түүнчлэн эрүүгийн эрх зүйн зарчмууд нь эрүүгийн процессийн эрх зүйтэй шууд хамааралтай байдаг. Учир нь материаллаг эрх зүйн үзэл санаа нь практик дээр гагцхүү процессийн эрх зүйгээр л дамжин хэрэгжилтээ олж, илэрдэг тул уг 2 салбар эрх зүй нь хоорондоо нягт уялдаа холбоотой байдаг. Өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудын агуулгыг уялдаа холбоо талаас нь харвал дараах дутагдал илэрч байна. Үүнд:

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 2015 оны “Эрүүгийн хууль” нь 2002 оны “Эрүүгийн хууль”-д заасан “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим”, “Энэрэнгүй ёсны зарчим”, “Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчим”, “Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим”-ыг хасаж хуульчилсан бөгөөд “Хүн бүр хууль, шүүхийн өмнө хүн эрх тэгш байх” зарчмыг хассанаараа “Монгол Улсын Үндсэн хууль”-ын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэх заалтыг, “Энэрэнгүй ёсны зарчим”-ыг хассанаараа “Монгол Улсын Үндсэн хууль”-ын 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт заасан “...Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэх заалтуудын эсрэг үйлдэл болсон байна. Учир нь иргэнийг өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглосон явдал бол иргэдийн эрүүл мэнд, эрх чөлөө, нэр төрийг төр, түүний албан тушаалтны /мөрдөн шалгах, шүүн таслах байгууллага, тэдгээрийн албан тушаалтан/ зүгээс үзүүлэх элдэв дарамт, шахалт, хүчирхийллээс хамгаалж, тэгснээрээ эрүү шүүлтийн ямар нэг хэлбэрийг шүүн таслах эрхийг хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд гаргуулахгүй байх нь шударга шүүхээр шүүлгэх эрхийн хууль зүйн баталгаа нь болдог.

Гэтэл өнөөгийн практикт “Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7 дахь “Урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн” гэсэн заалт нь “Ne bis in idem” буюу “нэг гэмт хэрэгт нэг л удаа ял шийтгүүлэх”

зарчимтай зөрчилдөж буй асуудал” болон “Гэмт хэрэгт холбогдсон хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахын өмнө гэрчээр мэдүүлэг авах асуудал” гэсэн 2 асуудал нийтлэг ажиглагдах болжээ. Уг асуудал нь өөрөө иргэний “Шударга шүүхээр шүүлгэх эрх”-ийг ноцтой зөрчиж буй хэрэг тул зайлшгүй засах хэрэгтэй асуудал билээ.

Иймд Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7-т “урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн” хэмээн заасан нь “Ne bis in idem” буюу “нэг гэмт хэрэгт нэг л удаа ял шийтгүүлэх” гэх зарчимтай зөрчилдөхөөс “Эрүүгийн хууль” болон “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-д тусгагдсан үзэл баримтлал, зарчмын хүрээнд шударгаар шүүлгэх гэсэн эрхтэй нь зөрчилдөж байх тул уг заалтыг хүчингүй болгох шаардлагатай байна. Мөн гэмт хэрэгт холбогдсон хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахын өмнө гэрчээр мэдүүлэг авч улмаар яллагдагчаар татах болсон практикийн хувьд ийнхүү авсан мэдүүлгийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ын 16.1.1-ийн дагуу хууль бусаар бэхжүүлсэн нотлох баримт хэмээн үзэж нотлох баримтад тооцохгүй байхаар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-д тусгах шаардлагатай юм.

## ЭХ СУРВАЛЖ

### *Хууль тогтоомж:*

#### *Монгол Улсын хууль тогтоомж:*

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017
3. Эрүүгийн хууль, 2015

#### *Гадаад Улсын хууль тогтоомж:*

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм, 1945
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт, 1966
3. Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, 1965

### *Ном зохиол, судалгааны ажил, материал*

1. Совд Г нар. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000
2. Цогтоо Ш. Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй - Харьцуулсан судалгаа. УБ., 2018
3. Сарантуяа Ц. Үндсэн эрх болон хүний эрх: Харьцуулалт, онолын эргэцүүлэл. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2000. №1
4. Баярсайхан Д. Эрүүгийн процессийн эрх зүй. УБ., 2020
5. Баярсайхан Д. Гадаад орнуудын эрүүгийн процесс. УБ., 2015
6. Лүндэндорж Н. Төрийн онол. УБ., 2020
7. Доржпалам Х. Монгол Улсын эрүүгийн эрх зүй - Ерөнхий анги. УБ., 2019
8. Эмнести интернэшнл. Шударгаар шүүлгэх эрх: Гарын авлага. УБ., 2010
9. Баярсайхан Д. Хүний эрхийн онолын сэтгэлгээ, уламжлал, шинэчлэлийн асуудал. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2000
10. Сэлэнгэ Х. Цэвэр эрх зүйн онол. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2010. №1-2 (18-19)
11. Мөнхсайхан О. Хууль дээдлэх ёс ба Монгол. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2020. №4 (52)
12. Бямбажаргал А. Эрх зүйн хэм хэмжээ орхигдуулсан буюу негатив хяналт ба Монгол Улсын жишиг. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2020. №3 (51)
13. Эрхэсхулан Ж. Шүүн шийдвэрлэх ажиллагаан дахь алдаа (Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд). “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2016. №1 (33)

### *Цахим эх сурвалж*

1. Эрх зүй мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn>
2. Хууль зүйн судалгаа бүтээлийн цахим сан, <https://legaldata.mn/>
3. Нээлттэй нийгэм форум. Эрүүгийн хууль дахь “Шударга ёсны зарчим”-ын хэрэгжилт зарим гэмт хэргийн жишээн дээр, 2020, [https://forum.mn/uploads/site/1126/res\\_mat/2021/RS\\_3.pdf](https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2021/RS_3.pdf)
4. Монгол Улсын ҮХЦ-ийн дүгнэлт №04: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2021.05.12/, <https://old.legalinfo.mn/law/details/16354?lawid=16354>

5. Монгол Улсын Их Хурлын тогтоол №42: Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай /2021.05.20/, <https://old.legalinfo.mn/law/details/16606?lawid=16606>
6. Монгол Улсын ҮХЦ-ийн тогтоол №07: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2021.10.20/, <https://old.legalinfo.mn/law/details/17056?lawid=17056>
7. Монгол Улсын Их Хурлын тогтоол №80: Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 07 дугаар дүгнэлтийн тухай /2021.10.28/, <https://old.legalinfo.mn/law/details/17027?lawid=17027>
8. R.C. van Caenegem. (2014). A note on chapter 39 of Magna Carta. [https://www.researchgate.net/publication/317450368\\_A\\_note\\_on\\_chapter\\_39\\_of\\_Magna\\_Carta](https://www.researchgate.net/publication/317450368_A_note_on_chapter_39_of_Magna_Carta)
9. World Justice Project (2022). The rule of law index. <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/global/2022/Mongolia/>
10. Нээлттэй нийгэм форум. Чухал сэдэв- Хэлэлцүүлгийн тэмдэглэл, 2022, <https://forum.mn/product/257155>

## IMPLEMENTATION OF THE RIGHT TO A FAIR TRIAL IN THE LAW ON CRIMINAL PROCEDURE

*Bolormaa.Kh*

*Ph.D. candidate, Senior lecturer, School of  
Law, NUM*

*Davaajargal.D*

*Researcher, Master's student, School of Law,  
NUM*

### ABSTRACT:

About the right to a fair trial of citizens is declared in the relevant provisions of the international treaties signed by Mongolia and in the 14th section of Article 16 of the Constitution of our country. The guarantee of this right is reflected in Article 1.1 of the “Law on criminal procedure”. The concept of a fair trial includes the guarantee that the case will be heard in a fair and open court. Whether the case was resolved fairly is expressed by the absence of any direct or indirect influence, pressure, or participation in the proceedings by any of the participants in the case. The right to a fair trial is one of the basic human rights, and this right is a concept inextricably linked with the concepts of “Justice”, “Human Rights”, and “The rule of law”, so valuing human rights and strictly maintaining equal rights and justice is the fundamental basis for the realization of these rights. However, the academic works written about the “right to a fair trial” usually have content that explains the right from the legal point of view of the Constitution, so through this work, the right to “trial by a fair court” is considered from the legal point of view of the criminal process. The implementation of this right is a detailed intended study.

### KEYWORDS:

The criminal process, The right to a fair trial, Human rights and freedoms, Law on criminal procedure

## ХУУЛЬ ЁСНЫ ИТГЭЛИЙГ ХАМГААЛАХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ ДЭХ ШҮҮХИЙН ХЯНАЛТ



**Б.Анирмаа**

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн  
магистрант, хуульч, өмгөөлөгч*



**Б.Билэгдэмбэрэл**

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5-р  
түвшиний оюутан*

### **ТОВЧЛОЛ:**

Захиргааны үйл ажиллагаанд “Хууль ёсны итгэлийг хамгаалах” зарчмыг баримтлаагүйн улмаас иргэдийн захиргаанд итгэх илтгэл буурах, захиргааны үйл ажиллагаа тогтворгүй болох, гарсан шийдвэр нь хожим эрх зүйн хүчин чадлаа алдах зэрэг сөрөг үр дагаврууд үүсэж байна. Үүнтэй холбоотойгоор өгүүлэлд тус зарчмын агуулга, онолын үндэслэл, шүүхээс захиргааны хэрэг маргааныг шийдвэрлэхэд тус зарчмыг нэгдмэл бус байдлаар хэрэглэж буй тохиолдлуудыг тус тус судалж, дүн шинжилгээ хийх замаар уг зарчмыг хэрэгжүүлэхэд анхаарвал зохих асуудлуудад дүгнэлт хийлээ.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим, хууль дээдлэх ёс, хууль хэрэглээний нэгдмэл байдал

## **I. ОРШИЛ**

Монгол Улсын Үндсэн хуулиар ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд баримтлах үндсийг тодорхойлсон. Эдгээр зарчмуудыг нийтийн захиргаанаас үйл ажиллагаандаа дагаж мөрдөхийн зэрэгцээ Захиргааны ерөнхий хуульд тусгагдсан тусгай зарчмууд болох хуульд үндэслэх; шуурхай, тасралтгүй байх; хуульд заасан төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байх; үр нөлөөтэй байх; зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх; бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах; ашиг сонирхлын зөрчилтэй захиргааны үйл ажиллагаанаас татгалзан гарах-боломжийг хангах; хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг нэгэн адил баримтална.

Захиргааны ерөнхий хуулиар тодорхойлсон “Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим” нь дотоодын эрх зүйн болоод захиргааны үйл ажиллагааны практикт уламжлалт бус эрх зүйн ойлголт юм. Хууль тогтоогчоос Захиргааны ерөнхий хуульд тус зарчмыг тусгайлан тусгасан хэдий ч захиргааны үйл ажиллагаанд баримтлахгүй байх, эсхүл нэгдсэн ойлголтоор тайлбарлаж, хэрэглэхгүй байх хууль зүйн практик нэгэнт бий болжээ. Захиргааны ерөнхий



хуулийн хэрэгжилтийн үр дагаварт 2018 онд Ханнс-Зайделийн сангийн дэргэдэх Эрх зүйн боловсрол академи үнэлгээ хийснээс хойш дахин үнэлсэн судалгааны тайлан гараагүй ч хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг дурдсан захиргааны хэргийн шүүхийн багагүй шийдвэр гарсан байна. Эдгээрийг судалж үзэхэд захиргааны хэргийн шүүхээс “Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим”-ыг зөрчсөн нэхэмжлэлийн үндэслэлтэй хэргийг хянан шийдвэрлэхэд уг зарчмыг тайлбарлахгүй,<sup>1</sup> маргааны үйл баримтад холбогдуулан дүгнэлт хийхгүй байх тохиолдол цөөнгүй байна. Тиймээс энэхүү өгүүллийн хүрээнд “Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим”-ын онолын үндэслэл, захиргааны хэргийн шүүхээс хэргийг шийдвэрлэхэд тус зарчмыг тайлбарлаж буй нөхцөл байдлыг тус тус судалж, харьцуулан дүн шинжилгээ хийх замаар уг зарчмыг нэгдмэл байдлаар тайлбарлаж хэрэглэхэд тулгамдаж буй асуудал, түүний сөрөг нөлөөллийг тодорхойлж, уг асуудлыг шийдвэрлэхэд анхаарах хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон болно.

## II. Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим

### 2.1. Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын агуулга, хэрэглээ

Хууль дээдлэх өс (*Rule of law*) нь эрх зүйн тогтолцоо тогтвортой байх, дүрэм журмууд нь ирээдүйд хэрэгжих үр нөлөөтэй байхыг шаарддаг<sup>2</sup> боловч нөгөө талаас дүрэм журам нь ач холбогдолгүй болох үед эсхүл нийтийн сайн сайхны төлөө шинэ хэрэгцээ шаардлага үүсэхэд<sup>3</sup> түүнд өөрчлөлт оруулдаг байхаар эрх зүйн тогтолцоог уян хатан<sup>4</sup> байхыг шаарддаг. Хуулийн энэхүү тогтвортой байдал ба уян хатан байдлын хоорондын зөрчилд хууль буцаан хэрэглэхгүй байх болон хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмууд яригдана.<sup>5</sup> Өөрөөр хэлбэл иргэний хуулийн дагуу хийсэн үйлдэл нь хууль, эрх зүйн акт өөрчлөгдсөнөөр дагаж өөрчлөгдөхгүй гэдэгт итгэлтэй байхыг итгэл хамгаалах зарчим гэдэгт хамаатуулан ойлгоно.<sup>6</sup>

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиар баталгаажуулж, ардчиллын суурь зарчмуудын нэг болгон хуульчилсан хууль дээдлэх өс нь нийтийн эрх мэдлийг хязгаарлаж, хувь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах баталгаа болох чадвартай учир эрх мэдлийг урвуулан ашиглах явдлаас сэргийлдэг.<sup>7</sup> Улмаар эрх зүйт ёсонд захирагдан амьдарч байгаагийн хувьд бид хуулиар тусгай эрх олж авсан захиргааны байгууллагын хууль ёсны шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй төдийгүй захиргааны байгууллагын шийдвэрт итгэх зүй ёсны эрхтэй.<sup>8</sup> Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.8-д заасан Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь Үндсэн хуулиас эхтэй, Үндсэн хуулийн эрх зүйд анх үүссэн хууль дээдлэх ёсны зарчмаас захиргааны эрх зүйд буюу захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах зарчим болон хөгжжээ. Тус зарчмын ач холбогдол, хэрэглээг тодорхойлохын тулд энэ зарчмын үүсэл хөгжил, хэрхэн тайлбарлаж хэрэглэж байсныг судлах нь арга зүйн ач холбогдолтой гэж үзлээ.

<sup>1</sup> www.shuukh.mn, Шүүхийн шийдвэрийн цахим сан, Анхан шатны шүүхийн шийдвэр, 2018.12.03. Дугаар 128/ШШ2018/0768; www.shuukh.mn, Шүүхийн шийдвэрийн цахим сан, Улсын дээд шүүхийн тогтоол, 2018.12.10. Дугаар 494

<sup>2</sup> Joseph RAZ, *The Authority of Law: Essays on Law and Morality*, Oxford University Press, Oxford, 2009, p. 214-216; John FINNIS, *Natural Law and Natural Rights*, 2nd edition, Oxford University Press, Oxford, 2011, p.270.

<sup>3</sup> Timothy ENDICOTT, *Vagueness in the Law*, Oxford University Press, Oxford, 2000, p. 193.

<sup>4</sup> Lon FULLER, *The Morality of Law*, Yale University Press, New Haven and London, 1969, p. 29.

<sup>5</sup> Jaime Phillips Letelier Prof. “The normative foundations of retroactivity and legitimate expectation in the uk administrative law”, *Revista de Derecho Público: Teoría y Método Marcial Pons Ediciones Jurídicas y Sociales*, 2023, p.84. <https://www.revistasmarcialpons.es/revistaderechopublico/article/download/retroactivity-and-legitimate-expectation-in-the-uk-administrativ/1793/4591>

<sup>6</sup> Д.Сүнжид (Ph.D), *Захиргааны ерөнхий хууль: Үзэл баримтлал, хэрэглээ*, 2017, 51 дэх тал.

<sup>7</sup> О.Мөнхсайхан (LL.D), *Хууль дээдлэх өс: Ерөнхий хандлага ба Монгол*, 2020, 5 дахь тал, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1936>

<sup>8</sup> Д.Баттулга, *Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим*, 2018, 1 дэх тал



Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын агуулга нь хууль баталгаатай байх гэсэн ойлголттой салшгүй холбоотой.<sup>9</sup> Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим захиргааны эрх зүйд өөрийн байр суурийг эзлэх болсноор судлаачид түүнийг захиргааны эрх зүйн зүрх<sup>10</sup>, шүүхийн практикт улам бүр нэр хүндтэй болж буй нийтийн эрх зүйн чухал зарчим<sup>11</sup> гэх зэргээр ач холбогдлыг нь тодорхойлжээ. Гэхдээ тус зарчмын үзэл санаа, хэрэглээ одоог хүртэл хөгжсөөр байгаа тул ямар тохиолдолд хууль ёсны итгэл үүссэн гэж үзэх, ямар маргаанд хэрэглэх вэ гэдэг нь манай улсын төдийгүй олон улсад эцэслэн тодорхойлогдоогүй байна.

Захиргааны байгууллага өөрт олгогдсон эрх мэдлээ урвуулан ашиглаж шийдвэр гаргахаас сэргийлэх зорилгоор хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг Английн эрх зүйн тогтолцоотой улсуудад шүүхүүд хэрэглэх замаар хөгжүүлж байна.<sup>12</sup> Тухайлбал, 1987 онд Европын Хүний Эрхийн Шүүх *Council of Civil Service Unions v. Minister for the Civil Service*<sup>13</sup> хэргийг шийдвэрлэхдээ хууль ёсны бөгөөд үндэслэлтэй итгэл нийтийн захиргааны байгууллагын нэрийн өмнөөс өгсөн амлалтаас эсхүл нэхэмжлэгч ердийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлж болно гэсэн үндэслэлтэй хүлээлт<sup>14</sup> буюу тогтсон практикаас үүсч болно гэж үзсэн. Мөн 1983 оны *Attorney General of Hong Kong v Ng Yuen Shi*<sup>15</sup> хэргийн шийдвэрт захиргааны байгууллага өөрийн хэлсэн үгэндээ хариуцлага хүлээх ёстой буюу амлалт нь хууль ёсны итгэлийг бий болгох боломжтой<sup>16</sup> гэж үзсэн сонгодог кейс гэж үздэг. Дээрх амлалт, практикаас гадна төрийн бодлого нь хууль ёсны итгэлийг бий болгох арга зам болохыг 1984 оны *R v Home Secretary, ex p Khan*<sup>17</sup> хэргийн шийдвэр харуулдаг. Тодруулбал, Их Британийн цагаач гэр бүл Пакистанаас дүүгийнхээ хүүхдийг үрчлэн авах хүсэлт гаргасныг Дотоод хэргийн яам хүлээн авахаас татгалзсан бөгөөд тухайн үед Их Британийн цагаачлалын журамд хүүхэд үрчлэн авахтай холбоотой заалт байгаагүй, харин Их Британийн хуулийн дагуу хүүхэд үрчлэн авахад тавигдах нөхцөл шаардлагыг хүсэлт гаргагч хангасан байсан. Энэ тохиолдолд шүүхээс цагаач иргэн хүүхэд үрчлэхтэй холбоотой тухайлсан журам, хязгаарлалт байгаагүй нь хүсэлт гаргагчид хууль ёсны итгэл үүсгэсэн бөгөөд итгэл хамгаалах зарчмыг зөрчсөн гэж үзэж Дотоод хэргийн яамны хүүхдэд нэвтрэх зөвшөөрөл олгохоос татгалзсаныг хүчингүй болгосон.

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг зарим судлаачид эрх зүйн хамгаалалтын зарчмын нэг хэсэг гэж үзээд эрх зүйт төрийн зарчимтай холбон тайлбарладаг байхад нөгөө хэсэг нь үндсэн эрхтэй холбон тайлбарладаг.<sup>18</sup> Тухайлбал, Герман, Грек, Латви, Польш, Бельги, Словени улсуудад<sup>19</sup> хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь Үндсэн хуульд

<sup>9</sup> Т.Мөнх-Эрдэнэ, Г.Гэсэр, “Монгол Улсын захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим”, 2019, 2 дахь тал. <https://legaldata.mn/buteel/pdf?id=618>

<sup>10</sup> Farrah Ahmed, Adam Perry, “The coherence of the doctrine of legitimate expectations”, 2014, [https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract\\_id=2163255](https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2163255)

<sup>11</sup> Peter Leyland, *Textbook on Administrative Law*, Seventh Edition, p.353. <https://facultymembers.sbu.ac.ir/jalali/wp-content/uploads/2016/02/129.pdf>

<sup>12</sup> Aakansha Kumar Uchariya, “Comparative analysis of doctrine of legitimate expectation”, 2022. <https://www.ijrti.org/papers/IJRTI2205037.pdf>

<sup>13</sup> Council of Civil Service Unions v. Minister for the Civil Service [1985] AC 374. [https://hudoc.echr.coe.int/eng#%7B%22item\\_id%22:%7B%22001-389%22%7D%7D](https://hudoc.echr.coe.int/eng#%7B%22item_id%22:%7B%22001-389%22%7D%7D) Их Британийн Төрийн албаны Үйлдвэрчний эвлэлийн зөвлөл, төрийн зарим албан хаагч нарын нэхэмжлэлтэй хэрэг.

<sup>14</sup> A.K.Srivastava, Doctrine of “Legitimate Expectation”, 1995, p.1, <https://ijtr.nic.in/articles/art13.pdf> дам эшлэв.

<sup>15</sup> *Attorney-General of Hong Kong v Ng Yuen Shiu* [1983] 2 AC 629 (PC) Тус хэрэгт Хонконгийн Засгийн газар хууль бус цагаачдыг албадан гаргах эсэхээ тухайн хэрэг тус бүрийн үндэслэлийг харгалзан шийдвэрлэнэ гэж амласан бөгөөд энэхүү амлалт нь нэхэмжлэгчид нэхэмжлэл гаргаж чадна гэх хууль ёсны итгэлийг бий болгосон байсан. Гэтэл ийнхүү амласан дагуу нэхэмжлэгчээс тайлбар авахгүйгээр түүнийг албадан гаргах тогтоол гаргасныг шүүхээс хууль ёсны итгэл үүссэн гэж үзэж, тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

<sup>16</sup> Farrah Ahmed, Adam Perry, “The coherence of the doctrine of legitimate expectations”, 2014, p4, [https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract\\_id=2163255](https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2163255)

<sup>17</sup> *R v Home Secretary, ex p Khan* [1984] 1 WLR 1337 (CA). <https://www.uniset.ca/other/cs2/19841WLR1337.html>

<sup>18</sup> П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 2008, 94 дэх тал.

<sup>19</sup> The Protection of Legitimate Expectations in Administrative Law and EU Law, April 2016, p3. [https://www.aca-europe.eu/seminars/2016\\_Vilnius/VIL\\_GeneralReport\\_en.pdf](https://www.aca-europe.eu/seminars/2016_Vilnius/VIL_GeneralReport_en.pdf)

тусгалаа олсон, Үндсэн хуулийн зарчимд үндэслэсэн гэж үздэг бол Мөн Энэтхэг улсын дээд шүүхийн шийдвэрлэсэн нэгэн хэрэгт хууль дээдлэх ёс (*Rule of law*)-оос үүсэлтэй хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын дагуу захиргааны байгууллагыг олон нийттэй харилцах харилцаанд тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой байхыг шаарддаг гэжээ.<sup>20</sup> Харин Финланд, Унгар, Болгар, Латви, Монтенегро улс<sup>21</sup> энэ зарчмыг захиргаа болон иргэн, хуулийн этгээд хоорондын эрх зүйн харилцаанд хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн зарчим гэж үзэж байна.

Дүгнэвэл, захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь хууль тогтоомж өөрчлөгдөх тухай бүрд иргэдэд дарамт учруулахаас хамгаалах чухал ач холбогдолтойн дээр захиргааны байгууллага шийдвэр гаргалт, үйл ажиллагаандаа үнэнч, шударга, хариуцлагатай хандахыг сануулдаг. Иймд тус зарчим иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг захиргааны байгууллагын тогтворгүй, хууль зөрчсөн үйл ажиллагаанаас хамгаалах захиргааны эрх зүйн үндсэн зорилгыг өөртөө агуулдаг байна.

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын суурь нь “хууль ёсны итгэл” юм. Хууль ёсны итгэл нь процессийн (procedural) болон материаллаг (substantive) байж болно.<sup>22</sup> Процессийн хууль ёсны итгэл нь захиргааны байгууллагын үйл ажиллагаанаас үүдэн болох бөгөөд захиргаанаас аливаа шийдвэр гаргахын өмнө тодорхой журам, дарааллын дагуу ажиллана, шийдвэр гаргахаас өмнө мэдэгдэх, сонсох ажиллагаа хийнэ гэсэн хүлээлт үүссэн үед бий болдог. Мөн түүнчлэн процессийн хууль ёсны итгэл нь материаллаг эрх зүйн хувьд хууль бус болсон хэдий ч захиргааны шийдвэр процедурын хувьд зөв гарсан байх тохиолдлыг хамардаг. Жишээлбэл, Захиргааны ерөнхий хууль, Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохын өмнө эрх бүхий этгээдээс урьдчилан мэдэгдэж, мэдэгдэл ирүүлэх, мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзвэл тайлбар, холбогдох баримт бичгийг хүргүүлэх ажиллагаа хийгдэнэ, ийм ажиллагаа хийгдээгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл хүчингүй болохгүй гэж итгэх нь үүнд хамаарна.

Харин материаллаг хууль ёсны итгэл гэдэг нь тухайн захиргааны байгууллага бодит асуудал дээр өөрийн тогтсон байр суурь, бодлогын дагуу ажиллана гэсэн хүлээлт бий болсон тохиолдолд хамаарах итгэлийг хэлнэ.<sup>23</sup> Өөрөөр хэлбэл, материаллаг хууль ёсны итгэл нь иргэд захиргааны байгууллагаас тодорхой үр дүн хүлээж байх үед<sup>24</sup> буюу ашиг тус, давуу талыг эдэлж байгаа хүн түүнийгээ үргэлжлүүлэн авах болно гэж маргах үед, эсвэл тухайн хүн ямар нэгэн ашиг тус, давуу талыг хараахан хүртээгүй байгаа боловч түүнийг хүртэх нь зөв гэж үзэж маргах тохиолдолд<sup>25</sup> бий болдог. Жишээлбэл, зохицуулагч байгууллага компанийг тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулах боломжийг 5 жилийн хугацаанд олгосон бөгөөд энэ хугацаанд нэмэлт зохицуулалт бий болгоогүй. Энэхүү зохицуулагч байгууллагын өмнөх үйл ажиллагаа болон шинэ дүрэм, журам батлаагүй нь компанид цаашид тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа үргэлжлүүлж болно гэх итгэлийг бий болгосон. Хэрэв зохицуулагч байгууллага энэ итгэлийг зөрчиж, компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх шийдвэр гаргасан тохиолдолд компани материаллаг хууль ёсны итгэл зөрчсөн гэж маргаж болно.

<sup>20</sup> Usha Anarhvedi, “Judicial review of administrative actions and principles”, 2008, p.10, (Chanchal Goyal (Dr) v. State of Rajasthan, (2003) 3 SCC 485). [https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract\\_id=1104955](https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=1104955)

<sup>21</sup> The Protection of Legitimate Expectations in Administrative Law and EU Law, April 2016, p4. [https://www.aca-europe.eu/seminars/2016\\_Vilnius/VIL\\_GeneralReport\\_en.pdf](https://www.aca-europe.eu/seminars/2016_Vilnius/VIL_GeneralReport_en.pdf)

<sup>22</sup> John C Robertson, “Legitimate expectations”, 1990, p.158. [https://journals.co.za/doi/pdf/10.10520/AJA02586568\\_213](https://journals.co.za/doi/pdf/10.10520/AJA02586568_213)

<sup>23</sup> Robert Thomas, The Protection of Legitimate Expectations in UK Administrative Law, 2012,

<sup>24</sup> ALISON L.YOUNG, “Stuck at a crossroad? substantive legitimate expectations in english law”, *Cambridge Law Journal*, 80(S1), 2021, p.186. <https://www.cambridge.org/core/services/aop-cambridge-core/content/view/AF53BD9A32B44DBFF47446F2685B5C04/S000819732100057Xa.pdf/stuck-at-a-crossroad-substantive-legitimate-expectations-in-english-law.pdf>

<sup>25</sup> Chaminda Jayasinghe, “Making sense of the concept of substantive legitimate expectation”, 2013, p.9. [https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract\\_id=2276592](https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2276592)

Дээр дурдсан хууль ёсны итгэлийн хоёр байдал нь итгэл бий болох үйл явцаараа ялгагдана. Өөрөөр хэлбэл, процессийн хууль ёсны итгэл нь хувь хүн тодорхой үйл явцын талаар хүлээлттэй байх үед үүсдэг бол материаллаг хууль ёсны итгэл нь тодорхой үр дүнг хүлээж байгаа үед үүсдэг<sup>26</sup> байна. Гэхдээ дээрх 2 хууль ёсны итгэлийн байдал нь практикт хоорондоо уялдаатай, бүр нэгдэх хандлагатай байж болно.<sup>27</sup>

Нөгөөтэйгөөр, захиргааны байгууллага эрх мэдлээ хэрхэн хэрэгжүүлэх талаар иргэдэд итгэл буюу хүлээлт бий болж, тэрхүү итгэлд найдсанаараа хохирох тохиолдолд шүүх хөндлөнгөөс оролцож төрийн байгууллагуудыг өөрсдийн бий болгосон хууль ёсны итгэлийг биелүүлэхийг албадах буюу иргэдэд бий болсон хууль ёсны итгэлийг хамгаалах<sup>28</sup> хэмээн ойлгож байна. Мөн хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь захиргааны байгууллагын үйл ажиллагаанд итгэсэн хүмүүсийг хамгаалах замаар захиргааны байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилготой.<sup>29</sup> Тийм ч учир энэхүү зарчмын дагуу захиргааны байгууллага өгсөн амлалт болон өнгөрсөнд хийсэн тогтвортой үйл ажиллагаанаас үүдэн иргэдэд бий болсон хууль ёсны итгэлийн дагуу үйл ажиллагаагаа явуулах үүрэг хүлээдэг.<sup>30</sup> Үүнээс үзвэл иргэд захиргааны байгууллагын хууль бус, тогтворгүй үйл ажиллагааны улмаас эрх, эрх чөлөөгөө зөрчигдөхөөс хамгаалуулах баталгаатай байх, ийм итгэлтэй байх нь уг зарчмын гол зорилго юм.

## 2.2. Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын хамрах хүрээ

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим дараах хэд хэдэн урьдчилсан нөхцөлийг хангасан тохиолдолд үйлчилнэ. Нэгдүгээрт, иргэн, хуулийн этгээдэд эдийн болон мөнгөн үр дагавар үүсгэж буй захиргааны акт<sup>31</sup> байх шаардлагатай. Тухайлбал, Улсын Дээд шүүх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын агуулгыг “захиргааны байгууллагаас ямар нэгэн итгэл хүлээлгэсэн тодорхой захиргааны акт гаргасан тохиолдолд уг зарчим хэрэгжих боломжтой<sup>32</sup>” хэмээн тайлбарлан хэрэглэж байна. Үүнээс үзвэл нэхэмжлэгч иргэн захиргааны байгууллагын хууль бус эс үйлдэхүйн улмаас шүүхэд даалгах нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдолд иргэнд хамгаалагдах хууль ёсны итгэл үүсэхгүй гэж шүүх үзжээ.

Хоёрдугаарт, хууль бусаар бий болсон итгэлийг хамгаалахгүй. Тодруулбал, хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын хүрээнд захиргааны байгууллага хуулийн дагуу хийж чадахгүй зүйлээ амлах, эрх олгогдоогүй буюу зөвшөөрөлгүй этгээд амлалт өгөх зэрэг тохиолдолд хууль ёсны итгэл хамгаалагдахгүй юм.<sup>33</sup> Өөрөөр хэлбэл захиргааны байгууллагад хууль тогтоомжоор оногдуулсан нийтийн чиг үүргүүдтэй нь зөрчилдөх тохиолдолд энэхүү зарчим хэрэгжихгүй.<sup>34</sup> Гуравдугаарт, тус зарчим нь иргэнд эерэг үр дагавар үүсэхээр байсан ч иргэн, захиргаа хоорондын харилцаа аль хэдийн дуусгавар болсон тохиолдолд үйлчлэхгүй<sup>35</sup>. Тухайлбал, материаллаг бус харилцаа болох иргэний харьяалал олгох, тусгай зөвшөөрөл олгох зэрэг харилцаанд үйлчлэхгүй юм. Дөрөвдүгээрт, хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь зарим хууль, дүрэм журамд гэхээсээ илүү

<sup>26</sup> Мөн тэнд.

<sup>27</sup> John C Robertson, “Legitimate expectations”, 1990, p.158. [https://journals.co.za/doi/pdf/10.10520/AJA02586568\\_213](https://journals.co.za/doi/pdf/10.10520/AJA02586568_213)

<sup>28</sup> Matthew Groves, “Substantive Legitimate Expectations in Australian Administrative Law” (2008) 15 *MelbULawRw* 32(2) 470, <http://www5.austlii.edu.au/au/journals/MelbULawRw/2008/15.html>

<sup>29</sup> Paul Reynolds, “Legitimate Expectations and the Protection of Trust in Public Officials” (2011) 2 *Public Law* 330, 340-41

<sup>30</sup> Foram R. Patel, Rishin Patel, “The doctrine of legitimate expectation: from development in England to Indian scenario”, *ILI Law Review*, Winter Issue 2021, p.1. [https://ili.ac.in/pdf/win21\\_8.pdf](https://ili.ac.in/pdf/win21_8.pdf)

<sup>31</sup> Т.Мөнх-Эрдэнэ, Г.Гэсэр, “Монгол Улсын захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим”, 2019, 6 дахь тал. <https://legaldata.mn/buteel/pdf?id=618>

<sup>32</sup> [www.shuukh.mn](http://www.shuukh.mn), Шүүхийн шийдвэрийн цахим сан, Улсын дээд шүүхийн хуралдааны тогтоол, 2019.04.01, Дугаар 95

<sup>33</sup> Peter Leyland, Gordon Anthony, *Textbook on Administrative Law*, Seventh Edition, 2016, p.368 <https://faculty.members.sbu.ac.ir/jalali/wp-content/uploads/2016/02/129.pdf>

<sup>34</sup> A Perry and F Ahmed, “The Coherence of the Doctrine of Legitimate Expectations” *Cambridge Law Journal*, 2014, Revisiting FIRS vs Halliburton – For the Records. <https://www.proshare.co/articles/revisiting-firs-vs-halliburton-for-the-records?menu=Finance&classification=Read&category=Personal%20Tax>

<sup>35</sup> Захиргааны ерөнхий хуулийн 4.2.8. ... Харин энэ хуулийн 48.2-т заасан тохиолдол үүсвэл захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн итгэл хамгаалагдахгүй. Иргэн, хуулийн этгээдэд эерэг үр дагавар үүсэхээр байсан ч уг харилцаа дууссан бол итгэл хамгаалах зарчим хэрэглэгдэхгүй.

бодлого, нийтийн ашиг сонирхолд гарсан өөрчлөлтөд хамаарна.<sup>36</sup>

Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны итгэл бий болох гурван арга зам бий гэж үздэг.<sup>37</sup> Үүнд:

1. Төрийн эрх баригчид тодорхой арга замаар ажиллана, эсвэл ажиллахгүй гэдгээ “тодорхой бөгөөд хоёрдмол утгагүй” илэрхийлэх;
2. Төрийн байгууллага практикаараа дамжуулан хүлээлт үүсгэх буюу тодорхой хугацааны туршид хэрэгжсэн, хэвшсэн байдал бий болгох;
3. Тухайн цаг үед хэрэгжиж байсан бодлого нь өөрчлөгдөх тохиолдолд өмнөх бодлогоор захиргааны байгууллага өөрт нь амлалт өгсөн бол амлалтаа хэрэгжүүлнэ гэж найдах;

Нөгөө талаас хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэж шийдвэрлэсэн тохиолдлуудыг ерөнхийд нь 4 төрөлд хуваан авч үздэг<sup>38</sup>. Нэгдүгээрт, тухайн иргэн нийтлэг хэрэглэгддэг бодлого эсхүл дүрэм журамд найдаж байсан боловч өөр бодлого эсхүл дүрэм журамд хамаарагдсан байх явдал. Хоёрдугаарт, эхнийхээс ялгаатай нь нийтлэг хэрэглэгддэг бодлого эсхүл дүрэм журам нь хэвээр үйлчилж байгаа боловч тухайн тохиолдолд хэрэгжээгүй явдлыг хамаатуулна. Гуравдугаарт, иргэнд өгсөн амлалт, эсвэл дүрэм журам нь өөрчлөгдсөний улмаас бий болсон тохиолдол. Дөрөвдүгээрт, захиргааны шийдвэр гаргагч тухайн тохиолдолд өгсөн амлалтынхаа талаарх бодлоо өөрчилсний улмаас бий болсон тохиолдол. Иймд дээр дурдсан дөрвөн тохиолдолд хамаарахгүй тохиолдолд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим үйлчлэхгүй гэж үзэж болохоор байна.

Дүгнэвэл, захиргаа нь зөвхөн хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд, хууль тогтоогчоос зөвшөөрсөн үйл ажиллагааг явуулах үүрэг хүлээнэ. Энэ үүргийг хэрэгжүүлэх явцад иргэн, хуулийн этгээдэд итгэл хэрхэн бий болсныг тохиолдол бүрд шалгаснаар тус зарчмын хамрах хүрээ тодорхойлогдохоор байна.

### III. Монгол Улс дахь зохицуулалт, түүний хэрэгжилт: тогтож буй практик

#### 3.1 Монгол Улс дахь хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын зохицуулалт

Нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас иргэдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь харилцааг зохицуулах Захиргааны ерөнхий хууль 2015 онд батлагдан хэрэгжиж эхэлснээр Монгол Улсын Захиргааны эрх зүйн тогтолцоо, системчлэлийн хувьд бүрэн болсон<sup>39</sup>. Монгол Улсад хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хуульчлах болсон зорилго нь эрх зүйт төрийн хууль тогтоомжийн хүрээнд иргэн, хуулийн этгээдэд үүсдэг хууль ёсны итгэлийг захиргааны байгууллага хүндэтгэж, хамгаалж ажиллах явдлыг бэхжүүлэх явдал<sup>40</sup> гэж үздэг.

Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.8-д захиргааны үйл ажиллагаанд “Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим”-ыг баримтлахаар заажээ. Мөн заалтын аутентик<sup>41</sup> тайлбарт “Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим гэж нийтийн эрх зүйн аливаа харилцаанд захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдэд эдийн буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эрх зүйн үр дагавар үүссэн тохиолдлыг ойлгоно. Харин энэ хуулийн 48.2-т заасан тохиолдол үүсвэл захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн

<sup>36</sup> Aakash Kumar Uchariya, “Comparative analysis of doctrine of legitimate expectation”, 2022, p.219. (Madras city wine Merchants association v. State of Tamil Nadu (1994) 5 SCC 50) <https://www.ijrti.org/papers/IJRTI2205037.pdf>

<sup>37</sup> Richard Clayton, “Legitimate expectations, policy, and the principle of consistency”, *The Cambridge Law Journal*, Vol. 62, No. 1, 2003, p.95. [https://www.jstor.org/stable/4508971?read-now=1&seq=1#page\\_scan\\_tab\\_contents](https://www.jstor.org/stable/4508971?read-now=1&seq=1#page_scan_tab_contents)

<sup>38</sup> Matthew Groves, “Substantive Legitimate Expectations in Australian Administrative Law” (2008), p.473

<sup>39</sup> Ц.Цогт, “Захиргааны ерөнхий хууль: Боловсруулсан үе шат, үзэл баримтлал, хэрэгжилт, хүлээгдэж буй ач холбогдол”, 2019, 34 дэх тал.

<sup>40</sup> “Эрх зүйн боловсрол” академи, Ханнс-Зайделийн сан, “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ”, 2018, 68 дахь тал.

<sup>41</sup> С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, анхны хэвлэл, 648 дахь тал. Энэ нь аутентич гэсэн үгнээс гаралтай, холбоотой байна. Аутентич гэдэг нь (Анг: Authenticity) жинхэнэ, анхдагч эх сурвалжид нийцсэн гэсэн үг байна.

итгэл хамгаалагдахгүй. Иргэн, хуулийн этгээдэд эерэг үр дагавар үүсэхээр байсан ч уг харилцаа дууссан бол итгэл хамгаалах зарчим хэрэглэгдэхгүй” гэж зааснаар тус зарчмын хүрээг тодорхойлсон. Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2-т Эерэг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны актыг хүчингүй болгох тохиолдлыг нэрлэн заажээ.<sup>42</sup>

### 3.2 Монгол Улс дахь практик

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-76 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”<sup>43</sup>-ын 6.7-д “Захиргааны ерөнхий хуулийн 4.2.8-д заасан хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам”-ын дагуу байгуулагдсан Төсөл сонгон шалгаруулах хорооны хурлаас шалгарч дэмжигдсэн боловч санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцээгүйн улмаас санхүүжигдээгүй төслүүдэд тухайн төсөл сонгон шалгаруулалтад тавьсан нөхцөл, болзлын дагуу зээлийн санхүүжилтийг нөхөн олгож болно.” гэж заасан байна. Энэхүү журам хүчингүй болсон бөгөөд одоогоор Монгол Улсад хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг дурдсан өөр ямар нэгэн захиргааны байгууллагын хүчин төгөлдөр шийдвэр нээлттэй байхгүй байна.

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 03 дугаар дүгнэлтэд<sup>44</sup> “Европын Холбооны Венецийн комиссоос Европын орнууд болон бусад хэд хэдэн орны хууль тогтоомжийн хүрээнд 2015 онд хийсэн гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон этгээдийн парламентад нэр дэвших эрхийг хязгаарлах талаарх судалгаанд нийтийн ашиг сонирхлын эсрэг, эсхүл ноцтой гэмт хэрэг үйлдсэн хүнээр улс төрийн (тухайн улсын нийт иргэн, улсын ашиг сонирхлын хүрээнд) шийдвэр гаргуулахгүй байх нь олон нийтийн ашиг сонирхолд нийцэх бөгөөд энэ нь иргэдийн хууль ёсны итгэлийг хамгаалах нийтийн эрх зүйн зарчимд үндэслэгдэнэ гэжээ.” хэмээн олон улсын туршлагыг үндэслэл болгож, хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг дурдсан байна.

2012 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д “Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтны гаргасан алдааны улмаас илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг шүүхийн журмаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.” гэж заасан нь хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын нэг илрэл гэж үзэж болохоор байна. Тодруулбал, тухайн иргэн халамжийн мөнгийг өөрт нь хууль ёсны дагуу олгогдсон хэмээн итгэж зарцуулсан байх боломжтой тул илүү авсан тэтгэмжийг төлөх үүргийг иргэнд ногдуулахгүйгээр захиргааны байгууллагын буруутай этгээдэд үүрэг бий болгосон байна. Иймд Захиргааны ерөнхий хуулиас гадна хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын үзэл санаа энэ хуульд байсан болох нь харагдаж байна.

#### 3.1.2. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 2 жилийн дотор Захиргааны хэргийн шүүх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчимд үндэслэн хэрэг

<sup>42</sup> Захиргааны ерөнхий хууль, 2015.

48.2.Эерэг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны актыг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

48.2.1.хууль, захиргааны хэм хэмжээний актаар, эсхүл захиргааны актад түүнийг хүчингүй болгохоор заасан;

48.2.2.бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн;

48.2.3.захиргааны актаар олгосон эрхийг хэрэгжүүлээгүй;

48.2.4.захиргааны актыг гаргуулахдаа хууран мэхлэх, айлган сүрдүүлэх, авлига өгөх буюу бусад хууль бус аргыг хэрэглэсэн;

48.2.5.нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан.

<sup>43</sup> Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам, 2017.

<sup>44</sup> Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.2.9, 32.3.11 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15323>



шийдвэрлэсэн зөвхөн 1 тохиолдол байсан<sup>45</sup> бол энэ өгүүллийг бичих үеийн байдлаар Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийж үзэхэд<sup>46</sup> хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг дурдаж, тайлбарласан нэлээдгүй шүүхийн шийдвэр байна. Өгүүллийн энэ хэсэгт хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг шүүхүүд хэрхэн хэрэглэж, тайлбарлаж байгаа болохыг үзүүлэхээр Улсын Дээд шүүхийн 2, анхан шатны шүүх 1 тогтоолыг сонгон авч дүн шинжилгээ хийлээ.

**1) УДШ, №2020.02.19, №001/ХТ2020/0088 тогтоол<sup>47</sup>**

**Хэргийн агуулга:** Нэхэмжлэгч “Н” ХХК-д Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/130 дугаар захирамжаар тус компанийн хүсэлтийн дагуу 200 тонн барагшуныг түүж бэлтгэх зөвшөөрлийг олгосон бөгөөд тус зөвшөөрлийн дагуу “Н” ХХК нь барагшуныг түүж бэлтгэсэн. Гэвч 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр БОАЖС-ын “Барагшуныг түүж бэлтгэх, экспортлохыг түр хугацаагаар хориглох тухай” А/86 дугаар тушаал гарч барагшуныг 5 кг-аас дээш хэмжээгээр гадаад улсад гаргах зорилгоор түүж бэлтгэх, боловсруулах экспортлохыг 5 жилийн хугацаагаар хоригложээ. Нэхэмжлэгч компани БОАЖС-д хандаж “... 200 тн барагшун бэлтгэсэн тул зөвшөөрөл олгоно уу” хэмээн хүсэлт гаргахад 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 06/2874 дүгээр албан бичгээр А/86 дугаар тушаалыг үндэслэн тус компанид нийт 50 тн барагшуныг экспортлох зөвшөөрлийг олгож, үлдсэн 150 тн барагшунд зөвшөөрөл олгох боломжгүй гэсэн хариу өгсөн. Иймд нэхэмжлэгч нь “Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн “Зөвшөөрөл олгохоос татгалзах тухай” 06/2874 дүгээр шийдвэрийг хүчингүй болгуулах, 142.32 тн барагшуныг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгохыг хариуцагчид даалгах” нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд гаргасан байна.

**Шүүхийн шийдвэрийн агуулга:** Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Улсын Дээд шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг тухайлан тайлбарлахгүйгээр “... Хариуцагч нь нэхэмжлэгчид барагшуныг анх түүж бэлтгэх зөвшөөрөл олгосон хэмжээгээр нь экспортод гаргах зөвшөөрөл олгох үүрэггүй, нэхэмжлэгчид 50 тн барагшуныг хориглосон хугацаанд экспортод гаргахыг зөвшөөрсөн зэргээс үзэхэд дахин нэмж экспортод гаргах зөвшөөрөл олгохоос татгалзсан хариуцагчийн үйлдэл хуульд нийцсэн” хэмээн үзсэн байна. Харин Улсын Дээд Шүүхийн шүүгчийн тусгай саналд<sup>48</sup> “Иргэн, хуулийн этгээд нь төрийн хууль тогтоомж, шийдвэрт итгэсний үндсэн дээр хөрөнгө оруулалт, худалдан авалт хийх, үйл ажиллагаагаа өргөтгөх, төлөвлөх зэргээр тодорхой хэмжээний зарлага гаргадаг, иймд энэхүү иргэдийн итгэл хамгаалагдах ёстой. Нэхэмжлэгч компани нь төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр 200 тн барагшуныг А/86 дугаар тушаал батлагдахаас өмнө түүж бэлтгэсэн, ийнхүү түүж бэлтгэхэд тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулсан, мөн цаашдын үйл ажиллагаагаа төлөвлөсөн зэрэг нөхцөл байдал нь хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын агуулга, хэрэгжих хүрээнд хамаарч байна.” хэмээн хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим тухайн тохиолдолд зөрчигдсөн гэж үзжээ.

**Дүн шинжилгээ:** Дээрх хэргийн тухайд Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/130 дугаар захирамжаар нэхэмжлэгчид 200 тн барагшун бэлтгэх зөвшөөрөл олгосноор нэхэмжлэгчид түүсэн барагшуныг экспортолж

<sup>45</sup> “Эрх зүйн боловсрол” академи, Ханнс-Зайделийн сан, “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ”, 2018, 9 дэх тал. [https://mongolia.hss.de/fileadmin/user\\_upload/Projects\\_HSS/Mongolia/Dokumente/2018/Zakhirgaanii\\_yerenkhii\\_huuli\\_sudalгаа\\_niit.pdf](https://mongolia.hss.de/fileadmin/user_upload/Projects_HSS/Mongolia/Dokumente/2018/Zakhirgaanii_yerenkhii_huuli_sudalгаа_niit.pdf)

<sup>46</sup> Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангаас 2024.08.02-ны өдрийн байдлаар “итгэлийг хамгаалах зарчим”, “итгэл хамгаалах зарчим” гэх утгаар шүүлт хийхэд нийт 974 шүүхийн шийдвэр гарч ирсэн.

<sup>47</sup> [www.shuukh.mn](http://www.shuukh.mn), Шүүхийн шийдвэрийн цахим сан, Улсын дээд шүүхийн хуралдааны тогтоол, 2020.02.19, Дугаар 001/ХТ2020/0088

<sup>48</sup> Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тусгай санал: “Н” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт Захиргааны ерөнхий хуульд заасан “зорилгодоо нийцсэн,...”, “хууль ёсны итгэл хамгаалах” зарчмуудыг тайлбарлан хэрэглэх тухай

болно гэх итгэлийг бий болгожээ. Улмаар зөвшөөрөлтэй тул барагшун бэлтгэх хооронд захиргааны байгууллагын зүгээс холбоотой дүрэм, журам өөрчлөгдөнө гэсэн хүлээлтгүй байсан ч хариуцагчаас барагшун түүж бэлтгэх, экспортлохыг түр хугацаанд хориглосон нь нэхэмжлэгч түүсэн барагшунаа экспортлож чадахгүй болж, улмаар эдийн засгийн алдагдал хүлээх эрсдэлтэй нөхцөлийг бий болгожээ. Энэ тохиолдолд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын хоёр урьдчилсан нөхцөл болох итгэл хууль ёсоор бий болсон, хуулийн этгээдэд эдийн болон мөнгөн үр дагавар үүсгэж буй захиргааны акт байх шинжүүд хангагдаж байхаас гадна онолын хэсэгт дурдсан хууль ёсны итгэл үүсэх “төрийн эрх баригчид тодорхой арга замаар ажиллана, эсхүл ажиллахгүй гэдгээ тодорхой бөгөөд хоёрдмол утгагүй илэрхийлэх” гэх агуулгад хамаарч байна.

Захиргааны байгууллагаас дүрэм, журмыг зайлшгүй тохиолдолд буюу хэрэгцээгүй болсон, нийтийн ашиг сонирхлын үүднээс өөрчлөх нь зөвшөөрөгддөг боловч сүүлд хүчин төгөлдөр болсон дүрэм, журмын хувьд иргэдийн материаллаг ашиг сонирхол хөндөгдөж байгаа энэ тохиолдолд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим хэрэгжих боломжтой байна. Учир нь захиргааны шийдвэр болгон хуулийн үндэслэлтэй байх гээд хүний эрхэд үндэслэлгүйгээр халдсан байх ёсгүй тул энэ тохиолдолд захиргааны шүүх маргаан бүхий актыг гаргахдаа шийдвэр гаргах ажиллагааны журмыг баримталсан эсэхийг дүгнэхээс гадна захиргааны үйл ажиллагааны зарчмыг баримталсан эсэхэд дүгнэлт өгөх учиртай. Иймд захиргааны байгууллагын үйл ажиллагааны гэнэтийн өөрчлөлтөд иргэн хохирч үлдэхээс хамгаалах “хууль ёсны итгэлийг хамгаалах” зарчмыг шүүгч тусгай саналдаа дурдсан нь тус зарчмын хэрэглээнд чухал ач холбогдолтой байна.

## 2) УДШ, №2021.02.24, №001/ХТ2021/0051 тогтоол<sup>49</sup>

**Хэргийн агуулга:** Нэхэмжлэгч Д.А нь Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу 2561 м<sup>2</sup> газрыг 2014 оноос 2019 он хүртэл 5 жилийн хугацаатай, зуслангийн зориулалтаар эзэмшиж, 2019 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын захирамжаар дахин газар эзэмших эрхийн хугацааг 15 жилээр сунгаж, эзэмшил газрын хэмжээг 20862 м<sup>2</sup> болгон томруулсан. Гэтэл 2019 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр Нийслэлийн Засаг даргын А/902 дугаар захирамжаар Д.А-д анх олгосон газар нь бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцацан хэмээн газар эзэмших эрхийн гэрчилгээг нь хүчингүй болгосон байна. Улмаар Д.А нь “Нийслэлийн Засаг даргаас газар эзэмших хүсэлт гаргахдаа хуульд заасан бүх шаардлагыг хангаж, баримтуудыг бүрдүүлсэн. Үүний дотор Газрын тухай хуулийн 31.3-т заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас тодорхойлолт авч үзэхэд хэн нэгний газартай давхцаагүй гэсэн дүгнэлтийг төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан, үүнийг үндэслэж Нийслэлийн Засаг дарга захирамж гаргасан, мөн анх газрыг эзэмшихдээ газрын суурь хураамжийн төлбөрт 28 сая гаруй төгрөгийг төлсөн, 60 сая гаруй төгрөгийн хашааг барьж байгуулсан ... тул хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим зөрчигдсөн” хэмээн захиргааны хэргийн шүүхэд хандаж Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/902 дугаар захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болгох, Д.А-тай газар эзэмших гэрээ байгуулах ... тухай нэхэмжлэл гаргажээ.

**Шүүхийн шийдвэрийн агуулга:** Захиргааны хэргийн гурван шатны шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Ингэхдээ “хариуцагч нь маргаан бүхий газрыг анх нэхэмжлэгчид эзэмшүүлэхдээ гуравдагч этгээдийн газартай давхцуулж Газрын тухай хуулийн холбогдох зүйл заалтуудыг зөрчсөн атлаа уг алдаагаа залруулалгүйгээр дахин 15 жилийн хугацаатай, зуслангийн зориулалтаар эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн нь буруу. Мөн нэгэнт хариуцагч өөрийн гаргасан хууль бус шийдвэрээ Газрын тухай хуулийг зөрчсөн болохыг хожим тогтоож хүчингүй болгосон тул хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим үйлчлэхгүй” гэж шийдвэрлэсэн.

<sup>49</sup> www.shuukh.mn, Шүүхийн шийдвэрийн цахим сан, Улсын дээд шүүхийн хуралдааны тогтоол, 2021.02.24, Дугаар 001/ХТ2021/0051



**Дүн шинжилгээ:** Үүнээс үзвэл хариуцагч захиргааны байгууллага өмнө нь нэхэмжлэгчид 5 жилийн хугацаатайгаар газрыг эзэмшүүлсэн тул нэхэмжлэгчид тухайн газар давхцалгүй байсан гэх итгэлийг бий болгожээ. Өөрөөр хэлбэл захиргааны байгууллага өөрийн үйл ажиллагаагаараа дамжуулан иргэнд итгэл бий болгосон байна. Гэхдээ Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1-д “хууль, захиргааны хэм хэмжээний актаар, эсхүл захиргааны актад түүнийг хүчингүй болгохоор заасан”, 48.2.2-д “бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн” зэрэг тохиолдолд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим үйлчлэхгүй гэж заасан. Иймд нэхэмжлэгчид бий болсон итгэл нь хуулийн дээрх заалтуудад хамаарахаас гадна “итгэл нь хууль ёсны байх”, “хууль бусаар бий болсон итгэлийг хамгаалахгүй” гэх тус зарчмын урьдчилсан нөхцөлийг хангахгүй байна. Гэхдээ гурван шатны шүүх уг зарчим үйлчлэхгүй гэж шийдвэрлэхдээ яагаад үйлчлэхгүй болохыг тухайлан дүгнэж бичээгүй байна.

**3) АШШ, №2023.12.05, №128/ШШ2023/0930 шийдвэр<sup>50</sup>**

**Хэргийн агуулга:** Нэхэмжлэгч Ж.Ч нь иргэн Э.Х-тэй тохиролцон түүний 870 м.кв газрыг эзэмших эрхийн гэрээ байгуулж, төрийн байгууллагад холбогдох материалыг бүрдүүлэн өгснөөр Б дүүргийн засаг даргын 2018 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн газар эзэмших эрхийн гэрчилгээний дагуу газрыг 15 жилийн хугацаатай эзэмшихээр болсон. Гэтэл 2019 оны 9 дүгээр сард Нийслэлийн авто замын газраас зам тавих болсонтой холбогдуулан Ж.Ч-ийн газрыг чөлөөлөх шаардлага тавьжээ. Харин Ж.Ч нь өөрийн эзэмшиж буй газрын хажуу дахь газрыг шилжүүлэн авах хүсэлт гаргасныг Б дүүргийн Газрын албанаас “Б дүүрэгт шинээр эзэмшүүлэх газрын нөөц байхгүй тул уг хүсэлтийг нь шийдвэрлэх боломжгүй тул газрын нөөцтэй бусад дүүргийн нутаг дэвсгэрт газар эзэмших саналаа ирүүлнэ үү” гэжээ. Ийнхүү нэхэмжлэгч нь НГЗБА-д холбогдуулан “НГЗБА-аас Ж.Ч-ийн газрыг хураан авсан үйлдэл, эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоох, НГЗБА-ны хууль бус үйл ажиллагааны улмаас Ж.Ч-д учирсан хохирол 180,000,000 төгрөгийг НГЗБА-аас гаргуулж Ж.Ч-д олгохыг даалгах” нэхэмжлэлийн шаардлагыг гаргажээ.

**Шүүхийн шийдвэрийн агуулга:** Шүүхээс нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэхдээ хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим зөрчигдсөн гэж үзжээ. Тодруулбал, шийдвэрийн үндэслэх хэсэгт “хариуцагч захиргааны байгууллага нь нэхэмжлэгчийн хүсэлтэд удаа дараа өөр өөр үндэслэл дурдан нөхөх олговор олгох, эсхүл газрыг өөр байршилд шилжүүлэн олгох асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байсан нь хариуцагчийн хууль бус үйлдэл ба нэхэмжлэгчийн хувьд хариуцагч нөхөх олговор олгоогүй, нэхэмжлэгчийн хүсэлтийг шийдвэрлээгүй байгаа нөхцөлд хууль ёсны итгэл хамгаалах зарчим хэрэглэгдэхээр байна” гэж дүгнэжээ.

**Дүн шинжилгээ:** Дээрх тохиолдолд нэхэмжлэгчээс хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хөндөж маргаагүй ч шүүгч тус зарчмыг хэрэглэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ. Онолын хэсэгт дурдсанчлан хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь хэд хэдэн нөхцөл хангагдсан тохиолдолд, тухайлбал, захиргааны байгууллагаас тодорхой хувь хүнд чиглэсэн, эрх зүйн үр дагавар үүсгэсэн шийдвэрийн дагуу тухайн этгээдэд мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх ашиг сонирхол үүссэн бол уг эрхийг хамгаалах агуулгатай буюу захиргааны байгууллагаас нэхэмжлэгчид итгэл хүлээлгэсэн тодорхой захиргааны акт гараагүй тохиолдолд хууль ёсны итгэлийг хамгаалах боломжгүй. Гэхдээ дээрх шүүхийн шийдвэрт хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын нэг урьдчилсан нөхцөл болох захиргааны акт байх нөхцөлийг хангаагүй боловч хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим хэрэглэгдэнэ гэж шийдвэрлэсэн. Хэдийгээр нэхэмжлэгч даалгах нэхэмжлэлийн шаардлага гаргасан хэдий ч ийнхүү нэхэмжлэл гаргаж маргах болсон үндэслэл нь албадан чөлөөлөх шийдвэр байсан бөгөөд үүнээс үүдэлтэй маргаан үүсжээ. Энэ тохиолдолд шүүх

<sup>50</sup> www.shuukh.mn, Шүүхийн шийдвэрийн цахим сан, Анхан шатны шүүхийн шийдвэр, 2023.12.05, Дугаар 128/ШШ2023/0930

зөвхөн нэхэмжлэлийн шаардлагаар хязгаарлагдахгүйгээр маргаан үүсэх болсон анхны нөхцөл байдалтай холбон тус зарчмыг хэрэглэсэн байна. Ингэхдээ шүүх захиргааны байгууллагын үйл ажиллагаанаас үүдэн нэхэмжлэгчид учирсан хохирлыг юун түрүүнд анхаарч үзсэн бөгөөд үүний үр дүнд нэхэмжлэгчийн эрх ашиг хамгаалагдсан байна. Үүнээс үзвэл хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь дээрх тодорхойлогдсон урьдчилсан нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд л хэрэглэгдэнэ гэж үзэх нь зөв эсэх асуудал урган гарч байгаа нь хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын хэрэглээнд ахиц болохуйц, ач холбогдолтой шийдвэр болжээ.

### 3.2.1. Харьцуулсан судалгаа

Эрх зүйт төр нь захиргааны үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцсэн байх ёстой гэж үздэг<sup>51</sup> тул түүнд үндэслэсэн хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь Монгол Улсад төдийгүй олон улсад нийтлэг бөгөөд 1976 оны Герман улсын Захиргааны үйл ажиллагааны тухай хуулиас нутагшуулах замаар эх газрын эрх зүйн бүлийн улсуудад дэлгэрсэн байдаг. Судалгааны энэхүү хэсэгт захиргааны эрх зүйг анхлан хөгжүүлсэн эх газрын эрх зүйн бүлийн томоохон төлөөлөгч болох Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын (ХБНГУ)-ын эрх зүйн зохицуулалтыг судаллаа.

ХБНГУ-д хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг<sup>52</sup> Үндсэн хуулийн гол зарчим хэмээн хүлээн зөвшөөрсөн байдаг<sup>53</sup>. Уг зарчмын дагуу захиргааны байгууллагын гаргасан хууль бус шийдвэр нь олон нийтийн ашиг сонирхлоос илүү чухал гэж шүүх үзвэл шийдвэрийг хүчинтэй хэвээр үлдээж болно<sup>54</sup> гэж үзэж байгаа нь Монгол Улсын зохицуулалттай төстэй байна. Харин Монгол Улсын зохицуулалтаас ялгаатай нь Үндсэн хуульд тусгалаа олсон эрх зүйн үндсэн зарчмын нэг бөгөөд зөвхөн мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх урьдчилсан нөхцөл тавихгүйгээр хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим үйлчилнэ гэж үздэг. Тодруулбал, тусгай зөвшөөрөл, хөдөлмөрийн гэрээ, иргэншилтэй холбоотой хууль бус захиргааны үйл ажиллагааг хүчингүй гэж үзсэн тохиолдолд иргэн, хуулийн этгээдэд нөхөн төлбөр олгож, оронд нь тэдгээрийг хүчингүй болгох боломжтой байна.<sup>55</sup>

ХБНГУ-ын 1976 онд батлагдсан Захиргааны процессийн хуулийн<sup>56</sup> 48 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хууль бус захиргааны актаар иргэнд нэг удаагийн буюу үргэлжилсэн мөнгөн тэтгэмж, материаллаг ашиг тус олгосон, эсхүл түүний урьдчилсан нөхцөл болох хууль бус захиргааны актыг иргэн хүчинтэй хэвээр үлдэнэ гэсэн итгэлийг өөрт бий болсон бөгөөд захиргааны актыг хүчингүй болгохоос илүүтэйгээр түүний итгэл олон нийтийн ашиг сонирхлоос илүү хамгаалагдах ёстой бол захиргааны актыг хүчингүй болгож болохгүй. Иргэн нь олгосон хөрөнгө орлогыг зарцуулсан, цаашид цуцлах боломжгүй санхүүгийн зохицуулалт хийсэн, эсвэл цуцалбал түүнд их хэмжээний хохирол учрах тохиолдолд түүний итгэл хамгаалагдана. Харин дараах тохиолдолд иргэний хууль ёсны итгэл хамгаалагдахгүй. Үүнд:

1. Захиргааны актыг хууран мэхлэх, заналхийлэх, авлига өгөх замаар гаргуулсан;
2. Захиргааны актыг гаргуулахдаа илтэд буруу, дутуу мэдээлэл өгсөн;
3. Захиргааны актыг хууль бус болохыг урьдаас мэдэж байсан, эсхүл илт хайхрамжгүйн улмаас мэдээгүй байсан” гэж, мөн 48 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заагаагүй хууль бус захиргааны актыг хүчингүй болгосон тохиолдолд тухайн байгууллага нь нийтийн ашиг сонирхлыг харгалзан

<sup>51</sup> О.Мөнхсайхан (LL.D), Хууль дээдлэх ёс: Ерөнхий хандлага ба Монгол, Эрх зүй сэтгүүл, 2020 №4, Цуврал 52, 15 дахь тал.

<sup>52</sup> Герман хэлээр: Vertrauensschutz

<sup>53</sup> Trevor Zeyl, “Charting the wrong course: The doctrine of legitimate expectations in investment treaty law”, p.215. <https://albertalawreview.com/index.php/ALR/article/view/131/131>

<sup>54</sup> C.F.Forsyth, “The Provenance and Protection of Legitimate Expectations”, *The Cambridge Law Journal*, Vol. 47, No. 2 (Jul., 1988), p.244.

<sup>55</sup> Мөн тэнд.

<sup>56</sup> *Verwaltungsverfahrensgesetz (VwVfG)*, 1976.

үзэж, итгэлийг хамгаалах ёстой бол захиргааны актын үйлчлэлд итгэсэн этгээдэд учирсан хохирлыг түүний хүсэлтийн дагуу нөхөн арилгана.” гэж заасан.

ХБНГУ-ын хувьд онолын хувьд захиргааны байгууллага, албан тушаалтны бүхий л үйлдэл хууль ёсны итгэлийг үүсгэж болзошгүй гэж үздэг боловч энэхүү захиргааны тогтсон зан үйл, үйлдлийг хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын үүднээс хамгаалагдах ёстой гэж үзэхийн тулд тухайн хэргийн нөхцөл байдалд маш сайн судалж, дүгнэх ёстой байна. Тухайлбал, захиргааны акт нь материаллаг буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх агуулгатай байвал хувь хүний ашиг сонирхлыг шүүхээс илүүд үзэх хандлагатай байдаг бол, материаллаг бус агуулгатай, тухайлбал тусгай зөвшөөрөлтэй холбоотой тохиолдолд захиргааны актыг хүчингүй болгох нийтийн ашиг сонирхол давамгайлна<sup>57</sup> гэж үздэг. Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим зөрчигдсөн гэж шүүх үзвэл иргэнд нөхөх олговор олгох бөгөөд үүнийг захиргааны байгууллага гагцхүү улсын төсвийн ашиг сонирхлын үүднээс эсэргүүцэх эрхтэй байна.

Цаашлаад хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын хэрэглээ нь зөвхөн захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэлийн шаардлагаар хязгаарлагдахгүй бөгөөд шинээр захиргаанаас хэм хэмжээний акт гаргах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, захиргаанаас эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ адил тэгш хандах, шийдвэртээ тууштай байх үүргийг хамтад нь агуулдаг.<sup>58</sup> ХБНГУ-д хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь хувь хүний эрхийг хамгаалахад чиглэсэн зарчим гэж үздэг бөгөөд энэ зарчмын агуулга Үндсэн хууль (Grundgesetz)-д сууснаар иргэн захиргааны байгууллагатай харилцах харилцаанд хүний эрхийн хамгаалалт илүү хүчтэй болсон байна. Мөн Холбооны захиргааны шүүх хууль ёсны итгэлийг хамгаалах (Vertrauensschutz) гэх нэр томъёо, зарчмын зохицуулалтыг шийдвэрүүддээ байнга хэрэглэдэг бөгөөд тус зарчмын хэрэглээтэй холбоотой нэлээдгүй шүүхийн шийдвэр гарсан байна.<sup>59</sup> Гэхдээ эдгээр нь нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан үр дүнг баталгаажуулдаггүй.

Дээрхээс дүгнэвэл, ХБНГУ-д хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь хүний эрхийг хамгаалахад чиглэсэн зарчим болохын хүлээн зөвшөөрч, энэ зарчмын агуулга Үндсэн хууль (Grundgesetz)-д сууснаар иргэн захиргааны байгууллагатай харилцах харилцаанд хүний эрхийн хамгаалалт илүү хүчтэй болсон байна. Тодруулбал, иргэн одоо байгаа дүрэм, журам, практикт найдах боломжийг энэ зарчим баталгаажуулдаг ба ийнхүү найдаж байсан иргэнд сөргөөр нөлөөлөх захиргааны практик эсхүл хууль тогтоомжийн гэнэтийн, шударга бус өөрчлөлтөөс хамгаалах хамгаалалтыг өгдөг байна. Мөн хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хууль дээдлэх зарчмын гол бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж, захиргааны шүүхүүд хууль ёсны итгэлийг хамгаалах гэх нэр томъёог хэрэглэж, тайлбарлаж хэвшсэн бөгөөд энэ зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх талаар практик тогтохуйц олон тооны шүүхийн шийдвэр гарсан байна.

Манай улсын хувьд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим Үндсэн хуульд шууд тусгагдаагүй ч хууль дээдлэх зарчмаас үүдэлтэй захиргааны эрх зүйн зарчим болон хөгжсөн гэж үзэж болох бөгөөд захиргааны үйл ажиллагааны тусгай зарчим болгон хуульчилсан. Ихэвчлэн захиргааны үйл ажиллагаа, шийдвэр гаргах ажиллагаанд баримталсан эсэхийг захиргааны шүүх бүрэн эрхийн хүрээнд хянаж байна. Итгэл хамгаалах зарчмыг дурдсан, тайлбарласан захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүд цөөнгүй байгаа боловч хэрэглээний нэгдмэл байдалтай холбоотой практик тогтохуйц хэмжээнд шүүхийн шийдвэрүүд гараагүй байна. Учир нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэх нь тийм ч чухал биш бөгөөд зарчим баримтлан

<sup>57</sup> Klaus Rennert, “The Protection of Legitimate Expectations under German Administrative Law”, 2016, p.5.

<sup>58</sup> The Protection of Legitimate Expectations in Administrative Law and EU Law, April 2016, p12. [https://www.aca-europe.eu/seminars/2016\\_Vilnius/VIL\\_GeneralReport\\_en.pdf](https://www.aca-europe.eu/seminars/2016_Vilnius/VIL_GeneralReport_en.pdf)

<sup>59</sup> Мөн тэнд, Захиргааны шүүхийн шийдвэрийн цахим санд 2016 оны байдлаар хууль ёсны итгэлийг хамгаалах гэж дурдсан 1800 шийдвэр байсан.

шийдвэрлэх нь системийн хувьд хөгжөөгүйгээс гадна тус зарчмыг практикт (захиргааны байгууллагын үйл ажиллагаанд) хэрхэн хэрэгжүүлэх талаар практик тогтоогүй байна.

#### IV. ДҮГНЭЛТ

Захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь дэлхий нийтэд тархсан бөгөөд өөрийн зүй ёсны шаардлагын дагуу бий болсон, зайлшгүй байх ёстой чухал зарчим мөн. Захиргааны үйл ажиллагаанд хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны үр дүнд гаргасан шийдвэрийн үндэслэлтэй болон тогтвортой байдлыг хангахад хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим гол үүрэг гүйцэтгэдэг. Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь захиргааны үйл ажиллагаа, түүний үр дүнд гарч буй шийдвэр нь тогтвортой хэрэгжих шинжээ хадгалж, уг шийдвэрийн дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн явуулж буй иргэн, хуулийн этгээдийн итгэлийг хамгаалах зорилготой. Улмаар аль нэг бүлгийн эсхүл хувийн ашиг сонирхлыг тэргүүнд тавьж, захиргааны үйл ажиллагаа, шийдвэрийг байнга өөрчлөхөөс сэргийлж, захиргааны албан тушаалтны өмнөх практикаас зөрсөн гэнэтийн шийдвэрийг хязгаарлахад чиглэгдэнэ.

Монгол Улсад тус зарчим хуульчлагдаад 9 гаруй жилийн хугацаа өнгөрч байгаа, хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг дурдсан шүүхийн шийдвэрүүд цөөнгүй байгаа ч шүүхийн шийдвэрүүдээс үзвэл тус зарчмын хэрэглээ нэгдмэл бус байна. Энэ нь нэг талаас шүүгч шийдвэр гаргахдаа “зарчим” баримтлан шийддэггүйтэй холбоотой байж болох юм. Тодруулбал, захиргааны байгууллага маргаан бүхий актыг гаргах эрхтэй юу, шийдвэр гаргахдаа зохих дараалал, журмаар ажилласан эсэх гэдэг хяналт ихэвчлэн хийдэг. Энэхүү хяналт нь хуульд үндэслэх зарчимд илүүтэй нийцэж байж болох ч иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилгод нийцэхгүй байх талтай.

Нөгөөтэйгөөр, хууль ёсны итгэл гэх ойлголт захиргааны үйл ажиллагаанд хэвшээгүй байгаагаас захиргааны байгууллага хууль ёсны итгэл бий болохуйц үйлдэл хийж байгаагаа ухамсарладаггүй, цаашлаад энэ нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихүйц нөхцөл байдал болохыг хүлээн зөвшөөрөөгүй байна. Захиргааны үйл ажиллагаанд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим хэрэглэгдэх практик тогтоход захиргааны шүүх тухайн хэргийн тохиолдол, нөхцөл байдалд яагаад тус зарчим хэрэглэгдэх ёстойг, эсхүл хэрэглэгдэхгүй болохыг тайлбарлаж, дүгнэж байх нь ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, хууль ёсны итгэл хамгаалах зарчим тухайн маргааны тохиолдолд үйлчлэх эсэх урьдчилсан нөхцөл бүрийг тухайлан шалгаж, дүгнэлт өгөх ажиллагаа хийгдсэнээр тус зарчмын хэрэглээний нэгдмэл байдал бий болно. Хариуцагч захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаандаа тусгай зарчмыг баримталсан эсэхийг ялангуяа, нэхэмжлэгчээс хууль ёсны итгэл хамгаалах зарчмыг зөрчсөн гэж маргаж, нэхэмжлэлийн үндэслэлээ тодорхойлж, тайлбарлаж байгаа тохиолдолд, нэхэмжлэгчид үүссэн итгэл яагаад “хууль ёсны” эсхүл биш болохыг үндэслэлтэй тайлбарлах нь энэ зарчмын хэрэгжилт дэх шүүхийн хяналтыг сайжруулах, энэ зарчим сонгодог утгаараа бүрэн агуулгаараа хэрэгжих нэг алхам болно гэж үзэж байна.

## ЭХ СУРВАЛЖ

**Эрх зүйн актууд:**

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Захиргааны ерөнхий хууль, 2015
3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016
4. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам, 2017.
5. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.2.9, 32.3.11 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, <https://legalinfo.mn/detail?lawId=15323>

**Судалгаа, өгүүлэл, ном:**

1. Ханнс-Зайделийн сангийн дэргэдэх “Эрх зүйн боловсрол академи”, Судалгааны тайлан: Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, УБ, 2018
2. Т.Мөнх-Эрдэнэ, Г.Гэсэр, “Монгол Улсын захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим”, 2019 <https://legaldata.mn/buteel/pdf?id=618>
3. О.Мөнхсайхан (LL.D), Хууль дээдлэх ёс: Ерөнхий хандлага ба Монгол, 2020, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1936>
4. Д.Сүнжид (Ph.D), Захиргааны ерөнхий хууль: Үзэл баримтлал, хэрэглээ, 2017
5. П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 2008
6. Ц.Цогт, “Захиргааны ерөнхий хууль: Боловсруулсан үе шат, үзэл баримтлал, хэрэгжилт, хүлээгдэж буй ач холбогдол”, 2019
7. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, анхны хэвлэл,
8. Ш.Цогтоо, Монгол Улсын захиргааны эрх зүй: Ерөнхий, тусгай анги, 2021,
9. Oluchi C. Maduka, PhD., Opeyemi A. Gbadegesin. LLM, LLB, BL, Bukola O. Ochei PhD., “An Examination of the Doctrine of Legitimate Expectation as a Ground of Review of Administrative Decisions in Nigeria”, p.2. <http://www.journals.ui.edu.ng/index.php/uijr/article/view/1068/907>
10. Aakansha Kumar Uchariya, “Comparative analysis of the doctrine of legitimate expectation”, 2022. <https://www.ijrti.org/papers/IJRTI2205037.pdf>
11. Chaminda Jayasinghe, “Making sense of the concept of substantive legitimate expectation”, 2013, [https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract\\_id=2276592](https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2276592)
12. Farrah Ahmed, Adam Perry, “The coherence of the doctrine of legitimate expectations”, 2014, [https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract\\_id=2163255](https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2163255)
13. Peter Leyland, *Textbook on Administrative Law*, Seventh Edition, p.353. <https://facultymembers.sbu.ac.ir/jalali/wp-content/uploads/2016/02/129.pdf>
14. Foram R. Patel, Rishin Patel, “The doctrine of legitimate expectation: from development in England to Indian scenario”, *ILI Law Review Winter Issue 2021*. [https://ili.ac.in/pdf/win21\\_8.pdf](https://ili.ac.in/pdf/win21_8.pdf)
15. Usha Antharvedi, “Judicial review of administrative actions and principles”, 2008, p.7. [https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract\\_id=1104955](https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=1104955)
16. Matthew Groves, “Substantive Legitimate Expectations in Australian Administrative Law” (2008) 15 *MelbULawRw* 32(2) 470, <http://www5.austlii.edu.au/au/journals/MelbULawRw/2008/15.html>
17. Paul Reynolds, “Legitimate Expectations and the Protection of Trust in Public Officials” (2011) 2 *Public Law* 330, 340-41
18. Joseph RAZ, *The Authority of Law: Essays on Law and Morality*, Oxford University Press, Oxford, 2009, p. 214-216; John FINNIS, *Natural Law and Natural Rights*, 2nd

- edition, Oxford University Press, Oxford, 2011, p.270.
19. Timothy ENDICOTT, *Vagueness in the Law*, Oxford University Press, Oxford, 2000, p. 193.
  20. Lon FULLER, *The Morality of Law*, Yale University Press, New Haven and London, 1969, p. 29.
  21. Jaime Phillips Letelier Prof. “The normative foundations of retroactivity and legitimate expectation in the UK administrative law”, *Revista de Derecho Público: Teoría y Método Marcial Pons Ediciones Jurídicas y Sociales*, 2023, p.84. <https://www.revistasmarcialpons.es/revistaderechopublico/articulo/download/retroactivity-and-legitimate-expectation-in-the-uk-administrativ/1793/4591>
  22. Georg Nolte, “General Principles of German and European Administrative Law - A Comparison in Historical Perspective”, 1994, p.195. <https://onlinelibrary.wiley.com/doi/pdf/10.1111/j.1468-2230.1994.tb01932.x#:~:text=There%20are%20three%20major%20principles,of%20the%20principles%20in%20turn.>
  23. John C Robertson, “Legitimate expectations”, 1990, p.158. [https://journals.co.za/doi/pdf/10.10520/AJA02586568\\_213](https://journals.co.za/doi/pdf/10.10520/AJA02586568_213)
  24. C.F.FORSYTH, “The provenance and protection of legitimate expectation”, 1988, p.240. <https://www.jstor.org/stable/4507165?seq=3>
  25. Robert Thomas, *The Protection of Legitimate Expectations in UK Administrative Law*, 2012,
  26. ALISON L.YOUNG, “Stuck at a crossroad? Substantive legitimate expectations in English law”, *Cambridge Law Journal*, 80(S1), 2021, p.186. <https://www.cambridge.org/core/services/aop-cambridge-core/content/view/AF53BD9A32B44DBFF47446F2685B5C04/S000819732100057Xa.pdf/stuck-at-a-crossroad-substantive-legitimate-expectations-in-english-law.pdf>
  27. A Perry and F Ahmed, ‘The Coherence of the Doctrine of Legitimate Expectations’ *Cambridge Law Journal*, 2014, Revisiting FIRS vs Halliburton – For the Records.
  28. <https://www.proshare.co/articles/revisiting-firs-vs-halliburton-for-the-records?menu=Finance&classification=Read&category=Personal%20Tax>
  29. Richard Clayton, “Legitimate expectations, policy, and the principle of consistency”, *The Cambridge Law Journal*, Vol. 62, No. 1, 2003, p.95. [https://www.jstor.org/stable/4508971?read-now=1#seq=1#page\\_scan\\_tab\\_contents](https://www.jstor.org/stable/4508971?read-now=1#seq=1#page_scan_tab_contents)
  30. Klaus Rennert, “The Protection of Legitimate Expectations under German Administrative Law”, 2016, p.4.
  31. Trevor Zeyl, “Charting the wrong course: The doctrine of legitimate expectations in investment treaty law”, p.215. <https://albertalawreview.com/index.php/ALR/article/view/131/131>

#### **Цахим мэдээллийн сан:**

1. Монгол Улсын Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
2. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)
3. [www.shuukh.mn](http://www.shuukh.mn), Шүүхийн шийдвэрийн цахим сан, Улсын дээд шүүхийн хуралдааны тогтоол, 2019.04.01, Дугаар 95
4. [www.shuukh.mn](http://www.shuukh.mn), Шүүхийн шийдвэрийн цахим сан, Улсын дээд шүүхийн хуралдааны тогтоол, 2020.02.19, Дугаар 001/ХТ2020/0088
5. [www.shuukh.mn](http://www.shuukh.mn), Шүүхийн шийдвэрийн цахим сан, Улсын дээд шүүхийн хуралдааны тогтоол, 2021.02.24, Дугаар 001/ХТ2021/0051
6. [www.shuukh.mn](http://www.shuukh.mn), Шүүхийн шийдвэрийн цахим сан, Анхан шатны шүүхийн шийдвэр, 2023.12.05, Дугаар 128/ШШ2023/0930



---

## JUDICIAL REVIEW ON THE IMPLEMENTATION OF THE PRINCIPLE OF LEGITIMATE EXPECTATION

*Anirmaa.B*

*Lawyer, Master's student, School of Law,  
NUM*

*Bilegdemberel.B*

*Bachelor's student, School of Law, NUM*

### **ABSTRACT:**

Non-compliance with the “principle of legitimate expectation” in administrative practices can lead to several negative consequences, including a decline in public confidence in the administration, instability in administrative operations, and the potential loss of legal validity for decisions made. This article explores the substance of the principle, its theoretical foundations, and instances where courts have inconsistently applied it in dispute resolution. It also identifies key issues that should be addressed when implementing this principle.

### **KEYWORDS:**

Principle of legitimate expectation, rule of law, uniformity of law enforcement



## БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН ЭРХИЙН ХАМГААЛАЛТЫН ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ АСУУДАЛД



**Б.Одгэрэл**

*Дотоод хэргийн их сургуулийн докторант*

### **ТОВЧЛОЛ:**

Монгол Улсын Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгад (2021) шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентын эрхийн хамгаалалтын хүрээг шинээр тодорхойлсон байх бөгөөд хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “патентын эрхийн хамгаалалтын хүрээг шинэ бүтээл, ашигтай загварын хувьд томьёололд зааснаар, бүтээгдэхүүний загварын хувьд тодорхойлолтод зааснаар тодорхойлно” гэж заажээ. Оюуны өмчийн эрхийн хамгаалалтын хүрээг тогтоох асуудал оюуны өмчийн төрөл тус бүрийн ялгаатай байдалтай салшгүй холбоотой. Бүтээгдэхүүний загварын патентын эрхийн хамгаалалтын хүрээг бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын мөн чанар, бүтээгдэхүүний загварын патент олгох үйл явц, улмаар патент олгож өмчлөх эрхийг баталгаажуулах хүрээнд судлах замаар бүтээгдэхүүний загварын патентын эрхийн хамгаалалтын хүрээг тогтоохтой холбоотой одоогийн эрх зүйн орчны тулгамдсан асуудлыг тодорхойлохыг зорьсон.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Эрхийн хамгаалалтын хүрээ, бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын мөн чанар, бүтээгдэхүүний загварын патент, патент олгох үйл явц, эрх зүйн орчин

### **I. ОРШИЛ**

Оюуны өмчийн эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлох асуудал нь оюуны өмчид хамааруулсан төрлүүдийн шинж чанар, онцлог болоод оюуны өмчийн онцгой эрхийн илрэх хэлбэр патент, гэрчилгээ олгох үйл ажиллагаатай салшгүй холбоотой. Аж үйлдвэрийн өмчийн нэг төрөл болох бүтээгдэхүүний загварын эрх оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас бүтээгдэхүүний загварын патент олгосноор эхэлдэг. Оюуны өмчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Аж үйлдвэрийн өмчийн эрх нь оюуны өмчийн асуудал хариуцсан байгууллагад эрхийн хамгаалалт хийлгэж, улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ” хэмээн хуульчилжээ. Эрхийн хамгаалалт хийлгэх хүрээнд бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт тавигдах шаардлага болон бүтээгдэхүүний загварын патентаар хамгаалагдах зүйл, шалгуурт нийцэх шаардлагатай байна. Тухайлбал Патентын тухай хуулийн (2021) 28, 29 болон 30 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан бол патентын мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс буюу анхдагч огнооноос хойш 15 жилийн

хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх патент олгодог. Бүтээгдэхүүний загварын патентыг захиран зарцуулах онцгой эрхийг патент эзэмшигч эдлэх бөгөөд патентаар хамгаалагдсан загварыг зөвшөөрөлгүй ашиглахыг хориглох, эрхээ бусдад шилжүүлэх, ашиглуулах, өв залгамжлуулах болон зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрх эдэлнэ. Патент эзэмшигчид олгосон онцгой эрхийн хүрээг оюуны өмчийн салбарын хуулиудад тусгайлан зохицуулаагүй ирсэн байх бөгөөд Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2021), Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлтөөр (2021) хуулиар нэр зааж хамааруулсан оюуны өмчийн төрлүүдийн эрхийн хамгаалалтын хүрээг шинээр тодорхойлжээ.

Эрхийн хамгаалалтын хүрээг шинэ бүтээл, ашигтай загварын хувьд томьёололд зааснаар, бүтээгдэхүүний загварын хувьд тодорхойлолтод зааснаар<sup>1</sup>, барааны тэмдгийн тухайд бүртгэгдсэн хэлбэр болон бүртгэгдсэн бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалтын хүрээ<sup>2</sup>-д тус тус тодорхойлжээ. Үүнийг шинэ бүтээл, ашигтай загварын тухайд томьёололд бичигдсэн ялгагдах шинж, бүтээгдэхүүний загварын хувьд тодорхойлолтод бичигдсэн өвөрмөц шинж, бүртгэгдсэн барааны тэмдгийн хувьд хэрэглэх бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалт эрхийн хамгаалалтын хүрээг тогтооно гэж тайлбарлан тодорхойлж болох юм. Эрхийн хамгаалалтын хүрээг оюуны өмчид хамааруулсан төрлүүдийн тухайд авч үзвэл патент, гэрчилгээгээр олгогдсон өмчлөх эрхийн хил хязгаарыг тогтоох хүрээнд авч үзэж болно. Оюуны өмчийн онцгой эрхийн хил хязгаарыг тогтоох асуудалд оюуны өмчийн төрөл тус бүрийн онцлогийг харгалзах шаардлагатай. Оюуны өмчийн зарим төрлүүдийн хувьд эрхийн хамгаалалтын хүрээг тогтоох асуудал үндэсний хууль тогтоомжийн хүрээнд тогтсон байсан гэж үзэх үндэслэлтэй байна. Шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэг гаргахад томьёоллын шаардлагад эрхийн хамгаалалтын хүрээг тогтоосон байх талаар Патентын хуулийн (1993) 1999<sup>3</sup> оны нэмэлт болон 2006<sup>4</sup> оны Патентын тухай хуульд тусгагдсан байна. Барааны тэмдгийн хувьд хэрэглэх бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалтын хүрээнд барааны тэмдгийн эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлсоор ирсэн байх бөгөөд тухайлбал барааны тэмдгийн гэрчилгээ олгохдоо гэрчилгээнд "... барааны тэмдгийн дүрс, онцлог шинж чанар, олон улсын ангиллын дагуу ангилсан тухайн барааны тэмдэгт хамаарах бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалт..."<sup>5</sup> заадаг, барааны тэмдгийн хугацааг сунгахад "...барааны тэмдгийг өөрчлөхгүй бөгөөд бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалтад нэмэлт хийхгүй"<sup>6</sup> хэмээн хуульчилжээ. Дээрх зохицуулалтууд шинэ бүтээл, ашигтай загвар, барааны тэмдгийн эрхийн хамгаалалтын хүрээг Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгад (2021) шинээр тодорхойлоход суурь үндэс болсон гэж үзэж болохоор байна. Харин бүтээгдэхүүний загварын тухайд эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлох асуудлыг хуульд тусгаж байгаагүй болон энэ талаар тухайлан судалсан судалгаа одоогоор байхгүй байна. Түүнээс гадна олон улсад бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлох асуудлыг дагнан судласан судалгаа илрэхгүй байх бөгөөд судлаачдын хувьд бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг гаргахад эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлдог зурагт гол анхаарлаа хандуулах талаар бүтээлдээ дурджээ.<sup>7</sup> Иймд бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлолтод заасан хүрээнд тодорхойлох асуудлыг судлагдаагүй шинэ дутмаг ойлголт гэж үзэх үндэслэлтэй бөгөөд цаашид судлах нөхцөлийг бий болгож байна.

<sup>1</sup> Патентын тухай хууль, 2021, 47 дугаар зүйлийн 47.1.

<sup>2</sup> Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, 2021, 12 дугаар зүйл, 12.2.

<sup>3</sup> Патентын тухай хууль, 1999, 6 дугаар зүйлийн 6.3, Патентын тухай хууль, 1999, 7 дугаар зүйлийн 7.1.

<sup>4</sup> Патентын тухай хууль, 2006, 7 дугаар зүйлийн 7.3.2, Патентын тухай хууль, 2006, 7 дугаар зүйлийн 7.5.

<sup>5</sup> Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, 2010, 9 дүгээр зүйлийн 9.2.

<sup>6</sup> Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, 2010, 10 дугаар зүйлийн 10.4.

<sup>7</sup> Philippe J.C. Signore, "Design Patent Protection in the United States", *epi Information Journal*, 2/2001 (June), p. 81-87, <https://www.oblon.com/publications/design-patent-protection-in-the-united-states>

Энэхүү өгүүлэлд бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлох асуудлыг аж үйлдвэрийн өмчид хамааруулсан төрлүүдийн эрхийн хамгаалалтын хүрээг тогтоосон хүрээнд хязгаарлаж, харьцуулах замаар бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын мөн чанар, бүтээгдэхүүний загварын патент олгох үйл ажиллагаанд тулгуурлан үндэсний хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын оюуны өмчийн гэрээ хэлэлцээр, олон улсын жишиг тогтолцооны хүрээнд авч үзсэн.

## II. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ

Монгол Улсын Патентын тухай хууль анх 1993 онд батлагдаж бүтээгдэхүүний загварын эрх зүйн зохицуулалтыг шинэ бүтээл, оновчтой саналтай хамтатган зохицуулж, бүтээгдэхүүний загварыг эзэмших, ашиглах, захиран зарцуулах онцгой эрхийг зохицуулсан байдаг. Уг хуульд бүтээгдэхүүний загварын патентын эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлоогүй боловч бүтээгдэхүүний загварын патент олгох шийдвэр гаргах болон патент олгохдоо бүтээгдэхүүний загварын төлөөлөх зургийг үндэслэдэг байхаар зохицуулсаар иржээ. Тухайлбал хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д “патент олгохоор шийдвэрлэсэн шинэ бүтээлийн ном зүй, томьёолол, бүтээгдэхүүний загварын зургийг патентын хэвлэлд нийтэлж зарлана”, мөн 12 дугаар зүйлд “Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент олгох”-доо ... бүтээгдэхүүний загварын зургийг патентын хэвлэлд нийтэлснээс хойш 3 сарын дотор патентын байгууллагад патент олгохыг няцаасан нотолгоо ирээгүй, маргаан гараагүй бол патент олгохоор<sup>8</sup> заажээ. Бүтээгдэхүүний загварын патент олгох шийдвэр гаргах<sup>9</sup> болон патент олгох<sup>10</sup>-доо бүтээгдэхүүний загварын төлөөлөх зургийг үндэслэдэг зарчим Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгад (2021) хадгалагдсан хэвээр зохицуулагджээ. Бүтээгдэхүүний загварын патент олгохдоо бүтээгдэхүүний загварын тодорхойлолтыг авч үздэггүй, харин бүтээгдэхүүний загвар нь шинэ<sup>11</sup> болоод өвөрмөц шинж<sup>12</sup>-ийг агуулсан эсэх, бүтээгдэхүүний загварт тооцохгүй зүйл<sup>13</sup>-д хамаарч байгаа эсэх, мөн бүтээгдэхүүний загварын патент олгохгүй зүйлд хамаарч байгаа эсэх<sup>14</sup> шалгууруудыг хангасан эсэх талаарх шийдвэрт үндэслэдэг байна. Бүтээгдэхүүний загварын патент олгох тухай шинжээчийн дүгнэлт “Маягт БЗ-15”<sup>15</sup>-д шинжээчийн патент олгох боломжтой гэсэн дүгнэлт “мэдүүлсэн бүх загвар” эсхүл “мэдүүлсэн зарим загвар” буюу бүтээгдэхүүний загварыг төлөөлөх зургийг авч үздэг байна. Бүтээгдэхүүний загварыг төлөөлөх зурагт үзүүлсэн харагдах шинжүүдийг харьцуулан үзэж гаргасан шинжээчийн дүгнэлтэд үндэслэн патент олгох шийдвэр гаргадаг гэж тодорхойлох боломжтой байх бөгөөд уг шийдвэрийг холбогдох мэдээллийн хамт нийтэд мэдээлснээс хойш хуулийн хугацаанд патент олгохыг няцаасан нотолгоо ирүүлээгүй эсхүл ирүүлсэн ч авч үзээгүй бол патент олгох шийдвэр гарсан бүтээгдэхүүний загварын зурагт бүтээгдэхүүний загварын патентыг олгодог байна.

Бүтээгдэхүүний загварын патентын эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлолтод зааснаар тодорхойлно гэж үзвэл хуулийн хүрээнд тодорхойлолтод “тухайн бүтээгдэхүүний загварын гадаад дүрс, хийц, хэлбэр, өнгө, бүтцийн болон хээ чимэглэлийн шинэ болон өвөрмөц шинжийг тодорхойлон бичнэ”<sup>16</sup> гэсэн шаардлага тавьснаас өөрөөр патентын онцгой эрхийн хүрээг тогтоохуйц бүтээгдэхүүний загварын шийдлийн гадаад гоо зүйн

<sup>8</sup> Патентын тухай хууль, 1994, 12 дугаар зүйл 12.1.

<sup>9</sup> Патентын тухай хууль, 2021, 37 дугаар зүйл 37.1.

<sup>10</sup> Патентын тухай хууль, 2021, 39 дүгээр зүйл 39.1.

<sup>11</sup> Патентын тухай хууль, 2021, 28 дугаар зүйлийн 28.2.

<sup>12</sup> Патентын тухай хууль, 2021, 28 дугаар зүйлийн 28.3.

<sup>13</sup> Патентын тухай хууль, 2021, 29 дүгээр зүйл.

<sup>14</sup> Патентын тухай хууль, 2021, 30 дугаар зүйл.

<sup>15</sup> Оюуны өмчийн газрын даргын тушаал, 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр, дугаар А/121, Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэгт мөн чанарыг шүүлт хийх, нийтэд мэдээлэх, патент олгох, улсын бүртгэлд өөрчлөлт оруулах журам батлах тухай тушаалын зургаадугаар хавсралт.

<sup>16</sup> Патентын тухай хууль, 2021, 33 дугаар зүйлийн 33.8.

онцлог шинж чанарыг тодорхойлох тусгайлсан шаардлагыг тавиагүй байна. Үүнээс гадна бүтээгдэхүүний загварын нэг мэдүүлэгт загварын нэг ангилалд хамаарах 50 хүртэлх бүтээгдэхүүний загварыг мэдүүлж болохоор<sup>17</sup> хуульчилсан хэдий ч эдгээр загвар бүрд тодорхойлолт бичих эсэхийг зохицуулаагүй байна. Бүтээгдэхүүний загварын нэг мэдүүлэгт 50 бүтээгдэхүүний загварыг мэдүүлээд патент олгогдсон бол 50 бүтээгдэхүүний загварт патент олгосон гэж үзэх боломжтой, энэ тохиолдолд нэг тодорхойлолтод зааснаар эдгээр патентын эрхийн хамгаалалтын хүрээг тогтоох боломжгүй гэх үндэслэлтэй байна. Энд 5 хувилбарт бүтээгдэхүүний загварыг жишээ болгож авлаа. Оюуны өмчийн газрын бүтээгдэхүүний загварын сан<sup>18</sup>-д патент олгохоор 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хэвлэсэн MN30-2023-0004676 дугаартай “Белаз брэнд” Etemon belaz түлхүүрний оосор болон ширээн дээрх бэлэг дурсгал нэртэй мэдүүлэгт 5 хувилбарт бүтээгдэхүүний загварыг дараах байдлаар тодорхойлжээ.

... белазыг харах зургаа даруулах байдаг ба үзсэн харсныг нь дурсгалын зүйл болгож жижигсгэж илүү бодитой 3D болгон яг адилхнаар бэлэг дурсгал, сувинерын хэлбэрт оруулж гаргахаар бэлтгэл ажил хангагдаад бэлэн бүтээгдэхүүн болоод байна. Бүтээгдэхүүнийг гар аргаар хийдэг бөгөөд Белазаа 3D хэвлэлээр PLA материалаар 3см хэвлүүлэн гаргаж аваад акрилан будгаар нэг бүрчлэн деталь болгоныг нь өнгө өнгөөр будаад будаг нь хатсаны дараа тэвшин дээрээ чулуугаа хийж бөөрөнхий, зуван, дөрвөлжин, 5н талт, пирамидан зэрэг зөөлөн хэвэндээ хийж найруулсан эпоксигоо хэвээ дүүртэл хийж 24 цагийн дараа эпокси нь хатаж ширээн дээрх дурсгалын зориулалттай болон түлхүүрний оосрон белаз маань бэлэн болно...

Энэ тодорхойлолтоос ямар өнгө, хэлбэр дүрстэй түлхүүрийн оосор дүрслэгдэж байгаа нь тодорхойгүй байх бөгөөд ийм тодорхойгүй шинж чанараар патентаар олгогдсон өмчлөх эрхийн хил хязгаарыг тогтоох нь бүтээгдэхүүний загварын патентаар олгогдсон онцгой эрхийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэнэ. Харин жишээ болгож буй дээрх мэдүүлэгт хавсаргасан 5 хэсэг 31 зургийг харвал бүтээгдэхүүний загварын шинэ болоод өвөрмөц шинжийг ялгаж харах боломжтой байгаа нь харагдах байдлаараа илэрхийлэгдэх бүтээгдэхүүний загварын үндсэн шинжтэй салшгүй холбоотой гэж дүгнэх боломжтой байна. Дээрх тодорхойлолтыг зургаар илэрхийлсэн бүтээгдэхүүний загварын өнгө дүрсний ялгарал, зохицолдоо, нарийн хийцийг зурагт харуулсан байдлаар бүрэн дүүрэн илэрхийлж бичээгүй байна гэсэн үндэслэлээр мөн чанарын шүүлтийн явцад оюуны өмчийн газрын шинжээч дүгнэлт гаргах хуулийн зохицуулалт байхгүй байгаа нь бүтээгдэхүүний загварын патент олгох шийдвэр гаргах үйл явц бүтээгдэхүүний загварын тодорхойлолтод биш бүхэлдээ бүтээгдэхүүний загварын зурагт хамаарч байна гэж тодорхойлох үндэслэлтэй байна. Ийн тодорхойлолтод зааснаар бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлох асуудал нь бүтээгдэхүүний загварын патент олгох үйл явцтай нийцэхгүй байна.

Бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт бүтээгдэхүүний гаднах харагдах байдалтай шууд хамааралтай. Хуульд бүтээгдэхүүний загварт бүтээгдэхүүний гадаад харагдах байдалд хамаарах дүрс, хийц, хэлбэр, өнгө, бүтцийн болон хээ чимэглэлийн уран сайхны шийдлийг<sup>19</sup> хамааруулсан. Ерөнхийдөө бүтээгдэхүүний загварт бүтээгдэхүүний харагдах байдлыг илэрхийлэх гурван хэмжээст дүрслэл, хээ чимэглэл, дүрслэл, хээ угалз, өнгөөр илэрхийлэгдэх хоёр хэмжээст дүрслэл ба эдгээрийн хосолсон загвар хамаардаг<sup>20</sup> буюу бүтээгдэхүүний гадна хэлбэр бүтээгдэхүүний загварт хамаардаг байна. Бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын мөн чанар нь тухайн бүтээгдэхүүний загварын харагдах

<sup>17</sup> Патентын тухай хууль, 2021, 33 дугаар зүйлийн 33.10.

<sup>18</sup> Оюуны өмчийн газар, Оюуны өмчийн газрын аж үйлдвэрийн сан, <https://publish.ipom.mn/wopublish-search/public/designs?1&query=OFCO:MN#> [Сүүлд үзсэн: 2024.04.30].

<sup>19</sup> Патентын тухай хууль, 2021, 3 дугаар зүйлийн 3.1.4.

<sup>20</sup> Оюуны өмчийн газар, Оюуны Өмч-Бизнес цуврал дугаар 2, *Хараа булаахуй*, орч. Г.Оюунгэрэл, 2004, 4 дэх тал

байдлаар илэрхийлэгдэх хэлбэрийн шинжтэй бөгөөд харагдах байдлыг тодорхойлдог бүтээгдэхүүний загварын зургийг түүний эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлох нэг шалгуураар авч үзэх боломжтой. Бүтээгдэхүүний загварт хамаарах бүтээгдэхүүний хувьд давхар оюуны өмчийн бусад төрлүүдээр хамгаалагдах боломжтой. Жишээлбэл, гурван хэмжээст эзлэхүүнт дүрсийн хувьд бүтээгдэхүүний загвараас гадна барааны тэмдгээр хамгаалагдах боломжтой<sup>21</sup>. Барааны тэмдэг нь дүрсээр илэрхийлэгдэж болох бөгөөд бүтээгдэхүүний загвартай ижил хэлбэрийн шинжийг агуулдаг, эрхийн хамгаалалтын хүрээг уг дүрсээс гадна түүнийг хэрэглэх бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалтын хүрээнд тодорхойлдог онцлогтой. Бүтээгдэхүүний загвар өөрөө бүтээгдэхүүний загварын патентын эрхийн хамгаалалтын хүрээг тогтоодог онцлог ялгаатай гэж тодорхойлж болох юм. Иймд бүтээгдэхүүний загварын патентын эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлолтын хүрээнд тогтоож байгаа нь бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын мөн чанарт нийцэхгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна.

### III. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Бүтээгдэхүүний загварыг хамгаалахад Монгол Улсын нэгдэж орсон оюуны өмчийн олон улсын гэрээ хэлэлцээрүүд үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Бүтээгдэхүүний загварыг олон улсын түвшинд зохицуулсан олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн хувьд бүтээгдэхүүний загварын эрхийн хүрээг зохицуулаагүй байна. Тухайлбал, Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц<sup>22</sup>-д бүтээгдэхүүний загварыг оюуны өмчид хамааруулсан байх бөгөөд Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын хэлэлцээр<sup>23</sup>-ийн 5 *quinquies* зүйлд гишүүн бүх улсад бүтээгдэхүүний загварыг хамгаална гэж, Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр<sup>24</sup> -ийн 4 дүгээр анги бүтээгдэхүүний загварт хамаарч, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “гишүүд бие дааж бүтээгдсэн бүтээгдэхүүний шинэ буюу өвөрмөц загварт хамгаалалт олгоно” гэж, Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай Локарногийн хэлэлцээр<sup>25</sup>-ийн 1 дүгээр зүйлийн 3(3)-д бүтээгдэхүүний загварт хамаарах бүтээгдэхүүнийг ангилсан жагсаалт, тэдгээрт хамаарагдах ангилал болон дэд ангиллыг тогтоосон байх бөгөөд бүтээгдэхүүний загварт хүнсний бүтээгдэхүүн, гоёл чимэглэл, хөгжмийн зэвсэг, тавилга, эмнэлгийн болон лабораторийн, гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнийг зөөж тээвэрлэх болон худалдаалахад зориулсан сав баглаа боодол зэргээр бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн 32 ангилж<sup>26</sup>, бүтээгдэхүүний загварын объектод хамааруулжээ. Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах хэлэлцээр<sup>27</sup>-ийн 26 дугаар зүйлд “Эрх хамгаалагдсан бүтээгдэхүүний загвар эзэмшигч нь эрх хамгаалагдсан загварын жинхэнэ хувь буюу хуулбар байдлаар загварыг үйлдвэрлэх, борлуулах болон мэдэгдэхүйц хэмжээгээр хуулбарласныг гаднаас оруулж байгаа бүтээгдэхүүнд эрх эзэмшигчээс зөвшөөрөл аваагүй уг үйлдлийг худалдааны зорилгод хэрэглэж байвал гуравдагч этгээдийг хориглон зогсоох эрх эдлэх”-ээр заажээ. Харин Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээр<sup>28</sup>-ийн тусламжтай гишүүн орнуудад нэг мэдүүлгээр нэг зэрэг бүтээгдэхүүний загвараа хамгаалуулах боломжийг олгодог бөгөөд олон улсын хадгалалтад бүтээгдэхүүний загварын зургийг хамааруулдаг байгаа нь бүтээгдэхүүний загварын хамгаалалтыг олон улсад хавсаргасан зургийн хүрээнд авч үздэгийг илтгэж байна гэж дүгнэх боломжтой.

<sup>21</sup> Оюуны өмчийн газар, Оюуны Өмч-Бизнес цуврал дугаар 2, *Хараа булаахуй*, орч.Г.Оюунгэрэл, 2004, 4 дэх тал, 8 дахь тал

<sup>22</sup> Монгол Улс 1978 оны 10 дугаар сарын 10-ны өдөр соёрхон баталсан.

<sup>23</sup> Монгол Улс 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталсан.

<sup>24</sup> Монгол Улс 1997 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр нэгдэн орсон.

<sup>25</sup> Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр соёрхон баталсан.

<sup>26</sup> Оюуны өмчийн газар, *Оюуны өмчийн үндсэн асуудал*, орч. Б.Одгэрэл, З.Гэрэлмаа, 2021, 32-33 дахь тал

<sup>27</sup> Монгол Улс 1997 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр нэгдэн орсон

<sup>28</sup> Монгол Улс 1997 оны 3 дугаар сарын 12-ны өдөр нэгдэн орсон



Тухайлбал уг хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн дагуу олон улсын хадгалалт нь мэдүүлэг, загварын нэг буюу түүнээс олон гэрэл зураг эсхүл график дүрслэлээс бүрддэг бөгөөд тогтмол хэвлэлд хадгалуулсан гэрэл зураг буюу график дүрслэлийн хар цагаан буюу хэрэв мэдүүлэг гаргагч хүсвэл өнгөт хуулбарыг нийтлэхээр заажээ. Бүтээгдэхүүний загварын олон улсын хамгаалалтын хувьд бүтээгдэхүүний загварын зургийг хадгалуулж, хамгаалдаг олон улсын тогтолцоо үйлчилж байна. Дээрх гэрээ хэлэлцээрүүдэд бүтээгдэхүүний загварын патентын онцгой эрхийн хүрээг тодорхойлоогүй байгаа нь бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын мөн чанар, онцлогоос хамааралтай гэж үзэх үндэслэлтэй.

Түүнээс гадна бүтээгдэхүүний загварын тодорхойлолт ба зургийн хоорондын хамаарлын талаар эдгээр гэрээ хэлэлцээрүүдэд дурдаагүй байна. Зарим оюуны өмчийн төрлүүдийн хувьд олон улсын гэрээ хэлэлцээрээр эрхийн хамгаалалтын хүрээг тогтоох хүрээнд тухайлсан хамаарлыг тодорхойлсон байдаг, жишээлбэл шинэ бүтээлийн патентын тухайд шинэ бүтээлийн тодорхойлолт, томъёоллын хоорондын харилцан хамаарлыг Патентын хамтын ажиллагааны гэрээ<sup>29</sup>-ний 6 дугаар зүйлд "... шинэ бүтээлийн томъёоллын заалтууд нь ойлгомжтой, товч тодорхой бөгөөд шинэ бүтээлийн тодорхойлолтоор бүрэн баталгаажсан байвал зохино" гэж тусгайлан тодорхойлсон. Дээрх хамаарлаас шинэ бүтээлийн патентын эрхийн хамгаалалтын хүрээг тогтоодог томъёоллын агуулгыг тодорхойлолт тайлбарладаг гэж тодорхойлох боломжтой байна. Харин бүтээгдэхүүний загварын тодорхойлолтын хувьд бүтээгдэхүүний загварыг төлөөлөх зургийг тайлбарлах олон улсын зохицуулалт байхгүй байгаа нь бүтээгдэхүүний загварын тодорхойлолтын хууль зүйн ач холбогдол багатайг илтгэж байна гэж үзэх боломжтой байна. Бүтээгдэхүүний загварыг патентаар улс орнуудын хувьд өөр өөр арга зам, практикийг нэвтрүүлсэн байдаг<sup>30</sup> ч бүтээгдэхүүний загварын патентыг бүтээгдэхүүний загварын зурагт олгодог. БНХАУ-д загварын патентын эрхийн хамгаалалтын хүрээг зураг болон гэрэл зурагт харуулсан байдлаар тодорхойлдог байна.<sup>31</sup> АНУ-д мөн бүтээгдэхүүний загварын зураг өөрөө гол тодорхойлолт болдог ерөнхий зарчим үйлчилж, мэдүүлэгт заавал тодорхойлолт хавсаргах шаардлага тавьдаггүй, гэхдээ тодорхойлж бичихийг хориглодоггүй байна<sup>32</sup>. БНСУ-д загварын эрхийн хамгаалалтын хүрээг эрхийн хэрэгжилтийг хангах хүрээнд тодорхойлохдоо зурагт хамааруулсан байх бөгөөд "бүртгэгдсэн загвартай ижил загвар эсэхээс гадна тодорхой эрхийн хамгаалалтын хүрээний хувьд ижил төстэй эсэх, загварын эрхийг хангахад үндсэн зорилго хангагдахгүй хүрээнд тодорхойлдог байна."<sup>33</sup> Бүтээгдэхүүний загварыг олон улсын түвшинд зохицуулсан олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн хувьд болон бусад орнуудын хууль тогтоомжийн хүрээнд бүтээгдэхүүний загварын эрхийн хүрээг зохицуулаагүй байгаа нь олон улсын хэмжээнд бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын мөн чанар бүтээгдэхүүний гадаад харагдах байдлын уран сайхны шийдэл буюу бүтээгдэхүүний загварын зураг руу чиглэж, нүдэнд тусч ялгарах өвөрмөц шинжийг зурагт харуулахыг чухалчилж ирсэнтэй холбоотой гэж үзэх үндэслэлтэй байна.

#### IV. ДҮГНЭЛТ

Үндэсний хууль тогтоомжийн хүрээнд бүтээгдэхүүний загварт патент олгохдоо бүтээгдэхүүний загварын зургийг үндэслэж ирсэн байх бөгөөд энэ үндсэн зарчим Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгад (2021) хадгалагдан патент олгох шийдвэр гаргах болон патент олгохдоо бүтээгдэхүүний загварын зургийг авч үзэж байгаа нь тус хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт патентын эрхийн хамгаалалтын хүрээг бүтээгдэхүүний загварын хувьд тодорхойлолтод зааснаар тодорхойлох заалттай зөрчилдөж байна. Түүнээс

<sup>29</sup> Монгол Улс 1991 оны 2 дугаар сарын 27-ны өдөр нэгдэн орсон.

<sup>30</sup> Оюуны өмчийн газар, *Оюуны өмчийн үндсэн асуудал*, орч. Б.Одгэрэл, З.Гэрэлмаа, 2021, 23 дахь тал

<sup>31</sup> Patent law of China, 1984, Article 64 (2), <https://www.wipo.int/patent-judicial-guide/en/full-guide/china>

<sup>32</sup> USPTO, *Design patent application guide*, <https://www.uspto.gov/patents/basics/apply/design-patent>

<sup>33</sup> KIPO, *Designs*, 17 August 2021, [https://www.kipo.go.kr/en/HtmlApp?c=93001&catmenu=ek04\\_01\\_02](https://www.kipo.go.kr/en/HtmlApp?c=93001&catmenu=ek04_01_02)

гадна бүтээгдэхүүний загварын тодорхойлолт хавсаргасан зургийн харагдах байдлаас зөрвөл хэрхэх асуудлыг хуулиар зохицуулаагүй, бүтээгдэхүүний загварын тодорхойлолтод агуулгын тусгайлсан шаардлага тавьдаггүй, тодорхойлолт ба зураг хоорондын харьцааг тогтоосон эрх зүйн зохицуулалт үндэсний болоод олон улсын эрх зүйн тогтолцоонд илрэхгүй байгаа нь бүтээгдэхүүний загварын патентын эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлолтод заасны дагуу тодорхойлох асуудал нь бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын мөн чанартай зөрчилдөж байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Иймд бүтээгдэхүүний загварын патентын эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлох асуудлыг дахин эргэн харах хэрэгтэй байна. Судалгааны үр дүнд Патентын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын хүрээг бүтээгдэхүүний загварын зурагт хамааруулан өөрчлөх санал дэвшүүлж байна. Томьёоллын хувьд “бүтээгдэхүүний загварын хувьд бүтээгдэхүүний загварын зурагт харуулснаар” гэж өөрчлөх саналтай байна.

Бүтээгдэхүүний загварын үндсэн шинж нь харагдах байдлаараа илэрхийлэгддэг, тэрхүү харагдах байдлыг тодорхойлдог бүтээгдэхүүний загварын зураг нь түүний эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлох нэг шалгуур болно гэж үзэж байна. Ингэснээр бүтээгдэхүүний загварын эрхийн зүйн хамгаалалтын мөн чанарыг бүрэн тодорхойлох боломжтой болох юм.



**ЭХ СУРВАЛЖ****Хууль тогтоомж:**

1. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын хэлэлцээр, 1984.
2. Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай Локарногийн хэлэлцээр, 2000.
3. Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээр, 1997.
4. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, 2010, 2021.
5. Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц, 1978.
6. Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр, 1997.
7. Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах хэлэлцээр, 1997.
8. Оюуны өмчийн тухай хууль (2020).
9. Оюуны өмчийн газар, *Оюуны өмчийн хууль тогтоомжийн системчилсэн эмхтгэл*, 1999.
10. Оюуны өмчийн газрын даргын тушаал, 2021, “Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэгт мөн чанарыг шүүлт хийх, нийтэд мэдээлэх, патент олгох, улсын бүртгэлд өөрчлөлт оруулах журам батлах тухай тушаал”-ын зургаадугаар хавсралт.
11. Патентын тухай хууль, 1993, 2006, 2021.
12. Патентын газар, *Патентын тухай хууль тогтоомжийн эмхтгэлийн хавсралт*, 1996.
13. Үндэсний хөгжлийн газрын харьяа Патентын газар, *Патентын тухай хууль тогтоомжийн эмхтгэл*, 1994.

**Ном, сурах бичиг:**

1. Д.Дэмбэрэл, Г.Гомбо, Ц.Батжаргал, *Шинэ бүтээлийн патент*, МУТИС, 2000
2. Д.Цолмон, Э.Золзаяа, *Оюуны өмчийн эрх зүй*, гарын авлага, хоёр дахь хэвлэл, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөл, 2017.
3. Д. Цолмон, *Оюуны өмч*, Оюуны өмчийн газар, 2001
4. З.Намжил, *Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага, Оюуны өмчийн лавлах*, Урлах эрдэм, 2008.
5. З.Намжил, *Патент-эрх зүйн оньс*, Гэрэлт судар, 2000.
6. Н.Чинбат, *Иргэний эрх зүй лекцийн товчоон, Ерөнхий анги*, Адмон принт, 2014.
7. Оюуны өмчийн газар, *Оюуны өмчийн үндсэн асуудал*, орч. Б.Одгэрэл, З.Гэрэлмаа, 2021.
8. Оюуны өмчийн газар, *Хараа булаахуй*, орч. О.Оюунгэрэл, 2009.
9. Оюуны өмчийн газар, *Монгол улсын оюуны өмчийн байгууллагын үүсэл хөгжил*, Мөнхийн үсэг, 2007.
10. Техникийн дэвшил, стандарчиллын улсын хороо, *Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг*, 1990.
11. Э.Мягмардорж, *Оюуны өмчийн эрх зүйн үндсэн асуудлууд*, Оюуны өмчийн газар, 2003.

**Гадаад эх сурвалж:**

1. APIC, JPI, *IP Theses, IP Community*, 2005.
2. JPI, *Industrial property rights standard textbook*, 2007.
3. U.S. Patent and Trademark Office, *A guide to filing a design patent application*, 1998.

4. WIPO, *Intellectual property handbook*, 2012.
5. Philippe J.C. Signore, *Design Patent Protection in the United States*, epi Information Journal, 2/2001.

#### ***Цахим мэдээлэл***

1. Америкийн Нэгдсэн Улсын Патент, Барааны Тэмдгийн Газрын цахим хуудас: <https://www.uspto.gov/>
2. Бүгд Найрамдах Солонгос Улсын оюуны өмчийн газрын цахим хуудас: <https://www.kipo.go.kr/>
3. Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын цахим хуудас: <https://www.wipo.int/>
4. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/>
5. Оюуны өмчийн газрын Аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн сан: <https://publish.ipom.mn/>

## **THE ISSUE OF DETERMINING THE SCOPE OF PROTECTION OF A DESIGN PATENT RIGHT**

***Odgerel.B***

*Ph.D candidate of the University of Internal Affairs*

#### **ABSTRACT:**

In the revision of the Patent Law of Mongolia (2021), for the patent right for inventions, utility models, and designs, the scope of protection is newly regulated. In Article 47, Section 47.1 of the Law, “the scope of protection given by patent rights for inventions, utility models shall be defined as a claim, and for the design shall be defined as a description.” The issue of determining the scope of protection of intellectual property rights is inextricably linked to the basic differences between each type of intellectual property. This study aims to identify the current legal challenges in determining the scope of design patent right protection as defined by its description by examining substantial features of protection of a design right, patent granting procedure on a design patent, and then securing the ownership rights by granted patent.

#### **KEYWORDS:**

Scope of protection, substantial features of protection of a design right, design patent, patent granting procedure, legal environment

## ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ: ХАРЬЦУУЛАЛТ



**Ж.Сайнхишиг**

*Судлаач, МУИС-ийн Хууль зүйн сургууль болон  
Лондонгийн Күйн Мэри их сургуулийн магистр*

### ТОВЧЛОЛ:

Энэ өгүүллээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг хариуцаж буй Засгийн газрын болон парламентын харьяа байгууллага, албан тушаалтны чиг үүрэг, уялдаа холбоо, ажлын зохион байгуулалтыг харьцуулан судлав. Энэ хүрээнд өгүүллийн эхний хэсэг (1) хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын онолын ойлголт, (2) хуулийн төсөл боловсруулах ажлын зохион байгуулалтын загвар, төвлөрсөн, эс төвлөрсөн загварын тухай, зарим улсын хуулийн төсөл боловсруулах үүрэгтэй бүтцийн талаар судлав. Түүнчлэн хуулийн төсөл боловсруулах, хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх чиглэлээр гадаад улсын зарим парламентын тамгын газрын чиг үүрэг, бүтцийн тухай товч харьцуулалт хийж, Монгол улс дахь хуулийн төсөл боловсруулах эрх зүйн зохицуулалт, ажлын зохион байгуулалтыг тоймлон авч үзэв.

### ТҮЛХҮҮР ҮГС:

Хуулийн төсөл боловсруулах нь, хуулийн төсөл боловсруулах ажлын зохион байгуулалт, төвлөрсөн загвар, эс төвлөрсөн загвар, Хууль тогтоомжийн тухай хууль

### I. ОРШИЛ

Хууль тогтоох үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг судлан нийгмийн харилцааг хуульчлах санаачилга гаргах, хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх зэрэг тасралтгүй үргэлжлэх ажиллагаа юм. Хууль тогтоох ажиллагааны зохион байгуулалт нь хууль тогтоомжийн чанар, үр нөлөө, хэрэгжилтэд чухал ач холбогдолтой.

Улсын Их Хурлаас Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг 2001 онд, Хууль тогтоомжийн тухай хуулийг 2015 онд тус тус батлан хэрэгжүүлж эхэлснээс хойш хууль боловсруулах харилцааг хуулиар журамлан тогтоох ирсэн уламжлалтай. Гэвч Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг судлах, шаардлагатай бол зохих сайжруулалт хийх шаардлага тулгарч байна. Улсын Их Хурлаар хуулийн төсөл хэлэлцэх батлах үед төслийн боловсруулалт чанаргүйн улмаас их хэмжээний засвар орох, Үндсэн хуулийн үзэл баримтлалтай илтэд зөрчилтэй хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн

мэдүүлэх, хууль тогтоомжийн боловсруулалтын чанар хангалтгүйн улмаас хэрэгжилтэд хангалтгүй байх, хуулийн зохицуулалт батлагдсан даруйд, эсхүл хэрэгжиж эхлэхээс өмнө нэмэлт, өөрчлөлт дахин орох зэрэг хууль тогтоомжийн боловсруулалтын чанартай холбоотой асуудлууд манай улсад тулгамдаж байна.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын зохион байгуулалт, холбогдох төрийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээ, бүтцийг боловсронгуй болгох нь эдгээр асуудлыг шийдвэрлэх нэг гарц байж болно. Иймд энэхүү өгүүллээр гадаадын зарим улсын хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын зохион байгуулалтыг харьцуулан судлах замаар Монгол улсад хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааг боловсронгуй болгох санал дэвшүүлэхээр зорьсон болно. Энэ зорилгын хүрээнд (1) хуулийн төсөл боловсруулах тухай онолын ойлголт, (2) хуулийн төслийг боловсруулах ажлын зохион байгуулалт буюу төрийн байгууллагын чиг үүргийн харьцуулалт, (3) парламентын шатанд хуулийн төслийг боловсруулах, сайжруулах чиг үүргийг гүйцэтгэж байгаа бүтцийг харьцуулсан судалгаа.

## II. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Хуулийн төсөл боловсруулах ажил нь хууль тогтоох ажиллагааны нэг хэсэг юм. Энэ хэсэгт хуулийн төсөл боловсруулах ажлын ойлголт, цар хүрээг тодорхойлон авч үзнэ. Хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааг (legislative drafting) өргөн ба явцуу утгаар тодорхойлж болно. Өргөн утгаар авч үзвэл, хуулийн төсөл боловсруулах гэдэгт “(1) төсөл боловсруулах зааврыг ойлгох, (2) түүнд дүн шинжилгээ хийх, (3) хуулийн төслийн бүтцийг гаргах, (4) эх бичвэр зохиох болон (5) бүтээгдэхүүнийг шалгаж, туршихаар хүргүүлэх” гэсэн таван үе шатыг багтаан авч үздэг.<sup>1</sup> Явцуу утгаараа зөвхөн эх бичвэр зохиох үе шатыг төсөл боловсруулах ажил гэж тодорхойлж болно. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөл боловсруулах гэдэг нь хууль тогтоомжийн үзэл баримтлалыг хуулийн эх бичвэр болгон хувиргах үйл явц юм.<sup>2</sup> Энэ утгаараа хуулийн төсөл боловсруулах нь аливаа текст бичих явцтай адил шинжтэй гэж судлаачид үздэг.

Судлаачид төсөл боловсруулах үйл явцыг төлөвлөх, зохиох буюу бичих, засварлах, хянах (planning, composing, revising and editing) гэсэн дөрвөн үндсэн үе шатанд хуваан авч үзсэн байдаг.<sup>3</sup> Гэхдээ хуулийн төсөл боловсруулах ажил нь энэ дөрвөн үе шатаар шулуун явах шаардлагагүй, эдгээр үе шат дахин давтагдах буюу рекурсив шинжтэй ажил гэдгийг судлаачид тэмдэглэдэг.

Эхний шат буюу төлөвлөх шатанд хуулийн төсөл боловсруулахаас өмнө боловсруулах хуулийн норматив агуулгыг гаргана. Өөрөөр хэлбэл хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлно. Дараа нь шинээр боловсруулах хуулийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн сангийн аль хэсэгт хамаарахыг тодорхойлно. Үүнд, нийтийн эсхүл хувийн эрх зүйн салбар, тэр дундаа тухайлбал сонгуулийн эсхүл арилжааны хууль тогтоомжид хамаарна зэргээр тодорхойлж, эрх зүйн эрэмбийн хувьд органик хуулийн өмнө, эсхүл дараа орох зэргийг тодорхойлно. Дараа нь хуулийн эх бичвэрийн бүтцийг тоймлох, гол нэр томъёог тодорхойлно. Мөн нийтлэг эрх бүлийн орнуудын хувьд өмнөх прецедентийг тогтоох шаардлагатай. Эх бичвэрийн бүтцийг тодорхойлоход хоёр асуудлыг нарийвчлан авч үзэх ёстой.<sup>4</sup> Эх бичвэрийн бүтэц нь нэг талаас хуулийн агуулгын логик бүтцийг, тухайлбал, он цагийн дараалал, учир шалтгааны холбоо, зохион байгуулалтын шатлалыг тусгаж агуулгаа илэрхийлэх зорилготой бол нөгөө талаасаа тухайн хуулийн хаялагдсан этгээд буюу уншиж, хэрэглэх субъектэд хандсан байх ёстой.

<sup>1</sup> Энэ нь нийтлэг эрх зүйн бүлийн орнуудад түгээмэл хандлага юм. Н Xanthaki, Thornton's Legislative Drafting, 5th edn. London, Bloomsbury, 2013), Н Xanthaki, Drafting Legislation: Art and Technology of Rules for Regulation (Oxford, Hart Publishing, 2014)

<sup>2</sup> U Karpen, Н Xanthaki (Eds), Legislation in Europe: A Comprehensive Guide for Scholars and Practitioners (London, Bloomsbury, 2017) 145-63.

<sup>3</sup> Мөн тэнд.

<sup>4</sup> Мөн тэнд.

Дараагийн шат буюу эх бичвэрийг зохиох (бичих) шатанд хуулийн төслийн эхний хувилбарыг бичнэ. Ингэхдээ ерөнхийгөөс тусгай руу гэсэн аргаар бичилтийг хийж, агуулгыг хуулийн зүйл, хэсэг, заалт шаардлагатай бол бүлэг, ангид хувааж бичнэ. Ерөнхий зохицуулалт гэдэгт хуулийн зорилго, зохицуулах харилцаа, хамрах хүрээ зэргийг хамруулна. Эдгээрийг томъёолсны дараа гуравдугаар шат буюу хянан засварлах (revising) шатанд анхны төслийг гадна, дотно талаас нь хянаж засварлана. Судлаач Стефан Хөфлер нарын үзэж буйгаар эхний боловсруулсан төслийг “(i) төлөвлөсөн агуулга буюу зохицуулалтыг оновчтой (ассигасу) илэрхийлсэн эсэх; (ii) материаллаг ба формал легистиксийн дүрэмд нийцэж байгаа эсэх; ба (iii) хэл зүйн чанар, ялангуяа ойлгомжтой, уншихад хялбар байдал хангагдсан эсэх”<sup>5</sup> гэсэн гурван шалгуураар хянан засварлах шаардлагатай.

Сүүлийн шатанд нэгэнт боловсруулсан хуулийн төсөлд редакцийн засвар (editing) хийнэ. Энэ шатанд төсөлд томоохон өөрчлөлт оруулах боломжгүй бөгөөд редакцийн засвар нь төслийг хэвлэхэд шаардлагатай формаль болон хэл зүйн засварыг хийдэг байна.

### III. ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2017 онд хэвлэгдсэн “Европ дахь хууль тогтоомж” бүтээлд хуулийн төсөл боловсруулах ажлыг боловсруулах субъект, ажлын зохион байгуулалтын хэлбэр зэргийг шалгуур болгон төвлөрсөн, төвлөрсөн бус загвар гэж хуваан авч үзсэн байдаг.<sup>6</sup>

#### 3.1. Төвлөрсөн бус загвар

Төвлөрсөн бус загварт Франц, Герман, Швед, Швейцар зэрэг иргэнлэг эрх зүйн бүлийн орнууд багтдаг. Энэ загварын орнууд хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг ерөнхий, төвлөрсөн бус чиг үүрэг гэж үздэг бөгөөд тухайн салбарын мэргэжлийн мэдлэгтэй хүмүүс төслийг боловсруулдаг онцлогтой.<sup>7</sup> Өөрөөр хэлбэл, Засгийн газрын холбогдох яамны тухайн салбарыг хариуцсан мэргэжилтэн хуулийн төслийг боловсруулдаг. Мөн шаардлагатай тохиолдолд төсөл боловсруулах ажилд мэргэшсэн эрдэмтэн судлаач, хуульчдыг татан оролцуулж болно.

Төвлөрсөн бус загварын давуу тал нь төсөл боловсруулж буй мэргэжилтэн, уг хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий албан хаагчид хоорондоо мэдээлэл солилцох бололцоог бүрдүүлдэг явдал юм. Тухайлбал, салбарын яамны хөдөлмөр эрхлэлтийг хариуцсан мэргэжилтэн тухайн хуулийг төслийг боловсруулах асуудлыг хариуцдаг тул хууль тогтоомжийн хэрэглээ, практикт нийцэж байгаа эсэхэд анхаарал хандуулж чаддаг байна. Энэ загварт төсөл боловсруулагч нь бодлогын асуудалд оролцох боломжтой гэж үздэг. Харин уг загварын сул тал нь салбарын мэргэжилтнүүдийн хууль зүйн техник, хуулийн хэллэгийн мэдлэг, ур чадвар сул байдаг ажээ. Энэ сул талыг нөхөхийн тулд хууль зүйн техникийн тогтмол сургалт явуулах, хууль боловсруулах зааврыг гаргах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж болно.

#### 3.2. Төвлөрсөн загвар

Хоёр дахь загвар буюу төвлөрсөн загварт Австрали, Канад, Шинэ Зеланд, Их Британи, АНУ зэрэг нийтлэг эрх зүйн бүлийн орнууд багтдаг. Энэ загварын улсууд төсөл боловсруулах ажлыг тодорхой, төвлөрсөн чиг үүрэг гэж үздэг. Энэ загварт салбарын яам, парламент дахь бодлого тодорхойлогч нь төлөвлөж буй хууль тогтоомжийн эх бичвэрийг төлөвлөх, бичих ажлыг төсөл бичигч тусгай мэргэжилтэнд (drafting specialists) хариуцуулдаг байна.

Энэ загварын давуу тал нь хуулийн төслийг зөвхөн төсөл бичихэд мэргэшсэн, ур чадвар, туршлагатай мэргэжилтнүүд боловсруулдаг явдал юм. Мэргэжлийн төсөл

<sup>5</sup> Stefan Höfler, Markus Nussbaumer and Helen Xanthaki, Legislative drafting in U Karpen, H Xanthaki (Eds), Legislation in Europe: A Comprehensive Guide For Scholars and Practitioners (London, Bloomsbury, 2017) 145-63.

<sup>6</sup> Мөн тэнд.

<sup>7</sup> Мөн тэнд.

боловсруулагчид бусад салбарт ажилладаг төрийн албан хаагчидтай харьцуулахад материаллаг болон формал легистиксийн дүрэм, хууль зүйн хэл ашиглах арга техник илүү эзэмшсэн байдаг. Мөн төсөл бичигч нь бодлогын асуудалд оролцох нь бага байдаг. Дорсигийн онцолсноор “төсөл бичигчийн үүрэг бол нэгэнт гаргасан бодлогыг тодорхой, хууль зүйн үндэслэлтэй, зорьсон бодлогыг үнэн зөв тусгасан, хэрэгжүүлэхэд хангалттай хууль тогтоомжийн текст болгон хувиргах явдал”<sup>8</sup> гэжээ.

Төвлөрсөн загварт бодлого тодорхойлогч буюу хууль санаачлагч (төслийн баг-bill team), төсөл бичигч хоорондын харилцаа холбоог зохион байгуулахад хүндрэл гардаг. Энэ утгаараа хууль санаачлагч нь боловсруулах хуулийн төслийн талаарх зааварчилгаа нарийвчилсан байдлаар гаргах шаардлагатай.

Төсөл захиалсан албан тушаалтан нь хуулийн төслийн зорилгыг сайн мэдэж, бодлогын сонголт хийх эрх мэдэлтэй байх нь чухал.<sup>9</sup> Түүнчлэн төсөл боловсруулагчийн бичсэн төслийг хууль санаачлагч, салбарын мэргэжилтэн нар хянаж байх нь хуулийн эх бичвэр зөв боловсруулагдахад ач холбогдолтой.

Дараагийн дугаарт төслийг хянан засварлах (revising) үе шатны зорилго нь хоёр загварт харилцан адилгүй байдаг. Төвлөрсөн загварт хянан засварлах ажил нь төслийн зорилго агуулгын хувьд үнэн зөв байх талыг голчлон анхаардаг бол төвлөрсөн бус загварт хяналт нь материаллаг болон формал легистиксийн<sup>10</sup> дүрэм журамд нийцэж байгаа эсэх, хэл зүйн хувьд зөв бичсэн эсэхийг шалгахад чиглэгддэг байна.<sup>11</sup>

### Англи Улсын туршлага

Хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны зохион байгуулалтыг төвлөрсөн загварт хамаарах Англи улсаар жишээ болгон авч үзье. Тус улсад хуулийн төсөл<sup>12</sup> боловсруулахын өмнө салбарын яам, мэргэжлийн болон сайн дурын байгууллага, лобби бүлгүүд зэрэг сонирхогч талууд хуулийн төслөөр зохицуулах асуудлаар урьдчилсан байдлаар зөвлөлдөж хэлэлцэх ажиллагаа явагддаг байна. Дараа нь Засгийн газрын салбарын яам нь “хуулийн төслийн баг-Bills team”-ийг байгуулна. Уг баг нь хуулийн төслийг бэлтгэх, парламентаар хэлэлцүүлэх ажлыг зохицуулах бодлого тодорхойлогч, хуулийн зөвлөхүүдээс бүрддэг.<sup>13</sup>

Энэ багийн нэг гол үүрэг нь тухайн хуулийн төслийг төлөвлөж, боловсруулах үүрэг бүхий мэргэжлийн төсөл бичигчид зориулсан зааварыг бэлтгэж Парламентын зөвлөхүүдийн албанд (Office of the Parliamentary Counsel (ОПС))<sup>14</sup> хүргүүлэх явдал юм. Зааварт хууль зүйн өнөөгийн нөхцөл байдал, шинэ төслийн хүрээнд ямар зорилгод хүрэхийг тодорхойлно.

Нэг хуулийн төсөлд Парламентын зөвлөхүүдийн албаны хоёр төсөл боловсруулагч ихэвчлэн томилогдон ажилладаг. Төсөл бичигч нь захиалагчийн зааврыг шинжилж, бодлого тодорхойлогчоос зарим тодруулга авч болно. Төсөл бичигч нь хуулийн төслийг төлөвлөх, боловсруулах ажлыг гүйцэтгэж, албаны дотооддоо хянан засварлуулахаар шилжүүлнэ. Мөн уг төслөө захиалсан яам руу хянуулахаар илгээнэ. Яамны хуулийн төслийн багийн төслийг судалж, санал дүгнэлтээ өгөх бөгөөд Парламентын зөвлөхүүдийн албаны төсөл бичигч текстийг зохих ёсоор хянан засварладаг байна.<sup>15</sup> Энэхүү санал авч хянах ажиллагааг захиалагчийн хүсэлтээр давтан гүйцэтгэж болно.

<sup>8</sup> TA Dorsey, *Drafter's Deskbook: A Practical Guide* (Alexandria, TheCapitol.Net, 2006) 8.

<sup>9</sup> H Xanthaki, *Thornton's Legislative Drafting* 142–44.

<sup>10</sup> Нийтлэг эрх зүйн бүлийн орнуудын legislative drafting technique гэдэг ойлголтыг эх газрын эрх зүйн бүлийн орнуудад франц хэлний формаль легистик (Франц хэлний *legistique formelle*) гэсэн ойлголтоор илэрхийлж байна.

<sup>11</sup> U Karpen, H Xanthaki (Eds), *Legislation in Europe: A Comprehensive Guide for Scholars and Practitioners* (London, Bloomsbury, 2017) 145-63.

<sup>12</sup> Westminster Bill гэж нэрлэдэг.

<sup>13</sup> U Karpen, H Xanthaki (Eds), *Legislation in Europe: A Comprehensive Guide for Scholars and Practitioners* (London, Bloomsbury, 2017) 145-63.

<sup>14</sup> Парламентын зөвлөхүүдийн алба нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын харьяаны бүтцэд байдаг. Тус албаны чиг үүрэгтэй дараах холбоосоор танилцана уу. [www.gov.uk/government/organisations/office-of-the-parliamentary-counsel/about](http://www.gov.uk/government/organisations/office-of-the-parliamentary-counsel/about)

<sup>15</sup> U Karpen, H Xanthaki (Eds), *Legislation in Europe: A Comprehensive Guide for Scholars and Practitioners* (London, Bloomsbury, 2017) 145-63.



Боловсруулах ажлын сүүлчийн шатанд Нийтийн танхимын Хууль зүйн нарийн бичгийн дарга,<sup>16</sup> эсхүл Лордуудын танхим дахь Нийтийн хуулийн төслийн газар (the Public Bill Office) хуулийн төслийн бичвэр нь материаллаг болон формал легистиксийн дүрэмд нийцэж байгаа эсэхийг шалгадаг.<sup>17</sup> Энэ зөвшөөрөл гарсны дараа хуулийн төслийг парламентаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлнэ.<sup>18</sup>

#### IV. ПАРЛАМЕНТИЙН ТАМГЫН ГАЗРААС ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Парламентын шатанд өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эхийг барьж ажиллах нь парламентын ажлын албаны нийтлэг чиг үүрэг боловч улс орон бүрийн Парламентын ажлын албаны чиг үүрэг харилцан адилгүй байна. Тухайлбал, (1) хуулийн төслийг эхийг Тамгын газар бус Хууль зүйн яам, намын бүлгийн албан хаагчид барьж ажилладаг Герман зэрэг улсын загвар,<sup>19</sup> (2) Тамгын газар нь зөвхөн хуулийн төслийн эхийг барих, арга зүйн зөвлөгөө үзүүлдэг Монгол зэрэг улсын загвар, (3) Тамгын газар нь төслийн эхийг барихын зэрэгцээ парламентын гишүүдэд хуулийн төсөл боловсруулж өгөх үйлчилгээ үзүүлэх бүтэцтэй АНУ, Ирланд зэрэг улсын загварыг ялган тодорхойлж болох юм. Өгүүллийн энэ хэсэгт 3 дахь загварт багтах улсуудын туршлагыг дэлгэрүүлэн авч үзье.

##### 4.1. Ирланд Улсын Парламентын Тамгын газар

Энэ хэсэгт Ирланд улсын парламентын түвшинд хуулийн төсөл боловсруулах, парламентаар хэлэлцэхэд Тамгын газрын зүгээс мэргэжил, арга зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлж буй бүтэц, чиг үүргийн онцлогыг тоймлон авч үзье. Тус улсын хувьд Засгийн газраас санаачилсан хуулийн төслийг Хууль зүйн яам нь (the Office of the Attorney General) боловсруулдаг бол парламентын гишүүдийн санаачилсан хуулийн төслийг боловсруулахад Парламентын тамгын газрын холбогдох нэгж туслалцаа үзүүлж байна.

Ирланд Улсын парламентын Тамгын газар нь парламентын дээд, доод танхимд туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Ерөнхий нарийн бичгийн даргад туслах үүрэг бүхий 5 туслах нарийн бичгийн дарга нар Тамгын газрын нэгжүүдийг удирдан ажиллаж байна. Үүнээс Парламентын асуудал хариуцсан туслах нарийн бичгийн даргын удирдлага доорх Төлөөлөгчдийн танхимд үйлчлэх газар (House service) нь хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэхэд гол үүрэг гүйцэтгэж байна. Тодруулбал, Төлөөлөгчдийн танхимд үйлчлэх газрын<sup>20</sup> Хуулийн төслийн хэлтэс (Bills Office) нь дараах үүргийг гүйцэтгэнэ:<sup>21</sup>

- Засгийн газраас өргөн барьсан болон гишүүн санаачилсан хуулийн төслүүдийг хэвлэх, хэлэлцүүлгийн шатанд нэмэлт, өөрчлөлт орсон болон ёсчлогдсон хуулийг хэвлэх, тараах;

<sup>16</sup> the Clerk of Legislation in the House of Commons

<sup>17</sup> U Karpen, H Xanthaki (Eds), *Legislation in Europe: A Comprehensive Guide for Scholars and Practitioners* (London, Bloomsbury, 2017). Хуулийн төслийг боловсруулах бэлтгэл ажлын сүүлийн шатанд Парламентын Тамгын газраас хуулийн төслийг агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хянаж буй дээрх ажиллагааг Монгол Улсад боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна. Уг ажиллагааг Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар УИХ-ын Тамгын газар хуулийн төслийн бүрдүүлбэрийг хянах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэж байна.

<sup>18</sup> R Rogers and R Walters, *How Parliament Works*, 6th edn (London, Longman, 2006) 190–196; Cabinet Office, 'Legislative Process: Taking a Bill Through Parliament', available at [www.gov.uk/legislative-process-taking-a-bill-through-parliament](http://www.gov.uk/legislative-process-taking-a-bill-through-parliament).

<sup>19</sup> Бундестагийн тамгын газар, түүний хороодын ажлын алба (Committee secretariats) Бундестагийн санаачилсан хуулийн төслийг боловсруулахад үүрэг гүйцэтгэдэггүй. Энэ үүргийг нь хуулийн төсөл өргөн барьж буй намын бүлэг гүйцэтгэнэ. Засгийн газрыг бүрдүүлж буй улс төрийн намын тухайд хуулийн төсөл боловсруулахдаа холбогдох яамдаас тусламж авдаг байна. Байнгын хорооны хэлэлцүүлгийн шатанд Холбооны засгийн газрын албан хаагч нь хуулийн төслийн бичвэр, хэллэгийг хариуцан ажилладаг байна. Susanne Linn, Frank Sobolewski, *The German Bundestag: Functions and Procedures*, 18<sup>th</sup> electoral term (2015).

<sup>20</sup> Тус газар нь Хэвлэлийн алба ба Бизнесийн хороо, Хуулийн төслийн алба (Bills Office), Асуулгын алба гэсэн 3 хэлтэстэй.

<sup>21</sup> <https://www.oireachtas.ie/en/how-parliament-is-run/houses-of-the-oireachtas-service/more-about-the-service/>

- Хууль тогтоомжийг батлах явцыг Үндсэн хууль, парламентын дэг (Standing Order), парламентын даргын захирамжтэй нийцсэн эсэхийг нягтлах, нийцлийг хангуулах;
- Хуулийн төсөл, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг Үндсэн хууль, парламентын дэгд нийцэж байгаа эсэхийг хянах;
- Парламентын хоёр танхим, хороод, мөн гишүүдэд хууль тогтоомжтой холбоотойгоор процедурын дэмжлэг үзүүлэх;
- Дээд, доод танхим болон хороодын дарга, засгийн газрын яам, гишүүд, тэдгээрийн ажилтанд процедурын зөвлөгөө өгөх.

Хуулийн төслийн хэлтэс нь хуулийн төсөл Үндсэн хууль, парламентын дэгд нийцэж байгаа эсэхийг хянах чиг үүргийг гүйцэтгэж байгаа нь анхаарал татаж байна.

Тамгын газрын дараагийн онцлог нэгж нь Туслах нарийн бичгийн дарга бөгөөд Парламентын ахлах хуулийн зөвлөхийн удирдлагад ажиллаж буй Парламентын хуулийн зөвлөхүүдийн хэлтэс (The Office of Parliamentary Legal Advisers (OPLA)) юм. Уг тус хэлтэс нь хэд хэдэн төрлийн бие даасан хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын хуулийн нэгж юм.<sup>22</sup> Тус хэлтэс дотроо дараах 4 нэгжтэй. Үүнд:

- “Парламентын хуулийн нэгж”<sup>23</sup> нь парламентын гишүүд, холбогдох албан тушаалтан, хороо, Комисст хуулийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлдэг. Мөн уг нэгж нь гишүүд, хороодод Засгийн газрын бодлогыг хянахад тусалж болохын зэрэгцээ шүүх хуралдаанд байгууллагаа төлөөлж оролцох үүргийг гүйцэтгэнэ.
- “Байгууллагын хуулийн нэгж”<sup>24</sup> нь Тамгын газарт байгууллагын дотоод асуудлаар хуулийн зөвлөгөө өгнө.
- “Гишүүдийн хуулийн төсөлд зөвлөгөө өгөх нэгж”<sup>25</sup> нь парламентын хувь гишүүдэд хуулийн төсөлтэй холбоотой зөвлөгөө өгөх бөгөөд хэрэв хүсэлт ирвэл тухайн хуулийн төслийг хорооны өмнөх шатанд хяналтын уншлага хийхэд зөвлөгөө өгдөг.
- “Гишүүдийн хуулийн төсөл боловсруулах нэгж”<sup>26</sup> нь хувь гишүүдийн хуулийн төслийг боловсруулах, хуулийн төслийн тайлбар танилцуулга бэлтгэхэд туслах, тус албанаас боловсруулсан хуулийн төслийг Байнгын хорооны болон тайлангийн үе шатанд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулах зэрэг үүргийг гүйцэтгэнэ.

#### 4.2.АНУ-ын Конгрессын Хууль боловсруулах зөвлөхүүдийн алба

Тус улсын хувьд Хууль тогтоох эрх мэдлийн харьяа 10 орчим агентлаг, байгууллага ажилладаг. Сенат, Төлөөлөгчдийн танхим тус бүрдээ өөрийн нарийн бичгийн даргатай (the Clerk). Төлөөлөгчдийн танхимын хувьд тус танхим, байнгын хороодоор хуулийн төсөл хэлэлцэн батлах үе шатны зохион байгуулалтын ажлыг Нарийн бичгийн даргын газар хариуцдаг<sup>27</sup> бол хуулийн төслийн бичвэрийг Хууль боловсруулах зөвлөхийн алба хариуцдаг байна.

Хууль боловсруулах зөвлөхийн алба нь “Хууль боловсруулах алба” нэртэйгээр 1918 онд анх байгуулагджээ.<sup>28</sup> Парламентын хоёр танхимд тус бүр Хууль боловсруулах зөвлөхийн алба (Offices of Legislative Counsel) ажилладаг бөгөөд түүнийг хуулийн зөвлөх (Legislative counsel) удирддаг.<sup>29</sup> Тус алба нь Тус албаны эрх зүйн байдлыг Хууль

<sup>22</sup> Тус албаны танилцуулгатай танилцана уу. [www.oireachtas.ie/en/how-parliament-is-run/houses-of-the-oireachtas-service/opla/](http://www.oireachtas.ie/en/how-parliament-is-run/houses-of-the-oireachtas-service/opla/)

<sup>23</sup> The Parliamentary Legal Advisory Unit.

<sup>24</sup> The Corporate Legal Advisory Unit.

<sup>25</sup> The Private Members' Bills Legal Advisory Unit.

<sup>26</sup> Private Members' Bills Drafting Service.

<sup>27</sup> <https://clerk.house.gov/About#OfficeService>

<sup>28</sup> Tobias A Dorsey (2006) Legislative Drafter's Deskbook: A Practical Guide, 27.

<sup>29</sup> <https://legcounsel.house.gov/about>

тогтоох ажлыг дахин зохион байгуулах тухай хуулийн дагуу зохицуулдаг<sup>30</sup> бөгөөд нийт 60 зөвлөхтэй, зөвлөх бүр өөрсдийн туслахтай ажилладаг. Уг алба нь байнгын хороо, хувь гишүүнд хуулийн төсөл боловсруулах үйлчилгээ үзүүлэх, хууль тогтоох процесст шаардлагатай бусад баримт бичгийн төсөл боловсруулахад хороодод туслах үүргийг гүйцэтгэдэг байна.<sup>31</sup>

Гэхдээ Төлөөлөгчдийн танхимд хэлэлцэж буй бүх хуулийн төслийг уг алба боловсруулахгүй. Тус албаны оролцоо нь аливаа нэг хуулийн төслийг боловсруулах аль үе шатанд, ямар чиг үүрэгтэйгээр оролцохоос хамаарна. Тобиос А.Дорсигийн тэмдэглэснээр “зарим тохиолдолд бодлого боловсруулах эхний үе шатанд захиалагчид бодлогыг сайн ойлгож мэдэхэд болон төслийг бичих хугацааг багасгах зорилгоор тус албанаас үйлчилгээ авдаг байхад бусад тохиолдолд хуулийн зөвлөхөөс хуулийн эх бичвэрийг бичихэд зөвхөн техникийн туслалцаа авдаг байна. Уг албыг огт ашиглахгүй тохиолдол ч бас байдаг”<sup>32</sup> ажээ.

Тус алба нь үйл ажиллагаандаа үйлчлүүлэгчийн мэдээллийг нууцлах, хараат бус байх зарчмыг баримтална. Хуулийн төсөлд туслалцаа авах аливаа хүсэлт, үйл ажиллагаа нь өмгөөлөгч, үйлчлүүлэгч хоорондын нууцлалыг хадгалах гэсэн зарчмыг баримталж, нууц байдаг.

Хууль боловсруулах зөвлөхийн алба нь дараахь төрлийн хууль тогтоомжийн баримт бичгийг боловсруулахад туслалцаа үзүүлдэг:<sup>33</sup>

- Конгресст өргөн мэдүүлэхээр төлөвлөж буй шинэ хууль, тогтоолын төсөл;
- хуулийн төсөл, тогтоолыг Байнгын хороо, чуулганы хуралдаан дээр хэлэлцэх үед гаргасан нэмэлт, өөрчлөлт оруулах санал;
- Төлөөлөгчдийн Танхим, Сенатаас баталсан арга хэмжээний хоорондын зөрүүг шийдвэрлэхийн тулд Конфренц хороодын тайланд зориулсан хуулийн хэллэг;
- нэгдсэн хуралдаан дээр гаргасан тодорхой хүсэлтийн текст. Үүнд дэг, журмыг түдгэлзүүлэх тухай санал (гэхдээ хуулийн төслийн танилцуулсан хувилбарт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал байгаа бол), дахин санал болгох, чуулганд оролцогчдод зааварчилгаа өгөх саналууд багтана.

Үүнээс гадна Төлөөлөгчдийн танхимын хороод хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн мэдүүлбэл тус алба шаардлагатай бол төслийг хүчин төгөлдөр хуульд шигтгэж харьцуулсан хэвлэлтийг («Ramseyer» гэж нэрлэдэг) хорооны тайланд оруулахаар бэлтгэдэг.

Тус албаны ажлын ачааллын хувьд, 116 дугаар Конгрессын бүрэн эрхийн хугацаанд 29,414 хуулийн төсөл,<sup>34</sup> 2,373 тогтоолын төсөл, 16,021 нэмэлт, өөрчлөлтийн төсөл, нийт 47,588 хууль тогтоомжийн төсөл, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг боловсруулжээ.<sup>35</sup>

Тус улсын Төлөөлөгчдийн танхимын хувьд, захиргаа, зохион байгуулалт, мэдээллийн үйлчилгээг Клерк буюу Нарийн бичгийн дарга, түүний харьяа оффисууд хариуцаж байгаа бол хууль тогтоомжийн төсөл, нэмэлт, өөрчлөлтийн бичвэрийг Хууль боловсруулах зөвлөхийн алба хариуцаж байна. Өөрөөр хэлбэл, Байнгын хороо, гишүүдээс хуулийн төсөл санаачлах, боловсруулах, хэлэлцэн батлах ажиллагаанд хууль зүйн зөвлөгөө, туслалцааг үзүүлдэг тусгай бүтэц ажиллаж байна.

## V. МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсад хуулийн төсөл санаачлах, боловсруулах, хэлэлцэн батлах ажиллагааг

<sup>30</sup> Title V of the Legislative Reorganization Act of 1970 (2 U.S.C. 281 et seq.)

<sup>31</sup> Tobias A Dorsey (2006) Legislative Drafter's Deskbook: A Practical Guide, 27.

<sup>32</sup> Мөн тэнд.

<sup>33</sup> Тус албаны цахим хуудастай танилцана уу. <https://legcounsel.house.gov/about/our-services>

<sup>34</sup> Боловсруулсан хуулийн төслийн тоо олон боловч тус хугацаанд нийт 9,067 хуулийн төсөл Конгресст өргөн мэдүүлжээ.

<sup>35</sup> The Select Committee on the Modernization of Congress - Final Report (2022), 114.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан холбогдох аргачлалуудаар<sup>36</sup> тус тус зохицуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт хууль санаачлах эрхийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурал (УИХ)-ын гишүүн, Засгийн газар эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтоохоор заасан. Үүний дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд уг хүрээ, хязгаарыг хуульчилсан.

Хуулийн төсөл боловсруулах үе шатыг Хууль тогтоомжийн тухай хуульд дараах 8 үе шаттай явагдахаар заасан. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;
2. Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлах;
3. Хууль тогтоомжийн төслийг боловсруулах;
4. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх;
5. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах;
6. Хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах;
7. Хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;
8. Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, УИХ-д өргөн мэдүүлэх.

Дээрхээс үзэхэд, манай улс нь хуулийн төсөл боловсруулах ажлыг өргөн утгаар буюу тухайн хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлахаас эхлээд гарсан төслийг УИХ-д өргөн мэдүүлэх хүртэлх ажиллагааг хамруулж хуульд тодорхойлжээ.

Хуулийн төсөл боловсруулах үе шатны төлөвлөх шат нь хуулийн төслийн боловсруулалтын цаашдын чанарт нөлөөлөх чухал шат юм. Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд хуулийн төслийн үзэл баримтлалд тавигдах шаардлагыг тодорхойлсон байх бөгөөд уг шаардлагад төсөл нь Үндсэн хууль, бусад хуультай уялдах байдлыг тодорхойлохоор заасан. Гэвч манай улсад шинээр боловсруулах хуулийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн сангийн аль хэсэгт хамаарахыг тодорхойлох буюу эрх зүйн зохицуулалтын уялдааг хангах ажил хангалтгүй байгааг анхаарах нь зүйтэй.

Хуулийн төсөл боловсруулах ажлын зохион байгуулалтын тухайд Хууль тогтоомжийн тухай хуульд уг ажлыг хууль санаачлагч хариуцан зохион байгуулах<sup>37</sup> бөгөөд өөрөө буюу холбогдох байгууллагын албан тушаалтан, түүнчлэн судлаач, эрдэмтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулж болохоор заасан. Энэ утгаараа манай улс нь эс төвлөрсөн загварт ерөнхийдөө хамаарч байна. Өөрөөр хэлбэл, холбогдох яамд, УИХ-ын гишүүн, Ерөнхийлөгч хуулийн төсөл боловсруулах ажлыг хариуцан зохион байгуулдаг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар Засгийн газраас санаачлах хуулийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулахдаа холбогдох Засгийн газрын гишүүн хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг тухайн яам, холбогдох бусад яам, төрийн байгууллага, эрдэмтэн судлаач, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулдаг бөгөөд ажлын хэсгээс боловсруулсан хуулийн төслийн эхний хувилбарыг олон нийтээр хэлэлцүүлэх, цахим хуудсанд тавьж санал авах ажиллагааг явуулдаг.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төсөл Хууль

<sup>36</sup> “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”

<sup>37</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 9 дүгээр зүйл

тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцсэн эсэхийг эцэслэн хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгодог. Мөн шаардлагатай тохиолдолд, Сангийн сайд, Гадаад харилцааны сайд зөвшөөрөл олгохоор заажээ. Түүнчлэн Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн санаачилсан хууль тогтоомжийн төсөлдөө Засгийн газраас санал, дүгнэлт авдаг. Хууль тогтоомжийн тухай хуулийн дээрх зохицуулалтаас үзэхэд хуулийн төслийг нэгдсэн стандартад оруулах, Үндсэн хууль, бусад хуульд нийцэж байгаа эсэх асуудлаар Хууль зүй, дотоод хэргийн яам санал, дүгнэлтийн төсөл боловсруулах, зөвшөөрөл олгох чиг үүргийг гүйцэтгэж байна.

Парламентын хэлэлцүүлгийн шатанд Улсын Их Хурлын тамгын газар нь дараах ажлыг эрхлэн гүйцэтгэж байна:<sup>38</sup>

- Улсын Их Хурал, Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, ажлын хэсэг, гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, тусалцаа үзүүлэх;
- Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөл энэ хуулийн 36 дугаар зүйл, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдүүлбэр хангасан эсэхийг хянах, энэ хуулийн 13.1.14-т заасан тохиолдолд хууль зүйн дүгнэлт гаргах, төслийг зохих журмын дагуу өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангах;
- хуульд заасан үндэслэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн бусад төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах;
- Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийх;
- хууль тогтоомжийн төсөл өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх, батлах үйл ажиллагааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах;
- хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн төслийн эхийг барьж ажиллах;
- батлагдсан хууль тогтоомжийн эцсийн найруулгыг хийж албажуулах, нийтлэх, мэдээлэх;

Гэвч Улсын Их Хурлын гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийн хүрээнд тухайлсан гишүүний хуулийн төсөл боловсруулах ажлыг хариуцах чиг үүргийг УИХ-ын тамгын газар хэрэгжүүлдэггүй байна.

## VI. ДҮГНЭЛТ

Харьцуулсан судалгаанаас үзэхэд судлаачид дэлхийн улс орнуудын хуулийн төслийн боловсруулах ажлыг зохион байгуулалтын хувьд төвлөрсөн, эс төвлөрсөн гэсэн загварт хуваан авч үзсэн байна. Монгол Улсын тухайд хуулийн төслийг боловсруулах ажлыг хууль санаачлагчид зохион байгуулах үүргийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны зэрэгцээ Засгийн газраас боловсруулах хууль тогтоомжийн төслийг тухайн асуудлыг эрхэлсэн яам боловсруулж байна. Энэ утгаараа манай улс нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах эс төвлөрсөн ажлын зохион байгуулалттай улс гэж дүгнэж үзэхээр байна.

Гэтэл Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс хууль тогтоомжийн төсөл санаачлан боловсруулахад Улсын Их Хурлын харьяа буюу Тамгын газрын бүтцэд тусгайлсан, мэргэжлийн нэгж байгуулаагүй байгаа нь хуулийн тогтоомжийн нэгдмэл байдлыг хангахад сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Иймд Монгол Улсын тухайд АНУ-ын Конгрессын Хууль боловсруулах зөвлөхийн алба, Ирланд Улсын Парламентын хуулийн зөвлөхүүдийн алба зэрэг парламентын гишүүдэд хуулийн төсөл боловсруулах үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн алба буюу бүтэц байгуулаагүй асуудлыг цаашид анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

<sup>38</sup> Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйл

## ЭХ СУРВАЛЖ

### *Хууль тогтоомж*

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль, 2024 он
3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, 2024 он
4. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он
5. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан «Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал»,
6. “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”,
7. “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”,
8. “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”

### *Англи хэл дээрх*

1. H Xanthaki, Thornton’s Legislative Drafting, 5th edn. (London, Bloomsbury, 2013),
2. H Xanthaki, Drafting Legislation: Art and Technology of Rules for Regulation (Oxford, Hart Publishing, 2014)
3. U Karpen, H Xanthaki (Eds), Legislation in Europe: A Comprehensive Guide for Scholars and Practitioners (London, Bloomsbury, 2017)
4. TA Dorsey, Drafter’s Deskbook: A Practical Guide (Alexandria, TheCapitol.Net, 2006).
5. R Rogers and R Walters, How Parliament Works, 6th edn (London, Longman, 2006)
6. Cabinet Office, ‘Legislative Process: Taking a Bill Through Parliament’,
7. Susanne Linn, Frank Sobolewski, The German Bundestag: Functions and Procedures, 18th electoral term (2015).

## ORGANIZATION OF LEGISLATIVE DRAFTING: A COMPARISON

*Sainkhishig.J*

*(LL.M), NUM, Queen Mary University of London*

### **ABSTRACT:**

In this article, the functions, coordination, and work organization of governmental and parliamentary organizations and officials responsible for the drafting of legislation are compared. In this context, the first part of the article examines (1) the theoretical understanding of legislative drafting, (2) the organizational model of legislative drafting, centralized and decentralized models, and the structure responsible for drafting laws in some countries.

In addition, a brief comparison was made of the functions and structures of the parliamentary offices of some foreign countries in the field of draft law drafting and preparation for discussion of the draft law, and the legal regulations and work organization of draft law drafting in Mongolia were reviewed.

### **KEYWORDS:**

Legislative drafting, the drafting process, organizational models of legislative drafting; decentralization, centralization, Law on Legislation



## ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ ГАДААД УЛСААС МОНГОЛ УЛСАД БУЦААХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ



*Г.Ган-Эрдэнэ*

*Баянгол дүүргийн прокурорын газрын  
Хяналтын прокурор, Хууль цаазын дэд  
зөвлөх, хууль зүйн магистр*

### ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүллээр эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ болон хөрөн буцаах ажиллагаа нь практикт ямар түвшинд байгааг хууль тогтоомжийн үүднээс судалж, хөрөнгө буцаах ажиллагааны хүндрэл, тулгамдаж буй асуудал зэргийг онолын үндэслэл, шүүхийн практик, гадаад орнуудтай харьцуулан судалсан.

### ТҮЛХҮҮР ҮГС:

Хөрөнгө, хөрөнгө буцаах ажиллагаа, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ, олон улсын гэрээ, конвенц.

### I. ОРШИЛ

Гэмт хэргийн улмаас буюу хууль бус хөрөнгийг гадаад улсаас буцаан авчрах талаар Монгол Улс жил бүр тодорхой ажиллагааг хийж бусад улс оронтой эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулан ажилласаар байна. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ болон гадаад орнуудаас хөрөнгө буцаах ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль болон, Прокурорын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж тодорхой ажиллагааг хийж гүйцэтгэсний дараагаар хийж байна. Мөн гадаад орнуудаас мөнгө угаасан, авлигал авах зэрэг замаар бий болсон хууль бус хөрөнгийг буцаах ажиллагаанд Прокурорын байгууллага, Авлигатай тэмцэх газар хамтран ажилласаар байна.

Монгол Улс бол хөгжиж буй улс бөгөөд эдийн засгийн хувьд хараат, зах зээлийн эргэлтэд байгаа нийт бүтээгдэхүүний дийлэнх хэсгийг импортын бараа эзэлдэг, эдийн засаг болон төгрөгийн ханш тогтворгүй байдаг тул гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг гадаад улсаас буцаан авчрах, цаашлаад олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, холбогдох байгууллага, алба хаагчдын ур чадварыг энэ төрлийн ажиллагаанд чадварлаг болгох, хөрөнгө буцаах ажиллагааг хэвийн явуулах, бусад орны сайн туршлагыг судлах, суралцах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, тулгамдаж байгаа асуудлыг

шийдвэрлэх, хөрөнгө буцаах ажиллагааг нэмэгдүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөрөнгийг гадаад улс руу гаргах боломжийг олгохгүй байх зэрэг олон талын ач холбогдлыг харгалзан судалж өөрийн санал, дүгнэлтийг танилцуулж байна.

## **II. ХӨРӨНГӨ ОРЛОГО БУЦААХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ МӨН ЧАНАР, ЗОРИЛГО, ОНЦЛОГ**

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээгээр тухайн хоёр улс нь харилцах нийтлэг үндэслэл, харилцаж журам, хоёр талын эрх, үүрэг, иргэний хэрэг, эрүүгийн хэрэгт хэрхэн ажиллах, ялтан болон гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй хүнийг шилжүүлэх, хөрөнгө буцаах ажиллагааны талаарх зохицуулалтыг тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө буцаах ажиллагаа нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний нэг хэсэг юм.

Нэг улсаас, нөгөө улсад хөрөнгө буцаах ажиллагаа нь эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээнээс гадна олон улсын гэрээ, конвенцэд заасны дагуу явагдах бөгөөд тухайн хоёр улсын мөрдөн шалгах байгууллагууд харилцан гэмт хэрэгт тооцсон буюу гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө гэдгийг тогтоохын тулд хөрөнгийг битүүмжлэх, хязгаарлах ажиллагааг хийж гүйцэтгэдэг. Мөрдөн шалгах тодорхой ажиллагааны үр дүнд тухайн хөрөнгө нь гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө гэдэг нь тогтоогдож, тухайн улсын шүүхийн шийдвэр гарсны дагуу хөрөн буцаах ажиллагааг гүйцэтгэж байна.

Хөрөнгө буцаах ажиллагаа нь эрүүгийн хэргийн хүрээнд хөрөнгө буцаах ажиллагаа, захиргааны хэргийн хүрээнд хөрөнгө буцаах ажиллагаа, иргэний хэргийн хүрээнд хөрөнгө буцаах ажиллагаа гэсэн төрөлтэй байдаг.

Иргэний хэргийн хүрээнд хөрөнгө буцаах ажиллагаа нь улс орнууд иргэний хэргийн шүүхээр дамжуулан хөрөнгийг хязгаарлах, хураан авах, гэм хор, гэрээний үүргээ зөрчсөн, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргүүдтэй холбоотой үүссэн хохирол барагдуулах боломжтой.

Захиргааны хэргийн хүрээнд хөрөнгө буцаах ажиллагаа нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх журмаар хөрөнгө хураан авах нь тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилд хэрэглэгдэж, бага үнэлгээтэй хөрөнгө эсхүл тодорхой төрлийн эд хөрөнгөд хэрэглэгддэг. Зарим улс орнууд нь захиргааны хэргийн процессыг өндөр үнэлгээтэй хэргүүдэд шинэлэг байдлаар хэрэглэсэн байдаг. Үүнд захиргааны журмаар хөрөнгө хураан авах олон янзын арга хэрэглэж байгаагийн нэг нь “хууль ёсны ашиг сонирхлоосоо татгалзах” бөгөөд үүнд ижил процесс ажиллагааг баримталдаг.

## **III. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС БИЙ БОЛСОН ХӨРӨНГӨ БУЦААХ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр Монгол Улс нь 4 олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон байна.

Засгийн газар хооронд Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх талаар байгуулсан 2 талт гэрээ, хэлэлцээр 18 байна.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан хүний эрхийн 43, олон улсын аюулгүй байдал, зэвсэг хураах салбарын 22, дипломат консулын эрх зүйн 4, гэмт хэрэгтэй тэмцэх 25 конвенц, протоколд элссэн.

Гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг Монгол улсад буцаах ажиллагааг шүүхээр хянан шийдвэрлэгдэж, шүүхийн шийдвэр гарсны дараа буцаах ажиллагааг гүйцэтгэдэг. Үүний өмнө гадаад улсад байгаа тус хөрөнгийг хамгаалах, битүүмжлэх, эрэн сурвалжлах ажиллагааг гүйцэтгэж байна.

Дараах хууль, заавар, журамд хөрөнгө буцаах ажиллагааг тусгасан байна.

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль,
3. Улсын ерөнхий прокурорын баталсан “Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх” аргачилсан заавар,
4. Улсын ерөнхий прокурорын баталсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загвар” аргачилсан заавраар зохицуулсан байна.

Монгол Улсын шүүхийн шийдвэр гарсны дараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлд<sup>1</sup> заасан ажиллагааг явуулна, мөн тус хуулийн 19 дүгээр зүйлд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэхээр гүйцэтгэх хуудаст тодорхой заана. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахаар заасан байна. Гэтэл шүүхийн шийдвэрт гадаад улсад байгаа хөрөнгийг буцаах буюу гэмт хэргийн улмаас гадаад байгаа хөрөнгийг Монгол Улсад буцаан авчрах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тодорхой зохицуулаагүй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хамаарна.

Эрүүгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хөрөнгөтэй холбоотой асуудлыг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зохицуулалтууд нэгэн адил хамаарахаар зохицуулсан байна.

#### **IV. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС БИЙ БОЛСОН ХӨРӨНГӨ БУЦААХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ГАДААД ОРНЫ ЗАРИМ ТУРШЛАГА**

Хөрөнгө буцаах ажиллагааны чиглэлээр гадаадын зарим улс орнууд бие даасан хуультай бөгөөд энэхүү ажиллагаа нь өргөн цар хүрээтэй ойлголт юм. Улс орон бүр өөр өөрийн онцлогт тохируулан дотоодын хууль тогтоомждоо ялгамжтай байдлаар зохицуулж байна.

##### *Бүгд Найрамдах Солонгос Улс:*

Бүгд Найрамдах Солонгос Улс хөрөнгө буцаан авах ажиллагааг 2017 оноос Засгийн газрын албан ёсны тэргүүлэх чиглэлийн нэг болгож, улмаар энэ чиглэлийн үйл ажиллагааг идэвхтэй явуулах болсон байна.

Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг ихээр үйлдэгдэх болсонтой холбогдуулан 2018 онд Бүгд Найрамдах Солонгос Улсын Дээд прокурорын газрын бүтцэд хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураан авч буцаан олгох олон улсын хамтын ажиллагааны талаар судалгаа хийх, Ерөнхий прокурорын чиглүүлсэн хэргүүдэд хөрөнгийг мөшгөх, буцаан авах, буцаан олгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй тусгай нэгж - Эрүүгийн хэргийн улмаас олсон хөрөнгө буцаан авах алба /Criminal Asset Recovery Division/-ыг бий болгосон байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс гадаадын хэд хэдэн оронтой ялангуяа мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх өндөр эрсдэл бүхий татварын гэмт хэргүүд, залилах, авлигын хэргүүд, мөрийтэй тоглоом тоглох, завших, хэрэглэгчийг хуурч мэхлэх, бэлэн мөнгөөр болон виртуал хөрөнгийн худалдаа хийх зэрэг хэргүүд дээр хөрөнгө хураан авч буцаан авах ажиллагаанд сайтар анхааран ажиллаж байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс хөрөнгө буцаах ажиллагаа явуулах, эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар зохицуулахдаа хэргийн төрлөөс хамаарч процесс

<sup>1</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/12701>

ажиллагааг зохицуулсан тус тусдаа бие даасан хуулиудыг бий болгосон байна.<sup>2</sup>

Бүгд Найрамдах Хятад Ард Улс:

Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь хөрөнгө буцаах олон улсын ажиллагааны хүрээнд дотоодын холбогдох хууль тогтоомж болон нэгдэн орсон олон улсын конвенц, олон улсын хоёр талт гэрээг баримталдаг. Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг дэлхийн 50 гаруй улстай байгуулаад байгаа бөгөөд НҮБ-ын хэд хэдэн конвенц буюу НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод нэгдэн орсон байна.<sup>3</sup>

Сингапур Улс:

Хөрөнгө буцаах ажиллагааг “Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хууль”-ийн Гуравдугаар бүлэгт заасны дагуу мөрдөн шалгах болон хөрөнгө буцаах гэсэн 2 үе шаттайгаар авч үздэг.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хөрөнгийг мөшгөж, хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл, санхүүгийн баримтууд, нотлох баримтуудыг цуглуулах, үүний тулд эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээх ажиллагаа хийгдэнэ.

Хөрөнгө буцаах ажиллагаанд хөрөнгийг битүүмжлэх, хураан авах, хязгаарлах, хөрөнгийг буцаах ажиллагаа багтдаг.

Сингапур Улсад хууль бусаар байршуулсан хөрөнгийг гадаад улсын эрх бүхий байгууллагаас нэхэмжилж, иргэний журмаар шүүхэд хандах боломжтой байдаг.

Бүс нутгийн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (ARINs):

- (ARIN-SA) Өмнөд Африкийн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээнд Зүүн болон Өмнөд Африкийн улсууд багтдаг.
- (ARIN-WA) Баруун Африкийн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (2014 оноос хойш)
- (ARIN-EA) Зүүн Африкийн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (2013 оноос хойш)
- (ARIN-AP) Ази, Номхон далайн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (2013 оноос хойш) (ARIN-CARIB) Карибын хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (2016 оноос хойш)
- (ARIN-WCA) Баруун болон Төв Азийн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (2018 оноос хойш)
- RRAG (GAFILAT) Өмнөд Америкийн хөрөнгө буцаах сүлжээ: Өмнөд Америкийн орнуудын мэдээлэл солилцоо, холбоо тогтоох виртуал платформ Салбарын мэргэжилтнүүдийн бусад сүлжээ:
- ЭГМОНТ групп (EGMONT group): Санхүүгийн тагнуулын албадын олон улсын сүлжээ,
- Интерпол, Европол, Асеанпол, Америкпол: Олон улсын (бүс нутгийн) цагдаагийн байгууллагууд нь хил дамнасан цагдаагийн байгууллагуудын хамтын ажиллагаа хөнгөвчилдөг,
- Дэлхийн гаалийн байгууллага (WCO-World customs organization),
- Арабын авлигын эсрэг нэгдсэн сүлжээ (ACINET),
- Европын шүүхийн сүлжээ,
- Еврожаст нь Европын Холбооны гишүүн орнуудын шүүгч, прокуроруудаас бүрдэж хил дамнасан онц ноцтой эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, яллаж ажиллагаанд оролцож буй байгууллагуудад дэмжлэг үзүүлдэг агентлаг,
- Олон улсын прокурорын холбоо (IAP),
- Олон улсын төлбөр тооцооны банк, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага, Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо зэрэг банк, үнэт

<sup>2</sup> <https://spo.go.kr/site/spo/02/1020901000002018100812.jsp>

<sup>3</sup> Авлигын эсрэг НҮБ-ын 5 дугаар бүлэг (Хөрөнгө буцаах ажиллагаа)-ийн нөхцөл байдлын үнэлгээ /<https://www.undp.org/>

цаас, компанийн зохицуулалтын байгууллагуудын салбарын мэргэжилтнүүдийн сүлжээ<sup>4</sup> зэрэг нь хамтын ажиллагаатай байгаа нь гадаадын улс орнууд хөрөнгө буцаах ажиллагаанд ихээхэн анхаарч байгаа нь харагдаж байна.

## **V. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС БИЙ БОЛСОН ХӨРӨНГӨ БУЦААХ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод дэлхийн 189 улс нэгдэн орсон бөгөөд Монгол Улс нь 20 гаруй улстай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хонконг, Швейцар, Панам, Австри, Англи, АНУ, ОХУ, Франц, Латви зэрэг улс орнуудын холбогдох байгууллага руу эрх зүйн туслалцааны хүсэлт илгээж, мэдээлэл солилцож байна. Оффшор бүс болох Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Сингапур, Сейшель, Гибралтар, Бермуд, Виржинийн арлууд, Кипр зэрэг улсуудын санхүү, тагнуулын байгууллага, авлигатай тэмцэх байгууллагад хандан хамтран ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газраас гадаад улсын эрх бүхий мөрдөх байгууллага болон бусад байгууллагад 2015-2022 онд эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай 36 хүсэлт явуулсан бөгөөд 14 улсаас хариу ирүүлсэн байна. Үүнд ОХУ, АНУ, Австрали, Канад, Швейцар, Панам, Австри, Виржинийн арлууд, Украин, Лавти, Франц зэрэг орнууд байна.<sup>5</sup> Цаашид эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийн хариуг ирүүлэхэд анхаарч зохих арга хэмжээг авах шаардлагатай байна. Тус хариу хангалтгүй буюу дутуу ирж байгаа нь хөрөнгө буцаах ажиллагааны чиглэлээр мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тулгамдаж буй асуудлын нэг болж байна.

Прокурорын байгууллагаас эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг 2019 онд 29, 2020 онд 34, 2021 онд 16 удаа илгээсэн ч дийлэнх хүсэлтийн хариу хугацаандаа ирдэггүй байна.<sup>6</sup> Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг Авлигатай тэмцэх газар болон Улсын ерөнхий прокурорын газар хүргүүлж байгаа хэдий ч тэр бүр хугацаандаа ирдэггүй нь мөрдөн шалгах ажиллагаа удаашрах, цаашлаад гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг буцаах ажиллагаа удаашрах нөхцөл байдал үүсэж байна.

Гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө буцаах ажиллагааг хэрэгжүүлэхэд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд тухайн шалгаж буй гэмт хэрэг нь нөгөө улсын хуулиар гэмт хэрэгт тооцогдож байх ёстойг анхаарах хэрэгтэй. Иймд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхийг хүсэхдээ тухайн улс оронд үйлдэгдсэн гэх гэмт хэрэг нь тухайн улсын хууль тогтоомжид гэмт хэрэгт тооцогддог эсэхийг урьдчилан судалсан байх ёстой.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар, Засгийн газар хүргүүлж, мөн гэрээг байгуулан ажиллаж байна. Монгол Улсын шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсны дараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага энэ төрлийн ажиллагааг гүйцэтгэх хууль, эрх зүйн орчин байхгүй тул зохих арга хэмжээ авч чадахгүй байна.

Монгол Улс нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод 2005 онд нэгдэн орсон ч дотоодын хууль тогтоомжтой зөрчилдөж байна. Учир нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 53 дугаар зүйлд “Эд хөрөнгийг шууд буцаан олгох арга хэмжээ”, (а) хэсэгт “энэхүү конвенцын

<sup>4</sup> Жан-Пьер Бран, Анастасия Сотиропаолу, Ларисса Грей, Клаив Скотт, Кевин М.Стивенсон. Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага. УБ., 2020. 231 дэх тал

<sup>5</sup> Р.Баярмагнай. Авлигын эсрэг үндэсний чуулган. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц ба дотоодын хууль тогтоомж илтгэл. УБ., 2022. 59 дэх тал

<sup>6</sup> М.Чинбат. Авлигын эсрэг үндэсний чуулган. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц ба дотоодын хууль тогтоомж илтгэл. УБ., 2022. 63 дахь тал

дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэх замаар олж авсан эд хөрөнгийг өмчлөх эрх буюу өмчлөлийг тогтоох зорилгоор өөрийн шүүхэд иргэний хэрэг үүсгэхийг оролцогч өөр улсад зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авна”<sup>7</sup>, харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.4 дэх хэсэгт “эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх, арбитрын журмаар шийдвэрлэгдвэл зохих өөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээс өмнө уг хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй”<sup>8</sup> гэж заасантай зөрчилдөж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний хэргийг шүүх түдгэлзүүлэх нь гэмт хэргийг илрүүлэх, хөрөнгийг хамгаалах, хязгаарлах, буцаан авах ажиллагааг удаашруулж байна.

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд гэрээ, конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа хэдий ч цаашид Монгол Улсын хувьд энэ талаарх харилцааг улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

## VI. ДҮГНЭЛТ

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний нэг хэсэг болох хөрөнгө буцаах ажиллагаа нь өөрийн гэсэн эрх зүйн зохицуулалт, бие даасан ойлголттой учраас шинжлэх ухааны үүднээс эрдэмтэн, судлаачид судлах шаардлагатай байна. Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд ялтан шилжүүлэх гэрээний эрх зүйн зохицуулалтыг тодорхой хэмжээнд судалсан хэдий ч хөрөнгө буцаах ажиллагааны чиглэлээр ашиглах гарын авлага, судалгаа, судлагдсан байдал зэрэг хангалтгүй байна.

Мөнгө угаах, авлига, албан тушаал, мансууруулах бодис, үндэстэн дамнасан гэмт хэргүүд цар хүрээгээ тэлсээр байгаа энэ үед хөрөнгө буцаах ажиллагаа нь Монгол Улсын хувьд шинэ ойлголт юм. Монгол Улс анх 1968 онд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулсан хэдий ч тухайн үед гэмт хэргийн гаралт, олон улсын шинжтэй хил дамнасан гэмт хэрэг үйлдэгдэх магадлал маш бага байсан. Гэмт хэрэг үйлдэгдэхдээ улс дамнасан, олон улсын шинж чанартай болсон энэ үед эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээгээ шинэчлэх шаардлагатай байна.

Олон улсын гэрээ, конвенцод Монгол Улс нэгдэн орсон хэдий ч үндэсний хууль тогтоомжийн хувьд хөрөнгө буцаах ажиллагааны эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Хөрөнгө битүүмжлэх, хураах, эрэн сурвалжлах ажиллагааг дотоодын хууль тогтоомжид тусгасан хэдий ч гадаад улсаас хөрөнгө буцаах ажиллагааг тодорхой хуульчлаагүй буюу ерөнхий агуулгаар хуульчлагдсан тул нарийвчилсан зохицуулалт хангалтгүй байна.

Гадаад улсын сайн туршлагыг судлан үзвэл, Бүгд Найрамдах Солонгос Улс нь хөрөнгө буцаах ажиллагааг 2017 оноос Засгийн газрын албан ёсны тэргүүлэх чиглэлийн нэг болгосон ба гэмт хэргээс хамааран хөрөнгө буцаах ажиллагааг тусад нь зохицуулсан бие даасан хуультай байгаа нь процессын асуудлыг нарийн хуульчилсан, асуудлыг шийдвэрлэх арга зам нь тодорхой зохицуулсан байна. Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь хөрөнгө буцаах ажиллагааг хэрэгжүүлэх тодорхой механизмтай бөгөөд хураан авах, шилжүүлэх, саатуулах процессын асуудлыг нарийн хуульчилсан байгаа нь гадаад улсын сайн туршлага байна.

Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэхээр Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх 5ш ажиллагаа” нь 2022 оноос эхлэн хэрэгжиж байгаа нь сайшаалтай хэрэг юм. Авлигатай тэмцэх 5ш ажиллагааны хүрээнд Засгийн газар болон төрийн байгууллагууд тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхэд энэ чиглэлээр мэргэшсэн алба хаагч, онолын ойлголт, эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

<sup>7</sup> Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, <https://mfa.gov.mn/documentation/64207>

<sup>8</sup> Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/302>



## VII. САНАЛ

Гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг гадаад улсаас Монгол Улсад буцаах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь судалгааны дүнд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Монгол Улсын хуулийн талаар:

1.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хөрөнгийг битүүмжлэх, хамгаалах, хураах заалт нь ерөнхий утгаараа байгаа бөгөөд тус хуулийн 42 дугаар бүлэгт “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа”-ны талаар байх ба тус бүлэгт тусгайлан зааж нарийвчлан зохицуулах буюу Прокурорын байгууллага эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг байгуулахад ямар үүрэг оролцоотой талаар тусгах;

1.2. Прокурорын тухай хуулийн 3 дугаар бүлэгт “Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх ажиллагаа”-г хуульчлахдаа хөрөнгө буцаах ажиллагааг нарийвчлан зохицуулаагүй тул гадаад улсаас хөрөнгө буцаахад тус хөрөнгийг хамгаалах, битүүмжлэх, саатуулах, шилжүүлэх зохицуулалтыг тусгах;

1.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хөрөнгөтэй холбоотой асуудлыг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зохицуулалтаар зохицуулдаг. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 11 дүгээр бүлэг “Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын болон олон улсын байгууллагатай холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” гэх бүлэгтэй байх тул “Гадаад улсаас гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг буцаах ажиллагааны шийдвэр гүйцэтгэл” гэсэн бүлгээр нарийвчлан зохицуулах.

2. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний талаар:

2.1. Монгол Улс эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг анх 1968 онд байгуулсан нь одоо болтол хүчин төгөлдөр учир тус гэрээг шинэчлэх, тус гэрээнд хөрөнгө буцаах ажиллагааны зохицуулалтыг тусгайлан нарийвчлан зохицуулах,

3. Зохион байгуулалтын талаар:

3.1. Хөрөнгө буцаах ажиллагааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх талаар анхаарч ажиллах, тухайлбал, хууль зүйн их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт хөрөнгө буцаах ажиллагааг тусад нь бие даасан кредит хичээл болгон судлах зэрэг саналыг гаргаж байна.

## ЭХ СУРВАЛЖ

### ***Монгол Улсын хууль тогтоомж:***

1. Монгол Улсын Үндсэн хууль,
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль,
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
5. Прокурорын тухай хууль,
6. Банкны тухай хууль

### ***Монгол хэл дээрх***

### ***Ном, гарын авлага, баримт бичгийн эмхэтгэл:***

1. М.Гантулга, Г.Цэцэгмаа, Б.Бат-Орших, Ц.Ариунболд, Ж.Болорпүрэв, Д.Дуламсүрэн, С.Галбадрах, Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаа, УБ, 2020 он,
2. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцын V бүлэг (Хөрөнгө буцаан олгох)-ийн хэрэгжилтийн нөхцөл байдлын үнэлгээ, УБ., 2014 он,
3. Жан-Пьер Бран, Анастасия Сотирополу, Ларисса Грей, Клайв Скотт, Кевин М.Стивенсон. Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага. УБ., 2020 он / орчуулсан гарын авлага/,
4. Ц.Дөлгөөн, Б.Хонгорзул, А.Гуамарал, Ж.Төгс-Очир, З.Эрдэм, Б.Болд, Э.Баясгалан, Х.Баттөгс, Б.Тэмүүлэн. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх баримт бичгийн эмхэтгэл боть 1. УБ., 2020 он /орчуулсан баримт бичгийн эмхэтгэл/,
5. Монгол Улсын АЭК-ийн хэрэгжилтийн үнэлгээний үнэлгээний тайлангууд.

### ***Олон улсын гэрээ, конвенц:***

1. Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, түүний нэмэлт 3 дугаар протокол,
2. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц,
3. Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц,
4. Монгол Улс бусад улс оронтой байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнүүд,

### ***Гадаад хэл дээрх***

### ***Ном, гарын авлага:***

1. Kevin M.Stephenson, Larissa Gray, Ric Power, Jean-Pierre Brun, Gabriele Dunker, Melissa Panjer. Barriers Asset Recovery: An Analysis of the Key Barriers and Recommendations for Action., 2011
2. Jean-Pierre Brun, Molly Silver. Going for Broke: Insolvency Tools to Support Cross-Border Asset Recovery in Corruption Cases., 2020

### ***Цахим эх сурвалж:***

1. <https://legalinfo.mn/>
2. <https://www.undp.org/>
3. <https://star.worldbank.org/>
4. <https://iaac.mn/>
5. <https://www.mongolbank.mn/mn/>

6. <https://www.interpol.int/en>
7. <http://moj.gov.mn/>
8. [www./mfa.gov.mn/](http://www.mfa.gov.mn/)
9. <https://montsame.mn/>

**PROPERTY OBTAINED DUE TO CRIME: THE LAW OF RETURN FROM FOREIGN COUNTRIES TO MONGOLIA, MAKING THE ORGANIZATION EDUCATIONAL**

***Gan-Erdene.G***

*(LL.M) Bayangol District Prosecutor's Office,  
Supervising Prosecutor, Law Enforcement Deputy Counselor,  
Master of Laws*

**ABSTRACT:**

In this article, the level of mutual legal assistance agreement and asset restitution in practice is studied from the point of view of legislation, and the difficulties and problems of asset restitution are analyzed in comparison with theoretical foundations, court practice, and foreign countries.

**KEYWORDS:**

Assets, asset recovery, mutual legal assistance agreements, international agreements and conventions.

## ХӨРӨНГӨ, ОРЛОГЫГ ХУРААХ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



**О.Баярбаясгалан**

*Монголын Хуульчдын холбооны Эрүүгийн эрх зүйн хорооны тэргүүн,  
хуульч, өмгөөлөгч*

### **ТОВЧЛОЛ:**

Монгол Улс нь 1992 онд шинэ Үндсэн Хуулийг баталж, хүмүүнлэг иргэний нийгмийг цогцлон байгуулах болсноор эрх зүйн хүрээнд шинэтгэлийг хийж, хүний эрхийг хамгаалан хэрэгжүүлэх хэм хэмжээнүүдийг шинээр тогтоон хэрэгжүүлж ирсэн. Дээрхтэй холбогдож эрүүгийн эрх зүйн салбарт нэлээдгүй шинэчлэл хийгдсэний нэг илрэл нь 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн баталж, 2017.07.01-ний өдрөөс дагаж мөрдсөн явдал мөн. Монгол Улсын үе үеийн эрүүгийн хуулиудад хөрөнгө, орлогыг хураахтай холбогдсон асуудлыг хэрхэн хуульчилж ирсэн түүхэн уламжлал, албадлагын арга хэмжээний ойлголт үндсэн шинж онцлог, төрөл хэлбэрүүд тэр дундаа хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээний онол, үзэл баримтлалыг тодорхойлж, материаллаг хуулийн зохицуулалтын хийдэл, түүнээс үүдэн гарах эерэг, сөрөг үр дагавруудыг практикийн жишээ баримтаар баяжуулан судалж улмаар харьцуулан дүн шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорив.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээ, албадлагын арга хэмжээ, эрх зүйн зохицуулалт, эрүүгийн хууль, ял.

## **I. ОРШИЛ**

### **Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ түүний ойголт, онолын үндэслэл, үзэл баримтлал**

Судлан буй хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь эрүүгийн ял бус хариуцлагын төрөлд хамаарах бөгөөд энэ үүднээс эрүүгийн хариуцлагын ойголт, үндсэн шинж онцлог, төрөл хэлбэрийг тодорхойлон авч үзэх нь судалгааны ач холбогдолтой болно. Эрүүгийн хариуцлага нь хууль зүйн хариуцлагын нэг төрөл бөгөөд Эрүүгийн эрх зүйн үндсэн судлагдахуун. Эрүүгийн хариуцлагын ойлголтыг эрдэмтэд, судлаачид янз бүрээр тодорхойлсон авч үзэл бодол байр суурь нь “Нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнд ял хариуцлага оногдуулах төрийг төлөөлсөн эрх бүхий байгууллагын хооронд үүсэж буй эрүүгийн эрх зүйн харилцааны хүрээнд авч үзэх ёстой” гэдэг дээр нэгдмэл байдаг. Өөрөөр хэлбэл дээрх тохиолдолд төрд тухайн этгээдийг эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний дагуу шийтгэх, төрийн албадлага нөлөөллийг хэрэглэх эрх, нөгөө талаас

гэмт этгээд нь төрөөс өгсөн буруутгалыг хүлээн авах, ял хариуцлагыг эдлэх үүрэг тус тус үүснэ. Эрүүгийн хариуцлагын үндсэн хэлбэр болох ялын асуудлын онол үзэл баримтлалыг авч үзвэл: Ял нь хууль зүйн хариуцлагын анхны түүхэн хэлбэр төдийгүй гэмт явдалтай тэмцэх чухал хэрэглүүр бөгөөд эдүгээ онолын төдийгүй, жишгийн шалгуураар авч үзэх боломжтой нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэр томьёо болон төлөвшжээ.<sup>1</sup> Улс орон бүр өөрийн Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжилд олон янзын үзэл баримтлал, онол, хандлагыг бий болгосон байна.

Эх газрын эрүүгийн эрх зүйд ялын урсгал онолыг туйлын онол, харьцангуй онол, холимог буюу нийлмэл онол гэж авч үзсэн байдаг.<sup>2</sup> Туйлын онол нь эрт дээр үеэс уламжлагдан ирсэн бөгөөд хэн нэг этгээд гэмт хэрэг үйлдсэн л бол яллагдах учиртай. Наад зах нь ноцтой зөрчил гаргаж хүний эрхийг зөрчсөн хүн түүнийгээ эргүүлэн төлөхөд бэлэн байх ёстой. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн бол ялын тухай ойлголт заавал үүснэ. Энэ онолын дагуу ялын зорилго нь гэмт хэргийн хариу арга хэмжээ, өр төлөөс болоход чиглэгддэг. Гол төлөөлөгч Иммануал Кант, Георг Вильгельм Фридрих Гегель нар.

Харьцангуй онолоор ялыг дан ганц залхаан цээрлүүлэх бус харин нийгмийг ял шийтгэлээр айлгах, ирээдүйн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн тодорхой зорилго бүхий урьдчилан сэргийлэх шинжийг агуулж байдаг.<sup>3</sup> Гол төлөөлөгч Паул Иоханн Анселм фон Файербах (1775-1833) болон Францын фон Лист(1851-1919) нар байдаг.

Нийлмэл онолоор дээр дурдсан хоёр онолын нийлбэр бөгөөд ялыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг нийгэмшүүлэх зорилготой хариуцлагын арга хэмжээ гэж тодорхойлж болно.<sup>4</sup>

Монголын эрдэмтэн судлаачдаас Доктор Б.Содовсүрэн, ялыг “Тус улсын Эрүүгийн хуульд тодорхойлсон гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зөвхөн шүүхийн байгууллагаас хэрэглэдэг төрийн албадлага мөн бөгөөд түүний төрөл, байдал, хэмжээг эрүүгийн хуулиар тогтооно” гэж онолын тодорхойлолт өгсөн байна.<sup>5</sup> Академич С.Нарангэрэл, “Гэмт хэрэг үйлдсэний эрх зүйн үр дагавар нь ялын хэлбэр бүхий төрийн албадлага” хэмээн Монгол Улсын эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж нэг сэдэвт бүтээлдээ бичсэн байдаг.<sup>6</sup> Б.Ганболд, “Ял нь гэмт хэрэгтэй тэмцэх, эрүүгийн эрх зүйн харилцааг зохицуулах чухал арга хэрэгсэл бөгөөд эрүүгийн эрх зүйн үр дагавар, цээрлэлийн шинжээрээ хамгийн хүнд хэлбэрийн хууль зүйн хариуцлага болох эрүүгийн хариуцлагын бие даасан нэг төрөл мөн” юм.<sup>7</sup>

Эндээс үзвэл, шийтгэл бол гарцаагүй байна тодорхой эрх ашгийг хязгаарлана, улс оронд шийтгэлийн илрэн гарах хэлбэр нь янз бүр байх ч мөн чанар нь ижил юм. Ялыг эрүүгийн хуульд заасан байдаг тул түүнийг зөвхөн хуулийн дагуу шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага хэрэглэх эрхтэй. Тодорхой эрхийг хязгаарлан албадлага хэрэглэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлж байгаа нь шийтгэлийн нэг шинж чанар юм.

Дээр дурдсан ялын онолуудаас бидний судлан буй хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээний агуулга, ач холбогдлыг орчин үед ялын нийлмэл онолын хүрээнд тодорхойлж авч үзэх хандлага түгэн дэлгэрч байгаа бөгөөд ял, албадлагын арга хэмжээний агуулга, зорилго гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн олон сонголт бүхий төрөл хэлбэрийг хуульчлан баталгаажуулж, шүүхийн практикт хэрэглэх болсон. Ялын агуулга, мөн чанар, үр нөлөө ийнхүү шинэ агуулга,

<sup>1</sup> Д.Бадам “Насанд хүрээгүй хүнд оногдуулах хорих ялын эрх зүйн зохицуулалт”. 2017 он 6 дахь тал

<sup>2</sup> {德}克劳斯·罗克辛: 《德国刑法学总论》(第一卷), 王世洲译, 法律出版社2005年, 第36页

<sup>3</sup> Б.Одонтунгаалаг. “Эрх зүй сэтгүүл” Эрүүгийн эрх зүйн ялын тухай ойлголт. 2019.№4

<sup>4</sup> Т.Золбоо “Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги” Гэмт хэргийн бүтээц 2018 он 22 дахь тал

<sup>5</sup> С.Жанцан “Монгол Улсын эрүүгийн эрхийн онол /ялын тухай сургаал/” 2014 он 125 дэх тал

<sup>6</sup> С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган “Монгол Улсын эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж” 2019 он 245 дахь тал

<sup>7</sup> Б.Ганболд “Эрүүгийн эрх зүйн мэдлэг” 2009 он 170 дахь тал

хэлбэрээр баяжигдан тодорхойлогдож буй нь ял бус эрүүгийн хариуцлагын үндсэн шинж, онцлог, төрөл хэлбэрийг ялын дундын онолын хүрээнд тодорхойлж эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг өөрчилж, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын бие даасан төрөл болохын сацуу эрүүгийн хуулийн тусгай ангийн санкцид хуульчлагдсан тохиолдолд шүүх гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь нотлогдсон хүнд үндсэн ялтай хамт зайлшгүй хэрэглэх хуулийн шаардлагыг буй болгож байдаг. 2015 оны шинэчлэн батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн заалтаас үзэхэд Монгол Улс эрүүгийн хариуцлагын хувьд дуалист тогтолцоотой буюу гэмт хэрэгт ял оногдуулахын зэрэгцээ албадлагын арга хэмжээг хэрэглэж болохыг хуульчлан тогтоосноос харагдаж байна.

Хөгжингүй орнуудын Эрүүгийн хуулийн зохицуулалтын жишиг хандлагаас судалж үзэхэд ийм тогтолцоо бүхий орнууд түгээмэл байх бөгөөд “албадлагын” гэхээс илүүтэйгээр “аюулгүй байдлын болон хүмүүжлийн, нөлөөллийн арга хэмжээ” гэсэн агуулгаар тухайн этгээдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах, хангах үүднээс голлон хэрэглэгддэг ажээ. Хөрөнгө, орлого хураах эрх зүйн зохицуулалтыг Asset forfeiture, Asset seizure, Confiscation of assets хэмээн ойлгодог. Эд хөрөнгө хураах гэх ойлголт нь латин хэлний Confiscatio гэдэг үгнээс гаралтай бөгөөд энэ үг нь улсын төсөв рүү шилжүүлэх, төрийн санд шилжүүлэх гэх үгнээс гаралтай. Энэ үгийг ихэвчлэн хууль зүйн нэр томъёогоор хэрэглэдэг бөгөөд хууль сахиулах үйл ажиллагаа ялын хувьд эд хөрөнгө хурааж буй үйл явц юм.<sup>8</sup>

Монгол Улс нийтийн эрх зүйн хөгжил тэр дундаа эрүүгийн эрх зүйг хүмүүнлэг болгох олон улсын чиг хандлагад нийцүүлэн эрүүгийн хуулийг батлан гаргасны нэг илрэл нь эд хөрөнгө хураах ялаас татгалзаж хөрөнгө, орлого хураах зохицуулалтыг албадлагын арга хэмжээ болгон хуульчилсан явдал мөн. 2015 оны эрүүгийн хуулиас өмнөх Эрүүгийн хуулиудад эд хөрөнгө хураах нэмэгдэл ялын шинжтэйгээр хэрэглэж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ноогдох хөрөнгийг бүгдийг эсхүл заримыг хураан авахаар эрүүгийн хуулийн тусгай ангийн нэлээдгүй гэмт хэргийн санкцид хуульчлагдаж, хэрэгжиж ирснийг ийнхүү өөрчилсөн нь нэг талаас дэвшил болсон билээ. Гэсэн хэдий ч өмнө дурдсанчлан хуучин, уламжлалт тогтолцоо энэхүү арга хэмжээний агуулгад хадгалагдаж үлдсэнийг тэмдэглэх хэрэгтэй.

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэмцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулахыг хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээ гэж тодорхойлсон байдаг. “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно.<sup>9</sup>

Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлнэ. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна.

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн бол шүүх тухайн эд зүйлийг үнэлж гэмт хэрэг үйлдсэн хүн,

<sup>8</sup> О.Энххүслэн. Хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалтын шинэчлэл ба хүний өмчлөх эрхийн хязгаарлалттай холбоотой асуудал. 2022.

<sup>9</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015.



хуулийн этгээдийн хувьд ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хохирлыг төлүүлнэ. Тухайн хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон болохыг мэдсээр байж авсан болох нь тогтоогдвол шүүх уг эд зүйл, хөрөнгө, орлогыг бусдын өмчлөлд шилжүүлсэн хэлцлийг хүчингүйд тооцож, хөрөнгө, орлогыг хураан авч хохирлыг нөхөн төлүүлнэ хэмээн хуульчилсан байдаг.

Шүүх хөрөнгө, орлого хураан авахдаа хураан авах, хөрөнгө, орлогыг шийдвэртээ нэг бүрчлэн заадаг. Мөн үүнээс гадна Хуулийн этгээдэд оногдуулах Эрүүгийн хариуцлага болгож хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг ЭХ-ийн 9.2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт хуульчилсан байдаг. ЭХ-ийн 9.5, 9.6 дугаар зүйлд энэхүү зохицуулалт тодорхой харагддаг. Хуулийн этгээдийг татан буулгасан тохиолдолд хөрөнгө, орлогыг хураан авч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэдэг.

ШШГТХ-н 191 дүгээр зүйл: Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх талаар хуульчлан тогтоосон байна. ШШГТХ-д зааснаар хөрөнгө, орлогыг хураах шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэрт заасан эд зүйл, хөрөнгийг хариу төлбөргүйгээр албадан хураан авах, улсын орлого болгох зорилгоор төрийн холбогдох байгууллагад шилжүүлэх, худалдан борлуулж олсон орлогыг улсын төсөвт оруулах арга хэмжээнээс бүрдэнэ. ШШГТХ-ийн 191.3.Шийдвэр гүйцэтгэгч хураан авсан хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлүүлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ гэж заасан.

ЭХХШТХ-ийн 21 дүгээр бүлэг хураан авсан хөрөнгө, орлого эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээг хуульчилсан бөгөөд Шүүх, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрт гомдол гаргах, давж заалдах хугацаа дуустал хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг тусгай байранд хадгалж, энэ тухай баримтыг хавтаст хэрэгт хавсаргадаг. Хавтаст хэргийн материал, хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх, хууль ёсны эзэмшигчид нь буцаан олгох, улсын орлого болгох болон ЭХХШТХ-ийн 21.5-ын 1.1, 1.2, 1.3, 1.4-т заасан ажиллагааны журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор хамтран батална.

Прокурор хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон бол хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, эд мөрийн баримт, гэмт үйлдлийн замаар олсон орлого, түүнтэй адилтган үзэх бусад эд зүйлийг хууль ёсны эзэмшигчид нь олгох, эсхүл улсын орлого болгуулахаар шүүхэд санал гаргаж шийдвэрлүүлдэг. Хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь эрүүгийн ялын зорилгыг хангах, ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шүүхийн шийтгэх тогтоолоор эрүүгийн хуулийн тусгай ангийн санкцид заасан ял оногдуулахгүйгээр тэнсэж эсхүл оногдуулсан ял дээр нэмж ялтны эд хөрөнгийн эрхэд хязгаарлалт тогтоохыг ойлгоно гэж дүгнэж болохоор байна.

## **II. ХӨРӨНГӨ, ОРЛОГЫГ ХУРААХ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ**

Хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь эд хөрөнгө хураах ялын агуулга, мөн чанарт суурилсан бөгөөд удаа дараагийн эрүүгийн хуулиудад эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын шинжтэй оногдуулахаар тусгай ангийн тодорхой төрлийн зарим гэмт хэргүүдийн санкцид "...гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ноогдох хөрөнгийн бүгдийг буюу заримыг хураан авах"-аар хуульчлан баталгаажуулж иржээ. Иймд хөрөнгө орлогыг

хураах албадлагын арга хэмжээний эрүүгийн эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлалыг эд хөрөнгө хураах ялын түүхтэй салшгүй холбоотойгоор авч үзэх боломжтой. Ялын хөгжлийн түүхэн дэх ялын эртний хэлбэр болох талеоны ялуудаас татгалзах, цус алдалтыг аль болох багасгах үүднээс ялын шинэлэг хэлбэрүүд, композицийн ялын төрлүүд дундад зууны үед бий болсны нэг нь эд хөрөнгө ял юм. 1926 оны Шүүх цаазын бичиг: Эрүүгийн анхны төрөлжсөн эрүүгийн хууль болох Шүүх цаазын бичигт хуульчлагдсан ялын төрөлд “хөрөнгийг албадан хураах” ял орсон бөгөөд уг ялын агуулгыг “ялтан хүний хөрөнгийг албанд хураахад хууль цаазад тусгай заасан буй, эсхүл тэр гэмт явдлыг үйлдэж олсон нь үнэн болж илэрвээс уг хөрөнгийг бүр мөсөн буюу заримуудыг хураах ба түүний эм, хүүхэд буюу нэгэн хөрөнгийг ураг төрөлд нь хувь үлдээх явдлыг Шүүн таслах газраас тогтоовоос зохино. Гагцхүү гэрийн амьдрал ба аж үйлдвэрт чухал холбогдол бүхий зүйлүүдийг хурааж үл болно” гэжээ.<sup>10</sup> Хуулийн дээрх заалтаас харахад эд хөрөнгө хураах ялын агуулга нь хуурагдах хөрөнгө гагцхүү гэмт хэрэг үйлдсэний үр дүнд буй болсон байх, тэдгээрийг бүгдийг эсхүл хагасыг хураах, хураагдсан эд хөрөнгөөс гэр бүлийн гишүүдээс гадна ойр дотны хүмүүст хувь болгож үлдээж болох ажээ. Түүнчлэн хураагдах хөрөнгө гэмт этгээдийн хувьд эдийн засгийн ач холбогдол, үр нөлөөг харгалзахын чухлыг хуульчилсан нь онцлог зохицуулалт болсон байна.

Эд хөрөнгө хураах ялыг 1926, 1929 оны хуулиар гол төлөв, эд хахууль авах ба өгөх, хулгайлах, булаах, дээрэмдэх, хууль бус ан хийх, улсын ба ард олны эд хөрөнгийг сүйтгэх зэрэг шунахай сэдэлт бүхий гэмт хэргүүдэд эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартай хэрэглэж байв.

1934 оны Шүүх цаазын бичиг: 1934 оны Шүүх цаазын бичгийн 4 дүгээр бүлгийн 14-р зүйлийн 8 дахь хэсэгт хөрөнгийг бүрэн буюу заримыг хураах ялыг хуульчилсан ба 26 дугаар зүйлд “шийтгэгдсэн этгээдийн хувийн буюу бусадтай хамтарсан хөрөнгөөс түүнд ноогдох хувийг цөмийг нь буюу шүүх таслах газраас тодорхойлон заасан хэсэг хөрөнгийг үнэ өртөггүйгээр албадан авч улсын санд нийлүүлэхийг хөрөнгө хураах гэнэ”<sup>11</sup> гэж тодорхойлсон нь өмнөх шүүх цаазын бичгүүдээс агуулгын хувьд өөрөөр буюу гэмт хэргийн улмаас буй болсон хөрөнгө бус гагцхүү хувьд ноогдох хөрөнгийг хураах, нэгэнт хураагдах шүүхээс тодорхойлсон хөрөнгийг улсын санд нийлүүлэхээр хуульчлагдсанаар ялгаатай байна.

1942 оны Эрүүгийн хууль: Эрүүгийн хуулийн 4 дүгээр бүлэгт хуульчлагдсан ялын төрлүүдэд хөрөнгийг бүрэн буюу заримыг хураах ял хуульчлагдсан байх бөгөөд ерөнхий ангийн 39-40 дүгээр зүйлүүдэд уг ялын тодорхойлолт, хурааж үл болох хөрөнгийн жагсаалт, хураагдсан хөрөнгөөс нэхэмжлэгдсэн зүйлүүдийг хэрхэн төлж барагдуулахтай холбоотой асуудлууд, уг арга хэмжээг гүйцэтгэсний дараа нэхэмжилсэн зүйлүүдийг гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрөө хариуцах зэрэг зохицуулалтуудыг хуульчлан баталгаажуулжээ. Хуулийн дээрх заалт 1934 оны Шүүх цаазын бичгийн хөрөнгийг бүрэн буюу заримыг хураах ялын талаарх зохицуулалттай адил хуульчлагдсан байна.

1961 оны Эрүүгийн хууль: 1961 оны Эрүүгийн хуулийн 25 дугаар зүйлд “Шийтгэгдсэн этгээдийн амины өмч буюу бусадтай хамтарсан дундын өмч болох хөрөнгөнөөс түүнд оногдох хэсгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр хурааж улсын санд нийлүүлэхийг хөрөнгө хураах ял гэнэ” гэж хуульчилсан бөгөөд шийтгэгдсэн этгээдийн амины өмч буюу бусадтай хамтарсан дундын өмч болох хөрөнгөнөөс түүнд оногдох хэсгээс шийтгэгдсэн этгээд буюу түүний асрамжаар амьдарч байгаа хүмүүст зайлшгүй хэрэгцээтэй хурааж болохгүй эд зүйлийн жагсаалтыг хуульчлан заасан нь өмнөх хуулиудын зохицуулалттай харьцуулбал энэрэнгүй агуулгатай болсон.<sup>12</sup>

<sup>10</sup> Мөн тэнд.283 дахь тал

<sup>11</sup> Мөн тэнд.350 дахь тал

<sup>12</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/. УБ., 2011. 424-425 дахь тал

1986 оны Эрүүгийн хууль: 1986 оны Эрүүгийн хуулийг батлан гаргах болсон үндэслэл нь: Юуны өмнө 1961 оны эрүүгийн хуульд батлагдсанаас хойш жил дараалан шахуу нэмэлт өөрчлөлт оруулж байсан ч тухайн үеийн нийгмийн өөрчлөлтөд зохицон хэрэгжих боломжгүй болсон. 1980-аад оноос эхлэн дэлхийн дахинд өөрчлөлт, шинэчлэлийн үйл явц хүчтэй өрнөж энэ нь Монгол Улсын нийгэм эдийн засаг, улс төрийн хүрээнд нөлөөлөх болсонтой холбоотой. 1986 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлд эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр зааж байсныг хэвээр үлдээж, төрийн эсрэг онц аюултай гэмт хэргүүдэд нэмэгдэл ял болгон хэрэглэхээр тусгажээ. 2002 оны Эрүүгийн хууль: 2002 оны Эрүүгийн хуульд Эд хөрөнгө хураах ял гэдэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл, хэсэгт тодорхой гэмт хэрэгт оногдуулахаар заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох хөрөнгийг бүгдийг буюу заримыг шүүхийн шийтгэх тогтоолоор үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг хэлнэ. /2002 оны Эрүүгийн хуулийн 49-р зүйл/. 2002 оны Эрүүгийн хуулийн 49-р зүйлийн 2 дахь хэсэгт нэрлэж заасан эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана гэж өөрчилсөн юм. Хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээ нь цоо шинэ хууль зүйн ойлголт биш бөгөөд өнгөрч үлдсэн он жилүүдэд нэмэгдэл ялын шинжтэйгээр хэрэглэж байсан “эд хөрөнгө хураах” ялын агуулгатай үндсэндээ нийцэж байгаа нь түүхчилсэн судалгаанаас тодорхой харагдаж байна.

### **III. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬД, ХӨРӨНГӨ, ОРЛОГЫГ ХУРААХ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУУЛЬЧИЛСАН ЗОХИЦУУЛАЛТ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, ПРАКТИК ТОО БАРИМТ.**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейн 217/A/III/ тогтоолоор 1946 онд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан байдаг.<sup>13</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2 дугаар зүйлд: Хүн бүр бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хэл, хүйс, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой.

Мөн түүнчлэн тухайн хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжид байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй гэж заасан бөгөөд мөн тус тунхаглалын 17 дугаар зүйлд: Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй, хэний ч өмч хөрөнгийг дураар хураан авч болохгүй хэмээн тунхагласан байдаг.<sup>14</sup>

Авлига хээл хахуулын гэмт хэрэг өсөн нэмэгдэхийн хэрээр олон улсын үндэстэн дамнасан Авлигын гэмт хэрэгт хөрөнгө, орлого хураан авах асуудлыг бид бас анхаарах хэрэгтэйг олон улс сануулж байна. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний байгууллагын конвенцод<sup>15</sup>: “Эд хөрөнгө” гэж материаллаг буюу материаллаг бус, хөдлөх буюу үл хөдлөх, биет буюу биет бус бүх төрлийн хөрөнгө болон ийм хөрөнгийг өмчлөх эрх болон түүн дэх эрх, ашиг сонирхлыг гэрчилсэн эрх зүйн баримт бичиг буюу актыг хэлнэ;

е) “Гэмт хэргээс олсон орлого” гэж гэмт хэрэг үйлдэх замаар шууд буюу шууд бусаар олсон эсхүл авсан аливаа эд хөрөнгийг хэлнэ;

ф) “Битүүмжлэх” буюу “түр хураах” гэж шүүх буюу эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу эд хөрөнгийг шилжүүлэх, солих, захиран зарцуулах, хөдөлгөхийг түр хугацаагаар хориглох буюу түр хугацаагаар эзэмшил буюу хяналтад авахыг хэлнэ;

<sup>13</sup> Universal Declaration of Human Rights. <https://www.un.org/en/about-us/universal-declaration-of-human-rights>

<sup>14</sup> Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхтгэл. 2012.

<sup>15</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760279163531>

г) “Хураах” гэж хэрэглэх эрхийг оруулан, шүүх буюу эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу эд хөрөнгийг бүрмөсөн авахыг хэлнэ;<sup>16</sup>

Гэмт хэргээс олсон орлого, эд хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгслийг хураах хүсэлтийг конвенцын дагуу тогтоосон гэмт хэрэгтэй холбогдуулан хүлээн авсан оролцогч улс дотоодын эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд аль болох өргөн хэмжээнд хамтран ажиллахыг гишүүн улсууд зорилгоо болгосон байдаг. Олсон хөрөнгө, эд хөрөнгийг олон улсын гэрээ конвенцод авлига албан тушаалын гэмт хэрэг, үндэстэн дамнасан гэмт хэргүүд, мөнгө угаах ... гэх мэт хэргүүдэд илүү түлхүү олон улсын нэгдэн орсон гэрээ, конвенцод зааж өгсөн байна.

### **БНХАУ**

БНХАУ-ын эрүүгийн хуулийн 60, 59 дугаар зүйлд эд хөрөнгө хураах ялыг хуульчилсан байдаг. Энэхүү ял нь нэмэгдэл ял бөгөөд эд хөрөнгийг хураах нь гэмт этгээдийн өмчийн зармыг буюу бүхэлд нь нөхөн төлбөргүйгээр төр<sup>17</sup> улсын өмч болгохыг ойлгоно. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэр бүлийн амин чухал хэрэгцээний хөрөнгө, амьдралын зардлыг хурааж болохгүй гэж заасан байдаг.<sup>18</sup>

Эд хөрөнгө хураах ял, торгох ял нь 2-лаа хөрөнгийн шийтгэл боловч хоорондоо ялгаатай байдаг. Эд хөрөнгө хураах ял нь харьцангуй хүнд төрлийн гэмт хэрэгт оногдуулдаг бөгөөд социалист эдийн засгийн эсрэг гэмт хэрэг, үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн гэмт хэргүүдэд түлхүү оногдуулдаг. Харин торгох ялыг хөнгөн гэмт хэрэгт оногдуулдаг байна. Эд хөрөнгө хураах ялыг бүхэлд нь нэг л удаа хэрэглэдэг бөгөөд хэсэгчлэн хураах зохицуулалт байхгүй. Харин торгох ялыг хэсэгчлэн төрж болдог. Хэрвээ торгууль төлөх боломжгүй байгаа нь нотлогдвол Ардын шүүх харгалзан үзэж торгуулийг бууруулдаг. Гэмт хэрэгтнүүдийн хууль бусаар олж авсан эд хөрөнгө нь анхнаасаа төр, хүний өмч байсан бөгөөд түүнийг гаргуулах ёстой. БНХАУ-ын Эрүүгийн хуулийн эд хөрөнгө хураах ял оногдуулахад дараах зүйлсийг анхаарах ёстой.<sup>19</sup> Үүнд:

Нэг. Үндсэн ялтай хамт хэрэглэх ёстой. Өөрөөр хэлбэл, үндсэн ял оногдуулахтай зэрэгцээд эд хөрөнгийг нь хураах ёстой.

Хоёр. Эд хөрөнгө хураах ялыг зөвхөн шүүхээс оногдуулахаар тогтдог. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 390 дүгээр зүйлд зааснаар хээл хахууль авах гэмт хэрэг үйлдсэн хүнд гэмт хэрэгт 10-аас доошгүй жил хорих, эсхүл бүх насаар нь хорих ялаар шийтгэхээс гадна эд хөрөнгийг хураадаг.

Гуравдугаарт. Зөвхөн гэмт хэрэгтний өмчлөлийн эд хөрөнгийг хураадаг. Бүх эд хөрөнгийг хураах үед амь насыг нь тэтгэхэд шаардагдах зардал, гэмт хэрэгтэн болон түүний тэжээн тэтгэх гэр бүлийн гишүүдэд үлдээхийг анхаарах хэрэгтэй. БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлд зааснаар хууль ёсны өр төлбөрийг эд хөрөнгөнөөс нь төлөх зохицуулалтыг заасан байдаг. Тухайлбал, худалдах, худалдах авах, зээлэх, түрээслэх, хөдөлмөр эрхлэх гэх мэт иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн өр зээлийг ойлгох бөгөөд хураахгүйгээр төлж барагдуулдаг байна.

### **ХБНГУ**

Германы эрүүгийн эрх зүйн нэг гол эх сурвалж нь 1949 оны ХБНГУ-ын Үндсэн хууль, 1871 онд батлагдсан эрүүгийн хууль болон одоо үйлчилж байгаа 1998 оны эрүүгийн хууль болон холбооны тугсай хууль, мужийн эрүүгийн хууль тогтоомжоос бүрдэнэ. Уг хуулийн ерөнхий ангид 1969 онд, тусгай ангид 1975 онд агуулгын шинжтэй томоохон өөрчлөлт орсон юм. Германы Эрүүгийн эрх зүй нь өргөн утгаараа материаллаг эрүүгийн

<sup>16</sup> Монгол Улс тус конвенцид 2005 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр нэгдэн орсон. Улс орон бүр Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх зорилгоор оролцогч улс бүр биетээр оршдоггүй банк болон хуулиар зохицуулагддаг санхүүгийн бүлэгт харьяалагддаггүй банк байгуулахаас зохицуулагч ба хяналтын байгууллагуудынхаа тусламжтайгаар урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй бөгөөд зохистой арга хэмжээ авна.

<sup>17</sup> Criminal Law of the People's Republic of China 1979.

<sup>18</sup> 刑法规范总整理 (第十一版) 法律出版社. 页55(Total arrangement of criminal law rules. Law press china. 2019)

<sup>19</sup> 齐文远 “刑法学” Criminal law second edition.2011.

эрх зүй болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйг бүхэлд нь хамардаг. Германы Эрүүгийн хуулийн ерөнхий ангид оногдуулах ял болон түүний төрлийг хуульчлан тогтоожээ. Энэхүү хуулийн 74.1-д эд хөрөнгө хураах нөхцөлийг хуульчилсан байдаг. Тухайн эд хөрөнгийг гэмт хэрэг үйлдэх замаар бий болгосон, эсхүл уг эд хөрөнгийг гэмт хэрэг үйлдэхэд ашигласан бол тэрхүү эд хөрөнгийг албадан гаргуулж улсын орлого болгоно гэж заасан байдаг. Эд хөрөнгө хураах ялын хэмжээ нь гэмт хэргийн төрөл, зүйл, хөрөнгийн байдал, нийгэмд учруулсан хор хохиролд тохирсон байх ёстой.<sup>20</sup>

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 73 дугаар зүйлд Гэмт хэргийн улмаас олсон орлогыг гэмт хэрэг үйлдсэн этгээдээс хураан авах тухай хуульчилсан бөгөөд нэг, Гэмт хэрэг үйлдсэн этгээд хууль бус үйлдэл хийснийхээ төлөө буюу хууль бус үйлдлээрээ ямар нэгэн орлого олсон бол шүүх түүнийг хураан авах шийдвэр гаргана. Хоёр, Гэмт хэрэг үйлдсэн этгээд гэмт хэрэг үйлдэж олсон орлогоо ашиглан ашиг олсон бол шүүх мөн олсон ашиг мөн хураан авах шийдвэр гаргана. Гурав, Шүүх дараах байдлаар олж авсан эд зүйлийг хураан авах шийдвэр гаргадаг. А. Олж авсан зүйлсээ зарсан буюу устгасан, гэмтээх буюу хураалгах замаар сольсон Б. Олж авсан эрхийн үндсэн дээр гэсэн 2 тодорхой нөхцөлийг хуульчилсан байдаг.<sup>21</sup>

### **БНСУ**

Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хуулийн 41 дүгээр зүйлд ялын төрлийг хуульчилсан бөгөөд 41 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт эд хөрөнгө хураах<sup>22</sup> ялыг хуульчилсан байна.

“Хураах” гэдэг үг нь ихэвчлэн хуулийн хэллэгээр эрүүгийн гэмт хэргийн шинжтэй зүйлийг өмчлөх эрхийг нь хасаж, төрд буцаан авах гэсэн утгатай шийтгэлийн нэг төрөл юм. Эрүүгийн хуульд эд хөрөнгө хураах ял нь эд хөрөнгийн ялын нэг төрөл бөгөөд нэмэгдэл ял юм.<sup>23</sup>

Эд хөрөнгө хураах ял нь гэмт хэрэг дахин давтагдах болон гэмт хэргээс ашиг олохоос урьдчилан сэргийлэх зорилготой үндсэн ял боловч нэмэлт зүйлтэй байхаар хуульчлагдсан.<sup>24</sup> Уг ялын үндсэн зүйлийг Эрүүгийн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэмт хэрэгтэн өөрийн эзэмшилд харьяалагдахгүй эсхүл гэмт хэргийн дараа гадны нөхцөл байдлыг олж мэдээд олж авсан дараах зүйлийг бүхэлд нь болон хэсэгчлэн ураан авч болно.

Гэмт хэргийн үйл ажиллагаанд ханган нийлүүлсэн эсхүл нийлүүлэхээр төлөвлөсөн эд зүйл

Гэмт хэргийн улмаас бий болсон эсхүл эзэмшилдээ авсан эд зүйл

1, 2-р зүйлийн хариуд олж авсан эд зүйлс<sup>25</sup> гэж хуульчилсан бөгөөд 48 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд зүйлсийг хураан авах боломжгүй бол үнийг нь хураана гэж хуульчилжээ.

Харин уг ялын нэмэгдэл зүйлийн хувьд уг хуулийн 49 дүгээр зүйлд хуульчилсан байдаг. Энэхүү зүйлийн агуулга нь “тухайн этгээдийн гэм буруутайг шүүхээр тогтоогоогүй байсан ч эд хөрөнгө хураах үндэслэл байгаа үед зөвхөн эд хөрөнгө хураах ялыг ногдуулж болно”<sup>26</sup> гэх агуулгатай байна. Энэ нь эд хөрөнгө хураах ял нь шүүхээс гэм буруутай нь тогтоогдсон гэмт хэрэгтэнд үндсэн ял дээр нэмж оногдуулах нэмэгдэл ял хэдий ч онцгой тохиолдолд буюу эд хөрөнгийг хураах үндэслэл байгаа тохиолдолд уг ялыг дангаар нь ногдуулж болох утгыг илэрхийлдэг.

<sup>20</sup> Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Тамир, Т. Золбоо, Б.Батбаяр “Монгол, Орос, Хятад, герман улсын эрүүгийн хууль.2021.

<sup>21</sup> Criminal code of Federal Republic of Germany.

<sup>22</sup> БНСУ-ын Эрүүгийн хууль 41.9 <https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EB%B2%95>

<sup>23</sup> [https://www.moleg.go.kr/mpbleg/mpblegInfo.mo?mid=a10402020000&mpb\\_leg\\_pst\\_seq=125486](https://www.moleg.go.kr/mpbleg/mpblegInfo.mo?mid=a10402020000&mpb_leg_pst_seq=125486), БНСУ-ын Засгийн газрын цахим хуудас дахь мэдээлэл

<sup>24</sup> <https://encykorea.aks.ac.kr/Article/E0018761>

<sup>25</sup> БНСУ-ын Эрүүгийн хууль 48.1

<sup>26</sup> БНСУ-ын Эрүүгийн хууль 49.1



Дэлхийн жишиг болсон улсуудын эрүүгийн хуулийн зохицуулалттай харьцуулан дүгнэвэл дээрх хууль тогтоомжуудад эд хөрөнгө хураах ялыг хуульчилсан ба зарим талаараа Монгол Улсын эрүүгийн хуультай адил зохицуулалттай байна. БНХАУ-ын Эрүүгийн хуульд эд хөрөнгө хураах ял нь чухал байр суурь эзэлж байна. Энэ нь нэг талаараа ял эдлүүлэх тогтолцоог хамгаалах, зохицуулалтыг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Гол төлөв гадаад улс орнууд эрүүгийн хуульдаа эд хөрөнгө хураах ялыг хэрэглэхэд гэмт хэргийн шинжтэй эд хөрөнгийг хураан авах зохицуулалттай байна. Үйлдсэн гэмт хэргийн хохирлоос шалтгаалж хорих ял дээр нэмээд эрх хасах ял, эсвэл эд хөрөнгө хураах ял оноож байна.

Хөрөнгө, орлогыг хураан авах албадлагын арга хэмжээг шүүхийн практикт хэрхэн хэрэглэдэг талаарх судалгааг Монгол Улсын шүүхийн тайланд тусгагдсан статистикийн тоо баримтад түшиглэн 2021-2023 он буюу сүүлийн 3 жилийн байдлаар судалж үзвэл:

2021 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 13091 хүн, 2 хуулийн этгээдэд холбогдох 12068 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэжээ.

Шүүхээр шийтгүүлэгчдэд оногдуулсан ялын төрлөөр авч үзэхэд 2518 хүнд хорих ял, 6179 хүн, 2 хуулийн этгээдэд торгох ял, 1518 хүнийг нийтэд тустай ажил хийлгэх ял, 1 хүн баривчлах ял, 1560 хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээг хэрэглэж 190 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 11263 хүнд ял шийтгэл оногдуулсан байна. Эндээс үзэхэд шүүхээр ял шийтгүүлэгчдийн 19.2 хувьд хорих ял, 58.8 хувьд хорихоос бусад төрлийн ял, 1.4 хувьд эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 11.9 хувьд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээг оногдуулсан ажээ.

Дээрх ял шийтгүүлэгчдээс 375 хүн, 5 хуулийн этгээдэд хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэж, 3 тэрбум 114 сая 483 мянга 131 төгрөгийг тус тус гаргуулан улсын орлого болгосон байна. Тэгэхээр уг арга хэмжээг нийт шүүхээр шийтгүүлэгчдийн 2.9 хувьд хэрэглэсэн гэж үзэж болох юм.

2022 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 16350 хүн, 10 хуулийн этгээдэд холбогдох 14202 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэжээ.<sup>27</sup>

Шүүхээр шийтгүүлэгчдэд оногдуулсан ялын төрлөөр авч үзэхэд 2919 хүнд хорих ял, 8165 хүн, 10 хуулийн этгээдэд торгох ял, 1552 хүнийг нийтэд тустай ажил хийлгэх ял, 1583 хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээг хэрэглэсэн байна. Эндээс үзэхэд шүүхээр ял шийтгүүлэгчдийн 17.8 хувьд хорих ял, 59.4 хувьд хорихоос бусад төрлийн ял, 9.6 хувьд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээг оногдуулсан ажээ.

Дээрх ял шийтгүүлэгчдээс 413 хүн, 35 хуулийн этгээдээс хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэж, 14 тэрбум 334 сая 385 мянга 024 төгрөгийг тус тус гаргуулан улсын орлого болгосон байна. Нийт шүүхээр шийтгүүлэгчдийн 2.5 хувьд хэрэглэсэн гэж үзэж болох юм.

2023 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 16511 хүн, 18 хуулийн этгээдэд холбогдох 13977 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэжээ.<sup>28</sup>

Шүүхээр шийтгүүлэгчдэд оногдуулсан ялын төрлөөр авч үзэхэд 2551 хүнд хорих ял, 8360 хүн, 18 хуулийн этгээдэд торгох ял, 1467 хүнийг нийтэд тустай ажил хийлгэх ял, 1814 хүнийг зорчих эрхийг хязгаарлах ялаар, 1535 хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээг хэрэглэсэн байна. Эндээс үзэхэд шүүхээр ял шийтгүүлэгчдийн 15.4 хувьд хорих ял, 70.5 хувьд хорихоос бусад төрлийн ял, 9.2 хувьд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээг оногдуулсан ажээ. Дээрх ял шийтгүүлэгчдээс 391 хүнд хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэж, 15 тэрбум 817 сая 454 мянга 340 төгрөгийг гаргуулан улсын орлого болгосон байна.

<sup>27</sup> <https://www.judcouncil.mn>

<sup>28</sup> <https://cd.gov.mn>.



Тэгэхээр уг арга хэмжээг нийт шүүхээр шийтгүүлэгчдийн 2.3 хувьд хэрэглэсэн гэж үзэж болох юм.

Жишээ 1. Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд иргэн Б нь 1.000.000 төгрөгийн үнэ бүхий контейнерыг тээврийн хэрэгсэл түрээслэн хулгайлж, 500.000 төгрөгөөр зарсан гэх хэрэгт тухайн иргэнд эрүүгийн хуульд заасан ялыг оногдуулж, хохирлын мөнгийг гэмт этгээдээс гаргуулахын дээр гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгслийн үнэ 18.000.000 төгрөгийг гаргуулж улсын орлого болгохоор шийдвэрлэсэн байна. Шүүх хуулийг зөв хэрэглэсэн учир нь эрүүгийн хуульд “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлого гэж” Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд болон шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого гэмт хэрэг үйлдэхэд ашигласан ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно” гэж заасан байна. Тухайн иргэний хувьд өөрийн гэсэн эд хөрөнгө, орлогогүйгээс шүүхийн шийдвэр 2 жилийн хугацаанд бүрэн биелэгдээгүй байгаа юм.<sup>29</sup>

Жишээ 2. Ижил гэмт хэрэгт холбогдож ял шийтгүүлсэн 2 иргэнд холбогдох шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд эрүүгийн хуулийн тусгай ангийн .....-р зүйлд заасан гэмт хэрэгт иргэн П нь 1.4 м.куб модыг бэлтгэж гэмт хэрэг үйлдэх үедээ ашигласан тээврийн хэрэгслийн үнэ болох 16.000.000 төгрөгийн хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан бол иргэн М нь түүнээс их хэмжээтэй буюу 5.4 м.куб модыг бэлтгэж гэмт хэрэг үйлдэх үедээ ашигласан тээврийн хэрэгслийн үнэ болох 2.000.000 төгрөгийн хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан байна. Шүүхээс тэдэнд хуульд заасан ял шийтгэлийг тохирох хэмжээгээр оногдуулсан бөгөөд байгаль экологид учруулсан хохирлыг гаргуулахын дээр тус тусын гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгслийн үнийн дүнг гаргуулж улсын орлого болгохоор шийдвэрлэсэн. Үүнээс харахад яг ижил төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ялгаатай үнийн дүнгээр албадлагын арга хэмжээ авагдсан нь харагдаж байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна хэмээн заасан. Эрүүгийн эрх зүйн салбар шинжлэх ухаанд “гэм хор”, “хохирол”, “хор уршиг” гэх ойлголтуудыг өөрөөр тодорхойлж ирсэн.

Гэм хор гэж тодорхой этгээдийн эрх зөрчигдсөнөөс түүнд бий болсон эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус сөрөг үр дагавар байдаг.<sup>30</sup> Гэм хорыг материаллаг болон материаллаг бус гэж ангилан материаллаг гэдэгт алдагдал, олох байсан орлого, зардлыг харин материаллаг бус гэдэгт амь нас, эрүүл мэндийг хохироосон, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан зэрэг үнэ өртгөөр илэрхийлдэггүй, хохирогчийн санаа сэтгэлийг дарамтад оруулсан үр дагаврыг ойлгодог.

Харин хохирол гэдэгт тооцож, хэмжиж болохуйц, нөхөн төлөгдөх шинжтэй гарз, сүйтгэл хамаарна. Гурав дахь ойлголт болох хор уршиг гэдгийг нийгэмд аюултай, эрүүгийн хууль зөрчсөн, гэм буруутай үйл явдлын үр дүнд хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаа болон гадаад ертөнцөд гарсан эрүүгийн хуульд заасан өөрчлөлт гэж зарим судлаач тодорхойлжээ.<sup>31</sup> Гэвч судлаачид эдгээр нэр томъёонуудын нэгдсэн нэг тодорхойлолтод хүрэхгүй байсаар өнөөг хүрсэн.

Ийнхүү 2017 оны Эрүүгийн хууль батлагдахаас өмнө хор уршигийг өргөн хүрээнд нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан материаллаг болон материаллаг бус

<sup>29</sup> Shuukh.mn <https://shuukh.mn/cases/2/1>

<sup>30</sup> С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол-1 дүгээр боть “Гэмт хэргийн тухай сургааль”, Уб., 2009 он. 357 дахь тал.

<sup>31</sup> С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (Схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал), Уб., 2011 он. 84 дэх тал.

гэм хорыг<sup>32</sup> гэж ойлгож байсан бол одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн дагуу хохирлын улмаас шууд бусаар үүсэж буй үр дагаврыг хор уршигт тооцож байна.

#### IV. ДҮГНЭЛТ

Ялын агуулга, зорилгыг хэрэгжүүлэх гол механизм нь нэг талаас шүүхээс оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх, нөгөө талаас ялаас чөлөөлөх, өөр төрлийн ялаар хөнгөрүүлэн солих, тэнсэх, албадлагын арга хэмжээгээр илэрдэг. Эдгээр нь нэгдэж нийлж ялын зорилгыг хангана. Онолын хувьд аваад үзвэл хөрөнгө, орлого хураах ажиллагаа нь шүүгдэгч, яллагдагчийн хууль бус үйл ажиллагаанаас олсон орлого байх ёстой. Гэтэл тээврийн хэрэгслийг хүн өдөр тутмын амьдралдаа өргөн ашигладаг дийлэнх тохиолдолд хууль ёсны өмчлөгч, эзэмшигч байна.

Хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээ нь хууль цаазын дурсгалт бичигт эртнээс уламжлагдан ирсэн бөгөөд Эрүүгийн хуулиудад эд хөрөнгө хураах ялаар хуульчлагдан ирсэн байна. 2017 оноос үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлэг тэнсэх, албадлагын арга хэмжээг хуульчилсан бөгөөд энэ бүлгийн 7.5-д хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ болгон хуульчлан ялын төрлөөс хасаж албадлагын арга хэмжээ болгон хуульчилжээ. Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуульд зохицуулахдаа гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, бусдад учруулсан хохирлыг барагдуулсан хөрөнгө, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хураахаар зохицуулсан байдаг.

Практик судалгаанаас харахад ашиг орлогоос гадна тээврийн хэрэгслийг хураах нь түгээмэл байна. Тээврийн хэрэгслийн үнэлгээ өнөөдөр өссөн үзүүлэлттэй байгаа. Тухайн тээврийн хэрэгслийг эзэмшиж буй этгээд хууль ёсны үндсэн дээр худалдан авдаг. Гадаад орны хууль тогтоомжид зааснаар хууль ёсоор авсан хөрөнгө, орлогыг хураахгүй хэмээн заасан бөгөөд БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлд зааснаар хууль ёсны өр төлбөрийг эд хөрөнгөнөөс нь төлөх зохицуулалтыг заасан байдаг. Тухайлбал, худалдах, худалдах авах, зээлэх, түрээслэх, хөдөлмөр эрхлэх гэх мэт иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн өр зээлийг ойлгох бөгөөд хураахгүйгээр төлж барагдуулдаг байна. Дэлхийн улсуудын эрүүгийн хууль тогтоомжийн жишигт нийцүүлэн шинэлэг байдлаар, позитив байр сууринаас тодорхойлох шаардлага өдгөө зүй ёсоор тулгарч байна.

#### V. САНАЛ

Эрүүгийн хуулийн Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулах заалтыг эрүүгийн хуулиас хасах. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, пактуудад ...хүн бүр эд хөрөнгийг ганцаар буюу бусадтай хамтран өмчлөх эрхтэй бөгөөд хэний ч өмчийг дураар хураан авч болохгүй гэсэн заалттай зөрчилдөж байна

Хүний хувьд ногдох эд хөрөнгө боловч гэр бүлийн гишүүдийн нэн ялангуяа гэжээн тэтгүүлэх эрх бүхий этгээдийн эрхийг тодорхой хэмжээнд зөрчиж байгааг анхаарч хуульд хязгаарлалт оруулах шаардлагатай холбоотой.

Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна” гэх заалтад “гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, эд зүйл нь тухайн этгээдийн амьжиргааны эх үүсвэр болох нь нотлогдсон бол хурааж авахгүй.” гэх заалтыг нэмж оруулах шаардлагатай гэж үзэж байна.

<sup>32</sup> С.Нарангэрэл, Ж. Эрдэнэбулган. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, Уб., 2019 он. 127 дахь тал.

**ЭХ СУРВАЛЖ*****Монгол хэл дээрх***

1. Д.Бадам “Насанд хүрээгүй хүнд оногдуулах хорих ялын эрх зүйн зохицуулалт”. 2017 он 6 дахь тал
2. Б.Одонтунгалаг. “Эрх зүй сэтгүүл” Эрүүгийн эрх зүйн ялын тухай ойлголт. 2019.№4
3. Т.Золбоо “Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги” Гэмт хэргийн бүтээц 2018 он 22 дахь тал
4. С.Жанцан “Монгол Улсын эрүүгийн эрхийн онол /ялын тухай сургаал/ “2014 он 125 дэх тал
5. С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган “Монгол Улсын эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж”2019 он 245 дахь тал
6. Б.Ганболд “Эрүүгийн эрх зүйн мэдлэг” 2009 он 170 дахь тал
7. О.Энххүслэн. Хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалтын шинэчлэл ба хүний өмчлөх эрхийн хязгаарлалттай холбоотой асуудал. 2022.
8. “Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Тамир, Т.Золбоо, Б.Батбаяр” “Монгол, Орос, Хятад, герман улсын эрүүгийн хууль.2021.
9. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол-1 дүгээр боть “Гэмт хэргийн тухай сургаал”, Уб., 2009 он. 357 дахь тал.
10. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (Схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал), Уб., 2011 он. 84 дэх тал.
11. Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015.
12. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/. УБ., 2011. 424-425 дахь тал
13. Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхтгэл. 2012.
14. БНСУ Эрүүгийн хууль.
15. “С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган”. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, Уб., 2019 он. 127 дахь тал.

***Гадаад хэл дээрх***

1. {德}克劳斯, 罗克辛: 《德国刑法学总论》 (第一卷), 王世洲译, 法律出版社2005年, 第36页
2. Universal Declaration of Human Rights. <https://www.un.org/en/about-us/universal-declaration-of-human-rights>
3. Criminal Law of the People’s Republic of China 1979.
4. 刑法规范总整理 (第十一版) 法律出版社.页55(Total arrangement of criminal law rules. Law press china. 2019)
5. 齐文远 “刑法学”Criminal law second edition.2011.
6. Criminal code of Federal Republic of Germany.

## **FORCED MEASURES FOR CONFISCATION OF ASSETS AND INCOME: LEGAL REGULATION**

***Bayarbayasgalan.O***

*Head of the Criminal Law Committee of the Mongolian Bar Association,  
lawyer and advocate*

### **ABSTRACT:**

Mongolia adopted a new Constitution in 1992, ushering in a comprehensive and humane civil society. This led to reforms in the legal framework and the establishment of new norms to protect human rights. As part of these reforms, significant changes were made in the field of criminal justice, notably with the approval of the Criminal Law in 2015, which was implemented on January 7, 2017. This study explores the historical tradition of legislating issues related to the confiscation of assets and income in Mongolia's criminal laws. It examines the concept of coercive measures, their main features and types, and the theory and practice of using such measures to confiscate assets and income. The study aims to analyze the consequences of these measures through practical examples and provide evaluations and conclusions.

### **KEYWORDS:**

Confiscation of property, Assets, and income obtained from crime, Illegally acquired property, Vehicles used in criminal activities, Compensation for criminal damage.

## ХУУЛИЙГ БУЦААН ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ЗАРЧМЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХЭРЭГЛЭЭ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



**Э.Отгонбаатар**

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант*

### ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүллээр “Хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчим” хуульд хэрхэн бэхжсэн болон практикт ямар байдлаар хэрэглэгдэж буй талаар манай улсын Үндсэн хуулийн цэц болон гадаадын зарим орны Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий шүүхээс шийдвэрлэсэн бодит хэргүүдэд дүн шинжилгээ хийж, харьцуулах байдлаар улс орнуудын хуулийг буцаан хэрэглэх асуудлаарх байр суурь, төлөв байдлыг судлахыг зорилоо. Үүний үр дүнд цаашид энэ сэдвийн хүрээнд өрнөх маргаанд асуудлыг олон талаас нь авч үзсэн үндэслэлүүдийг харьцуулан тунгааж, өөрийн орны онцлог хийгээд олон улсын чиг хандлагад нийцсэн үндэслэлтэй шийдвэр гаргахад судалгааны нэгэн эх сурвалж болох ач холбогдолтой хэмээн үзэж, өгүүллийн төгсгөлд судлаачийн зүгээс санал, дүгнэлтээ танилцуулсан болно.

### ТҮЛХҮҮР ҮГС:

Эрх зүйн тодорхой байдал, Эрүүгийн хууль, Үндсэн эрх, Үндсэн эрхийн хамгаалалт, Шударга ёс.

### I. ОРШИЛ

Аливаа хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн тулд түүний хийсэн үйлдэл, гаргасан эс үйлдэхүйг цаг хугацааны хувьд уг үйлдэл, эс үйлдэхүйг гаргахаас өмнө Эрүүгийн хуулиар хориглож, баталгаажуулсан байх ёстой. Эсрэг тохиолдолд хэн ч бай өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн хууль ёсны эсэхийг тухайн цаг үед мэдэх боломжгүй байдаг тул шударга бусаар ял шийтгэгдэх эрсдэл бий болдог. Ийм шударга бус нөхцөл байдлыг бий болгохгүйн тулд “хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчим”-ыг улс орнууд Үндсэн хууль, Эрүүгийн хуульдаа тусган бэхжүүлэх нь түгээмэл юм.

Манай Улсын хувьд Үндсэн хуульдаа энэ зарчмыг шууд тусган хуульчлаагүй. Харин өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй байх тухай хуульчилжээ. Дээрх тохиолдолд өрнөх гол асуудал нь Үндсэн хуулиас бусад хуулийг өөрчлөх, хүчингүй болгох нь процессын хувьд хуульд тогтоогчид харьцангуй хялбар байдаг тул уг зохицуулалтыг хууль тогтоогч хэдийд ч өөрийн бүрэн эрхийн хүрээнд өөрчлөх

боломжтой юм. Иймээс зайлшгүй шаардлагатай суурь буюу үндсэн эрхийг хамгаалахад чиглэсэн зохицуулалтуудыг улс орнууд Үндсэн хуульдаа тусгах замаар бэхжүүлдэг.

Жишээ нь Бүгд Найрамдах Аргентин Улсад өрнөсөн 1994 оны Үндсэн хуулийн шинэчлэлийн хүрээнд тус улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг шууд хориглосон байдаг<sup>1</sup>. Харин Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуулийн 103 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө тус гэмт хэргийг хуульчилсан байх тохиолдолд л эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” хэмээн хуульчилжээ. Энэ нь *Nullum crimen sine lege praeva* буюу Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчмын агуулга юм.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталж, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэрэгт холбогдсон ч, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээгээгүй иргэдийн хэргийг сэргээн шалгах үр дагавар бүхий нөхцөл байдлыг бий болгосон юм. Үүний дагуу хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчмын эрүүгийн эрх зүй дэх хэрэглээний асуудал Үндсэн хуулийн хүрээнд тавигдсан болно.

Энэхүү сэдвийн өмнө нь судлагдсан байдлыг авч үзвэл, Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх зарчмын талаар тухайлан нарийвчлан судалсан нэг сэдэвт бүтээл хараахан байхгүй боловч, дотоодын олон эрдэмтдийн бүтээлд “хууль ёсны зарчим”-ын хүрээнд өргөнөөр тусгагдсан байдаг. Хууль ёсны зарчмын агуулгыг бүрдүүлдэг дэд зарчмуудын нэгд “Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх зарчим” ордог бөгөөд тус зарчмын агуулгын талаар дурдсан байдал нь тус асуудлаар ерөнхий ойлголтыг өгч буйгаараа энэ сэдэвтэй холбогдох юм. Тухайлбал, Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, эмерит профессор С.Нарангэрэлийн “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” (1996), Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцангийн “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол: Гэмт хэргийн тухай сургааль” (2009), Хууль зүйн ухааны доктор Ж.Эрдэнэбулган, Хууль зүйн ухааны магистр Г.Эрдэнэбат нарын Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал: Хөтөлбөр, эх сурвалж, тулгуур ойлголт тест, казус зэрэг бүтээлүүдэд тусгагдсаныг харж болно. Мөн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотойгоор хууль буцаан хэрэглэх эсэх асуудлаар Хууль зүйн ухааны доктор Х.Сэлэнгэ “Монгол Улсын Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практик, эрх зүйн хийдэл” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж байжээ.

Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглохын зарчмын хүрээнд хөндөгдөж буй эдгээр асуудал нь энэхүү өгүүллээр авч үзсэн гадаадын зарим орны хувьд цаг хугацааны хувьд харьцангуй эрт тавигдсан бөгөөд тэдгээр улс орнуудын Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг шүүхүүд тухайн үед энэхүү асуудлыг хэрхэн шийдвэрлэж байсныг харьцуулж, дүгнэх нь нэг талаас манай улсын хуулийг буцаан хэрэглэх талаарх байр суурийг харуулах бол нөгөөтээгүүр ижил төстэй ойрын ирээдүйд гарах маргаануудыг олон талаас нь авч үзэж, оновчтой зөв шийдвэрлэхэд судалгааны эх сурвалж болж хэрэглэгдэх ач холбогдолтой хэмээн найдаж байна.

## II. ҮНДСЭН ХЭСЭГ

**Монгол Улс дахь хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчмын эрүүгийн эрх зүй дэх хэрэглээ (Үндсэн хуулийн хүрээнд өрнөсөн бодит хэрэг дээр хийсэн дүн шинжилгээ)**

Монгол Улсын Их Хурал 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан. Тус

<sup>1</sup> Kevin Jon Heller, Markus D.Dubber, *The Handbook of Comparative Criminal Law*, (Stanford, California: Stanford University Press, 2011), 17.



хуулиар 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр мөрдөн байцаалтын шатанд прокурорын тогтоолоор, шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болсон Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгахаар заасан. Мөн хуулийн 3 дугаар зүйлд дээр дурдсанчлан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар зохицуулсан юм.

Энэ хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж нэр бүхий иргэд Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасны дагуу маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн “01” дугаартай “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” тогтоолоор уг хуулийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж хүчингүй болгосон.

Тус тогтоолын тогтоох хэсэгт дурдсанаар:

- Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс тэгш байдал ...-ыг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”
- Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”
- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”
- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”
- Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино” гэх зохицуулалтууд тус тус зөрчигдсөн гэж үзжээ.

Уг дүгнэлтийг гаргахдаа Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дунд суудлын хуралдааны 02 дугаартай дүгнэлтийн үндэслэх хэсгийг эш үндэс болгосон юм.

Уг дүгнэлтийн үндэслэлийг хүснэгтээр харуулав.

<p>Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс тэгш байдал ...-ыг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”</p> <p>Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”</p>	<p>Хууль тогтоогч дээр дурдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулийн дагуу эрх бүхий этгээд болон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээн шалгахаар тогтоосон нь иргэдийн эрх зүйн байдлыг дордуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Энэ нь эрх зүйн тодорхой байдлыг тогтоож, хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх төрийн үүрэг болон дээр дурдсан Үндсэн хуулийн суурь зарчмыг зөрчиж, улмаар Үндсэн хуулиар тунхагласан хүмүүнлэг, энэрэнгүй ёсны үзэл баримтлалд харшилж байна.</p>
---	---

<p>Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”</p>	<p>Мөн тухайн хуулиар зөвхөн тодорхой төрлийн гэмт хэргийг буюу Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгахаар тусгасан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлийг бүрдүүлсэн байна. Ийнхүү Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой төрлийн гэмт хэргийг тухайлан зааж өөр журам тогтоосон нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын эрх тэгш байх зарчмыг хууль батлах замаар зөрчих буруу жишиг тогтох үр дагавартайг дурдах нь зүйтэй юм.</p>
<p>Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”</p>	<p>Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт «Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. ...», мөн зүйлийн 7 дахь хэсэгт «Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй.», мөн 26 дугаар зүйлд «Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. ...» гэж тус тус заажээ. Дээр дурдсан зарчмууд нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй.”, 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ.”, 2 дахь хэсэгт “Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт шинээр тооцсон, оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй.”, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ.” гэж баталгаажсан байна.</p>

Үүнээс үзвэл Монгол Улс хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчмыг Үндсэн хуульдаа шууд тусгаагүйгээс Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт нь хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчмыг тойрч, маргаанд хамааралтай байж болох Үндсэн хуулийн бусад зүйл заалтын хүрээнд дүгнэх байдлаар үр дагаврын хувьд дээрх хуулийг буцаан хэрэглэх зохицуулалт бүхий хуулийг хүчингүй болгож шийджээ. Хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчмыг дунд суудлын хуралдааны 02 дугаартай дүгнэлтийн хүрээнд маш товч дурдсан.

Тухайлбал, “Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт «Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. ...», мөн зүйлийн 7 дахь хэсэгт «Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн

улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй.», мөн 26 дугаар зүйлд «Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. ...» гэж тус тус заажээ. Дээр дурдсан зарчмууд нь ... Монгол Улсын Эрүүгийн хуулийн ... 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ.”, 2 дахь хэсэгт “Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт шинээр тооцсон, оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй. .... гэж баталгаажсан байна” хэмээн дурдсан.

Гэвч дээрх Пактын чухам яг аль заалт нь манай улсын Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд давхар тусгагдсаныг нарийвчлан тайлбарлаагүй юм. Нэг гэмт хэрэгт 2 удаа ял шийтгэхгүй байх тухай зарчмыг баталгаажуулсан тус Пактын 7 дахь хэсэг нь хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээгээгүй этгээдэд шууд хамааралтай заалт хараахан биш билээ.

Дээрх байдлаар Үндсэн хуулийн цэц нь манай улсын Үндсэн хуульд хууль буцаан хэрэглэхийг хориглох зарчим нь хэлбэрийн хувьд хуульчлагдаагүй ч агуулгын хувьд хуульчлагдсан эсэх асуултад хариулт өгөөгүй буюу хуулийг буцаан хэрэглэх асуудлыг Үндсэн хуулиар зөвшөөрсөн эсхүл хориглосон эсэх тухай асуудал нь ирээдүйд гарах ижил төстэй маргааны хувьд хэрхэн шийдвэрлэгдэх нь нээлттэй хэвээр үлдэж байна.

### III. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

#### ХБНГУ

Берлиний ханыг манаж байсан цэргүүд хил нэвтрэхээр завдсан олон тооны жирийн иргэдийг буудан хороосон хэрэг нь Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхээр шийдвэрлэгдсэн байдаг. Шүүгдэгчдийн дунд тушаал гүйцэтгэсэн цэргүүдээс гадна тэдэнд тушаал өгсөн цэргийн эрхтэнгүүд болон улс төрчид багтаж байв<sup>2</sup>. Шүүгдэгчид тухайн үеийн Зүүн Германы хуулийн дагуу уг хэргийг үйлдсэн тул тэдний үйлдэл нь хуулийн дагуу байсан. Иймд тэд гэм буруугүй хэмээн маргаж байв. Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүх 1996 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн шийдвэрээр Зүүн Германы хууль бусаар хил нэвтрэх, зэвсэг ашиглахаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу шүүгдэгчид өөрсдийгөө өмгөөлсөн ч хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зохицуулалт тэднийг гэм бурууг тогтооход саад болохгүй гэж үзсэн<sup>3</sup>.

Тухайлбал, “хуулийг буцаан хэрэглэхийг хориглосон зохицуулалт”-ыг шүүгдэгч эшлэх эрхтэй боловч Үндсэн хуулиар Эрүүгийн хуулийг батлах эрхийг олж авсан хууль тогтоогч нь Үндсэн хуульд тусгагдсан бусад бүхий л суурь эрхийг хүндэтгэн, бэхжүүлэх үүрэгтэй бөгөөд хууль тогтоомжийг ардчилсан зарчмаар батлах үүрэг хийгээд эрх зүйт төрийн суурь зарчмуудыг чанд мөрдөх үүрэгтэй<sup>4</sup> гэжээ. Өөрөөр хэлбэл шүүхийн үндэслэл нь тодорхой цор ганц эрхийг тусад нь авч үзэхээс илүү Үндсэн хуулиар хамгаалагдсан суурь шинжтэй эрхүүдийг бүхэлд нь авч үзсэн байна. Иймээс хууль тогтоогчийн баталсан хууль нь Үндсэн хуулиар хамгаалагдсан суурь буюу үндсэн шинжтэй эрхүүдийн баталгааг хангах ёстой бөгөөд энэ шаардлагаас хэт их гажих буюу нэг эрхийг хамгаалах замаар бусад суурь эрхийг үгүйсгэх боломжгүй юм.

<sup>2</sup> Greg Taylor, “Retrospective Criminal Punishment Under the German and Australian Constitutions”, UNSW Law Journal Vol.23, (2000):196

<sup>3</sup> Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн 1996 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн шийдвэр K.-H. W. v. Germany (coe.int) [Сүүлд үзсэн: 2024.07.07]

<sup>4</sup> Мөн тэнд.

Шүүхээс Үндсэн хуулийн 103 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хуулийг буцаан хэрэглэхийг хориглосон зохицуулалт нь Зүүн Германы үеийн хууль бусаар хил нэвтрэхээс урьдчилсан сэргийлэх тухай хуулийн дагуу үйлдсэн аллагын хэргийг зөвтгөх үндэслэл болж чадахгүй талаар дараах байдлаар үндэслэлээ тайлбарлажээ.

Холбооны Бүгд Найрамдах Улс нь гэмт үйлдлийг эрүүжүүлж хууль тогтоох эрхээ эдлэхдээ ардчилал, төрийн эрх мэдэл хуваарилалт, эрх зүйт төрийн зарчмыг чанд мөрдөх ёстой бөгөөд ингээгүй нь Үндсэн хуульд агуулагдсан эрх зүйт төрийн зарчим хийгээд хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зохицуулалтын хооронд томоохон зөрчлийг бий болгосон. Үндсэн хуулийн 103 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зохицуулалтын дагуу иргэний олж авах эрх зүйн хамгаалалт нь гагцхүү суурь эрхийг хүндэтгэдэг ардчилсан зарчмаар сонгогдсон хууль тогтоогчийн баталсан Эрүүгийн хуульд найдах онцгой итгэл бүхий ашиг сонирхол бий үед хэрэглэгдэнэ<sup>5</sup>. Хэрэв өөр дэглэм бүхий улс онц ноцтой гэмт үйлдлийг эрүүжүүлэхийн зэрэгцээ тодорхой бүс нутагт тухайн гэмт хэрэгт оногдуулах эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж, энэ нь олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн хэм хэмжээг ноцтойгоор зөрчиж байвал хуульд найдах онцгой итгэл бүхий ашиг сонирхол нь хамгаалагдахгүй юм.

Учир нь ийм явдлыг өөхшүүлснээр тухайн төр нь төрийн санхүүжилтээр шударга ёсыг ноцтой зөрчсөн үйлдлийн гүйцэтгэгч нь болж хувирах бөгөөд төрийн даалгавраар үйлдэл, эс үйлдэхүй гаргасан этгээд нь зөвхөн тухайн төр оршин буй нөхцөлд л хариуцлага хүлээхгүй байх боломжтой. Ийм онцгой нөхцөлд шударга ёсыг хэлбэрийн хувьд биш агуулгаар нь тайлбарлаж, олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг хүндэтгэж, гэмт этгээдүүдийг хариуцлагаас чөлөөлөх үр дагавар бүхий ийм эрх зүйн хамгаалалтыг хэрэглэхийг хориглох нь зүйтэй. Иймээс Үндсэн хуулийн 103 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр олж авах онцгой итгэл бүхий ашиг сонирхол энэ тохиолдолд хамгаалагдахгүй<sup>6</sup> хэмээжээ.

Энэ шийдвэрийн үндэслэлд үлэмж нөлөө үзүүлсэн эрх зүйн онол номлол нь Радбрухын томьёо юм. Германы нэрт хуулийн профессор, улс төрч Радбрух нь дэлхийн хоёрдугаар дайнаас өмнө хууль болон ёс суртахууны зааг ялгааг хүчтэй гаргадаг эрх зүйн позитивист үзэлтэн хэмээгддэг байсан ч гуравдугаар Рейхийн үеийн дарангуйлал түүний бодлыг өөрчилсөн гэж үздэг. Тэрээр 1946 онд дайн дууссаны дараахан анх удаа өөрийн нэрээр нэрлэгдсэн хууль хэрэглээний тухай томьёогоо танилцуулсан байдаг. Үүнийг товч толилуулвал:

Шударга ёс хийгээд эрх зүйн тодорхой байдлын дунд зөрчил бий болвол хэдий уг хууль нь шударга бус агуулга, зорилгыг агуулж байсан ч хууль тогтоох эрхтэй субъектийн баталсан хүчин төгөлдөр хуулийг дагаж мөрдөх ёстой. Харин шударга ёс хийгээд позитив эрх зүй (хууль) хоорондын зөрүү хүлцэн тэвчих аргагүй болж ирвэл уг хууль нь хуулийг хэлбэрийн төдий агуулж буй “хуурамч хууль” гэсэн үг. Ийм хуулийг ашиглаж аливаа маргааныг шийдэх боломжгүй. Хүлцэн тэвчих боломжгүй хэмжээний зөрүү гэж яг юуг хэлэх талаар нарийн тодорхойлох боломж хомс боловч “шударга ёсны хэлтэрхий ч үгүй, түүний цөм нь болсон тэгш байдлыг огоорсон хууль бол хуурамч хууль болоод зогсохгүй угаас хуулийн (эрх зүйн) мөн чанарыг агуулаагүй байдаг”<sup>7</sup> хэмээжээ.

## **БНАУ**

Чили улс Аргентинийг дарангуйлж байх үед Чилийн засгийн газрын даалгавраар Чилийн дарангуйллыг эсэргүүцэгчдийг хоморголон устгаж байсан Аранчибиа Клавел гэгч этгээдийг хүнийг алах болон бусад хүнд гэмт хэрэгт холбогдуулан 2000 онд яллагдагчаар татаж байв. Түүний үйлдсэн гэх хэргүүд нь 1974-1978 оны хооронд болж өнгөрсөн бөгөөд

<sup>5</sup> Мөн тэнд.

<sup>6</sup> Мөн тэнд.

<sup>7</sup> Brian H. Bix, Robert Alexy, Radbruch's Formula, and the Nature of Legal Theory, 37 Rechtstheorie (2006): 139.

2000 онд түүнийг яллагдагчаар татаж, шүүхэд шилжүүлсэн нь тус улсын хөөн хэлэлцэх хугацааны дээд хэмжээ болох 15 жилээс аль хэдийн хэтэрсэн байв<sup>8</sup>.

Гэвч анхан болон давж заалдах шатны шүүхээс Аранчибиа Клаведын үйлдсэн хэрэг нь олон улсын эрх зүйн дагуу хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг тул тус улсын эрүүгийн хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй гэж үзсэн. Шүүгдэгч хоёр шатны шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж, Дайны болон Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй тухай олон улсын конвенцод Аргентин улс 1995 онд нэгдсэн тул түүний үйлдсэн хэргийг дотоодын эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны дагуу хэлэлцэх ёстой хэмээн маргасан юм. 1995 оноос өмнө хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тухайлсан хөөн хэлэлцэх хугацааг тус улсын Эрүүгийн хуулиар тогтоогоогүй байсан бөгөөд ердийн хугацааг мөрдөж байсан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилсээр тус улсын Дээд шүүхэд шүүгдэгч гомдол гаргасан бөгөөд тус шүүхээс шүүгдэгчийн 1970-аад онд үйлдсэн гэмт хэргүүдэд тус улс 1995 онд нэгдэн орсон Дайны болон Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй байх тухай конвенцыг хэрэглэсэн нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг буцаан хэрэглэсэнд тооцогдох тул тус улсын Үндсэн хуульд харшлала хэмээн дүгнэсэн юм<sup>9</sup>.

Гэвч шүүхээс хэргийн үр дагаврыг шийдэхдээ олон улсын эрх зүйн дагуу Аргентинд тус конвенц нь агуулгаараа 1970-аад оноос өмнө хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн байсан гэх үндэслэл дэвшүүлж шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон<sup>10</sup> байдаг.

### БНСУ

Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нийт иргэд өөрсдийнхөө хийсэн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үйлдлийн төлөө эрүүгийн хариуцлагад татагдахгүй, мөн нэг гэмт хэрэгт давхар шийтгэл хүлээхгүй, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Нийт иргэд нь хуулийг буцаан хэрэглэх замаар улс төрийн эрхийг нь хязгаарлах, хөрөнгийн эрхийг нь хасахаас ангид байна<sup>11</sup>” гэж тус тус заасан байдаг. Бүгд найрамдах Солонгос улс (цаашид “БНСУ” гэх)-д хуулийг буцаан хэрэглэж байсан хэд хэдэн онцлох тохиолдлууд байдаг бөгөөд үүнтэй холбоотой БНСУ-н Засгийн газрын харьяа Хууль тогтоомжийн газрын хийсэн судалгаанд “Манай улс 8-р сарын 15-ны өдрийн чөлөөлөлт, 4-р сарын 19-ний өдрийн ардчилсан хөдөлгөөн, 5-р сарын 16-ны өдрийн цэргийн хувьсгал зэрэг түүхэн он цагуудад буцаан үйлчлэх хүчинтэй хуулиар иргэний эрхийг хязгаарласан олон тохиолдол гарч байсан тул БНСУ-н Үндсэн хуулийн холбогдох заалтууд ихээхэн ач холбогдолтой<sup>12</sup>” хэмээн тодотгосон байна.

БНСУ-д 1945 он хүртэл үйлдэгдсэн Японы колончлолын үеийн хүмүүнлэг бус үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зорилгоор 1948 онд буцаж үйлчлэх шинжтэй Үндэсний эсрэг үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай хуулийг баталж байсан бөгөөд холбогдох заалтыг дараах байдлаар боловсруулж байжээ. Үүнд:

1945 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс өмнөх Үндэсний эсрэг хэрцгий үйлдэлд эрүүгийн хариуцлага ногдуула. ① Японы засгийн газартай хуйвалдан Солонгос Японы нэгдэлд идэвхтэй хамтран ажилласан, Солонгосын бүрэн эрхт байдалд халдсан гэрээ, баримт бичигт гарын үсэг зурсан, хуйвалдаан хийсэн этгээд ② Японы эрхшээлд тусгаар тогтнолын төлөө тэмцэгч болон түүний гэр бүлийнхнийг санаатайгаар хөнөөсөн, хавчсан, энэ үйлдлийг удирдсан этгээд ③ тагнуул хийх замаар тусгаар тогтнолын хөдөлгөөнд саад учруулсан, хорлон сүйтгэх үйлдлээр япончуудад зусардсан, үндэстэнд хохирол учруулсан

<sup>8</sup> Kevin Jon Heller, Markus D.Dubber, *Supra* note 1, 17.

<sup>9</sup> Мөн тэнд.

<sup>10</sup> Мөн тэнд.

<sup>11</sup> БНСУ-ын Үндсэн хууль [1988 оны 2-р сарын 25-ны өдөр хүчин төгөлдөр болсон], [БНСУ-ын Үндсэн хууль №10, 1987 оны 10-р сарын 29-ний өдрийн шинэчилсэн найруулга] Constitution of the Republic of Korea | National Legal Information Center | Statute > text (law.go.kr) [Сүүлд үзсэн: 2024.07.07]

<sup>12</sup> Yang Mi-hyang, The principle of prohibiting retroactive legislation and its permissible limits, 2009. [https://moleg.go.kr/mpbleg/mpblegInfo.mo?mid=a1040202000&mpb\\_leg\\_pst\\_seq=130057](https://moleg.go.kr/mpbleg/mpblegInfo.mo?mid=a1040202000&mpb_leg_pst_seq=130057) [Сүүлд үзсэн: 2024.07.07]

этгээдэд бүх насаар нь цаазаар авах, бүх насаар нь хорих эсхүл 5 ба түүнээс дээш жил хорих ял оноож эд хөрөнгийг нь бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хураах, улс төрийн эрхийг 15 жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлж эд хөрөнгийг нь бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хураах гэж зааж байжээ.<sup>13</sup>

Мөн 1995 оны 12 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан “1980 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн ардчилсан хөдөлгөөний тусгай хууль” нь тухайн үед гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх агуулгатай хууль буцаан хэрэглэх зохицуулалт бүхий хууль болсон.

Хэргийн тухай товч дурдвал 1980 оны 05-р сарын 17-ны өдөр Кванжү хотод цэргийн дэглэм тогтоосныг эсэргүүцэж иргэд жагсаж эхэлсэн бөгөөд иргэдийн жагсаалыг тараахын тулд ардчилсан хөдөлгөөнд оролцогчдыг үй олноор нь цэргийн хүчээр зогсоож, амь насанд нь халдсан хэрэгт холбогдуулан тухайн үед төрийн эрхийг барьж байсан Ерөнхийлөгч Жон Дү Хуан болон түүний хамсаатнуудад эрүүгийн хариуцлага оногдуулсан. Тус хуулийг тухайлсан этгээдэд хандсан, хууль, шүүхийн өмнө хүн бүр эрх тэгш байх зарчимд харшилсан гэж Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргасан ч Үндсэн хуулийн шүүхээс иргэдийн хүсэл зориг, нийтийн эрх ашгийг эрхэмлэн хэрэгсэхгүй болгож, Үндсэн хуульд нийцсэн гэж шийдвэрлэсэн<sup>14</sup> юм.

#### IV. ДҮГНЭЛТ

Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчмыг улс орнууд харилцан адилгүй байдлаар эрх зүйн тогтолцоондоо бэхжүүлж иржээ. Тухайлбал, манай улс Үндсэн хуульдаа уг зарчмыг шууд тусгаагүй боловч Эрүүгийн хуульдаа тусгаж ирсэн байна. Харин дээр дурдсан БНАУ, БНСУ, ХБНГУ нь цөм Үндсэн хуулиараа Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглодог. Иймээс энэ хүрээнд хөндөгдөх тодорхой маргаанууд шууд Үндсэн хуулийн холбогдох заалтыг эшлэх замаар өрнөдөг тул тухайн улсын хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчмын эрүүгийн эрх зүй дэх хэрэглээний талаарх байр суурийг харуулдаг байна.

Харьцуулсан судалгааны үр дүнгээс үзвэл Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчим нь бичигдсэн байдлаараа шууд хэрэглэгддэг туйлын шинжтэй зохицуулалт хараахан биш ажээ. Тухайлбал, БНАУ-ын Аранчибиа Клаведын хэрэг, БНСУ-ын Жон Дү Хуан болон түүний хамсаатнуудын хэрэг, ХБНГУ-ын Берлиний хананд болсон аллагын хэрэг зэрэг нь Үндсэн хуулийн хамгаалалтыг үл хэрэгсэн хуулийг буцаан хэрэглэх үр дагавартайгаар шийдвэрлэгдсэн байна. Эдгээр хэргийн үндэслэлд төвлөрвөл эрүүгийн эрх зүйн шинжтэй хуулийг тодорхой нэг тохиолдолд буцаан хэрэглэх асуудлыг оновчтой шийдвэрлэхийн тулд шударга ёс, хувь хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхол, хууль ёсны итгэл зэрэг эрх зүйт төрийн тулгуур үнэт зүйлсийн талаар сайтар эргэцүүлж, дүн шинжилгээ хийж, зохистой байдлаар харьцуулж, сонгох шаардлагатай болох нь харагдаж байна.

Жишээ нь Аранчибиа Клавед нь тухайн үед Аргентин улсын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэгчдийг хоморголон устгадаг зартай алуурчин байсан бөгөөд тухайн цаг үед энэ төрлийн гэмт хэргийг олон улсад Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг хэмээн үзэж, хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар зохицуулсан байсан буюу тухайн үед Аранчибиа Клаведын үйлдэл нь ганц улсаар тогтохгүй олон улсад гэмт хэрэг хэмээн тодорхойлогдсон байсан гэсэн үг. Гэтэл тухайн улс дээрх конвенцэд гэмт хэрэг үйлдэгдсэний дараа албан ёсоор нэгдсэн нь дотоодын хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх үндэслэл болохгүй тухай тус улсын дээд шүүхээс шийдвэрлэсэн юм.

<sup>13</sup> Мөн тэнд.

<sup>14</sup> Мөн тэнд.



Үлдсэн хоёр хэргийн хувьд хувь хүний эрх, эрх чөлөө хийгээд тухайн цаг үеийн эрх зүйн тогтолцоонд найдах итгэлийг нийтийн ашиг сонирхол болон нийт иргэдийн шударга ёсны мэдрэмжтэй харьцуулах замаар шийдвэрлэсэн байх бөгөөд эдгээр эсрэг тэсрэг ашиг сонирхлыг гэтэлж, шийдвэр гаргах түлхүүр үндэслэл нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн өөрийнх нь шударга ёсны мэдрэмж буюу өөрийн үйлдлийн хууль ёсны байдал цаашид өөрчлөгдөж болохыг таамаглах боломжтой эсэхийг дүгнэсэн явдал байв.

Өмнө нь дурдсанчлан манай улсын хувьд эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглох зарчим Үндсэн хуульд агуулгын хувьд хуульчлагдсан эсэхийг тодруулсан шинжтэй бодит хэрэг маргаан субстанц байдлаар дахин өрнөх нь цаг хугацааны асуудал тул өөрийн орны онцлог, Үндсэн хуулиар хамгаалагдсан үнэт зүйлсэд нийцсэн оновчтой шийдвэр гаргаж, энэ асуудлаарх байр сууриа илэрхийлэхэд энэ мэт судалгаа өчүүхэн ч болов хувь нэмрээ оруулна хэмээн найдаж байна.

---

## ЭХ СУРВАЛЖ

### *Монгол хэл дээрх*

#### *Хууль тогтоомж*

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015.
3. Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2020.01.10. (Хүчингүй болсон)

#### *Шүүхийн шийдвэр*

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн “01” дугаартай “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” тогтоол.

### *Гадаад хэл дээрх*

#### *Хууль тогтоомж*

1. БНСУ-ын Үндсэн хууль, 1988.

#### *Ном, өгүүлэл, судалгааны тайлан*

1. Kevin Jon Heller, Markus D.Dubber, The Handbook of Comparative Criminal Law, (Stanford, California: Stanford University Press, 2011)
2. Yang Mi-hyang, The principle of prohibiting retroactive legislation and its permissible limits, 2009.
3. Brian H. Bix, Robert Alexy, Radbruch’s Formula, and the Nature of Legal Theory, 37 Rechtstheorie (2006).
4. Greg Taylor, “Retrospective Criminal Punishment Under the German and Australian Constitutions,” UNSW Law Journal Vol.23, (2000)

---

**THE APPLICATION OF THE PRINCIPLE OF NON-RETROACTIVITY IN  
CRIMINAL LAW: A COMPARATIVE STUDY**

***Otgonbaatar.E***

*Master's student, School of Law, NUM*

**ABSTRACT:**

The principle of non-retroactivity, a fundamental doctrine internationally recognized and enshrined in numerous Constitutions and Criminal codes, is pivotal in the global landscape of criminal law. This article endeavors to scrutinize and juxtapose the pertinent case laws and legislations of countries such as Mongolia, Argentina, Germany, and South Korea to elucidate the state of non-retroactivity's application in criminal law. Such an analysis could enrich future Mongolian cases with comprehensive judicial reasoning derived from its precedents and the jurisprudence of other countries. Additionally, the researcher has offered his perspectives and findings in the article's conclusion.

**KEYWORDS:**

Legal Certainty, Criminal Code, Basic Rights, Protection of the Basic Rights, Justice.

## ПРОКУРОРЫН ДҮГНЭЛТЭЭР ҮҮСЭХ ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ НЬ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН МАРГААНЫ ШИНЖТЭЙ



**О.Тэнхлүүн**

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант,  
УДШ-ийн дэргэдэх Шүүхийн академийн  
Захиргааны эрх зүйн секторын судлаач*

### **ТОВЧЛОЛ:**

Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлд хяналт тавьж, эрх бүхий албан тушаалтны шийдвэрт холбогдуулан дүгнэлт гаргаж буй нь захиргааны байгууллагыг хянах буюу прокурорын “ерөнхий хяналт” одоог хүртэл тодорхой хүрээнд байсаар байгааг, мөн прокурор захиргааны хэргийн шүүхэд дүгнэлт, нэхэмжлэл гаргаснаараа энэ нь захиргааны байгууллага хоорондын маргаан болох эсэхийг энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээр дамжуулан хүргэхийг зорилоо. Улмаар захиргааны хэргийн шүүхэд прокуророос төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэн нэхэмжлэл гаргах нь ач холбогдол багатайн дээр захиргааны зөрчлийн хэрэгт холбогдуулан дүгнэлт гаргаж буй нь ерөнхий хяналтын чиг үүргийг прокурор хэрэгжүүлсэн хэвээр байх ба энэ нь захиргааны байгууллага хоорондын маргаан болох тухай дүгнэлтэд хүрсэн болно.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Прокурор, захиргааны маргаан, зөрчлийн хэрэг, төр, нийтийн ашиг сонирхол, захиргааны шүүх, захиргааны байгууллага хоорондын маргаан.

### **I. ОРШИЛ**

Захиргааны хэргийн шүүхийн зорилго нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршдог. Харин энэхүү ажиллагаанд прокурорын оролцоо ямар хэмжээнд байх нь дэлхийн улс орнуудад харилцан адилгүй байдаг. Монгол Улсын хувьд прокурор захиргааны зөрчлийн хэрэгт дүгнэлт гаргах, төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн бол нэхэмжлэл гаргах зэргээр захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсоор байна.

Прокурорын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад төрлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хуульд заасан журмын дагуу оролцох асуудал дээр судлаачид өөр өөр байр сууринаас хандсаар байна. Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> Тавин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх..” “шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж заасныг зөвхөн эрүүгийн хэрэг бүртгэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцохыг хэлж байна уу, эсхүл захиргааны зөрчлийн хэрэг бүртгэл, иргэний болон захиргааны хэргийн аль ч шүүхэд төрийг төлөөлөх эрх хэмжээтэй байна уу гэдэг дээр нэгдсэн байр суурь тогтоогүй хэвээр. Энэхүү сэдвийн хүрээнд дараах судалгаа, шинжилгээний ажлууд хийгджээ. Эдгээрт, Ц.Цогт “Захиргааны эрх зүй дэх “хууч хамаарал” буюу прокурорын хяналт,” Г.Банзрагч, “Захиргааны хэргийн шүүхийн хяналтын хүрээг өргөжүүлэх үү, хязгаарлах уу?” Ж.Буджав “Прокурор Үндсэн хуулийн эсрэг зүгт явна,” Э.Болормаа “Захиргааны хэргийн шүүхэд прокурор дүгнэлт гаргах нь,” зэрэг эрдэм шинжилгээний өгүүллүүд болон Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоо” сэдэвт судалгааны тайлан байх бөгөөд судлаачдын дүгнэлт эрс ялгаатай байгаа нь ажиглагдлаа.

Хувь судлаачийн хувьд энэхүү өгүүллээр захиргааны зөрчлийн хэрэгт прокурор дүгнэлт гаргаснаар захиргааны байгууллага, эрх бүхий албан тушаалтанд хяналт тавьж, цаашлаад энэ нь захиргааны байгууллага хоорондын маргааны болох, хэрэв тийм бол хуульд заасан үндэслэл, шаардлагад нийцэх эсэх, мөн Прокурорын тухай хуульд зааснаар төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл прокурор төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж буй жишиг хэр оновчтой байх талаарх өөрийн дүгнэлтийг дэвшүүллээ.

## II. ҮНДСЭН ХЭСЭГ

### 2.1. Прокурорын хяналт

1930 оны 04 дүгээр сард БНМАУ-ын VI Их хурлаас “Тус улсын прокурорын тушаалыг Төв ба аймгуудын зэрэг газруудад үүсгэн байгуулж, хянан байцаах эрх хэмжээг тодорхойлон тогтоовол зохионо” гэсэн түүхэн шийдвэр гарч, мөн оны 08 дугаар сарын 14-нд Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 25 дугаар тогтоолоор прокурорын дагаж мөрдөх эрх, үүргийн дүрмийг<sup>2</sup> баталснаар Монгол Улсад прокурорын байгууллага бий болсон гэж үздэг.<sup>3</sup> Ингэхдээ тухайн цаг үеийн байдлаас улбаалан Зөвлөлт Холбоот Улсын улс төр, эрх зүйгээс эх аван “Ерөнхий хяналт”-ын загвараар бий болсон. Үүний улбаа нь 1920 оны үеэр Зөвлөлтийн захиргааны эрх зүйд шүүхийн функцийг биш харин “хувьсгалт хуулийг” сахин хамгаалахад “прокурорын ерөнхий хяналт” (англ. General Supervision)-ын системийг ашиглах нь зөв гэсэн үзэл баримтлал дэмжигдсэнтэй холбоотой.<sup>4</sup>

1960 оны Үндсэн хуулийн 72 дугаар зүйлд “БНМАУ-ын бүх яам, төв байгууллагууд тэдгээрийн харьяа албан газар, байгууллага, орон нутгийн засаг захиргаа болон олон нийт, хоршооллын бүх байгууллага, мөн албан тушаалтан ба ард иргэдээс хуулийг хэрхэн нарийн чанд биелүүлж байгааг нэгэн адил хянах дээд хяналтыг улсын прокурор гүйцэтгэнэ” хэмээн зохицуулснаас прокурорын ерөнхий хяналтын цар хүрээг харж болно. Тодруулбал, прокурорын байгууллага нь “ерөнхий хяналт”-ыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад хууль ёсыг сахиулах маш өргөн эрхийг эдэлж байсны зэрэгцээ төрийн захиргааны байгууллагуудын шийдвэр үйл ажиллагаанд хууль (социалист)

<sup>1</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992) №1.

<sup>2</sup> “Улсын прокуроруудаас гүйцэтгэх эрх, үүргүүдийн дүрэм” нэртэйгээр баталж, төрийн нэрийн өмнөөс хуулийн биелэлтэд хяналт тавих үүргийг прокурорын газарт хүлээлгэсэн.

<sup>3</sup> Ш.Сүхбаатар, Прокурорын байгууллагын түүхэн товчоон, 2020, 12 дахь тал.

<sup>4</sup> Ц.Цогт, “Захиргааны эрх зүй дэх “хууч хамаарал” буюу прокурорын хяналт,” 2018, 4 дэх тал. Legaldata-аас унших боломжтой: <https://legaldata.mn/b/387>

ёс алдагдахаас сэргийлэх хяналт тавих бүрэн эрхтэй байсан.<sup>5</sup>

1992 оны Ардчилсан Үндсэн хууль батлагдсанаар төрийн эрх мэдэл хуваарилах онолын дагуу хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг бэхжүүлэх зорилтын хүрээнд прокурорын байгууллагын хяналтын чиг үүрэг ихээхэн хумигдсан. Энэ тухай профессор Б.Чимид прокурорын “ерөнхий хяналт”-ын чиг үүргийг захиргааны хэргийн шүүхэд шилжүүлснээр “Монгол Улсын прокурорын газрууд бол Үндсэн хуулийн чиг үүргийн (функц)-хээ хувьд яриангүй эрүүгийн мөрдөн шалгах хүрээний мэргэшсэн байгууллага” болж, .. “мэргэшсэн байгууллага болж байгааг” тайлбарласан<sup>6</sup> байна.

Ийнхүү, Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн Тавин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” хэмээн прокурорын байгууллагын чиг үүргийг хуульчилсан. Үүнээс харвал прокурор нь зөвхөн хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж ажиллах ба өөрөөр хэлбэл эрүүгийн процесс ажиллагаанд<sup>7</sup> хяналт тавьж оролцох юм. Харин шүүх хуралдаанд “төрийн нэрийн өмнөөс” оролцоно гэсэн агуулга нь хяналт тавьж буй эрүүгийн хэрэг маргааны хүрээнд шүүхэд төрийг төлөөлөх гэх агуулгыг илэрхийлж байна.<sup>8</sup>

Тухайлбал, прокурорын хяналтаар хэргийн хохирогч, сэжигтэн яллагдагч, гэрч хуулиар олгогдсон эрхээ бүрэн эдлэх, зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал гаргахгүй байх зэрэгт анхаарч, гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр тогтоогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй тул яллагдагчийг зөрчил, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцуулахаар холбогдох хэргийг шүүхэд шилжүүлдэг. Улмаар прокурор шүүхийн өмнөх stagанд хэрэгжүүлсэн хяналтынхаа хууль зүйн үндэслэлийг нотлох чиг үүрэгтэй ба энэ утгаараа шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцож буй хэрэг болно. Харин иргэний болон захиргааны хэрэг маргаанд тодорхой хязгаарын хүрээнд оролцож болох эсэхийг хязгаарласан Үндсэн хуулийн зохицуулалт байхгүй бөгөөд гагцхүү прокурорын хяналт, шүүх хуралдаанд төрийг төлөөлөх эрх хэмжээг эрүүгийн эрх зүйн хэрэг маргаанаар хязгаарласан агуулгатай байхаар байна.

## **2.2. Прокурор бусад төрлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох нь**

Шинэ Үндсэн хуулиар прокурорын ерөнхий хяналтыг хумьж, захиргааны байгууллагыг хянадаг байсан тогтолцоог халах үндэс бүрдсэн боловч Үндсэн хуулийн Тавин зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасны дагуу Прокурорын байгууллагын тухай хуульд үндэслэн прокурорт иргэний болон захиргааны эрх зүйн маргаанд оролцох нөхцөл бүрдсэн. Прокурорын байгууллагын эрх зүйн байдлыг 1993, 2002, 2017 оны Прокурорын байгууллагын тухай хуулиудаар тогтоож ирснээс “төрийн нэрийн өмнөөс”, “төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах” гэх агуулгаар хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, ял эдлүүлэх ажиллагаатай холбогдолгүй шүүх хуралдаанд оролцох боломжтой болсон юм.

Тухайлбал, 1993 оны Прокурорын байгууллагын тухай хуулиар “...иргэн, захиргааны зэрэг бусад төрлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хуульд заасан журмын дагуу төрийг төлөөлөн оролцоно.”<sup>9</sup> 2002 оны хуулиар “захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх

<sup>5</sup> Мөн тэнд, 5 дахь тал.

<sup>6</sup> Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, 2 дахь хэвлэл, 2017, 320 дахь тал.

<sup>7</sup> Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 36 дахь хэсэгт заасаар “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, түүнд прокурор хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг хэлнэ хэмээн хуульчилсан.

<sup>8</sup> Ж.Буджав, “Прокурор Үндсэн хуулийн эсрэг зүгт явна,” 2023, 20 дахь тал. Legaldata-аас унших боломжтой: <https://legaldata.mn/b/1743>

<sup>9</sup> Прокурорын байгууллагын тухай хууль (1993), 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг.



ажиллагаанд тавих прокурорын хяналт,”<sup>10</sup> мөн “төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний болон бусад төрлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох”<sup>11</sup> зэргээр эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтээс хальсан өөр бусад асуудлаар хяналт тавих өргөн эрх олгогдсон.

Хэрэг бүртгэх ажиллагаанд прокуророос тавих хяналтыг 1993 оны хуулиар дан ганц эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд бус давхар захиргааны зөрчлийн хэрэг буюу төрийн захиргааны эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих агуулгаар баталсан байдаг. Цаашлаад, 2002 оны хуульд дээрх захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлд тавих хяналт улам өргөжиж батлагдсан ба эдгээрт:

- төрийн захиргааны эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх талаар явуулж байгаа ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх;
- захиргааны эрх бүхий байгууллагад ирсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхийг хянах;
- захиргааны шийтгэл үндэслэлгүйгээр оногдуулсан бол прокурор тогтоолоороо түүнийг хүчингүй болгох, өөрчлөх, шаардлагатай бол эрүүгийн хэрэг үүсгэж, харьяаллын дагуу шилжүүлж шалгуулах;
- захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх эрх бүхий байгууллагаас хэрэг бүртгэх ажиллагаа явуулж байгаа материалыг хянах, танилцах, тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр даалгавар өгөх;
- хуульд тусгайлан заасан тохиолдолд захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх эрх бүхий байгууллагаас хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, хязгаарласан ажиллагаа явуулах үед хянаж зөвшөөрөл олгох;
- захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны талаар прокурорын байгууллагад гаргасан гомдлыг шалгаж шийдвэрлэх гэх зэрэг прокурорын хяналтыг үнэмлэхүй нэмэгдүүлсэн зохицуулалтууд орсон.

Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэгт “Прокурор бусад төрлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хуульд заасан тохиолдолд оролцож болно” гэж зааснаас үзвэл прокурор нь төрийн ашиг сонирхол зөрчигдсөнөөс гадна хэрэв хуульд заасан бол бусад шалтгаанаар бүхий л төрлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцож болохоор зохицуулсан мэт ойлгогдохоор байжээ. Энэ талаар судлаачид өөрсдийн дүгнэлтийг хийсэн<sup>12</sup> ба тухайлбал Үндсэн хуулийн Тавин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэн хэсгийг таслалын өмнөх “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж,” гэсэн үндсэн хэсгээс тусад нь салгаж эрүүгийн хэргээс бусад “шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох” мэт агуулгаар өргөжүүлсэн (Үндсэн хуулийн агуулгаас хэтрүүлж).

Улмаар 2017 онд одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилж буй Прокурорын тухай хууль<sup>13</sup> батлагдаж, 2002 оны хуульд байсан захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналт<sup>14</sup>, прокурорын бүрэн эрхийн<sup>15</sup> талаарх зохицуулалтууд хэвээр орж ирсэн. Мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т “зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх,” 17.1.3-т “захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх” ажиллагаанд прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцохыг заасан. Энэ нь өмнөх хуулиудын адилаар прокурорт ерөнхий хяналт олгосон зохицуулалт болсон.

<sup>10</sup> Прокурорын байгууллагын тухай хууль (2002), 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг.

<sup>11</sup> Прокурорын байгууллагын тухай хууль (2002), 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг

<sup>12</sup> Ц.Цогт, *supra* note 3. 10.

<sup>13</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017) №24.

<sup>14</sup> Прокурорын тухай хууль (2017) 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг.

<sup>15</sup> Прокурорын тухай хууль (2017) 12 дүгээр зүйлийн 12.1 дэх хэсэг.

Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн бол дээр дурдсанчлан иргэний болон бусад хэрэг хянан шийдвэрлэх хуралдаанд оролцох зохицуулалт өмнөх Прокурорын байгууллагын тухай хуульд байсан бол 2017 оны хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” хэмээн өргөжиж нийтийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар иргэний шүүхээс гадна захиргааны хэргийн шүүхэд хандах эрхтэй болсон. Энэхүү зохицуулалтын “нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн” гэх агуулга 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиас эхтэй.<sup>16</sup> Үүнээс харвал прокурорын нийтийг ашиг сонирхлыг хамгаалах үүднээс төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хэмжээг хуулийн хүрээнд тодорхой байдлаар захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх чиг хүрээнд нь мөн олгосон байна. Тодорхой байдлаар гэсний шалтгаан нь 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “ЗХШТХ” гэх)-д прокурор төрийг төлөөлөх талаар дурдсанаас нийтийн ашиг сонирхлыг хамгаалах талаарх зохицуулалт ороогүй, цаашлаад 2016 онд шинэчлэн найруулсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>17</sup> (цаашид “ЗХШШТХ” гэх)-д захиргааны хэргийн шүүх хуралдаанд прокурорын оролцоог бүхэлд нь хассан байсан.<sup>18</sup>

Сүүлийн жилүүдэд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах тохиолдол ихсэхийн сацуу нэхэмжлэлийг гаргах эрх бүхий этгээд мөн эсэхийг тогтооход маргаантай, нэг мөр тогтсон ойлголт хэвшилгүй удсан. Прокурор төр, нийтийг ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах чиг үүргийн хувьд төрийн ашиг сонирхлыг нийтийг ашиг сонирхлоос ялгах хэрэгцээ шаардлага бий. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эрх хэмжээг органик хуулиар прокурорын байгууллагад олгосон байх ба үүнтэй холбогдуулан Улсын дээд шүүхээс тайлбар гарсан. Харин төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл үүнийг хэрхэн тайлбарлах, маргааны агуулгын хүрээг хэрхэн тогтоосон нь тодорхойгүй. Нийтийн ашиг сонирхол гэдэг нь “хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах” зорилготой бол төрийн ашиг сонирхол эдгээр агуулгаас ялгаатай юм.

### **2.3. Прокурорын дүгнэлтээр үүсэх зөрчлийн хэрэг нь захиргааны байгууллага хоорондын маргаан уу?**

2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хууль<sup>19</sup> болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль<sup>20</sup> хэрэгжиж эхэлснээс хойш прокурорын дүгнэлтээр захиргааны хэргийн шүүх зөрчлийн хэргийг хүлээн авч шийдвэрлэсээр байна. Энэ нь зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны оногдуулсан шийдвэр хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй, хуульд нийцээгүй гэж үзвэл тухайн зөрчлийн хэргийн оролцогчоос прокурорт хандан гомдол (шийтгэл оногдуулсан, эсхүл шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрт гаргасан), мэдээлэл гаргах, прокуророос тухайн зөрчлийн хэрэгт хяналт тавих, захиргааны хэргийн шүүхэд дүгнэлт гаргах процесс юм. Сурах бичигд дурдсанаар<sup>21</sup> захиргааны зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаа нь богино бөгөөд уг хэргийн оролцогч нь “гомдол гаргагч”-

<sup>16</sup> Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002) 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг “Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.”

<sup>17</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016) №09.

<sup>18</sup> 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар ЗХШШТХ-д 3.1.11 дэх заалтын нэмсэн бөгөөд үүнд “гомдол” гэж “...Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг” хэмээн нэр томъёоны тодорхойлолтод оруулснаар прокурор захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох зохицуулалт захиргааны процесс хуульд нэмэгдсэн.

<sup>19</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017) №24.

<sup>20</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017) №24.

<sup>21</sup> Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, 2 дахь хэвлэл, 2023 он, 117 дахь тал.


зөрчилд холбогдогч хүн, хуулийн этгээд, эсхүл прокурор болон “хариуцагч”-шийдвэр гаргагч эрх бүхий албан тушаалтан буюу улсын байцаагч гэсэн талууд байна гэжээ. Тэхээр прокурорын дүгнэлтээр үүссэн захиргааны зөрчлийн хэргийн талууд аль аль нь төрийн захиргааны байгууллага болно.

Харин захиргааны хэргийн шүүхийн зорилго, хэрэгжүүлэх хяналтыг ЗХШХШТХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “...хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн хуульчилсан. Үүнээс харвал захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах этгээд нь хүн, хуулийн этгээд, мөн тодорхой хязгаартайгаар захиргааны байгууллага байж болохоор байна. Өөрөөр хэлбэл захиргааны шүүхээс субъектив эрхийн хамгаалалтын хүрээнд эрх нь зөрчигдсөн эсхүл зөрчигдөж болзошгүй хүн, хуулийн этгээдийн нэхэмжлэлийн дагуу үүссэн хэрэг маргааныг, харин объектив эрхийн хяналтын хүрээнд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах болон захиргааны байгууллага хоорондын<sup>22</sup> маргааныг хянан шийдвэрлэдэг.

Тэгтэл зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд прокурорын байгууллага нь захиргааны байгууллагын шийдвэрийн улмаас эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээд биш. Мөн төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлж буй, эсхүл нийтийн эрх зүйн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн захиргааны байгууллагын аль ч биш байдаг. Захиргааны хэргийн шүүхээр ямарваа хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хариуцагч нь захиргааны байгууллага, албан тушаалтан байдаг. Тэрхүү хариуцагч захиргааны байгууллагаар дамжуулан төрийн ашиг сонирхол тодорхой хэмжээнд илэрхийлэгдэнэ, харин энэ тохиолдолд прокурор шүүхэд төрийг төлөөлөх ойлголт нь оновчгүй болж ирнэ.<sup>23</sup>

Сүүлийн жилүүдэд прокурорын дүгнэлтээр үүссэн зөрчлийн хэргийн тоо улам нэмэгдэх болсон ба 2023 оны байдлаар эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгуулах, өөрчлөлт оруулахаар 8,234 дүгнэлт бичсэн нь өмнөх оноос 3,983 буюу 93.7 хувиар өссөн ба шүүхээс прокурорын 6,501 дүгнэлтийг хэлэлцсэн тухай прокурорын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланд<sup>24</sup> тэмдэглэгджээ.

**График 1. Прокурорын эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хянаад бичсэн дүгнэлт**



<sup>22</sup> Бусад захиргааны байгууллагын шийдвэрийн улмаас нийтийн эрх зүйн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн захиргааны байгууллага Захиргааны хэргийн шүүхэд хандан нэхэмжлэл гаргахыг ойлгоно. Гэхдээ хүссэн захиргааны байгууллагаас нэхэмжлэл гаргах боломжгүй, тодорхой хязгаартайгаар буюу нэхэмжлэл гаргах эрхийг материаллаг хуулиар тусгайлан олгосон байна.

<sup>23</sup> А.Эрдэнэцогт, Монгол Улсын захиргааны процессын эрх зүй, 3 дахь хэвлэл, 2023 он, 195 дахь тал.

<sup>24</sup> Прокурорын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2023, 43 дахь тал. [https://drive.google.com/file/d/1krRYdFaKXm5c-\\_2BnQB7hH4ly9QNtV/preview](https://drive.google.com/file/d/1krRYdFaKXm5c-_2BnQB7hH4ly9QNtV/preview) (Сүүлд үзсэн: 2024.09.08)

Дээрх тоон мэдээллээс үзэхэд прокурорын бичсэн нийт 8234 дүгнэлтээс 6546 буюу 79.5 хувь нь эрх бүхий албан тушаалтны шийдвэрт өөрчлөлт оруулахаар, 1688 буюу 20.5 хувь нь эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгуулахаар бичжээ. Хүчингүй болгуулах тухай дүгнэлт өмнөх оныхтой харьцуулахад харьцангуй бага өөрчлөлттэй байх хэдий ч өөрчлөлт оруулах тухай дүгнэлт өмнөх оныхоос 147.4 хувийн өсөлттэй байна. Өөрөөр хэлбэл прокурорын дүгнэлтээр үүссэн захиргааны зөрчлийн хэргийн тоо өмнөх оныхоос 93.7 хувиар өссөн шалтгаан нь голчлон эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт өөрчлөлт оруулах шаардлагатай хэмээн прокуророос дүгнэлт гаргах тохиолдол ихэссэнтэй холбоотой юм.

Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж, мөн зөрчлийн хэрэгт хяналт тавьж, дүгнэлт гаргах зэргээр захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган зохигчоор оролцож байгаа нь мөн чанартаа захиргааны байгууллага хоорондын маргаан болох ба үүний үр дүнд хэн нэгэн хүн, хуулийн этгээдийн (гуравдагч этгээдийн) эрх, ашиг сонирхол хөндөгдөж байдаг.<sup>25</sup> Тодруулбал, Зөрчлийн хэргийн хувьд мэдээж прокурорын байгууллагын өөрийнх нь болон төр, нийтийн ашиг сонирхол хөндөгдөөгүй<sup>26</sup>, захиргааны байгууллагын хуульд заасан нийтийн эрх зүйн хүрээнд хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон нөхцөл байдал тогтоогдоогүй байхад захиргааны хэргийн шүүхэд хандаж буй жишиг нь захиргааны байгууллагад хөндлөнгийн хяналт тавих, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор оролцож өөр захиргааны байгууллагатай шүүхийн шатанд маргаан үүсгэж буй явдал. Илүү тодорхой болгох үүднээс жишээ татвал:

*Тохиолдол: Дорноговь аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагч У зөрчлийн холбогдогч иргэн Д-д шийтгэлийн хуудсаар Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-д зааснаар 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан.*

*Дорноговь аймгийн Прокурорын газрын хяналтын прокурор Ц-ээс Эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “нэг үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан хоёр, эсхүл түүнээс дээш зөрчлийн шинжтэй бол аль хүнд шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд нь шийтгэл оногдуулна” гэж заасныг зөрчиж хамгийн хөнгөн шийтгэл оногдуулахаар заасан Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-д зааснаар шийтгэл оногдуулж хууль зөрчсөн байна гэж үзсэн. Улмаар шийтгэлийн хуудасны 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсугай гэснийг 6.15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-д заасан таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, 100000... гэснийг ...500000... гэсэн өөрчлөлт оруулж зөвтгүүлэх үндэслэлтэй гэх дүгнэлт гаргасан байна.*

*Улмаар Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс прокурорын дүгнэлт бүхий гомдлыг хариуцагчаас бүхэлд нь хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.<sup>27</sup>*

Дээрх хэрэг маргааны хувьд зөрчлийн хэргийн холбогдогч гомдол гаргаагүй, нийтийн ашиг сонирхол хөндөгдөөгүй, захиргааны байгууллагаас хуульд заасан нийтийн эрх зүйн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон гэх ЗХШХШТХ-д заасан суурь үндэслэлүүд бүрдээгүй байхад прокурор дүгнэлт гарган зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хянаж, гуравдагч этгээдийн эрх ашгийн хөндсөн. Хэрэв зөрчлийн хэрэгт холбогдогч эрх бүхий албан тушаалтны шийтгэлийн хуудсыг эс зөвшөөрвөл өөрөө шүүхэд гомдол гаргах нь Захиргааны хэргийн шүүхийн зорилготой илүү нийцэх юм.

<sup>25</sup> Г.Банзрагч, “Захиргааны хэргийн шүүхийн хяналтын хүрээг өргөжүүлэх үү, хязгаарлах уу?”, Монголын төр, эрх зүй сэтгүүл, №108, (2024), 08 дахь тал.

<sup>26</sup> Улсын дээд шүүх, Хууль хэрэглээний нэгдмэл байдал: Улсын дээд шүүхийн тайлбарын эмхэтгэл, анхны хэвлэл (2024), 182 дахь тал.

<sup>27</sup> Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 115/ШШ2024/0009 дугаар шийдвэр, [https://shuukh.mn/single\\_case/16192?daterange=2024-01-01%20-%202024-08-07&id=1&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/16192?daterange=2024-01-01%20-%202024-08-07&id=1&court_cat=3&bb=1) (Сүүлд үзсэн: 2023.08.07)

Харин прокурор үүнд хяналт тавьж, захиргааны байгууллага хоорондын маргаантай ижил төсөөтэй маргааныг хуульд заасан “нийтийн эрх зүйн чиг үүргээ хэрэгжүүлэх боломгүй болсон” гэх үндэслэлийг харгалзалгүй үүсгэж буй нь ЗХШХШТХ-ийн анх баталсан үзэл баримтлалаас гажуудсан, сөрөг үр дагавартай юм.

### III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Прокурорын байгууллагаас төр, нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах, төрийн захиргааны эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас явуулж буй захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх, зөрчлийн хэргийн оролцогчоос ирсэн гомдол мэдээллийг хүлээн авч, дүгнэлт гаргаснаар захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор оролцож буй нь 1992 оны Үндсэн хууль батлагдахаас өмнөх үеийн прокурорын “ерөнхий хяналт” өнөөг хүртэл тодорхой хэмжээнд хэрэгжиж байгааг илтгэж байна. Улмаар энэхүү хяналт цаашид ч ихсэх төлөвтэй байгааг харж болохоор байна.

Тодруулбал, 2023 оны байдлаар эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгуулах, өөрчлөлт оруулахаар 8,234 дүгнэлт бичсэн нь өмнөх 2022 оноос 3,983 буюу 93.7 хувиар өссөн тоон үзүүлэлттэй байгаа талаар тайланд дурджээ. Мөн захиргааны хэргийн шүүхэд прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс нэхэмжлэл гаргах тохиолдол ихсэж байгаа бөгөөд “төрийн ашиг сонирхол” болон “нийтийн ашиг сонирхол”-ыг ялгах хэрэгцээ шаардлага бий. Учир нь төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл хохирол учруулсан этгээдүүдээс нөхөн төлбөрийг иргэний хэргийн шүүхэд нэхэмжилж болно. Харин захиргааны хэргийн шүүхэд төрийн ашиг сонирхлыг төлөөлж өөр бусад захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаатай холбогдуулан нэхэмжлэл, дүгнэлт гаргах нь ач холбогдол багатай.

Зөрчил хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны зөрчлийн хэрэг бүртгэл, шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрт хяналт тавьж, шүүхэд дүгнэлт гаргаж буй нь захиргааны хэргийн шүүхээс хэрэгжүүлэх субьектив болон объектив эрхийн хяналтын алинд ч нийцэхгүй. Учир нь прокурор дүгнэлт гаргаж буй зорилго бол хүн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, урьдчилан сэргийлэхээс илүүтэйгээр захиргааны байгууллагын үйл ажиллагааг хуульд нийцэж буй эсэхэд хяналт тавихад илүү чиглэгдсэн, мөн захиргааны зөрчлийн хэрэг, маргааны агуулга нь төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж буй хэрэг биш. Захиргааны байгууллагаас өөрийн чиг үүргийн хүрээндээ зөрчлийн хэрэгт холбогдуулан гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөлт оруулах дүгнэлтийг прокуророос гаргаснаар энэ нь захиргааны байгууллага хоорондын маргаан болж буй хэрэг юм. Гэвч энэ тохиолдолд хуульд заасан захиргааны байгууллагын нэхэмжлэл гаргах үндэслэл буюу нийтийн эрх зүйн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон нөхцөл байдал прокурорын байгууллагын хувьд тогтоогдохгүй.

Иймд судлаачийн зүгээс дараах саналуудыг дэвшүүлж байна. Прокурорын тухай хуульд заасан прокурорын үйл ажиллагаанаас захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих, улмаар зөрчлийн хэрэгт дүгнэлт гаргах эрх хэмжээг олгосон зохицуулалтуудыг хүчингүй болгох. Прокурор “төрийн ашиг сонирхол” зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцохыг заасан зохицуулалтыг хүчингүй болгох. Захиргааны байгууллага хоорондын маргааныг ЗХШХШТХ болон материаллаг хуулиудад нарийвчлан зохицуулах. Төрийн ашиг сонирхлыг нийтийн ашиг сонирхлоос ялгаж зааглах буюу төрийн ашиг сонирхолд хамаарах маргааны агуулгыг тодорхойлох саналыг дэвшүүлж байна.

## ЭХ СУРВАЛЖ

### *Монгол хэл дээрх*

#### *Хууль тогтоомж*

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992) №1.
2. Захиргааны ерөнхий хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015) №28.
3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016) №9.
4. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2002).
5. Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017) №24.
6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017) №24.
7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл (2002) №8.
8. Прокурорын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 он, №24.
9. Прокурорын байгууллагын тухай хууль (1993).
10. Прокурорын байгууллагын тухай хууль (2002).

#### *Ном, өгүүлэл, судалгааны тайлан*

1. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, 2 дахь хэвлэл, УБ, 2017.
2. Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, 2 дахь хэвлэл, УБ, Мөнхийн үсэг, 2023.
3. А.Эрдэнэцогт, Монгол Улсын захиргааны процессын эрх зүй, 3 дахь хэвлэл, УБ, Адмон принт, 2022.
4. Ш.Сүхбаатар, Прокурорын байгууллагын түүхэн товчоон, УБ, Адмон принт, 2020.
5. Улсын дээд шүүх, Хууль хэрэглээний нэгдмэл байдал: Улсын дээд шүүхийн тайлбарын эмхэтгэл, анхны хэвлэл, УБ, Мөнхийн үсэг, 2024.
6. Г.Банзрагч, «Захиргааны хэргийн шүүхийн хяналтын хүрээг өргөжүүлэх үү, хязгаарлах уу?», Монголын төр, эрх зүй сэтгүүл, №108, 2024.
7. Ц.Цогт, “Захиргааны эрх зүй дэх “хууч хамаарал” буюу прокурорын хяналт,” legaldata.mn, 2018.
8. Ж.Буджав, “Прокурор Үндсэн хуулийн эсрэг зүгт явна,” legaldata.mn, 2023.
9. “Прокурорын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайлан,” prokuror.mn, 2023.

#### *Шүүхийн шийдвэр*

1. Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 0009 дугаар шийдвэр.

#### *Цахим эх сурвалж*

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем - <https://legalinfo.mn/mn>
2. Монгол Улсын хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан - <https://legaldata.mn/>
3. Шүүхийн шийдвэрийн цахим сан - <https://shuukh.mn/>
4. Монгол Улсын Ерөнхий прокурорын газар - <https://prokuror.mn/>



---

**A VIOLATION CASE ARISING FROM THE PROSECUTOR'S CONCLUSION IS  
CHARACTERIZED AS AN INTERAGENCY DISPUTE**

***Tenlluun.O***

*Master's student, School of Law, NUM  
(Researcher, Administrative Law sector,  
Judicial Academy under the Supreme Court of Mongolia)*

**ABSTRACT:**

This article aims to convey that reviewing inquiries into violations and issuing conclusions related to decisions made by authorized officials still represents a form of 'general supervision' by the prosecutor over administrative bodies to some extent. Furthermore, by submitting conclusions and claims to the administrative court, the prosecutor could potentially turn the matter into an interagency dispute. Consequently, the act of the prosecutor filing a claim in the administrative court on the grounds of state interests being infringed carries limited significance. Moreover, issuing conclusions related to administrative offenses keeps the prosecutor's general supervision function intact, leading to the conclusion that this could indeed result in an interagency dispute.

**KEYWORDS:**

Prosecutor, administrative dispute, infringement case, state and public interest, administrative court, interagency dispute.

## ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД НОТОЛГООНЫ СТАНДАРТЫГ ТУСГАЙЛАН АВЧ ҮЗЭХ АСУУДАЛ



**З.Янжинлхам**

*УДШ-ийн дэргэдэх Шүүхийн академийн  
Эрүүгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан*

### **ТОВЧЛОЛ:**

Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа нь эрүүгийн процессийг цаг хугацааны хувьд боломжит богино хугацаанд явуулах, энгийн, хүндрэл чирэгдэлгүй байлгах үндсэн зорилготой. Энэ нь шүүхийн практик хэрэгцээнд үндэслэн хөгжсөн бөгөөд эрх зүйн системийн онцлог ялгаанаас үл хамааран энгийн, хялбар, богино хугацаанд хэрэгжих боломжтой байх шинжүүдийг аяндаа нөхцөлдүүлж байдаг. Эх газрын эрх зүйн бүлийн орнуудад хялбаршуулсан буюу түргэвчилсэн ажиллагаанд тавигдах эрүүгийн процессийн шаардлага, нотолгооны стандартыг ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай адил өндөр түвшинд байх шаардлагыг тавьдаг. Гэвч ингэснээр процессийн үр нөлөөг бууруулах сөрөг үр дагавартай болох нь бусад улс орнуудын туршлагаас харагдаж байна.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Эрүүгийн хэргийн бодит үнэн, эрүүгийн процесс дахь тохиролцох арга, эрүүгийн процессийн эрх зүй, ял тохиролцох, мөрдөн нотлох тогтолцоо

## **I. ҮНДСЭН ХЭСЭГ**

### **Нэг. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог**

Зөвшилцөх аргаар эрүүгийн хэргийг шийдвэрлэх явдал орчин үед улс орнуудын эрүүгийн процессийн хөгжлийн нийтлэг чиг хандлага болжээ. Үүний анхны хэлбэрийг жишгийн эрх зүйн бүлийн орнууд тэр дундаа АНУ-ын ял наймаалах аргаас эхлэлтэй гэж үздэг. Уламжлалт эрх зүйн онолд эрүүгийн эрх зүй, эрүүгийн процесс нь төрийн оролцоо бүхий эрх зүйн зохицуулалтын императив аргыг илүү тусгасан байдгаас үүдэн диспозитив ба зөвшин тохиролцох аргыг хэрэглэх ямар ч боломжгүй гэж үзэж байв. Харин Англи-Америкийн системийн эрх зүй судлалын онолд эрх зүйн императив, диспозитив зохицуулалтаас тусдаа компромисс арга, зарчим нь процессийн эрх зүй, тэр

тусмаа эрүүгийн процесст идэвхтэй хэрэглэгдэх боломжтой гэж үзсээр иржээ.<sup>1</sup> Улмаар энэ төрлийн аргыг эрүүгийн процесст хэрэглэх явдал зөвхөн жишгийн эрх зүйн бүлийн орнуудаар хязгаарлагдахгүйгээр эх газрын эрх зүйн бүлийн улс орнууд тогтолцооныхоо онцлогийг шингээж өөр өөрийн хувилбараар хөгжүүлсэн байдаг.

Эдүгээ АНУ-д нийт шийдвэрлэгдэж буй эрүүгийн хэргийн 90 гаруй хувийг ял наймаалах аргыг хэрэглэж шийддэг бөгөөд энэ нь тус улсын эрүүгийн процессийн үгүйсгэх аргагүй чухал хэсэг болж тогтсон байна.

Монгол Улсад 1949 оноос эхлэн “хохирогч нь яллагдагчтай эвлэрсэн” үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох зохицуулалтыг хуульчилж ирсэн ба 2007 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд (2002) хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх зохицуулалтыг анх нэвтрүүлсэн билээ.<sup>2</sup> Үүний дараа 2017 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт заасан “хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-аар яллагч, яллагдагч талууд мөрдөн байцаалтаас шүүхийн шат хүртэл “ялын тохиролцоо” хийх бололцоог олгосон. Энэ нь сонгодог хэлбэрийн ял наймаалах ажиллагаа буюу АНУ-ын plea bargaining ойлголтоос ялгаатай. Тодруулбал, хэргийн зүйлчлэл болон үйл баримтын талаар тохиролцох тухай ойлголт байхгүй. Ингэснээр нэг талаас инквизицийн буюу мөрдөн нотлох зарчимд тулгуурладаг эх газрын эрх зүйн бүлийн онцлогийг шингээсэн хэрэг бөгөөд илүүтэй прокурорын шийдвэрийн дагуу шүүхийн өмнөх болон шүүхийн процессийг түргэвчилсэн байдлаар явуулдаг загварыг хослуулан нутагшуулсныг илтгэнэ.

Мөрдөн нотлох тогтолцоотой орнуудад эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар, эвлэрүүлэн зуучлах болон бусад зөвшилцөх алтернатив аргуудыг ашиглахад эрүүгийн процессийн эрх зүйн суурь зарчмуудтай хэрхэн нийцүүлэх талаарх асуудал маргаан дагуулдаг. Тухайлбал, хялбаршуулсан журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар Оросын эрүүгийн процессийн эрдэмтэн Б.Т.Безлепкин “...эрх зүйт төрийн онол, бодит үнэний зарчмын үүднээс авч үзвэл энэ ажиллагаа нь нотолгооны эрх зүй болон позитив эрхийн агуулга талаасаа дэмжих боломжгүй, хэт субъектив хандлага юм...”<sup>3</sup> хэмээн бичжээ. Гэсэн хэдий ч эрүүгийн хэргийг ердийнхөөс богино хугацаанд хурдавчлан шийдвэрлэх арга, загварууд нь практик зайлшгүй хэрэгцээнээс урган гарсан байдаг. Голчлон гэмт хэрэг үйлдсэн этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, үйлдлийнхээ үр дагаврыг залруулсан бөгөөд гэмт хэрэг нь хүнд биш, хэргийн нөхцөл байдал харьцангуй тодорхой, энгийн нөхцөлд хэрэглэгддэг. Өөрөөр хэлбэл, үйл баримт нь нэгэнт илэрхий бөгөөд талуудын хооронд маргаангүй, хохирлоо нөхөн төлж зөрчигдсөн эрхийг сэргээсэн нөхцөлд зардал, хүч, цаг хугацаа хэмнэж мөрдөн шалгах, прокурор, шүүхийн байгууллагын хязгаарлагдмал нөөцийг зөв зохистой зарцуулах зайлшгүй шаардлагаар хэрэглээ нь зөвтгөгдөж иржээ.

Энэ нь нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн давуу тал бөгөөд үүнийг дотоодын эрдэмтэд, хуульчид нэгэн адил дэмждэг. Жишээлбэл, хууль зүйн ухааны доктор, профессор Ж.Бямбаа, дэд профессор Ж.Эрхэсхулан нар хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгыг нэгдүгээрт ЭХХША-г хялбар, шуурхай, энгийн ойлгомжтой, хүртээмж хүрэлцээтэй болгох; хоёрдугаарт процесс ажиллагааны зардлыг хэмнэх; гуравдугаарт гэм буруугаа үнэн сэтгэлээсээ хүлээн зөвшөөрөх, хохирлоо нөхөн төлөх, хор уршгаа арилгах зэрэг “зөөллөх” алхмуудыг дэмжих замаар нийгмийн амьдралын сөрөг уур

<sup>1</sup> Б.Бат-Орших, Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал /хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл/, (2021), 45 дахь тал.

<sup>2</sup> Эдгээр зохицуулалтууд нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны (цаашид ЭХХША гэх) практикт өргөн ашиглагдаж, үр нөлөөгөө гаргасаар иржээ. Гэсэн хэдий ч 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар хохирогч яллагдагчтай эвлэрснээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох зохицуулалтыг халсан нь судлаач, хуульчдын дунд шүүмжлэлийг дагуулсаар байна.

<sup>3</sup> Б.Бат-Орших дурдсан бүтээлээс дам эшлэв. Правоведение. Юридический журнал, 2009 (№1), с 18-20.

амьсгалыг аль болохоор намжаахад чиглэнэ хэмээн тодорхойлсноос харж болно.<sup>4</sup>

Гэвч үүнийг эрүүгийн процессийн эрх зүйн суурь зарчмууд ялангуяа хэргийн бодит үнэнийг бүх талаас нь бүрэн бодитой шүүхээс тогтоох зарчмын агуулгатай хэрхэн уялдуулах, онцгой тохиолдол болох үүднээс тусгайлан нотолгооны стандарт тогтоох эсэх асуудал нь онолын болоод практик бэрхшээлүүдийг дагуулж байна.

### **Хоёр. Эрүүгийн хэргийн нотолгооны стандарт ба хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхэд баримтлах нотолгооны стандарт**

Эрүүгийн хэргийн нотолгооны стандарт гэдэг нь гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд шаардагдах нотолгооны түвшин, зэрэглэлийг хэлнэ.<sup>5</sup> Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд уг ойлголтыг тодорхойлсон зохицуулалт байхгүй ба энэ нэр томьёо нь жишгийн эрх зүйн бүлийн орнуудад түгээмэл ашиглагддаг. Нотолгооны стандарт нь эрх зүйн зөрчил, маргааны төрөл, эрх зүйн бүлийн онцлогоос хамааран өөр өөр байна.

Тухайлбал, АНУ-д эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудаас хамаарч нотолгооны стандартын 3 өөр түвшинг баримталдаг. Хамгийн доод түвшний стандарт нь “үндэслэл бүхий сэжиг” (reasonable suspicion) буюу ердийн нэг зөн совингоос илүү, мөрдөгчийн мэргэшил, туршлага дээр суурилсан “хүнийг гэмт хэрэгт холбогдуулан сэжиглэхэд тодорхой бөгөөд объектив үндэслэлтэй, фактад тулгуурласан”<sup>6</sup> байна. Үүнд тулгуурлан Үндсэн хуулийн Дөрөвдүгээр нэмэлтэд заасан нэгжлэг хийх, эд зүйл хураан авах ажиллагаа зэрэг тодорхой төрлийн мөрдөн шалгах ажиллагаануудыг явуулж болно.<sup>7</sup> Үүний дараа “магадлалт чанар” (probable cause) орно. Энэ нь “тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэж байгаа гэж үзэх, эсхүл тухайн газарт гэмт хэрэгт хамааралтай тодорхой эд зүйлс байгаа гэж үзэх үндэслэл бүхий нөхцөл байдал үүссэн бөгөөд Үндсэн хуулийн Дөрөвдүгээр нэмэлтийн дагуу энэ нь зүгээр нэг сэжиг төдий биш боловч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох хэмжээний нотлох баримт цуглараагүй байна”. Аливаа этгээдийг баривчлах, эсхүл яллагдагчаар татахад (анг. indictment) энэ түвшний нотолгоог шаарддаг. Хамгийн сүүлчийн ба хамгийн өндөр түвшин бол “үндэслэл бүхий эргэлзээнээс ангид байх” (beyond reasonable doubt) буюу “яллах талаас шүүх хуралдаанд гаргаж буй нотлох баримтуудаар тогтоогдож байгаа хэргийн нөхцөл байдлаас шүүгдэгч тухайн хэргийг үйлдсэн гэдгээс өөрөөр ямар нэгэн логик дүгнэлт гарах боломжгүй”<sup>8</sup> бол энэ стандарт хангагдлаа гэж үзнэ. Энэ нь гэмт этгээдийн гэм бурууг шүүхийн өмнө нотлоход тавигдах хамгийн өндөр шаардлага юм.

Харин эх газрын эрх зүйн бүлийн орнуудад эрх зүйн маргааны төрөл тус бүрд тусгайлан тогтоосон нотолгооны стандартууд нийтлэг байдаггүй. Зарим судлаачид “шүүгчийн дотоод итгэл үнэмшил” (Intime convinence) нь эх газрын эрх зүйн бүлд нотолгооны стандартын үүргийг гүйцэтгэнэ гэж үзсэн нь бий.<sup>9</sup> Английн Дурхам их сургуулийн профессор, ХБНГУ-ын шүүгч асан Майкл Болэндр (Micheal Bohlander) үүнийг жишгийн эрх зүйн бүлийн орнууд дахь тангарагтны шүүгч нарын өмнө хэргийн үйл баримтыг нотлохтой адилтгажээ.<sup>10</sup> Түүхэн үүслийн хувьд XIII-XVIII дугаар зууны хооронд Ромын шашны эрх зүйгээс уламжлалтайгаар эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий орнуудад “legal proof” буюу аливаа хэргийн нотлох баримтыг үнэлэх урьдчилан тогтоогдсон хатуу шалгууруудыг баримталдаг байжээ. Жишээлбэл, бие даасан хоёр гэрч хэргийн үйл баримтын талаар

<sup>4</sup> Ж.Бямбаа болон Ж.Эрхэсхулан, Эрүүгийн процессийн эрх зүйн үндсэн асуудал, (2018), 69 дэх тал

<sup>5</sup> Black's Law dictionary 8<sup>th</sup> ed, (2004), 4399 page

<sup>6</sup> Roberts Schehr, “Standard of proof, presumption of innocence, and plea bargaining: how wrongful conviction data exposes inadequate pre-trial criminal procedure”, *California Western Law Review* (Vol.54, 2018), 59.

<sup>7</sup> Ibid.

<sup>8</sup> Ibid.

<sup>9</sup> Giovanni Tuzet, “Evidene assessment and standart of proof: a missy issue”, *International Journal on Evidential Legal Reasoning*, no.2 (November 2021); George Fletcher, *Basic Concepts of Criminal Law*, (Oxford University Press, 1998), 17; and Micheal Bohlander, *Principles of German Criminal Procedure*, (Hart Publishing, 2012), 24.

<sup>10</sup> Micheal Bohlander, *Principles of German Criminal Procedure*, (Hart Publishing, 2012), 24.

ижил мэдүүлэг өгсөн бол шүүгч түүнийг шууд үнэн гэж үзэх ёстой ба гэрчүүдийн хувийн байдал, мэдүүлгийн эргэлзээтэй нөхцөл байдлуудыг харгалзаж үзэх эрх хэмжээ шүүгчдэд байхгүй. Нөгөөтгээгүүр цорын ганц гэрч хэргийн үйл баримтыг бодитой нотолсон ч шүүгч түүнийг шийдвэрийн үндэслэл болгох эрхгүй байжээ. Өөрөөр хэлбэл, шүүгчид хэргийн үйл баримтыг үнэлэх талаар бүрэн эрх бараг эдлэхгүйгээр нотлох баримтуудыг урьдчилан тогтоосон шалгуурт нийцүүлэн тулгах л үүрэгтэй байв.<sup>11</sup> 1791 онд Францын Үндсэн хууль батлагдаж тус улсад тангарагтны шүүхийн элемент нэвтэрснээр эдүгээ эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудад баримталж буй шүүгчийн дотоод итгэл үнэмшилд (*intime conviction*) тулгуурлан хэргийн үйл баримтыг тогтоох тухай санаа бий болжээ.<sup>12</sup>

Шүүгчийн дотоод итгэл үнэмшилд тулгуурлах нь нотолгооны стандарт эсэх, эсхүл нотлох баримтыг үнэлэх аргад тооцогдох эсэх тал дээр судлаачдын дунд нэгдмэл байр суурь байхгүй.<sup>13</sup> Гэсэн хэдий ч тус хоёр ойлголт нь харилцан нэгнээ орлохоос илүүтэй, нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлж зэрэгцэн хэрэглэгдэх учиртай. Зарим улс орнууд үүнийг эрүүгийн хуульдаа хослуулан тодорхойлсон байна.<sup>14</sup>

Манай улсад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлд заасан хэргийн бодит үнэнийг бүх талаас нь бүрэн бодитой тогтоох зарчмыг нотолгооны стандарт гэж үзэх хандлага байдаг. Энэхүү зарчим нь хэргийн нотолгооны түвшнийг илтгэх боломжтой тал дээр маргахгүй боловч мөн чанартаа мөрдөн нотлох толтолцоотой орнуудын эрүүгийн процессийн суурь зарчим юм. Хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох нийтлэг чиг үүргийн хүрээнд шүүх хэргийн материалтай урьдчилан танилцах, идэвхтэй ажиллах, асууж тодруулах, нотлох баримтыг шинжлэн судлах, хэдийд ч тодруулах асуулт тавих эрхээр хангагдаж, шаардлагатай гэж үзвэл хэргийг мөрдөн байцаалтын шатанд буцаах ч эрхийг эдлэх<sup>15</sup> онцлог шинжийг илтгэнэ.

ЭХХША-ны явцад тогтоож буй “үнэн”-ий ойлголт нь үнэлэмжийн шинжтэй.<sup>16</sup> Процессийн нарийн журмуудыг баримтлан өнгөрсөнд болсон үйл явдлыг аль болох хамгийн өндөр магадлалт байдлаар нь сэргээн тогтоохыг зорьдог. Хүний танин мэдэх чадвартай харьцуулахад эргэлзээгүй, хөдөлшгүй бодитой үнэнийг тогтоох нь боломжгүй зүйл бөгөөд тухайн түвшинд хамгийн эргэлзээ багатай хувилбарыг үнэн гэж тооцдог. Иймээс эрх зүйн тогтолцооны ялгаанаас үл хамааран “үндэслэл бүхий эргэлзээнээс ангид байх” нь эрүүгийн хэргийн нотолгооны стандарт хэмээн ойлгох боломжтой гэж судлаачийн зүгээс үзэж байна.

<sup>11</sup> Ibid.

<sup>12</sup> Францын Эрүүгийн процессийн хуулийн 427 дугаар зүйлд зааснаар “шүүгч нотлох баримтад тулгуурлан өөрийн дотоод итгэл үнэмшлийн үндсэн дээр шийдвэр гаргана”. Үүнд дурдагдаж буй шүүгчийн дотоод итгэл үнэмшил гэдэг нь логик оюун дүгнэлтийн дүрмүүд, рациональ шаардлага, шинжлэх ухаан-танин мэдэхүйн хязгаарлалтуудаас ангид субъектив буюу сэтгэл хөдлөлд тулгуурлах тухай ойлголт биш. Эсрэгээрээ, хэрэг бүрийн онцлогийг харгалзан хариуцлагатай шийдвэр гаргах ухаалаг шийдвэр гаргагчаар дамжуулан хэрэг бүрд нотлох баримтыг ухаалгаар үнэлүүлэх тухай санаа юм. Францад үүсэж бий болсон дотоод итгэл үнэмшлийн баримтлах арга нь цаашлаад эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудад тархжээ. Тухайлбал, ХБНГУ-ын Эрүүгийн процессийн хуулийн 261 дүгээр зүйлд “Шүүгч шүүхийн хэлэлцүүлэгт үндэслэн өөрийн бүрэн эрх, итгэл үнэмшилд тулгуурлан нотлох баримтуудыг үнэлж шийдвэр гаргана” гэж заажээ.

<sup>13</sup> Giovanni Tuzet, *supra* note 10, 91.

<sup>14</sup> Тухайлбал, Италийн Эрүүгийн процессийн хуулийн 192 дугаар зүйлд “Шүүх шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтуудыг үнэлэх шалгуур, үүнээс үүссэн дүгнэлтийг тодорхойлох замаар нотлох баримтуудыг үнэлнэ” гэжээ. Өөрөөр хэлбэл, тодорхой аргачлал, стандарт заагаагүй боловч шүүгч өөрийн сонгосон шалгуур, үндэслэлийг тайлбарлахаар тусгасан байна. Мөн хуулийн 533 дугаар зүйлд “Шүүгчид тухайн гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай болох нь үндэслэл бүхий эргэлзээнээс ангид нотлогдсон бол шүүхээс түүнийг гэм буруутай талаар шийдвэр гаргана. Ийнхүү шийдвэр гаргаснаар шүүхээс ял болон албадлагын арга хэмжээ хэрэглэнэ” гэж зааснаас харвал тус улсад нотолгооны стандарт, нотлох баримтыг үнэлэх шүүгчийн чөлөөт эрх хэмжээг хамтад нь хэрэглэдэг болох нь харагдаж байна. Түүнчлэн Чили улсын эрүүгийн болон эрүүгийн процесс хуулиудад шүүгчийн дотоод итгэл үнэмшлийн зарчмыг илэрхийлсэн “*reglas de la sana crítica*” буюу шүүхийн шийдвэр нь логикийн хууль, орон зай ба цаг хугацаанаас хамаарах хамаарал, хүний эрүүл сэтгэлгээ зэрэгт тулгуурласан байх зарчим үндэслэл бүхий эргэлзээнээс ангид байх нотолгооны стандарттай зэрэгцэн үйлчилдэг байна.

<sup>15</sup> Ж.Эрхэсхулан, “Монголын Эрүүгийн процессийн амин сүнс ба сорилт, бэрхшээл”, Эрх зүй сэтгүүл 61 (1), 2023, 322-323 дахь тал.

<sup>16</sup> Ж.Эрхэсхулан, Шүүхийн шатанд эрүүгийн хэргийг үнэн бодитойгоор тогтоох онол практикийн үндсэн асуудал: Эрүүгийн процессийн эрх зүй, нотолгооны эрх зүй (хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээл), 2018, 38 дахь тал.

Харин хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж буй хэргийн хувьд баримтлах нотолгооны стандартыг анх 2007 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн нэмэлтээр хуульчилснаас эхлээд бага зэрэг ялгаатай нөхцөлөөр тогтоосон гэж үзэж болохоор байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн (2002) 416 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “хэрэг бүртгэгч хэргийг хэн үйлдсэн болохыг тогтоон сэжигтэн, хохирогч, шаардлагатай тохиолдолд гэрчээс мэдүүлэг авах ажиллагаа явуулж, урьд ял шийтгүүлж байсан эсэх талаар лавлагааг материалд хавсаргах”-аар хуульчилсан байна. Үүнээс энэ төрлийн процессоор хэргийг шийдвэрлэхэд ердийн журмаар хянан шийдвэрлэхтэй адил өргөн хүрээнд нотлох ажиллагаа хийхийг шаардахгүй болох нь харагдаж байна. Эрүүгийн хэргийг тал бүрээс нь бүрэн нотолж тогтоох, хянан хэлэлцэх ажиллагаа явагдахгүй, харин тухайн хэргийн болсон нөхцөл байдал нь маш энгийн эсхүл тодорхой нотлох баримттай, үүнийг сэжигтэн, яллагдагч, хохирогч харилцан хүлээн зөвшөөрсөн, гол нь хэргийг аль болох богино хугацаанд зардал, чирэгдэл багатай явуулж байхаар ойлгогдож байна.<sup>17</sup> Хэдийгээр 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон түүнд орсон удаа дараагийн нэмэлт өөрчлөлтүүдээр мөрдөн шалгах ажиллагааны төрлүүдийг өргөжүүлэн нэмсэн боловч үүнээс нотолгооны стандартыг нэмэгдүүлсэн гэж шууд дүгнэх боломжгүй юм.<sup>18</sup>

Энэ талаар хууль зүйн ухааны доктор Б.Бат-Орших “...хялбаршуулсан ажиллагааны мөн чанар нь процессийн үйлдэл, нотолгооны нөхцөлүүд шүүхээс өмнөх шатанд хангагддаг тул шүүхээс нотлох баримтыг нь дахин шинжлэх, хэлэлцэх, үнэлэх асуудал байх ёсгүй...” гэжээ.<sup>19</sup> Өөрөөр хэлбэл, энэ ажиллагааны онцлог нь нотолгооны стандартын асуудлыг шүүхийн шатанд шалгах шаардлагагүй гэж ойлгож болох юм. Үүнтэй төстэй байр суурийг бусад судлаачид мөн илэрхийлсэн нь байна.<sup>20</sup>

### Гурав. Шүүхийн практик

Үүнтэй холбоотойгоор шүүхийн практикийг судалж үзэхэд Улсын дээд шүүхээс дээрхтэй ижил байр суурийг баримталж буй нь харагдаж байна.

**Шийдвэрийн дугаар:** Улсын Дээд шүүхийн 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн №83 тогтоол<sup>21</sup>

**Хэргийн тухай товч:** Шүүгдэгч нь \*\*\* ХХК-ийн удирдах албан тушаалтнаар ажиллаж байхдаа татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор бизнесийн ямар нэгэн үйл ажиллагаа явуулдаггүй нэр бүхий 16 аж ахуйн нэгжүүдээс 2016 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хууль бусаар шивүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татварт ногдох нийт 10,206,218,038.15 төгрөгийн орлого, эд хөрөнгө, бараа үйлчилгээг зориуд худал тодорхойлсон 282 ширхэг падаан бүхий хуурамч санхүүгийн баримтуудыг бодитоор худалдан авсан мэтээр нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг татварын байгууллагад тайлагнаж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Татвар төлөхөөс зайлсхийх” гэмт хэрэгт холбогджээ.

<sup>17</sup> Ханне-Зайделийн сан болон Эрх зүйн боловсролын академи, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, (2010), 357 дахь тал.

<sup>18</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр яллагдагч мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн гэсэн нөхцөлийг нэмж хуульчилсан. Түүнчлэн үзлэг хийх; шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах; хохирогч, гэрчээс мэдүүлэг авах; хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах; эд хөрөнгийг битүүмжлэх; шинжээч томилох болон мөрдөгчийн бие даан явуулж болох бусад ажиллагаануудыг хийж гүйцэтгэхийг прокуророос даалгаж болохоор нэмж зохицуулсан.

<sup>19</sup> Б.Бат-Орших, өмнө дурдсан бүтээл 1, 66-67 дахь тал.

<sup>20</sup> Ч.Бямбасүрэн, Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа: Эрүүгийн процессийн эрх зүйн зарим асуудал /магистрын зэрэг горилсон бүтээл/, (2016), 13 дахь тал.

<sup>21</sup> Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: [https://shuukh.mn/single\\_case/3450?daterange=2018-01-01%20-%202023-09-27&id=3&court\\_cat=2&bb=1](https://shuukh.mn/single_case/3450?daterange=2018-01-01%20-%202023-09-27&id=3&court_cat=2&bb=1) [сүүлд үзсэн: 2024.07.26]



**Процессийн түүх:** Шүүгдэгч нь анхан шатны шүүх хуралдаанаас өмнө прокурорт гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хохирол буюу татварыг нөхөн төлж байгаа, анх удаа гэмт хэрэгт холбогдож байгаа зэргийг харгалзан үзэж өөрт холбогдох эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргажээ. Прокуророос хүсэлтийг хүлээн авч, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2022 оны 11 сарын 09-ний өдрийн шийтгэх тогтоолоор шүүгдэгчийг прокурорын гаргасан саналын дагуу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйлийн 1-д зааснаар 2,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож шийдвэрлэжээ.

Шүүгдэгч давж заалдах шатны шүүхэд гэм буруугийн талаар маргаж, гэмт хэрэг үйлдсэн талаар нотлох баримтаар хангалттай тогтоогоогүй, нотолбол зохих байдлыг бүрэн тогтоогоогүй үндэслэлээр гомдол гаргасныг давж заалдах шатны шүүх хүлээн авсан байна. Улмаар давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүх “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид ЭХХШТХ гэх)-ийн 16.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8.3-т “...яллагдагч, шүүгдэгчийн хэргээ хүлээсэн мэдүүлэг дангаараа гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайг нотлох шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй” гэж<sup>22</sup>; мөн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3; 17.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.1-д тус тус заасан гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар тогтоогдсон эсэхийг прокурор, шүүхээс хянах заалтуудыг зөрчсөн. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг үйлдсэн гэдгийг хөдөлбөргүй тогтоосны дараах яллах дүгнэлт үйлдэх, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаас илүү хурдан, хялбаршуулсан байдлаар явуулах процесс ажиллагаа” хэмээн дүгнэж шийтгэх тогтоолыг хүчин болгосон байна.

Прокуророос хяналтын шатны шүүхэд эсэргүүцэл гаргасны дагуу хяналтын шатны шүүх хэргийг хүлээн авч хянан шийдвэрлэхдээ дараах дүгнэлтийг хийжээ:

*“...Мөрдөн шалгах ажиллагааны явцад яллагдагч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлэхээ илэрхийлж, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн бол хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг гаргаснаар тухайн гэмт хэрэг үйлдсэнийг нотлох баримтаар нотлох үүргээс мөрдөгч, прокурор чөлөөлөгдөхгүй.*

*Өөрөөр хэлбэл, гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрснөөс үл хамаарч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нотлох ажиллагаа зэрэгцэж явагдах тул шүүх шүүгдэгчийн гэм бурууг эцэслэн тогтоох ажиллагаа нотлох баримтад үндэслэнэ.*

*Харин хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгдэгчийн гэм буруу, хэргийн үйл баримтыг сэргээн тогтооход нотолбол зохих байдал, түүнд шууд болон шууд бусаар ач холбогдолтой баримт, мэдээллийг нэг бүрчлэн хуульд заасан үндэслэл, журмын дагуу бүрэн дүүрэн хангалттай цуглуулан, бэхжүүлэх, түүнчлэн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг бүх талаас нь шалгаж, эргэлзээгүй тогтоох зарчим зэрэг хуулиар тогтоосон эрүүгийн хэрэгт баримтлах нотолгооны стандартыг баримтлахыг шаардахгүй...” гэжээ.<sup>23</sup>*

**Шүүхээс шийдвэрлэсэн байдал:** Хяналтын шатны шүүхээс дээрх агуулга бүхий дүгнэлтийг хийж “шүүгдэгч нь хуурамч санхүүгийн баримтуудыг бодитоор худалдан авсан мэтээр нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг харьяа татварын хэлтэст тайлагнаж, 1,020,621,803.85 төгрөгийн буюу их хэмжээний орлого буруулж, нуун дарагдуулсан, татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт үйлдлийг нэг мөр, эргэлзээгүй тогтоох нь хэргийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой” хэмээн үзэж давж заалдах болон анхан шатны шийтгэх тогтоол магадлалыг хүчингүй болгожээ.

<sup>22</sup> Прокуророос эсэргүүцэлдээ яллагдагч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, гэрчийн мэдүүлэг, аудитын шинжээчийн дүгнэлт зэрэг нотлох баримтуудыг эш татсан байна.

<sup>23</sup> Улсын Дээд шүүхийн 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн №83 тогтоолын 15, 17 дугаар цогцолбороос эшлэв.

Дээрх шийдвэрээс дараах дүгнэлтүүдэд хүрч болохоор байна. Үүнд:

Нэгдүгээрт, уг хэрэгт эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд мөрдөх нотолгооны стандартын талаар давах болон хяналтын шатны шүүхүүд эсрэг агуулга бүхий дүгнэлтүүд хийсэн атлаа эцсийн шийдэл ижил байгаа нь анхаарал татаж байна. Улсын дээд шүүхийн (цаашид УДШ гэх) дүгнэлтээс үзэхэд эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд нотлох ажиллагааг “тодорхой түвшинд” хийх боловч хуулиар тогтоосон эрүүгийн хэрэгт баримтлах нотолгооны стандартыг хангахуйц өндөр байх шаардлагагүй. Харин “тодорхой түвшинд” нотлох ажиллагааг явуулаагүй буюу хангалтгүй хийсэн нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох нөхцөл болж байна.

Хоёрдугаарт, судалгааны эхний бүлэгт дурдсанчлан манай улсад АНУ-тай адил сонгодог хэлбэрийн тохиролцоонд суурилсан аргыг хэрэглэдэггүй боловч нотолгооны стандартыг бууруулах нь зөвшилцөх мөн чанарын илрэл болно. Ингэснээр эрх зүйн зайлшгүй процессийн (due process) шаардлагуудын дагуу эргэлзээ үүсвэл ашигтайгаар шийдвэрлэх, хэргийн бодит үнэнийг тогтоох зарчимтай нийцэх эсэх нь маргаан дагуулах гол үндэслэл болдог.

Энэ талаар бусад орнуудын туршлагыг судалж үзэх нь ач холбогдолтой. Судалгааны хүрээнд АНУ болон ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт, онол, шүүхийн практиктай харьцуулан судаллаа.

## **Дөрөв. Харьцуулсан судалгаа**

### **4.1. АНУ-ын эрүүгийн ял наймаалах ажиллагаа дахь нотолгооны стандарт**

АНУ-ын Миннесотагийн их сургуулийн профессор Жоел Самаха бичихдээ ял наймаалах аргыг “... 100 жилийн туршид зохих хэмжээнд хэрэглэгдэж байсан боловч 1970 оноос л эхлэн АНУ-ын Дээд шүүх албан ёсоор хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан юм...” гэжээ. 1970 оны Брэди /Brady/-ийн хэргийн шийдвэрээр ял тохиролцох процессийн нөхцөл, зарчмыг анх удаа АНУ-ын хэмжээнд албан ёсоор бататгаж, хуульчлах баталгааг бүрдүүлсэн юм. Ял наймаалах аргыг гэмт хэргийн ангиллаас үл хамааран хэрэглэж болно. Прокурор яллагдагч гэм буруугаа хүлээнээр түүнд илүү хөнгөн ял оногдуулахаар ялыг наймаалах (plea bargaining), арай хөнгөн ялтай зүйлчлэлийн талаар тохиролцох (charge bargaining), хэд хэдэн зүйл ангитай яллагдагчтай зүйлчлэлийн талаар тохиролцох (count bargaining), эсхүл прокуророос шүүгдэгчийг яллаж буй хэргийн үйл баримтыг наймаалах (fact bargaining) гэсэн төрлүүдтэй. Хэрэв яллагдагч шүүх хуралдаанаас өмнө гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол түүнд холбогдох хэргийн гэм буруу, үйл баримтын талаар тангарагтны шүүгч нараар заавал хэлэлцүүлэх шаардлагагүй гэж үзэж шууд эрүүгийн хариуцлага оногдуулах шатанд шилжүүлнэ.

Энэ процесст хэргийг шүүхийн өмнө нотлоход тавигдах нотолгооны өндөр стандарт үйлчилдэггүй. АНУ-ын дийлэнх мужуудад хүнд ангиллын гэмт хэрэгт холбогдуулан яллагдагчаар татах ажиллагаа grand jury (зарим мужуудад pre-liminary hearing гэнэ) буюу тангарагтны өмнө прокуророос яллагдагчийг холбогдуулан буруутгаж буй гэмт хэрэг, түүний үндэслэл болсон нотлох баримтуудыг танилцуулж зөвшөөрүүлэх процессоор дамжиж хэрэгждэг. Өмнө дурдсанчлан энэ шатанд магадлалт чанарын стандарт (probable cause) хэрэгжих бөгөөд үүний дараа прокуророос яллагдагчтай ял наймаалах ажиллагааг явуулах боломжтой болдог. Өөрөөр хэлбэл, ял наймаалах ажиллагаанд магадлалт чанарын стандартыг хангасан байхад хангалттай байна.

Хүн бүр өөрийн хувь тавиланг шийдвэрлэх бүрэн эрх чөлөөтэй. Үүнийг хувь хүний автономи чанар (individual autonomy эсхүл self-rule, self-determination хэмээн нэрлэнэ) гэнэ. Энэхүү чанарыг хүлээн зөвшөөрөх нь хувь хүний эрхэм чанарыг (анг. human dignity) хүлээн зөвшөөрч буйн илэрхийлэл болдог. Эрүүгийн хэрэгт баримтлах нотолгооны стандартаас татгалзах эрх (right to a criminal standard of proof) нь хүний автономи байдлын

хүрээнд хамаарах<sup>24</sup> буюу хувь хүний шийдвэр гаргалт, түүнийг дагасан үүрэг хариуцлагатай холбож үздэг байна. Яллагдагч өөрийн үйлдсэн гэмт хэргийг тангарагтны шүүгч нарын өмнө шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс тагталзаж гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрснөөрөө “нотлогдох хүртлээ гэм буруугийд тооцогдох” эрхээсээ тагталзаж буйн илрэл гэж үздэг тул ял наймаалах процессийг Үндсэн хууль зөрчсөн гэж үздэггүй.<sup>25</sup> Ингэснээр гэмт хэрэг үйлдсэн этгээд илүү хүнд ял шийтгэлээс гадна, сэтгэл зүй, орлого, цаг хугацаа зэрэг бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас үүдэлтэй сөрөг үр дагавруудаас (анг. trial cost) чөлөөлөгдөх давуу талтай.<sup>26</sup>

АНУ-ын ял наймаалах тогтолцооны талаар тухайн улсын судлаачид эсрэг болон дэмжих байр сууриудыг илэрхийлдэг. Ял наймаалах ажиллагааг дэмжих байр суурьтай судлаачдын хувьд АНУ-ын мэтгэлцэх тогтолцоо нь өөрөө бодит байдалд хэрэгжихдээ тэнцвэртэй мэтгэлцээнийг бүрдүүлж чаддаггүй бөгөөд төрийн хүний нөөц, хэрэг хянан шийдвэрлэх цаг хугацаа зэргийг хэмнэх үүднээс ял наймаалах тогтолцоо нь ашигтай гэж үздэг байна.<sup>27</sup> Нөгөө талд trial tax хэмээх албан бус нэршилтэй далд дарамтаас үүдсэн хэрэгт холбогдогчийн чөлөөт хүсэл зоригийг мохоох хүчин зүйлийг ял наймаалах тогтолцоог шүүмжлэгчид хөнддөг. Trial tax гэдэг нь гэмт этгээд ял наймаалах прокурорын саналыг хүлээн авахаас тагталзаж өөрийн гэм бурууг шүүхээр тогтоолгохоор шийдсэн нөхцөлд оногдуулах боломжтой ялын хэмжээ болон ял наймаалах ажиллагааны үр дүнд оногдуулах ялын хэмжээ хоорондын зөрүүг илэрхийлдэг ойлголт юм. Шүүгдэгч прокурорын саналыг хүлээн авахаас тагталзсан тохиолдолд шүүхээ түүнд илүү хүнд ял оногдуулах айдсыг бий болгох бөгөөд ингэснээр түүнийг аргагүй байдалд оруулдаг талаар судлаачид шүүмжилдэг.<sup>28</sup>

АНУ-ын ял наймаалах ажиллагааны талаар судлаач, доктор А.Жеймсийн үзэж байгаагаар “Ял тохиролцоо процесс нь эрүүгийн процессийг тасралтгүй явуулах, хугацаа хэмнэх, шүүхийн ачаалал, зардлыг багасгах, хэргийг шуурхай шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой. Энэ нь процесст оролцогчдын эрхийг хангах, прокурор, шүүхийн чиг үүргийн уялдааг сайжруулахад ач тустай бөгөөд олон жилийн амьдрал, практикаар зөв болох нь батлагдсан тул үгүйсгэх боломжгүй...” гэжээ.<sup>29</sup> Тохиролцоонд суурилсан аргаар эрүүгийн хэргийг шийдвэрлэх нь өөрөө онолын гэхээс илүүтэй практик шалтгаанаар нөхцөлдсөн байдаг. Тус улсын эрүүгийн процессийн практикт нийт хэргийн 95%-97% нь ял наймаалах хэлбэрээр шийдвэрлэгддэг байна.<sup>30</sup> Уг ажиллагааны хэрэгжилтийн талаарх үзүүлэлтийг харвал 1989 оноос 2016 оныг хүртэл шүүхээс нийт 1886 хүнийг цагаатгаснаас 276 нь буюу 15 хүрэхгүй хувь нь ял наймаалах ажиллагааг хууль бусаар явуулсны улмаас цагаатгагджээ.<sup>31</sup> Нийт ял наймаалах ажиллагаагаар шийдвэрлэгдсэн хэргийн үзүүлэлттэй харьцуулахад энэ нь харьцангуй бага хувийг эзэлж байна.

#### **4.2. ХБНГУ дахь эрүүгийн хэрэгт ял тохиролцоо ажиллагаанд бодит үнэнийг тогтоох зарчмыг баримтлах нь**

Тус улсад 1) хялбаршуулсан журмаар /summary penalty order/; 2) түргэвчилсэн журмаар /expedited proceedings/ болон 3) шүүхийн шатанд зөвшилцөн тохиролцоо /negotiated agreement/ гэсэн хэд хэдэн төрлийн процессийг хуульчилсан. Мөрдөн нотлох тогтолцоотой тул эдгээрийн алинд нь ч нотолгооны стандартыг бууруулах буюу тусгайлан тогтоогоогүй.

<sup>24</sup> Talia Fisher, “The Boundaries of Plea Bargaining: Negotiating the Standard of Proof”, *The Journal of Criminal Law and Criminology* Vol. 97, (2007), 496

<sup>25</sup> Richard L.Lippke, *The Ethics of Plea Bargaining*, (Oxford University Press, 2011), 217-240.

<sup>26</sup> Talia Fisher, *supra* note 26.

<sup>27</sup> Richard L.Lippke, *supra* note ..., 217-240.

<sup>28</sup> Roberts Schehr, *supra* note ..., 57.

<sup>29</sup> *Ibid*, 50.

<sup>30</sup> *Ibid*, 63.

<sup>31</sup> *Ibid*, 65.

Нийгмийн хор аюул багатай жижиг хулгай зэрэг 90 хүртэлх хоногоор хорих ял оногдуулахаар заасан хөнгөн хэргүүдэд шүүх хуралдаан явуулахгүйгээр прокурорын саналыг үндэслэн ял оногдуулах шийдвэр гаргах процессийг хялбаршуулан шийдвэрлэх ажиллагаа гэнэ. Харин түргэвчилсэн гэдэгт үйл баримтын хувьд маргаангүй буюу илэрхий тодорхой, эсхүл хангалттай нотлох баримт цугларсан нөхцөлд<sup>32</sup> 1 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулах боломжтой гэмт хэргүүдэд шүүх хуралдааныг богино хугацаанд товлон явуулах журмыг ойлгоно. Эдгээр нь боломжтой хэргүүдийг богино хугацаанд шийдвэрлэх нөхцөлийг л бүрдүүлдэг бөгөөд тохиролцоо аргыг ашигладаггүй.

Харин зөвшилцөн тохиролцоо аргыг 2009 онд хуульчилжээ. Эрүүгийн процесс хуульд уг нэмэлт зохицуулалтыг оруулахаас өмнө шүүхийн ачаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах үүднээс хуулиас гадуур тохиролцооны аргыг хэрэглэх явдал шүүхийн практикт бий болжээ.<sup>33</sup> Хууль тогтоогчоос Эрүүгийн процесс хуулийн 257 дугаар зүйлд “зөвшилцөх тохиролцоо” (negotiated agreement)-г нэмж зохицуулахдаа эрүүгийн процессийн тулгуур зарчмуудыг шаардлагыг хөндөөгүй гэж үздэг.<sup>34</sup> Хуулийн 257 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүхээс тухайн хэрэгт тохиромжтой гэж үзвэл оролцогч талуудтай цаашид хэрэгжүүлэх процесс ажиллагаа (шүүхэд хэргийн үйл баримтыг тогтоохтой холбоотой ажиллагаануудыг хөнгөвчлөх З.Я) болон хүрэх үр дүнгийн (оногдуулах ял З.Я) талаар тохиролцоонд хүрч болох ба энэ нь бодит үнэнийг тогтоох зохицуулалтыг хөндөхгүй гэж заажээ.<sup>35</sup> Тохиролцоо процессийг шүүгчийн санаачилгаар эхлүүлэх бөгөөд шүүгч болон шүүгдэгчийн хооронд явагдана. Прокурор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий субъектийн хувьд уг процессийн хуульд заасан шаардлагуудын дагуу явагдаж байгаа эсэхийг хянаж, прокурор зөвшөөрсөн нөхцөлд тохиролцоо хүчин төгөлдөр болно.<sup>36</sup> Тохиролцооны агуулгыг шүүгч нээлттэй зарлах ба үүнд оногдуулах ялын дээд болон доод хэмжээг тодорхойлсон байх ёстой. Шүүгдэгчийн гэм буруугийн талаар шинээр нөхцөл байдал илэрсэн, эсхүл ач холбогдол бүхий нөхцөл байдлыг орхигдуулсны улмаас тохиролцоогоор тодорхойлсон ял нь шүүгдэгчийн гэм бурууд нийцэхгүй болсон гэж шүүх үзвэл тохиролцооноос буцаж болно.<sup>37</sup>

АНУ-тай харьцуулахад ХБНГУ-д эрүүгийн процесст тохиролцоог хязгаарлагдмал хүрээнд тодорхойлж иржээ. Хэргийн үйл баримтын талаар тохиролцоо хуулийн хүрээнд зөвшөөрөөгүй. Өөрөөр хэлбэл, ялын тохиролцоо нь эрүүгийн хэргийн нотолгооны стандартыг<sup>38</sup> хөнддөггүй. Тохиролцоо дангаараа шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй ба гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн нь нотлох баримтаар тогтоогдсон эсэхийг зайлшгүй шалгах ёстой.<sup>39</sup> Товчхондоо, шүүх болон шүүгдэгчийн хооронд зөвхөн ялын тохиролцоо явагдана. Харин хэргийн үйл баримт, шүүгдэгчийн гэм бурууг нотлох баримтаар хөдөлбөргүй тогтоосон байхыг шаарддаг байна.

Тус улсын Үндсэн хуулийн шүүхээс 2013 онд Эрүүгийн процесс хуулийн 257 дугаар зүйлд заасан тохиролцоо ажиллагаа нь Үндсэн хуулиар тогтоосон шударга шүүхээр шүүлгэх болон гэм буруугийн зарчмын шаардлагуудыг зөрчөөгүй гэж үзсэн. Шүүхийн шийдвэрийн үндэслэлд ял тохиролцоо процесс нь хуульд заасан шаардлагуудыг бүрэн хангасан бол шүүгдэгчийн Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг зөрчихгүй гэж дүгнэжээ.

<sup>32</sup> Micheal Bohlander, *supra note* ..., 86.

<sup>33</sup> Matthias Jahn and Charlotte Schmitt-Leonardy, “The German “Verständigung” and Consensual Elements in German Criminal Trials”, *German Law Review* (2020), page 1134-1148.

<sup>34</sup> Ibid.

<sup>35</sup> Criminal Procedure Code of Germany (1950), article 257c.1.

<sup>36</sup> Criminal Procedure Code of Germany (1950), article 257c.3.

<sup>37</sup> Criminal Procedure Code of Germany (1950), article 257c.4.

<sup>38</sup> Эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудын хувьд хэргийн бодит үнэнийг тогтоох зарчим нь нотолгооны стандартыг чиг үүргийг гүйцэтгэдэг.

<sup>39</sup> Alexander Schemmel, Christian Corell and Ntatie Richter, “Plea Bargaining in Criminal Proceedings: Changes to Criminal Defense Counsel Practise as a Result of the German Constitutional Court Verdict of 19 March 2013?”, *German Law Journal* (Vol.15, 2014), 43-64

Тухайлбал, шүүх хуралдааны явцад шүүгч шүүгдэгчтэй тохиролцоонд хүрсэн бол үүнийг шүүхийн тэмдэглэлд нэг бүрчлэн тусгах, шүүхийн шийдвэрийн үндэслэлд тохиролцооны талаар тодорхой бичих зэргээр тохиролцох процессийн ил тод байдлыг хангаж, хангалттай хэмжээнд баримтжуулах, шүүгдэгчийн давж заалдах эрхийг хангах зэргээр 257 дугаар зүйлд заасан шаардлагуудаас гадна процесс хуулийн ерөнхий шаардлагуудыг хангасан бол энэ ажиллагаа нь Үндсэн хуульд нийцсэн гэж үзнэ.

Ийнхүү Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр тохиролцох арга нь Үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн гэсэн дүгнэлт хүрсэн боловч уг шийдвэр гарснаас хойш практикт ялын тохиролцоог хэрэглэх тоо эрс багассан байдаг. Тухайлбал, 2012 онд ХБНГУ-ын 3 мужийн шүүгч, прокурор, өмгөөлөгч нарын дунд явуулсан судалгаагаар судалгаанд оролцогчдын 50-аас дээш хувь нь ял тохиролцох аргаар шийдвэрлэсэн нийт хэргийн 50-аас дээш хувийг хуульд заасан шаардлагуудыг бүрэн хангаагүй нөхцөлд шийдвэрлэсэн гэжээ. Харин 2017 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн нийт хэргийн ердөө 0.62% нь ял тохиролцох аргаар шийдвэрлэгдсэн байна.<sup>40</sup> Эндээс ял тохиролцох ажиллагаанд тавигдах стандарт шаардлагыг нэмэгдүүлэхээс өмнө энэхүү арга нь харьцангуй идэвхтэй хэрэглэгддэг байсан нь харагдана. Нөгөө талаар тохиролцох аргаар ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг давж заалдсан хэргийн 93.7% нь процессийн хуулиар тогтоосон хэлбэрийн шаардлагууд буюу шүүх хуралдааны тэмдэглэлд тусгах, шүүхийн шийдвэрийн үндэслэлд тодорхой бичих заалтуудыг зөрчсөн зэрэг үндэслэлээр гомдол гаргасан бол зөвхөн 7.4% нь шүүх хэргийн үйл баримтыг тогтоох үүргээ зөрчсөн агуулгаар гаргажээ.

Шүүхэд ял тохиролцох ажиллагааны хэрэгжилтийн чанарын үзүүлэлт нь АНУ-тай ойролцоо үр дүнг харуулж байна. Хэдийгээр тогтолцооны хувьд ялгаатай боловч үр дүн ойролцоо байгаа нь эрүүгийн процесс ажиллагааг хялбарчлах, богино хугацаанд шийдвэрлэхийг эрэлхийлсэн аргууд нь шүүхийн практикт тулгарсан хүндрэлүүдээс нөхцөлдсөн байдагтай холбоотой буюу хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг ач холбогдлыг харуулж байна.

## II. ДҮГНЭЛТ

Эрүүгийн хэргийг хялбаршуулж буюу зөвшилцөх аргаар шийдвэрлэх нь шүүхийн практик хэрэгцээнд үндэслэн хөгжсөн бөгөөд эрх зүйн тогтолцооны ялгаанаас үл хамааран энгийн, хялбар, богино хугацаанд хэрэгжих боломжтой байх шинжүүдийг аяндаа нөхцөлдүүлж байдаг. Цаашид ч эрүүгийн процесст энэ төрлийн ажиллагааны ач холбогдол улам бүр өссөн нэмэгдэхээр байна. Харин энэ явцад эрүүгийн хэргийн нотолгооны стандартыг хэрхэн тогтоох нь онолын бөгөөд практикт маргаан дагуулсан асуудал болж байна. Энэ талаар дотоодын судлаачдын бүтээлүүдийг судалж үзэхэд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь шүүхийн өмнөх шатанд нотолгооны нөхцөл хангагддаг учир шүүхийн шатанд энэ талаар дахин хэлэлцэх шаардлагагүй хэмээн байр сууриа илэрхийлжээ. Харин шүүхийн практикт ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай адил түвшинд нотлогдсон байхыг шаардахгүй боловч тодорхой түвшинд нотлох ажиллагааг явуулсан байхыг шаардаж байна. Үүний тулд ямар хэмжээнд нотлох ажиллагаа явуулсан байх нь тодорхойгүй хэвээр боловч ингэснээр хялбаршуулсан процессийн онцлог, мөн чанарт илүү нийцдэг нь бусад улс орнуудын туршлагаас харагдаж байна. Процессийн хэт өндөр шаардлага тавих нь эсрэгээрээ уг ажиллагааны үр дүнд сөрөг нөлөөлж болохыг ХБНГУ-ын туршлагаас харж болно. Цаашид энэ нь ердийнхтэй харьцуулахад аль зэрэг доогуур стандарттай байх талаар практик болон харьцуулсан судалгааг гүнзгийрүүлэх шаардлагатай.

Манай улсад хэрэглэгдэж буй хялбаршуулсан процесс нь АНУ-тай адил шүүхийн өмнөх шатанд хэрэгждэг боловч зөвхөн ялын тохиролцоо хийхийг зөвшөөрдгөөрөө

<sup>40</sup> Matthias Jahn and Charlotte Schmitt-Leonardy, *supra note 35*.

ХБНГУ-тай төстэй. Өөрөөр хэлбэл, хэргийн үйл баримт, зүйлчлэлийн талаар тохиролцох ойлголт байхгүй. Гэхдээ яллагдагч мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж, гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлэх нь ялын тохиролцооны урьдчилсан нөхцөл болдгоос үзвэл талууд “тодорхой түвшинд” харилцан буулт хийх агуулга тусгагдсан. Үүнээс өмнө хэрэг бүртгэлтийн шатанд тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн талаарх шаардлагатай нотлох ажиллагааг хийж гүйцэтгэсний дараа түүнд холбогдуулан ЭХХША-г цааш хэрхэн үргэлжлүүлэх талаар яллагдагчид өгч буй нэг хэлбэрийн сонголт юм.

Эрүүгийн хэргийн нотолгооны стандартыг бууруулах нь энэхүү сонголтоос шууд шалтгаална. АНУ-д уг сонголт хийх эрхээ эдлэх үйл явц нь хувь хүний автономн байдалд тулгуурлаж хөндлөнгийн нөлөөллөөс ангид due process-ын шаардлагад нийцсэн нөхцөл байдал дор явагдах ба эргээд сонголт хийх эрх чөлөөгөө эдэлсний үүрэг, хариуцлагыг ухамсарлах чадвартай гэж үзнэ. Үүнээс үзэхэд гэмт хэрэгт холбогдуулан шалгагдаж буй этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрснөөр нотлогдох хүртлээ гэм буруугүйд тооцогдох эрх болон бусад процессийн хамгаалалтуудаас сайн дураараа татгалзаж буй талаар бүрэн ойлголттой болсны үндсэн дээр “мэдээлэлд үндэслэсэн зөвшөөрөл” гаргах баталгааг хангах нь чухал юм.



**ЭХ СУРВАЛЖ*****Эрх зүйн эх сурвалж:***

1. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, (2002)
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, (2017)
3. Criminal Procedure Code of Germany, (1950)

***Шүүхийн шийдвэр:***

Улсын Дээд шүүхийн 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн №83 тогтоол

***Монгол хэл дээр:***

1. Б.Бат-Орших, Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал /хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл/, (2021)
2. Ж.Бямбаа болон Ж.Эрхэсхулан, Эрүүгийн процессийн эрх зүйн үндсэн асуудал, (2018)
3. Ж.Эрхэсхулан, Шүүхийн шатанд эрүүгийн хэргийг үнэн бодитойгоор тогтоох онол практикийн үндсэн асуудал: Эрүүгийн процессийн эрх зүй, нотолгооны эрх зүй (хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээл), (2018)
4. Ж.Эрхэсхулан, “Монголын Эрүүгийн процессийн амин сүнс ба сорилт, бэрхшээл”, Эрх зүй сэтгүүл 61 (1), (2023)
5. Ханнс-Зайделийн сан болон Эрх зүйн боловсролын академи, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, (2010)
6. Ч.Бямбасүрэн, Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа: Эрүүгийн процессийн эрх зүйн зарим асуудал /магистрын зэрэг горилсон бүтээл/, (2016)

***Гадаад хэл дээр:***

1. Alexander Schemmel, Christian Corell and Ntatie Richter, “Plea Bargaining in Criminal Proceedings: Changes to Criminal Defense Counsel Practise as a Result of the German Constitutional Court Verdict of 19 March 2013?”, German Law Journal (Vol.15, 2014)Black’s Law dictionary 8<sup>th</sup> ed, (2004)
2. Giovanni Tuzet, “Evidene assessment and standard of proof: a missy issue”, International Journal on Evidential Legal Reasoning, no.2 (November 2021)
3. George Fletcher, Basic Concepts of Criminal Law, (Oxford University Press, 1998)
4. Micheal Bohlander, Principles of German Criminal Procedure, (Hart Publishing, 2012)
5. Matthias Jahn and Charlotte Schmitt-Leonardy, “The German “Verständigung” and Consensual Elements in German Criminal Trials,” German Law Review (2020)
6. Roberts Schehr, “Standard of proof, the presumption of innocence, and plea bargaining: how wrongful conviction data exposes inadequate pre-trial criminal procedure,” California Western Law Review (Vol.54, 2018)
7. Richard L.Lippke, The Ethics of Plea Bargaining, (Oxford University Press, 2011)
8. Talia Fisher, “The Boundaries of Plea Bargaining: Negotiating the Standard of Proof”, The Journal of Criminal Law and Criminology Vol. 97, (2007)

## THE STANDARD OF PROOF IN SIMPLIFIED CRIMINAL PROCEDURE

*Yanjinkham.Z*

*Researcher at the criminal Law sector of  
Judicial Academy of Mongolia.*


### **ABSTRACT:**

In light of increasing efforts and dedication to reducing the complexity of criminal procedures, simplified or expedited processes-rooted in the urgent need to effectively manage judicial resources and ensure the efficient administration of justice-have gained traction worldwide. Regardless of whether the criminal procedure is based on the inquisitorial or adversarial system, simplicity, and efficiency are essential to its implementation. Nonetheless, bearing its inquisitorial tradition, some countries have been insisting on their stringent procedural requirements, including the high standards of proof for simplified processes. This insistence has proven to have a counterproductive effect on implementation in those countries.

### **KEYWORDS:**

The principle of material truth, negotiation in criminal procedure, criminal procedural law, plea bargaining, the inquisitorial system

## 18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН БУСДАД УЧРУУЛСАН ХОХИРЛЫН УЛМААС ҮҮДЭХ ЭЦЭГ, ЭХИЙН ГЭМ ХОРЫН ХАРИУЦЛАГЫН АСУУДАЛ



*Б.Хэрлэнчимэг*  
*Хууль зүйн магистр*

### ТОВЧЛОЛ:

Монгол Улсын Иргэний хууль дахь эцэг, эхийн гэм хорын хариуцлагын тухай зохицуулалт нь “гэм буруугийн зарчим”-д суурилсан. Энэхүү зохицуулалт нь олон талын эрх, ашиг сонирхлыг нэгэн дор зохистойгоор зохицуулахыг зорьсон ба 1) хүүхэд хамгаалал болон 2) хохирогчийн хохирлоо нөхөн барагдуулах ашиг сонирхлоос гадна, хүүхдэд тавих хяналтын үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэдгээ нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөх боломжийг олгосноор 3) гэм хорын хариуцлага хүлээх субъект болох эцэг, эхийн эрх чөлөөт байдлыг ч мөн анхаарч үзсэн байна. Гэсэн хэдий ч эцэг, эхэд хуулиар оногдуулж буй хараа, хяналт тавих үүргийн агуулга тодорхой бус байх ба үүнээс улбаалан гэм буруугийн зарчим тогтолцооны түвшинд хэрэгжих, ялангуяа эцэг, эхийн үйл хөдлөл хийх эрх чөлөө бодитоор хангагдах боломж хомс байгаа болохыг суурь зарчмын үүднээс шүүмжлэлтэйгээр авч үзэхийг зорилоо.

### ТҮЛХҮҮР ҮГС:

Гэм буруугийн зарчим, эцэг, эхийн үйл хөдлөл хийх эрх чөлөө, хараа хяналт тавих үүрэг, хүүхэд хамгаалал, хохирогчийн хохирлоо нөхөн барагдуулах эрх

### I. ОРШИЛ

Энэхүү өгүүллээр Монгол Улсын Иргэний хууль дахь 18 хүртэлх насны хүүхэд<sup>1</sup>-ийн бусдад учруулсан хохирлын улмаас үүдэх эцэг, эхийн гэм хорын хариуцлагын талаар авч үзэх болно.

Насанд хүрсэн иргэний адилаар өөрийн үйлдлийн үр дагаврыг бүрэн ухамсарлах чадвар хараахан бүрэлдээгүй улмаас 18 хүртэлх насны хүүхэд осол, аварга өртөх, сониуч, сахилгагүй үйлдлээр бусдад хохирол учруулах тохиолдол багагүй бий. Улмаар тэдний бусдад учруулсан хохирлыг эцэг, эх нь хариуцан арилгах ёстой гэх ойлголт олон нийтийн дунд нийтлэг байх боловч эрх зүйн үүднээс авч үзвэл, дан ганц хохирогчийн хамгаалалтаас

<sup>1</sup> Хэдийгээр Иргэний хуулийн 503 дугаар зүйлд “7-14 хүртэлх насны иргэн”, “насанд хүрээгүй иргэн [14-18 хүртэлх насны]” болон “эрх зүйн чадамжгүй иргэн [7 хүртэлх насны]” гэх нэр томъёо ашиглагдсан байх боловч энэхүү өгүүллэд 0-18 хүртэлх насны иргэний эрх зүйн хязгаарлагдмал чадамж бүхий бүх этгээдийг хамтад нь “хүүхэд” гэх нэр томъёогоор илэрхийлсэн болно. Энэ нь Хүүхдийн эрхийн тухай хууль (2016)-ийн 3.1 дэх хэсэгт “хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хамгаалахад энэ хууль үйлчилнэ” гэж заасан тус хуулийн үйлчлэх хүрээтэй нийцэх юм.

гадна, хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжлийн суурь асуудал, эцэг, эхийн эрх чөлөөт байдал гэх мэтчилэн төрөл бүрийн зохицуулалтын зорилгыг агуулдаг, гэм хорын эрх зүй болон гэр бүлийн эрх зүйн огтлолцол дээр орших онцлог зохицуулалт гэж хэлж болно.

Манай улсын Иргэний хууль дахь эцэг, эхийн гэм хорын хариуцлагын тухай зохицуулалт нь “гэм буруугийн зарчим”-д суурилах ба хохирогч болон хүүхэд хамгааллын зорилгоос гадна эцэг, эхийн эрх чөлөөт байдлыг ч мөн анхаарч үзсэн, өөрөөр хэлбэл олон талын эрх, ашиг сонирхлыг нэгэн дор зохистойгоор зохицуулахыг зорьсон систем юм. Гэсэн хэдий ч эцэг, эхэд хуулиар оногдуулж буй хяналт тавих үүргийн агуулга тодорхой бус байх ба үүнээс улбаалан гэм буруугийн зарчим тогтолцооны түвшинд хэрэгжих, ялангуяа эцэг, эхийн үйл хөдлөл хийх эрх чөлөө бодитоор хангагдах боломж хомс байгаа болохыг суурь зарчмын үүднээс шүүмжлэлтэйгээр авч үзэхийг зорилоо.

Ингэхдээ одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хуулийг 1994 оны Иргэний хуультай харьцуулах замаар тус зохицуулалтын онолын үндэслэл, зарчмын асуудлыг тодруулж (нэгдүгээр хэсэг), дараагаар нь шүүхийн практик дахь хууль хэрэглээний асуудлын талаар шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхийг зорьсон болно (хоёрдугаар хэсэг).

## II. Монгол Улсын Иргэний хууль дахь зохицуулалт

1952<sup>2</sup> оноос эхлэн Монгол Улс анх удаа эцэг, эхийн гэм хорын хариуцлагын тухай асуудлыг Иргэний хуульд тусгах болсон. Түүнээс хойш 1963<sup>3</sup>, 1994 оны Иргэний хуулийн шинэчилсэн найруулгаар багахан хэмжээний нэмэлт өөрчлөлтүүд орсон боловч суурь зарчмын хувьд ижил, төсөөтэй зохицуулалтууд уламжлагдан ирсэн байна. Харин 2002 оны Иргэний хууль дахь эцэг, эхийн гэм хорын хариуцлагын тухай зохицуулалт нь зарчмын хувьд томоохон өөрчлөлт хийснээрээ ихээхэн онцлог тул 1994 болон 2002 оны Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг харьцуулан авч үзэх нь ач холбогдолтой юм.

### 2.1. 1994 оны Иргэний хууль дахь эцэг, эхийн гэм хорын хариуцлагын тухай зохицуулалт

Иргэний хууль дахь эцэг, эхийн гэм хорын хариуцлагын тухай зохицуулалт нь гэм хорын тусгай төрөл<sup>4</sup>, мөн “иргэний эрх зүйн чадамж”<sup>5</sup>-ийн тухай ойлголттой нягт уялдаа

<sup>2</sup> З.Сүхбаатар нар, *Монгол Улсын Иргэний хууль тогтоомж (түүхэн эмхэтгэл) 1206-2012*, Монгол өмгөөлөгч хууль зүйн фирм, 2012, 112 дахь талаас БНМАУ-ын Иргэний хууль (1952) -ийн холбогдох заалтыг ишлэв.

255 дугаар зүйл: Эрх ба үүргийг эдлэх чадваргүй этгээд нь бусдад гэм хорыг учруулбал үл хариуцах бөгөөд харин түүнийг асран харж байгаа этгээд хариуцах болно. Насанд хүрээгүй боловч 14 нас хүрсэн хүүхдээ бусдад гэм хорыг учруулсан байвал түүнийг насан хүрээгүй хүүхдийн хамтаар түүний эцэг, эх нь асран харж буй хүмүүс хариуцна.

<sup>3</sup> З.Сүхбаатар (2) 191 дэх талаас БНМАУ-ын Иргэний хууль (1963) -ийн холбогдох заалтыг ишлэв.

321 дүгээр зүйл: Бага насны хүмүүс гэм хор учруулсны хариуцлага: Бага насны (арван таван нас хүртэлх) хүмүүсийн учруулсан гэм хорыг тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч хариуцна. Бага насны хүмүүс нь сургууль, хүүхэд хүмүүжүүлэх байгууллага, эмнэлгийн газрын шууд хяналтын дор байхдаа бусдад учруулсан гэм хорыг тэдгээр сургууль, хүүхэд хүмүүжүүлэх буюу эмнэлгийн байгууллага хариуцна.

322 дугаар зүйл: Насанд хүрээгүй хүмүүс гэм хор учруулсны хариуцлага: Насан хүрээгүй (арван таваас арван найм хүртэлх насны) хүмүүс бусдад учруулсан гэм хорыг өөрсдөө хариуцна. Насанд хүрээгүй хүмүүс хөдөлмөрийн хөлс авдаггүй буюу учруулсан гэм хороо арилгахад хүрэлцэх хөрөнгөгүй бол тийнхүү хүрэлцээгүй хэмжээгээр тэдгээрийн эцэг, эх, харгалзан дэмжигч төлөх ёстой. Тэдгээрийн эцэг, эх, харгалзан дэмжигч нь хэрэв учрах гэм хорыг таслан зогсоож чадахгүй нөхцөлд байсан буюу гэм хор учруулсан этгээд насанд хүрсэн, эсхүл насанд хүрээгүй хүмүүс нь учруулсан гэм хорыг нөхөн төлөхөд хүрэлцэх хөдөлмөрийн хөлс, эд хөрөнгөтэй болсон бол дурдсан хариуцлагаас чөлөөлөгдөнө.

<sup>4</sup> З.Сүхбаатар (2) 328 дахь талаас 1994 оны Иргэний хуулийн холбогдох заалтыг ишлэв. 1994 оны Иргэний хуулийн 377.1 дэх хэсэгт “бусдын амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг бүрэн хариуцаж арилгах үүрэгтэй”, 377.2 дахь хэсэгт “гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд ийнхүү гэм хор учруулсны хариуцлага хүлээхгүй” гэж тус тус заасан. Энэхүү заалтын хүрээнд авч үзвэл гэм буруугийн нотлох үүргийн хуваарилалтыг хариуцагч талд шилжүүлсэн боловч үндсэн зарчмын хувьд “гэм буруугийн зарчим” үйлчилж байсан гэж хэлж болно. Харин эцэг, эхийн гэм хорын хариуцлагын тухайд эцэг, эхийн гэм буруугийн асуудлыг хариуцлага хүлээлгэх үндэслэл болгон авч үздэггүй байснаараа эцэг, эхийн гэм хорын хариуцлагын асуудал нь гэм хорын ерөнхий зохицуулалтаас зарчмын хувьд ялгаатай, гэм хорын тусгай зохицуулалт болон ангилагддаг байсан байна.

<sup>5</sup> Иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж, үүрэг бий болгох чадварыг эрх зүйн чадамж гэх ба энэхүү чадвар нь 18 наснаас эхлэн бүрэн үүснэ (1994 оны ИХ 9-р зүйл).

холбоотой зохицуулагдаж ирсэн онцлогтой. Улбаалан, 1994 оны Иргэний хуульд тус зохицуулалт нь хүүхэд гэм хор учруулахад “бага насны” буюу 14 хүртэлх настай байсан, эсхүл “насанд хүрээгүй” буюу 14-18 настай байсан эсэхээс шалтгаалан дараах байдлаар ялгажтай тусгагджээ.

Юун түрүүнд, бага насны буюу 14 хүртэлх насны хүүхдийн бусдад учруулсан гэм хорыг тэдний хууль ёсны төлөөлөгч болох эцэг эх, асран хамгаалагч хариуцан арилгана (1994 оны ИХ 381.1 дэх хэсэг). Түүнчлэн, хууль ёсны төлөөлөгчөөс гадна, бага насны хүүхэд сургууль, хүүхэд хүмүүжүүлэх болон эрүүл мэндийн байгууллагын шууд хяналтын дор байхдаа бусдад учруулсан гэм хорыг эдгээр байгууллага (цаашид “сургууль болон бусад этгээд” гэх) хариуцан арилгана (1994 оны ИХ 381.2 дэх хэсэг).

Харин 14-18 насны хүүхэд бусдад гэм хор учруулсан тохиолдолд, тухайн этгээд өөрөө гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй (1994 оны ИХ 383.1 дэх хэсэг). Гэвч, гэм хорыг арилгахад тэдний ажил эрхэлж олсон цалин, хөлс, орлого зэрэг хүрэлцэхгүй бол ийнхүү хүрэлцэхгүй хэмжээгээр эцэг эх, харгалзан дэмжигч нөхөх хариуцлага хүлээнэ (1994 оны ИХ 383.3 дэх хэсэг).

#### **А) Зохицуулалтын зорилго**

Энэхүү зохицуулалтын зорилгыг насанд хүрээгүй хүүхэд болон хохирогчийн эрх, ашиг сонирхлын үүднээс дараах байдлаар тайлбарлаж болох юм.

Нэгдүгээрт, үйлдлийнхээ зөв, бурууг ялгаж салгах чадвар бүрэн төлөвшөөгүй, хөдөлмөр эрхлэх дадлага, туршлага хараахан эзэмшээгүй байгаа эдийн засгийн ямар ч чадавхгүй бага насны хүүхдэд төлж баршгүй өндөр үнийн дүн бүхий гэм хорын хариуцлага оногдуулах нь дааж давшгүй хүнд ачаа болох ба хүнлэг ёсны зарчимтай нийцэхгүй юм<sup>6</sup>. Улмаар бага насны хүүхдийг гэм хорын хариуцлагаас чөлөөлж, оронд нь тэдний эцэг эхээр хохирол нөхөн төлүүлэхээр тусгасан дээрх зохицуулалтын цаана хүүхэд хамгааллын бодлого тусгагдсан гэж тайлбарлаж болох юм. Хэдийгээр 14-18 насны хүүхэд бие даасан хариуцлагын субъект болох боловч, эцэг эхийн нөхөх хариуцлагын хүрээнд хүүхэд хамгааллын зорилго зохих түвшинд хэрэгжсээр байх болно.

Хоёрдугаарт, иргэний эрх зүйн хязгаарлагдмал чадамж бүхий иргэнд оногдуулсан хэлцлийн хязгаарлалтын улмаас 14 хүртэлх насны хүүхэд гэм хорыг арилгах эд хөрөнгөгүй байх<sup>7</sup> ба гэм хорын хариуцлага оногдуулсан ч хэрэгжих боломж ихээхэн хомс билээ. Улмаар, хохирогчийн хохирлоо нөхөн барагдуулах ашиг сонирхлын үүднээс бага насны хүүхдийг хариуцлагаас чөлөөлж, харин эдийн засгийн чадамж бүхий эцэг, эх, эсхүл сургууль болон бусад этгээд холбогдох хохирлыг нөхөн төлүүлэхээр зохицуулжээ. Харин 14-18 насны хүүхдийн тухайд авч үзвэл, тодорхой зөвшөөрөгдсөн хэмжээнд хэлцэл хийж, эд хөрөнгө олж авах, түүнийгээ захиран зарцуулах эрх хуулиар олгогдсон<sup>8</sup> байх тул бусдад учруулсан гэм хорыг арилгах эд хөрөнгөтэй байх магадлал 14 хүртэлх насны хүүхэдтэй харьцуулахад харьцангуй өндөр юм. Улмаар, хохирогч 14-18 насны хүүхдээ гэм хорын хохирлоо гаргуулахаар шаардах эрхтэй ч, хүрэлцэхгүй байгаа хэмжээгээр эцэг, эхээс мөн шаардах эрхтэй байхаар хуульчилснаар хохирогчийн эрх, ашиг сонирхол сайтар хамгаалагдсан байгаа юм.

<sup>6</sup> Ж.Оюунтунгалаг, *Иргэний эрх зүйн онолын асуудал*, 2 дахь хэвлэл, УБ, 2018, 180 дахь тал. “Гэм хорыг арилгах үүргийн тусгай төрөл: Эрх зүйн чадамжгүй болон зарим чадамжтай этгээдийн гэм хорын хариуцлага” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллээс ишлэв.

<sup>7</sup> “Бага насны” буюу 14 хүртэлх насны хүүхэд өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцлийг бие даан хийх чадвартай боловч үүнээс бусад төрлийн хэлцлийг түүний нэрийн өмнөөс хууль ёсны төлөөлөгч болох эцэг эх, асран хамгаалагч хийхээр зохицуулжээ (1994 оны ИХ 10-р зүйл).

<sup>8</sup> “Насанд хүрээгүй” буюу 14-18 насны хүүхдийн хувьд өөрийн үйлдлийн үр дагаврыг ухамсарлан ойлгож, шийдвэр гаргах чадвар төлөвшихийн хэрээр бие даан хийж болох хэлцлийн цар хүрээ ч мөн өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж байв (1994 оны ИХ11-р зүйл). Тухайлбал, тэд эцэг, эхийн зөвшөөрөлгүйгээр өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого зэргийг захиран зарцуулах эрхтэй.

## **В) Эцэг, эх ба сургууль болон хүмүүжлийн байгууллагын хариуцлагын харилцан хамаарал**

14 хүртэлх насны хүүхдийн бусдад учруулсан гэм хорын тухайд, эцэг, эхээс гадна сургууль болон бусад этгээдийн хариуцлагын асуудал тусгагдсан байна. Энэхүү зохицуулалт нь 1963 оны Иргэний хуулийн 321 дүгээр зүйлээс<sup>9</sup> уламжлагдан ирсэн ба 1974, 1989 оны Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолуудад “шүүх иргэний хуулийн 321-р зүйлд зааснаар хариуцагчаас гэм хор учруулсны хохирлыг гаргуулахдаа бага насны хүмүүс, хэний асрамж, хяналтад байхдаа бусдад хохирол учруулсныг нарийн шалган тогтоохгүй байгаагаас тэдгээр хүмүүс цэцэрлэг, сургуулийн хяналтад байх үедээ бусдад учруулсан хохирлыг эцэг, эхээр нь хариуцуулдаг явдал буруу болохыг заасугай”<sup>10</sup> гэж тэмдэглэгджээ.

Ийнхүү 1994 оны Иргэний хуулиар эцэг, эхийн гэм хорын хариуцлагын асуудлыг иргэний эрх зүйн чадамжийн хязгаарлалт, эдийн засгийн чадавхтай нягт уялдуулан гэм хорын тусгай төрөл болгон авч үзэхийн зэрэгцээ, хүүхэд хамгааллын асуудал болон хохирогчийн хохирлоо нөхөн барагдуулах механизмыг сайтар анхаарч үзсэн зохицуулалттай байсан байна гэх дүгнэлтэнд хүрч болох юм. Харин хариуцлага хүлээх субъектыг тодорхойлоход хэн нэгний гэм буруугийн асуудал огт хөндөгддөггүй байсан ба хүүхэд гэм хор учруулахад хэний шууд хараа, хяналтан дор байсан бэ гэх байршил, цаг хугацааг голчлон авч үздэг байсан болохыг дээр дурдсан шүүхийн тогтоолуудаас харж болохоор байгаа юм.

### **2.2. 2002 оны Иргэний хуулийн холбогдох зохицуулалт**

Эцэг, эхийн гэм хорын хариуцлагын тухай зохицуулалт нь 2002 оны Иргэний хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд гэм хорын тусгай төрөл<sup>11</sup>, мөн иргэний эрх зүйн чадамжийн тухай ойлголт<sup>12</sup>-нд тулгуурласан гэх онцлог шинжүүдээ хадгалсаар ирсэн боловч, үндсэн суурь зарчмын хувьд томоохон өөрчлөлтийг хийснээрээ өмнөх зохицуулалтаас ихээхэн ялгаатай.

Юун түүрүүнд 14 хүртэлх насны хүүхдийн бусдад учруулсан гэм хорыг тэдгээрийн эцэг, эх хариуцан арилгах боловч (ИХ 503.1), гэм буруугүй буюу хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэдгээ нотолж чадвал гэм хорын хариуцлагаас чөлөөлөгдөж болно (ИХ 503.4). Мөн түүнчлэн зөвхөн 7-14 насны хүүхдийн тухайд, сургууль, хүүхэд хүмүүжүүлэх

<sup>9</sup> Ишлэл (3)-г харна уу.

<sup>10</sup> Ж.Амарсанаа нар, *Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл (1959-2010)*, УБ, МУИС-Хууль зүйн сургууль, 2013, 163 ба 435 дахь тал, Бүгд Хурлын 1974 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 11/32-р тогтоол, 1989 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн БНМАУ-ын Дээд Шүүхийн Бүгд Хурлын Тогтоол №42.

<sup>11</sup> 2002 оны Иргэний хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд гэм хорын ерөнхий зохицуулалт болох 497.1 дэх хэсэгт “гэм буруу”-г шаардах эрхийн нэг бүрэлдэхүүн болгон хуульчилж, улмаар гэм буруугийн нотолгооны хуваарилалтыг нэхэмжлэгч талд оноосноороо өмнөх зохицуулалтаас ихээхэн ялгаатай. Гэвч, тус хуваарилалтыг хариуцагч талд оногдуулсан 1994 оны Иргэний хуулийн 377.2 дахь заалт 2002 оны Иргэний хуулийн 497.2 дахь хэсэгт уламжлагдан ирсэн байна. Улмаар, нэхэмжлэгч болон хариуцагчийн аль нь гэм бурууг нотлох ёстой вэ гэх асуудал тодорхойгүй байх ба зайлшгүй шийдвэрлэх ёстой суурь зарчмын асуудлын нэгээр тавигдсаар байна. Дэлгэрэнгүйг, Р.Пүрэвбаатар, “Иргэний хуулийн 497 дугаар зүйлийг нотлох үүргийн онолын үүднээс тайлбарлах нь” *Шүүх эрх мэдэл сэтгүүл* №3 (2018) 126 дахь талаас үзнэ үү. Хэрэв гэм хорын ерөнхий зохицуулалтын хүрээнд ч гэм буруугийн презумци үйлчилнэ гэж тайлбарлавал, гэм хорын ерөнхий зохицуулалт болон эцэг, эхийн гэм хорын тусгай зохицуулалтын аль аль нь гэм буруугийн нотлох үүргийг хариуцагчид оногдуулсан болох юм. Улбаалан, гэм хорын ерөнхий болон тусгай зохицуулалт гэж системчлэн авч үзэх онцын шаардлага бий эсэх нь эргэлзээтэй болох юм.

<sup>12</sup> 2002 оны Иргэний хуулиар 18 хүртэлх насны иргэний эрх зүйн чадамжийг дараах 3 төрөлд ангилан авч үзэх болсон. Нэгдүгээрт, 7 хүртэлх насны хүүхэд “иргэний эрх зүйн чадамжгүй” гэж тооцогдох ба бүх төрлийн хэлцлийг тэдний нэрийн өмнөөс хууль ёсны төлөөлөгч болох эцэг, эх нь хийнэ (ИХ 18-р зүйл). Хоёрдугаарт, 7-14 насны хүүхэд “иргэний эрх зүйн зарим чадамжтай” ба өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцлээс бусад хэлцлийг тэдгээрийн нэрийн өмнөөс эцэг, эх нь (ИХ 17-р зүйл) хийнэ. Гуравдугаарт, 14-18 насны хүүхэд “иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай” ба эцэг, эхийн зөвшөөрөлгүйгээр бие даан хийж болох хэлцлийн хүрээ өргөжиж, өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого зэргийг захиран зарцуулах эрхтэй (ИХ 16-р зүйл).



болон эрүүл мэндийн байгууллага<sup>13</sup>-ын (цаашид “сургууль болон бусад этгээд” гэх) шууд хяналтан дор байхдаа бусдад учруулсан гэм хорыг тухайн этгээд хариуцан арилгана (ИХ 503.2).

Дараагаар нь, 14-18 дээш насны хүүхэд бусдад учруулсан гэм хорыг өөрөө хариуцан арилгах үүрэгтэй (анхдагч хариуцлагын субъект) боловч түүний цалин, хөлс захиран зарцуулах эрхэд нь байгаа хөрөнгө гэм хорыг арилгахад хүрэлцэхгүй бол хүрэлцэхгүй байгаа гэр хэмжээгээр эцэг эх нь нөхөх хариуцлага хүлээнэ (хоёрдогч хариуцлагын субъект) (ИХ 503.5). Мөн, 14-18 насны хүүхдэдээ хараа хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэдгээ нотолж чадвал эцэг, эх дээрх хариуцлагаас чөлөөлөгдөж болно (ИХ 503.6).

### **А) Зохицуулалтын зорилго**

2002 оны Иргэний хууль эцэг, эх хараа хяналт тавих үүргээ зөрчсөн эсэхийг шалгуур болгон гэм хорын хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэлийг шинэчлэн тусгаснаараа эцэг, эхийн гэм хорын хариуцлагын асуудлыг “гэм буруугийн зарчим”-д үндэслэх шинэ тогтолцоо руу шилжсэн. Өөрөөр хэлбэл, 18 хүртэлх насны хүүхдийн бусдад учруулсан хохирлын учир, шалтгааныг хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэх эцэг, эхийн санаатай болон болгоомжгүй гэм буруутай үйлдэлтэй холбон тайлбарлах болсон юм<sup>14</sup>.

Гэм буруугийн зарчим нь тогтолцооны түвшинд дараах ач холбогдолтой<sup>15</sup>. Юун түрүүнд, “гэм буруутай бол хариуцлага оногдуулна” гэж анхааруулах байдлаар нийгмийн харилцаанд оролцох үед бусдад хохирол учруулахгүйн тулд өөрийн үйлдэлдээ сайтар анхаарал, болгоомжтой байх инсентивийг төрүүлдэг бол нөгөөтэйгүүр, “гэм буруугүй бол хариуцлага хүлээхгүй байж болно” гэж гэм хорын хариуцлагаас чөлөөлөгдөх баталгааг бий болгосноор үйл хөдлөлдөө анхаарал, болгоомжтой хандаж буй иргэнд сэтгэл амар, тайван байх боломжийг бүрдүүлсэн байна.

Ийнхүү эцэг, эхийн гэм хорын хариуцлагын асуудлыг гэм буруугийн зарчимд үндэслэх болсноор эцэг, эх хүүхдэдээ тавих хараа, хяналтаа ухамсартайгаар удирдан зохицуулж, түүнээс үүдэн гарах эрх зүйн үр дагаврыг урьдчилан таамаглах боломжтой болох ба цаашлаад зохицуулалтын зорилгын түвшинд эцэг, эхийн үйл хөдлөл хийх эрх чөлөө хуулиар хамгаалагдах болсон юм. Энэхүү зохицуулалтын зорилго тогтолцооны түвшинд хэргэжлийн тулд мэдээж хуулиар оноож буй үүргийн агуулга, гэм буруу буюу үүргийн зөрчлийг тогтоох аргачлал тодорхой байх зайлшгүй шаардлагатай билээ.

Харин гэм буруугийн нотолгооны хуваарилалтын тухайд эцэг, эх гэм буруугүй гэдгээ нотлохоос нааш хариуцлагаас чөлөөлөгдөхгүй буюу тус хуваарилалтыг хариуцагч тал болох эцэг, эхэд шилжүүлсэн байгаа нь онцлог юм (гэм буруутайн презумпци<sup>16</sup>). Энэхүү нотлох үүргийн хуваарилалтын талаар судлаач Б.Буянхишиг, хүүхдийн бусдад учруулсан үйлдлийн тухайд гэм хорын объектив бүрэлдэхүүнийг хангасан<sup>17</sup>, мөн тухайн үйлдэл нь хууль бус болох нь тогтоогдсон бол “хууль өөрөө хяналт тавих, шалгах үүрэг бүхий этгээд гэм буруутай байх тухай таамаг дэвшүүлж байгаа юм”<sup>18</sup> гэжээ.

Ийнхүү нотлох үүргийн хуваарилалтыг хариуцагч талд шилжүүлсэн нь нэг талаасаа хүүхдийн зан авирын төлөвшил эцэг, эхийн хүмүүжил, хараа хяналтаас шууд хамааралтай байх нь нийтлэг гэх ерөнхий ойлголтоос улбаатай, нөгөөтэйгүүр хохирогчийн хохирол барагдуулах механизмыг илүү хөнгөвчлөх гэсэн зорилгыг агуулсан байж болох юм.

<sup>13</sup> Хэдийгээр Монгол Улсын Иргэний Хуулийн тайлбарт ИХ-н 503.2 дахь хэсэгт заасан байгууллагуудын талаар дэлгэрүүлсэн тодорхойлолт тусгагдаагүй байх боловч, холбогдох эрх зүйн актуудад дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал, Боловсролын ерөнхий хууль (2023)-ийн 18.1 дэх хэсэгт “боловсролын сургалтын байгууллага нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, дээд сургууль, их сургууль байна.”; Эрүүл мэндийн тухай хууль (2011)-ийн 3.1.4 дэх хэсэгт “эрүүл мэндийн байгууллага гэж хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг” хэлнэ гэж тус тус заажээ.

<sup>14</sup> Ж.Оюунтунгалаг (6) 180-181; 183-184 дэх тал.

<sup>15</sup> Ryoichi Yoshimura, *Tort law*, Yuhikaku Publishing Co.Ltd, 6th ed, 2022, p.7. Atsumi Kubota, *Tort law: Understanding Civil Law*, Yuhikaku Publishing Co.Ltd, 2nd ed, 2018, p.5-9.

<sup>16</sup> Ж.Оюунтунгалаг (6) 185 дахь тал.

<sup>17</sup> Б.Буянхишиг, *Иргэний эрх зүйн тусгай анги*, Анхны хэвлэл, Соёмбо хэвлэлийн компани, 2010, 362 дахь тал.

<sup>18</sup> Б.Буянхишиг (17) 359 дэх тал.

### **В) Эцэг эхийн хараа хяналт тавих үүргийн хүрээ ба хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл**

Дээр дурдсанчлан гэм буруугийн зарчмын зорилгын үүднээс авч үзвэл, эцэг, эхийн хараа хяналт тавих үүргийн агуулга тодорхой байснаар эцэг, эхийн үйл хөдлөл хийх эрх чөлөө хамгаалагдахад чухал ач холбогдолтой.

Манай судлаачдын дунд эцэг эхийн хяналт тавих үүргийг Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйл<sup>19</sup>-д заасан хүүхдээ асран хамгаалж, хүмүүжүүлэх үүрэгтэй холбож тайлбарлах, тус үүргийн агуулгыг орон зай, цаг хугацаанаас үл хамааран хэрэгжсээр байдаг үргэлжилсэн шинж чанартай гэж өргөн хүрээнд авч үзэх хандлага ажиглагдаж байна.

Тухайлбал судлаач Ж.Оюунтунгалаг “хүүхдийн учруулсан гэм хорыг төлөх эцэг, эхийн хариуцлагын хувьд биеллэн тавих хараа хяналтын үүрэг гэхээс илүүтэй хүүхдийн хүмүүжлийг суурь болгон авч үзсэн” ба “хүүхдийн муу хүмүүжилд тухайн эцэг, эхтэй холбоогүй гэх нөхцөл байдлыг нотолсон тохиолдолд гэм буруугүй гэж үзэхээр байна” гэжээ<sup>20</sup>. Мөн түүнчлэн, судлаач Т.Мөнхжаргал дараах байдлаар дурджээ<sup>21</sup>. Хэдийгээр хүүхдээ танил, садан төрлийн хүн, гэрийн үйлчлэгч, асрагчийн хяналтад түр үлдээсэн ч, эцэг эх хүүхдээ асран хамгаалж, хүмүүжүүлэх үүргээ хэрэгжүүлсээр байна гэж үзэх ба бага насны хүүхэд дээрх этгээдүүдийн хараа хяналтан дор байхдаа бусдад учруулсан хохирлыг зөвхөн эцэг эх хариуцан арилгах ёстой. Цаашлаад, эцэг эх хүүхэдтэй хамтран амьдардаг эсэх, гэрлэлтийг хүчингүйд тооцсон эсэх, эцэг эх гэрлэлтээ бүртгүүлсэн эсхүл цуцлуулсан эсэхээс үл хамааран эцэг, эхийн дээрх үүрэг хэрэгжсээр байна.

Ийнхүү судлаачид эцэг эхийн хяналт тавих үүргийг өргөн хүрээнд тодорхойлохын зэрэгцээ тус үүргээ зохих ёсоор биелүүлсэн үндэслэлээр хариуцлагаас чөлөөлөгдөх боломж ихээхэн хомс, бараг байхгүй шахам болохыг цохон тэмдэглэсэн байна<sup>22</sup>.

### **С) Эцэг, эхийн хариуцлага ба сургууль болон бусад этгээдийн хариуцлага хоорондын харилцан хамаарал**

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хууль эцэг, эхийн гэм хорын хариуцлагын зохицуулалтыг “гэм буруугийн зарчим”-д үндэслэх болсноороо өмнөх хуулиудаас ихээхэн ялгаатай боловч, эцэг эхийн гэм бурууг огт асуудал болгон авч үздэггүй байсан хуучин хуулийн зарим заалт ч мөн 503 дугаар зүйлд уламжлагдан ирсэн байна.

Тухайлбал, Иргэний хуулийн 503.2 дахь заалтыг харвал, 1994 оны Иргэний хуулийн 381.2 дахь заалт буюу хүүхэд сургууль болон бусад этгээдийн хяналтад байхдаа бусдад учруулсан гэм хорыг тухайн байгууллага хариуцан арилгана гэх зохицуулалт хэвээр байгаа юм. Улмаар, эцэг, эхийн хариуцлага ба сургууль болон бусад этгээдийн хариуцлага хоорондын холбоо хамаарлыг 503 дугаар зүйлийн суурь үндэслэл болох “гэм буруугийн зарчим”-ын үүднээс онолын зөрчилдөөнгүйгээр тайлбарлах, заалт бүрийн уялдаа холбоог сайжруулах шаардлага зүй ёсоор тулгарч байгаа юм.

Сургууль, хүмүүжлийн байгууллага нь хүүхдийн хүмүүжил, төлөвшилд анхаарал тавьж, тодорхой хугацаанд хүүхдийг хяналтдаа байлгаж, харж хандах үйл ажиллагаа явуулдаг учраас<sup>23</sup> гэм хорын хариуцлага хүлээх субъектын нэг маргаангүй мөн. Гагцхүү гэм буруугийн зарчмын үүднээс авч үзвэл, хүүхдийн үйлдлийн улмаас хохирол учрахад хэний санаатай болон болгоомжгүй үйлдэл буруутай байсан зөвхөн тэр этгээд хариуцлага

<sup>19</sup> Гэр бүлийн тухай хууль (1999) 26 дугаар зүйл: Хүүхдээ хүмүүжүүлэх эрх, үүрэг 26.2. Эцэг, эх дараах үүрэг хүлээнэ: 26.2.1 хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх ; 26.2.2. хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх; 26.2.3. хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох; 26.2.4. хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах.

<sup>20</sup> Ж.Оюунтунгалаг (6) 189 тал.

<sup>21</sup> Т.Мөнхжаргал, *Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй*, УБ, Сутай дээд сургууль, 2005, 44 дэх тал.

<sup>22</sup> Т.Мөнхжаргал (21) 44-45 дахь тал; Ж.Оюунтунгалаг (6) 186 дахь тал.

<sup>23</sup> Т.Мөнхжаргал (21) 49 дэх тал.

хүлээх ба эцэг эх, сургуулийн аль алиных нь гэм буруу зэрэг тогтоогдсон тохиолдолд, хамтран хариуцлага хүлээх ч бүрэн боломжтой юм.

Гэсэн хэдий ч, 503.2 дахь заалтыг өмнөх хуулиудын нэгэн адилаар тайлбарлах хандлага өнөөдрийг хүртэл ажиглагдсаар байна. Тухайлбал, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбарт, “7-14 хүртэлх насны буюу иргэний эрх зүйн зарим чадамжтай иргэний бусдад учруулсан гэм хорыг хариуцах этгээдийг тодорхойлж, тогтооход гэм хор учруулсан орон зай, цаг хугацаа буюу хэний асрамж, хамгаалалт, хяналтад байсныг харгалзан” үзнэ<sup>24</sup>, “хүүхэд биеийн тамирын хичээл дээр хөл бөмбөг тоглож байгаад цонх хагалахад хууль ёсны төлөөлөгч хохирол нөхөн төлөх үүрэг хүлээхгүй”, харин “...хүүхэд хичээлээсээ тарж яваад айлын цонх хагалсан бол гэм хорыг хууль ёсны төлөөлөгч арилгана”<sup>25</sup> гэж дурджээ. Эдгээр тайлбар нь 1963 оны Иргэний хуулийн 321 дүгээр зүйл, 1994 оны Иргэний хуулийн 381.2 дахь заалтын тайлбартай төстэй байх бөгөөд хариуцлага хүлээх субъектийн гэм бурууг харгалзан үзэх гэхээс илүүтэйгээр хохирол учирсан байршил, цаг хугацаанд үндэслэн хариуцлагыг хэд хэдэн субъектэд хуваарилах зарчим үйлчилж байгаа юм.

Нөгөөтэйгүүр, дээрх тайлбарыг эцэг, эхийн хяналт тавих үүргийн агуулга талаас нь дараах байдлаар тайлбарлаж болох юм. Тухайлбал, эцэг эхийн хараа, хяналт тавих үүргийн агуулгыг “хүүхдээ өөрийн шууд хяналтан дор байлгаж, биечлэн харж хандах үүрэг” гэж тодорхойлжээ. Энэ тохиолдолд, хүүхдээ сургууль, цэцэрлэг зэрэг төлөөлөн хяналт тавих эрх бүхий субъектын хяналтад шилжүүлэн өгснөөр эцэг, эх дээрх үүргээ биелүүлсэнд тооцогдоно. Улмаар Иргэний хуулийн 503.2 дахь хэсэгт заасан нөхцөл байдал нь 503.4 дэх хэсэгт заасан “эцэг эх хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлсэн” гэдэгтэй дүйцэж байгаа юм<sup>26</sup> (ИХ 503.2 = ИХ 503.4).

Хэдийгээр, хэт бага насны хүүхдийн тухайд (жишээлбэл 3 настай) авч үзвэл, эцэг эхийн 24/7 биечилсэн хараа хяналт зайлшгүй шаардлагатай ба эцэг, эх хүүхдээ биечлэн харах боломжгүй тохиолдолд бусад этгээдэд тус хяналтыг шилжүүлэх шаардлага зүй ёсоор тулгардаг. Хэт бага насны хүүхэд нь эцэг, эхийн захиасыг ойлгож, дагаж биелүүлэх чадвар хараахан бүрэлдээгүй байдагтай холбогдуулан, эцэг эхийг хүүхдээ хүмүүжүүлэх үүргээ биелүүлээгүй гэж буруутгахаас илүүтэйгээр, шууд хяналт тавих боломжтой байсан этгээдийн анхаарал болгоомжгүй үйлдлийг магадлах нь зохистой.

Энэ утгаараа дээрх агуулга бүхий хараа хяналтын үүрэг нь эрх зүйн чадамжгүй буюу 7 хүртэлх насны хүүхдэд зохистой мэт боловч, 7-14 насны хүүхэд буюу эцэг эхийн биечилсэн хараа хяналтгүйгээр бие даан сургууль болон бусад этгээдийн үйл ажиллагаанд оролцох боломжтой хүүхдийн насаар 503.2 дахь заалтыг хязгаарласан нь ихээхэн хачирхалтай юм. Бодит байдал дээр 7-14 насны хүүхдийг байнга дэргэдээ байлгаж, үйлдэл бүрийг нь харж хянах боломж, бололцоо ихээхэн хомс байхаас гадна, ийнхүү байлгахыг шаардах нь зөвхөн эцэг эх гэлтгүй, хүүхдийн бие даасан байдал, үйл хөдлөл хийх эрх чөлөөнд ч сөргөөр нөлөөлж болзошгүй.

Ийнхүү манай улсын Иргэний хуулийн 503 дугаар зүйл дэх эцэг, эхийн гэм хорын хариуцлагын тухай зохицуулалт нь эцэг, эхийн гэм бурууг хариуцлага хүлээх үндэслэл болгон авч үзсэнээрээ зохицуулалтын зорилгоо тэлж, эцэг эхийн үйл хөдлөл хийх эрх чөлөө хуулиар хамгаалагдах болсон. Энэхүү зохицуулалтын зорилго нь манай улсын судлаачдын дунд хэдийнээ танигдаж, эцэг эхийн хяналт тавих үүргийн агуулга, хүрээг тодорхойлох тухай асуудал хөндөгдсөөр байна. Судлаачдын зүгээс тус үүргийн агуулгыг эцэг, эхийн хүүхдээ хүмүүжүүлэх үүрэгтэй холбон тайлбарлах замаар өргөжүүлэх, улмаар эцэг, эхийн хариуцлагаас чөлөөлөгдөх боломжийг хязгаарлах хандлагатай байгаа юм.

<sup>24</sup> Монгол Улсын Дээд Шүүх, *Монгол Улсын Иргэний Хуулийн Тайлбар* (Гэрээний бус үүрэг IV), УБ, Тоонот принт ХХК, 2016, 73 дахь тал.

<sup>25</sup> Ё. Канот нар, *Монгол Улсын Иргэний Хуулийн Тайлбар: I, II, III хэсэг*, УБ, МИМ ХХК Хэвлэлийн газар, 2010, 32 дахь тал.

<sup>26</sup> Ж.Оюунтунгалаг (6) 189 дэх тал.

Нөгөөтэйгүүр, хэдийгээр манай улс 2002 оны Иргэний хуулийн шинэчилсэн найруулгаар эцэг, эхийн гэм хорын хариуцлагын асуудлыг “гэм буруугийн зарчим”-ын үүднээс авч үзэх болсон боловч, гэм бурууг огт асуудал болгон авч үздэггүй байсан өмнөх хуулийн зарим зүйл заалт ч мөн уламжлагдан иржээ. Улмаар эцэг, эхийн гэм хорын хариуцлагын тухай 503 дугаар зүйл нь “гэм буруугийн зарчим” ба “гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчим”-ын хослолоос бүрдэх ба зарчим хоорондын зөрчилдөөн бүхий нөхцөл байдалд байгаа юм. ИХ-ийн 503.4 дэх заалтыг 503.2 дахь заалттай зөрчилдөөнгүйгээр тайлбарлахыг оролдвол, эцэг эхэд оноож буй хяналтын үүргийн агуулгыг “хүүхэддээ биечлэн хяналт тавьж, дэргэдээ байлгах үүрэг” гэж тодорхойлох шаардлагатай болох боловч, энэхүү тайлбар нь эцэг эх болоод хүүхдийн чөлөөт байдалд томоохон хязгаарлалтыг бий болгох эрсдэлтэй юм.

Дараагийн хэсэгтээ Монгол Улсын шүүхийн практик дахь эцэг, эхийн гэм хорын хариуцлагын асуудлыг авч үзэх ба гэм буруугийн зарчмын хэрэгжилтэнд голчлон анхаарах болно.

### III. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА<sup>27</sup>

Энэхүү хэсэгт Монгол Улсын шүүхийн практик дахь эцэг эхийн 503 дугаар зүйлийн хууль хэрэглээ, тэр дундаа гэм буруугийн зарчмын хэрэгжилтэнд голчлон анхаарч, эцэг эхийн гэм хорын хариуцлага ба тэдний гэм буруутай үйлдэл хоорондын холбоо хамаарлыг тодруулахыг зорилоо. 14 хүртэлх насны хүүхдийн бусдад учруулсан хохирлын улмаас эцэг эхийн 503.1-д заасан гэм хорын хариуцлага хөндөгдсөн шүүхийн шийдвэр, 14-18 насны хүүхдийн хүүхдийн бусдад учруулсан хохирлын улмаас эцэг эхийн 503.5-д заасан гэм хорын хариуцлага хөндөгдсөн шүүхийн шийдвэр гэсэн дарааллын дагуу авч үзье.

#### 3.1. 14 хүртэлх насны хүүхэд бусдад хохирол учруулсан тохиолдлууд

Шүүхийн шийдвэрийн санд 14 хүртэлх насны хүүхдийн бусдад учруулсан хохирлын улмаас эцэг эхийн 503.1-д заасан хариуцлагын асуудал хөндөгдсөн нийт 19 шүүхийн шийдвэр байгаагаас, эцэг эхийн гэм буруу буюу хяналт тавих үүргийн зөрчил маргааны зүйл болохгүй байх хандлагатай байна. Тухайлбал, хариуцагч эцэг, эхийн гэм буруугийн асуудлыг хянан магадласан эсэхийг шалгуур болгон ангилж авч үзвэл, зөвхөн 3 шүүхийн шийдвэр эцэг, эхийн гэм бурууг хариуцлага хүлээх үндэслэл болгон авч үзсэн байх бол 16 шүүхийн шийдвэрт тус асуудал огт хөндөгдөөгүй байна<sup>28</sup>.

#### А) Эцэг, эхийн гэм бурууг гэм хорын хариуцлага хүлээх үндэслэл болгон шийдвэрлэсэн шийдвэрүүд

Дараах 3 шүүхийн шийдвэрт хариуцагч эцэг, эхийн хяналт тавих үүргийн зөрчлийн асуудал хөндөгдсөн байх ба эцэг, эхийн гэм буруу нь 503.1-т заасан гэм хорын хариуцлага хүлээх шалтгаант үндэслэл болсон байна.

**Шүүхийн шийдвэр №1:** Нэхэмжлэгч шөнийн 3 цагийн орчим машинаасаа буухдаа автомашин оношилгооны төхөөрөмжөө машин дээрээ тавиад мартаж, гэр лүүгээ орж амарсан ба тус өдрийнхөө үдээс өмнө 11 цагийн орчим төхөөрөмжөө авахаар очтол

<sup>27</sup> Энэхүү судалгааны ажилд ашиглагдсан шүүхийн шийдвэрүүд нь 2015 оноос 2021 он хүртэлх анхан, давах болон хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүдийг хамрах ба “Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан” <https://shuukh.mn/> сайтыг ашигласан. Тус цахим санд 2021 он хүртэл түлхүүр үгийн хайлтын тусламжтайгаар тодорхой хуулийн зүйл, заалт ашиглагдсан шүүхийн шийдвэрийг хайж олоход амар, хялбар байсан ба дээрх шүүхийн шийдвэрүүд нь “503 дугаар зүйлийн 503.1”, “503 дугаар зүйлийн 503.2”, “503 дугаар зүйлийн 503.5”, “хяналт тавих үүрэг” зэрэг түлхүүр үгийн хайлтын тусламжтайгаар олдсон шийдвэрүүд болно. Харин “шүүхийн шийдвэр №5” нь 2007 оны шийдвэр байх ба Монгол Улсын Дээд Шүүх, *Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхэтгэл (Иргэний хэрэг) Цуврал 7, 2008-г* ашигласан болно.

<sup>28</sup> Нотлох үүргийн хуваарилалтын үүднээс авч үзвэл, хариуцагч эцэг, эхийн гэм буруу хууль зүйн таамаглалын түвшинд тогтоогдох ба хариуцагч талаас өөрийгөө гэм буруугүй болохыг нотолсон тохиолдолд тус таамаглал няцаагдах юм. Улмаар хариуцагч талын үүрэг, оролцоо ихээхэн чухал байх боловч, гэм буруугийн талаар огт маргалгүйгээр, хохирлын хэмжээн дээр маргах нь нийтлэг байдлаар ажиглагдав. Улмаар энэхүү хариуцагчийн идэвхгүй байдал нь шүүхийн практикт эцэг, эхийн гэм буруугийн асуудал огт хөндөгдөхгүй байх шалтгаант хүчин зүйлийн нэг мөн болохыг дурдах нь зүйтэй болов уу.

тус төхөөрөмж нь алга болсон байжээ. Улмаар машины зогсоолын камерын бичлэгийг шүүж үзтэл хариуцагчийн 12 настай охин А тус төхөөрөмжийг аван, цааш явж буй дүрс бичигдсэн байна. Улмаар нэхэмжлэгч Иргэний хуулийн 503.1-т заасны дагуу өөрт учирсан эд хөрөнгийн хохирлоо хариуцагчаас гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Хяналтын шатны шүүхээс<sup>29</sup> хариуцагч хяналт тавих үүргээ зөрчсөн гэм буруутай болохыг тогтоохын зэрэгцээ, нэхэмжлэгчийн хэт хайхрамжгүй үйлдэл гэм хор учрахад нөлөөлсөн гэж үзэж хариуцагчийн хариуцлагыг 50 хувиар бууруулж шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр<sup>30</sup>-ийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна. Хариуцагчийн гэм буруугийн талаар шүүх “хуульд заасан хамгаалалтыг хариуцагч ... нь хэрхэн хэрэгжүүлсэн нь тодорхойгүй, өөрөөр хэлбэл, охин ... бусдад гэм хор учруулсан нь эцэг, эхийн буруугаас болоогүй гэдгийг нотлох баримт хэрэгт авагдаагүй, эцэг, эхийн хувьд хүүхэд нь бусдын өмчлөлийн эд зүйлийг гэртээ авчирч байхад эзэн холбогдогчийг олж тогтоох, зохих газарт нь мэдэгдэх, эсвэл авсан газарт нь буцаан тавиулах зэрэг арга хэмжээ аваагүй буруутай гэж үзэх үндэслэлтэй” гэжээ.

**Шүүхийн шийдвэр №2:** Хариуцагчийн хүү 11 настай А нэхэмжлэгчийн хүү Б-тэй хамт гудамжинд гар аргаар хийсэн нум сумаар тоглож байгаад А нь Б-н зүүн нүдрүү харвасны улмаас Б зүүн нүдэндээ хүндэвтэр хэмжээний гэмтэл авсан. Улмаар нэхэмжлэгч эмчилгээний зардал болон бусад хохирлыг хариуцагчаас гаргуулахаар Иргэний хуулийн 503.1 дэх хэсэгт заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Анхан шатны шүүх<sup>31</sup> нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг нэхэмжлэгчийн талд гаргуулахаар шийдвэрлэсэн ба хариуцагчийн хяналт тавих үүргийн зөрчлийн талаар дараах байдлаар шийдвэртээ тусгажээ. Тухайлбал, “хариуцагч ... нь хүүхдээ хаана, хэнтэй, ямар тоглоомоор хэрхэн тоглож байгаа талаар хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэм буруутайн улмаас түүний хүү А нь нэхэмжлэгчийн хүү Б-н зүүн нүдийг тоглоомон нум сумаар харваж гэмтээсэн, ингэснээр эрүүл мэндийн хохирол учирсан шалтгаант холбоотой байх бөгөөд тогтсон ажил эрхэлж, орлого олдоггүй нь хуульд заасан хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй юм.” гэж дурджээ.

Шүүхийн шийдвэр №1, 2-оос авч үзвэл, хохирол үүссэн учир шалтгааныг дан ганц хүүхдийн үйлдэл гэхээсээ илүүтэйгээр хяналт тавих үүргээ зөрчсөн гэх эцэг эхийн гэм буруутай үйлдэлтэй холбон тайлбарлах оролдлого тодорхой хэмжээнд хийгдэж байна гэж дүгнэж болохоор байгаа юм. Гэвч эцэг, эхийн гэм буруугийн талаарх шүүхийн дүгнэлт ганц, ганц өгүүлбэрээр хязгаарлагдаж буй тул, хараа хяналт тавих үүргийн агуулга, хүрээг шүүх хэрхэн тодорхойлж буй талаар таамаглал дэвшүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байгаа юм.

Дараагийн танилцуулах шүүхийн шийдвэр нь 503.4-т заасны дагуу эцэг, эх хараа хяналт тавих үүргээ зөрчөөгүй буюу гэм буруугүй гэсэн үндэслэлээр эцэг, эхийг хариуцлагаас чөлөөлж шийдвэрлэсэн цор ганц шийдвэр бөгөөд хэргийн агуулгыг танилцуулвал:

**Шүүхийн шийдвэр №3<sup>32</sup>:** Хариуцагч С нь өөрийн ой гаруйтай хүүхэд болох В-г 12 настай А-р харуулахаар түүний ээжээс зөвшөөрөл аван, А-г гэртээ авчирсан ба хариуцагч С-г ажилдаа явсан хойгуур А нь В-н хамт тэдний гэрт үлджээ. Хариуцагч С-н эзгүйд А гал алдсаны улмаас тэдний гэрт гал түймэр гарч, хажуу айл болох нэхэмжлэгчийн орон сууц мөн галд автсан байна. Улмаар нэхэмжлэгч хариуцагч С болон А-н аав болох хариуцагч Д нараас өөрт учирсан эд хөрөнгийн хохирлоо гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Анхан шатны шүүх хариуцагч Д-н гэм хорын хариуцлагын тухайд, хэдийгээр Иргэний хуулийн 503.1-т заасны дагуу А-н бусдад учруулсан хохирлыг түүний эцэг, эх нь хариуцан арилгах үүрэгтэй боловч “тухайн үед хүүхдэдээ хяналт тавих боломжгүй байсан

<sup>29</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн Иргэний хэргийн танхим, Дугаар 001/ХТ2019/00527, 2019.04.11.

<sup>30</sup> Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дугаар 216/МА2018/00024, 2018.12.04.

<sup>31</sup> Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 0141, 2016.04.21.

<sup>32</sup> Говьсүмбэр аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 85, 2007.05.22, Монгол Улсын Дээд Шүүх, *Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхэтгэл (Иргэний хэрэг) Цуврал 7*, 2008, 188-191 дэх тал.



нь “З” ХХК-ны [хариуцагч Д-ын ажил олгогч]... тоот албан бичиг болон хариуцагч С-н “А-г ээжээс нь зөвшөөрөл аваад хүүхдээ харуулахаар гэр лүүгээ авч явсан” гэсэн тайлбар зэргээр нотлогдож байх тул хариуцагч Д-г 503.4 дэх хэсэгт зааснаар хариуцлагаас чөлөөлөх үндэслэлтэй байна” хэмээн түүнд холбогдох нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй орхисон байна. Харин хариуцагч С-н гэм хорын хариуцлагын тухайд, “бага насны хүүхдийг өөрийн шууд хяналтдаа байлгаж байсан” гэж үзэж, ИХ-ийн 503.2 дэх сургууль болон бусад этгээдийн хариуцлагын заалтыг төсөөтэй хэрэглэх байдлаар нэхэмжлэгчид учирсан хохирлыг хариуцагч С-с гаргуулан шийдвэрлэжээ.

Шүүхийн шийдвэр №3-т эцэг эх хүүхдэд хяналт тавих боломжгүй байсан буюу 503.4 дэх хэсэгт заасны дагуу хараа хяналт тавих үүргээ зөрчөөгүй гэсэн үндэслэлээр хариуцлагаас чөлөөлөгдсөн байна. Ийнхүү эцэг эх гэм буруугүй байсан гэсэн дүгнэлтэнд хүрэхэд хариуцагч Д-н охин А нь бусад этгээдийн шууд хяналтан дор байсан учраас биечлэн хяналт тавих боломжгүй байсан гэх үйл баримт шууд нөлөөлсөн байна. Улмаар шүүхээс эцэг, эхийн хараа хяналт тавих үүргийн хүрээг “биечлэн хараа, хяналт тавих үүрэг” гэж тайлбарласан байх ба цаашлаад 503.4 дэх хэсэгт заасан “хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлсэн” гэх нөхцөл байдлыг 503.2 дахь хэсэгт заасан хүүхэд төлөөлөн хяналт тавих эрх бүхий этгээдийн хяналтан дор байсан нөхцөл байдалтай адилтган авч үзсэн байна (ИХ 503.2 = ИХ 503.4).

#### **В) Эцэг, эхийн гэм буруу маргааны зүйл болоогүй шүүхийн шийдвэрүүд**

Дийлэнх буюу 16 шүүхийн шийдвэрт эцэг, эхийн хараа хяналт тавих үүргийн зөрчлийн асуудал огт хөндөгдөөгүй байна. Дээрх 16 шийдвэрээс 14 шүүхийн шийдвэр<sup>33</sup> нь нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн ба ингэхдээ хохирол учирсан нь тогтоогдсон, хариуцагч нь хүүхдийн хууль ёсны төлөөлөгч буюу эцэг эх мөн, хүүхэд гэм хор учруулах үед сургууль болон бусад этгээдийн хяналтад байгаагүй<sup>34</sup> гэсэн үйл баримтад голчлон анхаарсан байна. Харин 2 шүүхийн шийдвэрт эцэг эхийн гэм хорын хариуцлага үгүйсгэгдсэн байх ба аль аль нь сургуулийн хяналтан дор байхдаа хүүхэд бусдад хохирол учруулсан тохиолдлууд байгаа юм.

**Шүүхийн шийдвэр №4:** Хариуцагчийн хүү А нь ЕБС-ийн 7 дугаар ангийн сурагч ба нэг ангид хамт сурдаг нэхэмжлэгчийн хүү Б рүү сургууль дээрээ хичээлийн цагаар бал шидсэний улмаас Б-н зүүн нүдэн тус газарт цохиж, эрүүл мэндэд нь хүндэвтэр хэмжээний хохирол учруулсан. Улмаар нэхэмжлэгч хүү Б-н эрүүл мэндэд учирсан хохирлыг хариуцагчаас гаргуулахаар Иргэний хуулийн 503.1 дэх хэсэгт заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Анхан шатны шүүх<sup>35</sup> нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй орхисон ба тухайн үндэслэлийг дараах байдлаар тайлбарлажээ. Тухайлбал, Иргэний хуулийн 503.2-т “7-14 хүртэлх насны иргэн сургууль, хүүхэд хүмүүжүүлэх болон эрүүл мэндийн байгууллагын шууд хяналтын дор байхдаа бусдад учруулсан гэм хорыг эдгээр хуулийн этгээд хариуцан арилгана” гэж заасан тул нэхэмжлэгч нь гэм хорын хохирлыг А-н эцэг, эхээс шаардах

<sup>33</sup> 1) Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 442, 2015.7.30; 2) Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 88, 2015.12.23; 3) Булган, Орхон, Хөвсгөл аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дугаар 40, 2016.3.15; 4) Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 183/ШШ2017/00262, 2017.1.25; 5) Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 303, 2017.1.31; 6) Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх, Дугаар 137, 2017.3.22; 7) Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 1062, 2018.3.27; 8) Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дугаар 2106, 2018.10.03; 9) Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 103/ШШ2020/00131, 2020.3.5; 10) Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 101/ШШ2020/00813, 2020.3.5; 11) Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 1317, 2020.4.16; 12) Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 182/ШШ2020/01001, 2020.5.6; 13) Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 3043, 2020.9.3; 14) Монгол Улсын Дээд Шүүхийн Иргэний Хэргийн Танхим, Дугаар 001/ХТ2021/01546, 2021.12.16;

<sup>34</sup> Ишлэл (33)-аас шүүхийн шийдвэр 10),11),13)-т гэм хор учрах үед хүүхэд сургууль болон бусад этгээд шууд хяналтан дор байгаагүй, эсхүл талууд энэ талаар маргаагүй тухай дурдсан байна.

<sup>35</sup> Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 146/ШШ 2019/00184, 2019.06.18.



эрхгүй. “7-14 хүртэлх насны буюу иргэний эрх зүйн зарим чадамжтай иргэний бусдад учруулсан гэм хорыг хариуцах этгээдийг тогтоохдоо гэм хор учруулсан орон зай, цаг хугацаа буюу хэний асрамж, хамгаалалт, хяналтад байсныг харгалзан үзэх ёстой юм” гэжээ. Улмаар, дээрх шүүхийн шийдвэр гарсны дараахан нэхэмжлэгч ЕБС-иас хохирлоо гаргуулахаар тус шүүхэд дахин нэхэмжлэл гаргасан ба шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна<sup>36</sup>.

**Шүүхийн шийдвэр №5:** Хариуцагчийн хүү А ба нэхэмжлэгчийн хүү Б нар нь ЕБС-ийн 8а ангийн сурагчид ба сургуулийн спорт зааланд бэлтгэл хийж байх үед А нь Б-н хөл рүү өшиглөж, гэмтэл учруулжээ. Улмаар нэхэмжлэгч нь хүү Б-н эрүүл мэндэд учирсан хохирлыг хариуцагчаас гаргуулахаар ИХ-ийн 503.1-д заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Хариуцагчийн зүгээс тухайн үйл явдал нь сургууль дээр буюу хичээлийн цагаар болсон учраас сургууль ч мөн хариуцлага хүлээх ёстой хэмээн үзэж, сургуулийг хариуцагчаар татах тухай хүсэлт гаргасан боловч, анхан шатны шүүхээс<sup>37</sup> хичээлийн хуваарьт заасны дагуу тухайн осол гарах үед 8а анги нь хуваарьт хичээлгүй байсан болох нь тогтоогдож байна гэсэн үндэслэлээр тус хүсэлтийг хүлээн авахаас татгалзжээ.

Улмаар хариуцагч анхан шатны шүүхийн шийдвэр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэж үзэж давж заалдсан ба давж заалдах шатны шүүхээс<sup>38</sup>, сургуулийн 1 жилийн ойн тайлан тоглолтонд зориулж 8а, 8б ангиудад нэгдсэн гимнастикийн бэлтгэл хийх нэмэлт цаг гаргаж өгсөн тухай нотлох баримт хэрэгт авагдсан байсныг анхан шатны шүүх анхаарч үзэлгүйгээр хариуцагчийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан нь ИХШХТХ-ийг үндэслэлгүйгээр зөрчсөн байна гэж үзэж, дээрх шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүх рүү буцаасан байна.

Шүүхийн шийдвэр №4-с үзвэл, эцэг эхийн хараа хяналт тавих үүргийн зөрчлийг асуудал болгон авч үзэлгүйгээр, ИХ-ийн 503.2 дахь хэсэгт заасны дагуу хүүхэд сургууль болон бусад этгээдийн шууд хяналтан дор байсан гэх үйл баримтад тулгуурлан гэм хорын хариуцлагыг сургуульд оноож, оронд нь эцэг эхийг хариуцлагаас чөлөөлж шийдвэрлэжээ. Энэхүү эцэг эхэд гэм хорын хариуцлага оногдуулах эсэх тухай асуудлыг шийдвэрлэхэд гэм хор учруулсан байршил, цаг хугацааг чухалчлан авч үзэх хандлагыг шүүхийн шийдвэр №5-с мөн харж болно. Хэдийгээр хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүх рүү буцаасны дараа тухайн хэрэг эцсийн байдлаар хэрхэн шийдвэрлэгдсэн болох нь тодорхойгүй байх боловч, үйл явдал сургалтын буюу хичээлийн цагаар болсон эсэх нь гэм хорын хариуцлага хүлээх этгээдийг тодорхойлоход чухал ач холбогдолтойд тооцогдож байгаа юм.

### 3.2. 14-18 насны хүүхэд бусдад хохирол учруулсан тохиолдлууд

14-18 насны хүүхдийн бусдад учруулсан хохирлын улмаас эцэг, эхийн 503.5-д заасан хариуцлага хөндөгдсөн шүүхийн шийдвэр нийт 8 байгаагаас<sup>39</sup>, бүх шүүхийн шийдвэрт хариуцагч эцэг, эхийн гэм буруугийн асуудал огт хөндөгдөөгүй байх ба насанд хүрээгүй хүүхэд бусдад хохирол учруулсан нь үнэн, хариуцагч эцэг эх нь хүүхдийн хууль ёсны төлөөлөгч мөн гэсэн үйл баримтанд тулгуурлан эцэг, эхээр холбогдох гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэжээ. Харин нэхэмжлэгч талын гэм бурууг харгалзаж үзэх үед (ИХ 514.1) хохирогч хүүхэд ба түүний эцэг, эхийн гэм буруугийн талаар хэсэгхэн дурдсан шүүхийн шийдвэр 1 байсан тул доорх хэсэгт дэлгэрүүлэн авч үзье.

<sup>36</sup> Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 146/ШШ 2019/00354, 2019.12.16.

<sup>37</sup> Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 143/ШШ2018/00083, 2018.03.02.

<sup>38</sup> Өмнөговь аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дугаар 13, 2018.04.18.

<sup>39</sup> Сэлэнгэ аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 39, 2016.1.7; 2) Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 5483, 2016.8.19; 3) Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дугаар 258, 2017.1.23; 4) Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 2347, 2018.9.20; 5) Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 277, 2019.6.24; 6) Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 487, 2019.11.21; 7) Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 102/ ШШ2020/ 03121, 2020.10.20; 8) Шүүхийн шийдвэр №6-г харна уу.

**Шүүхийн шийдвэр №6:** Чингэлтэй дүүргийн 24-р сургуулийн баруун талд байрлах хөл бөмбөгийн талбайд үдээс хойш 12:30 цагаас 12:40 минутын үед нэхэмжлэгчийн хүү 11 настай Б, хариуцагчийн хүү 15 настай А нар хөл бөмбөг тоглож байх үед харилцан мөргөлдсөний улмаас Б баруун хөлдөө хүндэвтэр хэмжээний гэмтэл авсан. Нотлох баримтаар авагдсан камерын дүрс бичлэгт, А бөмбөг өшиглөсөөр Б-н хамгаалж буй хаалганы наана гулгаж унахдаа уг бөмбөгийг хаахаар түүний өмнөөс гүйж ирсэн Б-н хөл рүү нь жийснээр Б түүний дээрээс унаж, улмаар хөл нь хугарсан гэх үйл баримт бичигдсэн байна. Улмаар нэхэмжлэгч өөрийн хүү Б-н эрүүл мэндэд учирсан хохирлыг ИХ-ийн 503.5 дахь хэсэгт заасны дагуу хариуцагчаас гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Анхан шатны шүүхээс<sup>40</sup>, Б-н эрүүл мэнд хохироход А-н болгоомжгүй үйлдэл шалтгаант холбоотой боловч, гэм хор учрахад хохирогчийн өөрийн болгоомжгүй үйлдэл мөн нөлөөлсөн гэж үзэж, хариуцагчийн хариуцах гэм хорын хэмжээг 50 хувиар багасгаж шийдвэрлэсэн байна. Түүнчлэн давж заалдах шатны<sup>41</sup> болон хяналтын шатны<sup>42</sup> шүүхүүд дээрх шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн ба 3 шатны шүүх нэхэмжлэгч талын гэм буруугийн талаар “А нь 12:15 цагаас хичээл тарсны дараа, Б нь 14.00 цагт эхлэх хичээлээс өмнө, эцэг эхийн хараа хяналтад байвал зохих сургалтын бус цагаар, сургуулийн ойролцоо байрлах тоглоомын талбай дээр 12:30 цагаас 12:40 минутын хооронд тоглож, бөмбөгтэй хүний өөдөөс гүйж, мөргөлдөж унасан Б-н болгоомжгүй үйлдэл, хичээлийн цагаас эрт, сургууль орчмоор эцэг эхийн хараа хяналтгүй байсан нь гэм хор учрахад нөлөөлсөн гэж үзсэнийг буруутгах үндэслэлгүй” гэж санал нэгтгэйгээр дүгнэжээ. Хэдийгээр хариуцагч дээд шатны шүүхүүдэд гомдол гаргаж, хүү А-г санаатай эсхүл болгоомжгүй гэм буруутай үйлдлээр бусдад гэм хор учруулаагүй, цэвэр тохиолдлын шинжтэй мөргөлдөөний улмаас осол гарсан гэж маргасан боловч, давах болох хяналтын шатны шүүхүүдээс А-г гэм буруугүй гэдгээ нотлох үүргээ биелүүлээгүй гэж дүгнэж, гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй орхисон байна.

Шүүхийн шийдвэр №6 нь хариуцагчийн гэм хорын хариуцлагыг 50 хувиар бууруулах үед, нэхэмжлэгч талын гэм буруутай үйлдлийг харгалзаж үзсэн байх ба ингэхдээ эцэг, эхийн хяналтад байвал зохих сургалтын бус цагаар сургуулийн ойролцоо хөл бөмбөг тоглосон гэх Б-н үйлдэл, мөн түүнчлэн хичээлийн цаг эхлэхээс өмнө Б-г хараа хяналтгүйгээр хичээлд нь явуулсан гэх түүний эцэг эхийн үйлдэл, эс үйлдэхүй нь нэхэмжлэгч талыг буруутгах үндэслэл болсон байна. Улмаар энэхүү шүүхийн шийдвэр нь эцэг, эхчүүдэд сургалтын цагаас бусад үед хүүхдээ өөрийн шууд хяналтаа буюу дэргэдээ байлгахыг үүрэг болгосон байх ба хөл бөмбөг тоглох явцад үүсэж болох ослоос урьдчилан сэргийлэхийн тулд, эцэг эх нэг бол хүүхдээ гэрээс нь гаргахгүй байх, үгүй бол хөл бөмбөг тоглох үед дэргэд нь байж, харж хянах ёстой байсан зэргээр эцэг, эхийн хяналт тавих үүргийн хүрээг маш явцуу хүрээнд тодорхойлсон байна.

18 хүртэлх насны хүүхдийн бусдад учруулсан хохирлын улмаас эцэг, эхийн 503.1, 503.5-т заасан гэм хорын хариуцлага хөндөгдөж буй шүүхийн шийдвэрүүдэд дүн шилжилгээ хийсний үр дүнд дараах дүгнэлтэд хүрлээ. Юун түүрүүнд, хүүхдийн насны онцлогоос үл хамааран дийлэнх тохиолдолд эцэг, эхийн гэм буруугийн асуудал маргааны зүйл болохгүй байх ба хүүхэд бусдад хохирол учруулсан нь тогтоогдмогц эцэг эхээр гэм хорын хохирлыг нөхөн төлүүлж шийдвэрлэх хандлагатай байна. Харин эцэг, эх хариуцлагаас чөлөөлөгдөх цор ганц үндэслэл нь ИХ-ийн 503.2 дахь хэсэгт заасанчлан хүүхэд сургууль болон бусад этгээдийн хяналтан дор байсан гэх нөхцөл байдал байх ба үүнээс шалтгаалан гэм хор учрах үеийн байршил, цаг хугацаа гэх хүчин зүйлс чухал ач холбогдолтойд тооцогдож байна (шийдвэр №4, 5).

<sup>40</sup> Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 102/ШШ2019/02777, 2019.10.18.

<sup>41</sup> Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дугаар 2093, 2019.12.13.

<sup>42</sup> Монгол Улсын Дээд Шүүх Иргэний Хэргийн Танхим, Дугаар 001/ХТ2021/00451, 2021.05.18.

Нөгөөтэйгүүр эцэг эхэд хариуцлага хүлээлгэж буй үндэслэлийг эцэг эхийн гэм буруу буюу хараа хяналт тавих үүргийн зөрчилтэй холбон тайлбарласан цөөхөн хэдэн шүүхийн шийдвэр байх боловч эцэг эхэд оноож буй үүргийн агуулга, зөрчлийг илрүүлж буй аргачлал тодорхой дурдагдаагүй байв (шийдвэр №1, 2). Үүнээс гадна, хараа хяналт тавих үүргийн агуулга, хүрээг “биечлэн хараа хяналт тавих үүрэг” гэж тодорхойлох хандлага ажиглагдсан (шийдвэр №3, 6) ба энэ нь эцсийн дүндээ эцэг эхэд хүүхэддээ 24/7 биечилсэн хяналт тавихыг үүрэг болгож буйтай агаар нэг юм.

#### IV. ДҮГНЭЛТ

Энэхүү өгүүллээр Иргэний хууль (2002) дахь 18 хүртэлх насны хүүхдийн бусдад учруулсан хохирлоос үүдэх эцэг, эхийн гэм хорын хариуцлагын тухай зохицуулалтыг авч үзлээ. Ингэхдээ, 1994 оны Иргэний хуулийн холбогдох зохицуулалттай харьцуулан авч үзэх байдлаар тус зохицуулалтын онолын үндэслэл, суурь зарчмын асуудлыг тодруулсны дараагаар, шүүхийн практик дахь маргааныг хянан шийдвэрлэж буй ерөнхий төлөв, хууль хэрэглээний асуудлыг задлан авч үзсэний үндсэн дээр тулгамдаж буй асуудлыг дэвшүүлэхийг зорилоо.

Манай улс өмнөх хуульдаа эцэг, эхийн гэм хорын хариуцлагын зохицуулалтын зорилгыг авч үзэхдээ насанд хүрээгүй хүүхдийг хариуцлагаас чөлөөлөх, хохирогчийн хохирлоо нөхөн барагдуулах механизмыг хөнгөвчлөх явдалд голчлон анхаарч ирсэн. Харин шинэ хуулиараа тус зохицуулалтыг гэм буруугийн зарчимд үндэслэх болсноор зохицуулалтаа зорилгоо тэлж, эцэг эхийн эрх ашиг сонирхлыг ч мөн анхааран авч үзэх болсон.

Энэхүү зохицуулалтын зорилго, зарчмын асуудал манай улсын судлаачдын дунд хэдийнээ танигдаж, судлагдсан байхаас гадна, шүүхийн практикт ч мөн хүүхдийн бусдад учруулсан хохирлын учир, шалтгааныг эцэг, эхийн хяналт тавих үүргийн зөрчилтэй холбон тайлбарлах практик тодорхой түвшинд тогтож байна.

Уг зохицуулалтын зорилгын нэг болох эцэг, эхийн үйл хөдлөл хийх эрх чөлөө бодитоор хэрэгжихэд хараа, хяналт тавих үүргийн агуулга болоод гэм буруу буюу үүргийн зөрчлийг тодорхойлох аргачлал тодорхой байх нь чухал ач холбогдолтой. Гэсэн хэдий ч судлаачдын зүгээс эцэг, эхийн хяналт тавих үүргийг хүүхдээ асран хамгаалж, хүмүүжүүлэх үүрэгтэй холбон тайлбарлах замаар хэт өргөжүүлэн хийсвэрлэх, нөгөөтэйгүүр шүүхийн практикаас авч үзвэл, тус үүргийн агуулгыг хүүхдээ дэргэдээ, шууд хяналтдаа байлгах явдал гэж хэт явцуу хүрээнд тайлбарлаж байгаагийн улмаас эцэг, эхийн үйл хөдлөл хийх эрх чөлөө бодитоор хэрэгжих суурь хараахан бэхжээгүй байна гэж дүгнэж болно.

Нөгөөтэйгүүр Иргэний хуулийн 503 дугаар зүйлд эцэг эхийн гэм бурууг огт асуудал болгон авч үздэггүй байсан хуучин хуулийн заалт уламжлагдан ирсэн байх ба гэм буруугийн зарчим ба гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчим хоорондын зөрчилдөөн бүхий нөхцөл байдлыг бий болгож байгаа юм. Манай улсын шүүхийн практикийг харж үзвэл, эцэг эхийн гэм буруугийн асуудал огт хөндөхгүй байх нь түгээмэл ба гэм хорыг арилгах этгээдийг тодорхойлоход хэн нэгний гэм буруутай үйлдлийг тогтоох гэхээс илүүтэйгээр гэм хор учирсан үеийн байршил, цаг хугацаа зэрэг хүчин зүйлсэд тулгуурлан хариуцлагыг нэг бол эцэг, эхэд нөгөө бол сургууль болон бусад этгээдэд хуваарилах хандлагатай байна. Товчхондоо, бодит байдал дээр “гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх” хуучин хуулийн зохицуулалт руу хэлбийх хандлагатай байна.

Үүнээс улбаалан, эцэг, эхийн гэм хорын хариуцлагын тухай зохицуулалтыг ямар зарчмын үүднээс авч үзэх нь зохистой эсэх талаарх суурь зарчмын асуудлыг дахин харж үзэх шаардлага зүй ёсоор тулгарч байгаа юм. Иргэний эрх зүйн суурь зарчимтай уялдуулан эцэг, эхийн гэм хорын хариуцлагын зохицуулалтыг ч мөн гэм буруугийн зарчмын үүднээс авч үзэх нь зүйтэй бөгөөд эцэг, эхийн чөлөөт байдлыг хангахад тус зарчим нь чухал ач

холбогдолтой гэж үзэх тохиолдолд хуулиар эцэг, эхэд оноож буй хяналтын үүргийн агуулга, гэм бурууг тогтоох аргачлалыг боловсронгуй болгох нэн шаардлагатай байгаа юм.

Харин гэм буруугийн зарчмаас илүүтэйгээр эцэг эхэд хатуу хариуцлага хүлээлгэх нь илүү зохистой гэж үзсэн тохиолдолд, иргэний эрх зүйн суурь зарчмаас хазайж, гэм буруугүйгээр хариуцлага оноож буй суурь үндэслэл, түүнээс улбаалан гарч болзошгүй эрх зүйн үр дагаврыг магадлах шаардлага ч мөн зүй ёсоор тулгарч байгаа юм.

**ЭХ СУРВАЛЖ*****Хууль, тогтоомж***

1. Боловсролын ерөнхий хууль, 2023
2. Гэр бүлийн тухай хууль, 1999
3. Иргэний хууль, 2002
4. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016
5. Эрүүл мэндийн тухай хууль, 2011

***Ном, сурах бичиг***

1. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, Анхны хэвлэл, Соёмбо хэвлэлийн компани, 2010.
2. Ж.Амарсанаа нар, Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл (1959-2010), УБ, МУИС-Хууль зүйн сургууль, 2013.
3. Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүйн онолын асуудал, 2 дахь хэвлэл, УБ, 2018.
4. З.Сүхбаатар нар, Монгол Улсын Иргэний хууль тогтоомж (түүхэн эмхэтгэл) 1206-2012, Монгол өмгөөлөгч хууль зүйн фирм, 2012.
5. Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV), УБ, Тоонотпринт ХХК, 2016.
6. Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхэтгэл (Иргэний хэрэг) Цуврал 7, УБ, 2008.
7. Т.Мөнхжаргал, Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй, УБ, Сутай дээд сургууль, 2005.
8. Ё.Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар: I, II, III хэсэг, УБ, МИМ ХХК Хэвлэлийн газар, 2010.
9. Atsumi Kubota, Tort law: Understanding Civil Law, Yuhikaku Publishing Co.Ltd, 2nd ed, 2018.
10. Ryoichi Yoshimura, Tort law, Yuhikaku Publishing Co.Ltd, 6th ed, 2022.

***Судалгааны өгүүлэл***

1. Р.Пүрэвбаатар, “Иргэний хуулийн 497 дугаар зүйлийг нотлох үүргийн онолын үүднээс тайлбарлах нь” Шүүх эрх мэдэл сэтгүүл №3 (2018)

***Шүүхийн шийдвэр***

1. Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 442, 2015.7.30.
2. Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 103/ ШШ2020/00131, 2020.3.5.
3. Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 102/ ШШ2019/02777, 2019.10.18.
4. Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 102/ ШШ2020/ 03121, 2020.10.20.
5. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 88, 2015.12.23.
6. Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 5483, 2016.8.19.
7. Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 1062, 2018.3.27.
8. Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 101/ ШШ2020/00813, 2020.3.5..
9. Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 1317, 2020.4.16
10. Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 3043, 2020.9.3.
11. Говьсүмбэр аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 85, 2007.05.22.

12. Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дугаар 216/МА2018/00024, 2018.12.04.
13. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх, Дугаар 137, 2017.3.22.
14. Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 277, 2019.6.24.
15. Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 487, 2019.11.21.
16. Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 146/ШШ 2019/00184, 2019.06.18.
17. Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 146/ШШ 2019/00354, 2019.12.16.
18. Өмнөговь аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дугаар 13, 2018.4.18.
19. Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 2347, 2018.9.20.
20. Сэлэнгэ аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 39, 2016.1.7.
21. Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 0141, 2016.04.21.
22. Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 183/ШШ2017/00262, 2017.1.25.
23. Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 303, 2017.1.31.
24. Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Дугаар 182/ШШ2020/01001, 2020.5.6.
25. Булган, Орхон, Хөвсгөл аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дугаар 40, 2016.3.15.
26. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дугаар 258, 2017.1.23.
27. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дугаар 2106, 2018.10.03.
28. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дугаар 2093, 2019.12.13.
29. Монгол Улсын Дээд Шүүхийн Иргэний Хэргийн Танхим, Дугаар 001/ХТ2019/00527, 2019.04.11.
30. Монгол Улсын Дээд Шүүхийн Иргэний Хэргийн Танхим, Дугаар 001/ХТ2021/00451, 2021.05.18.
31. Монгол Улсын Дээд Шүүхийн Иргэний Хэргийн Танхим, Дугаар 001/ХТ2021/01546, 2021.12.16.

#### *Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл*

1. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, <https://shuukh.mn/> [сүүлд үзсэн: 2024.07.21]



---

**PARENTAL TORT LIABILITY FOR DAMAGES CAUSED BY MINORS UNDER  
18 YEARS OLD**

***Kherlenchimeg.B***

*(LL.M), Research Assistant*

**ABSTRACT:**

The parental tort liability provision in the Civil Code of Mongolia is grounded in the “fault principle.” This framework aims to balance various conflicting interests, including 1) child protection, 2) victims’ rights to compensation, and 3) individuals’ (parents) liberty to act by exempting parents from tort liability if they can prove they have fulfilled their duty to supervise their children. However, the ambiguity surrounding the content of the duty to supervise has prevented the fault principle from operating effectively, particularly in preserving parents’ liberty to act. This article critically examines the current state of parental tort liability in Mongolia through the lens of the fault principle.

**KEYWORDS:**

Fault principle, individuals’ (parents) liberty to act, duty to supervise, child protection, victims’ right to compensation

## ШИНЭ ЭРДЭМТНИЙ ИНДЭР



**Б.Нинжин**

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн  
Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш,  
хууль зүйн ухааны доктор (Ph.D)*

Батаагийн Нинжин нь 2016 онд ОХУ-ын Урал хуулийн их сургуулийг эрх зүйч мэргэжлээр (LL.B) дүүргэж, 2017 онд Унгар улсын Дебрецений их сургуульд олон улсын болон Европын бизнесийн эрх зүй чиглэлээр хууль зүйн магистр зэрэг (LL.M), 2021 онд мөн сургуульд олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн чиглэлээр хууль зүйн ухааны докторын зэргийг (Ph.D) тус тус хамгаалсан.

Тэрээр 2022 оноос МУИС-ийн Хууль зүйн сургуульд ахлах багшаар ажиллаж байгаа бөгөөд олон улсын хувийн эрх зүй, олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй, олон улсын арбитрын эрх зүй зэрэг олон улсын салбар эрх зүйн хичээлийг орж байна. Мөн Монголын болон олон улсын арбитрын ажиллагаанд оролцдог ба арбитрын ажиллагааны дүрмийн нийцэл, хяналтын ажил хийж байсан туршлагатай.

Зүүн өмнөд Ази болон Төв Азийн гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, Европын Холбооны хөрөнгө оруулалтын зохицуулалтын шинэтгэл, олон улсын арилжааны болон хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх механизм, олон улсын арбитрын байгууллагуудын дүрмийн шинэчлэл зэрэг сэдвийн хүрээнд судалгааны ажил хийж байжээ.

Б.Нинжин нь сургалтын үйл ажиллагаанаас гадна, ХЗС-д багшлах хугацаандаа олон улсын арилжааны арбитр болон хөрөнгө оруулалтын шүүхийн мэтгэлцээний тэмцээнд Хууль зүйн сургуулийн багийг дасгалжуулан амжилттай оролцсоор ирсэн. Тухайлбал, Австри улсад зохион байгуулагддаг “Виллем С. Висийн нэрэмжит олон улсын арилжааны арбитрын мэтгэлцээний тэмцээн”, Япон улсад зохион байгуулагддаг “Олон улсын арилжааны арбитр, бизнес хэлэлцээрийн тэмцээн”, “Олон улсын хөрөнгө оруулалтын арбитрын тэмцээн” зэргийг онцлох нь зүйтэй.

Хууль зүйн ухааны доктор Б.Нинжин таны цаашдын эрдэм судлалын ажилд нь амжилт хүсэж, сайн сайхныг ерөөе!

**2024 ОНЫ III УЛИРЛЫН  
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ  
(МЭДЭЭ)**

## “ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛЫН СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ” ЗОХИОН БАЙГУУЛЛАА


Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн санаачилгаар Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсад хоёр дахь удаагаа зохион байгуулж буй "Хууль тогтоомжийн судалгааны аргачлалын сургагч багш бэлтгэх сургалт"-ыг 2024 оны 07 дугаар сарын 22-ноос 07 дугаар сарын 26-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав.



*/Сургалтын үеэр/*

Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийн үндэсний комисс, Эрчим хүчний зохицуулах хороо, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургуулийн нийт 31 судлаач, багш, мэргэжилтнүүд хамрагдлаа.

Тус сургалтыг ХБНГУ-ын Доод Саксон мужийн Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам болон Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга асан, хатагтай Фридерикэ Витте удирдаж явуулав.



*/Сургагч баги, хатагтай Фридерикэ Вумме/*

Сургалт “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах”, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх”, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх” зэрэг сэдвийн хүрээнд явуулав.



*/Сертификат гардуулах ёслол/*

## “ӨМНӨД, ХОЙД СОЛОНГОС БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЭМНЭЛГИЙНИ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЧИГ ХАНДЛАГА БА ЗОРИЛТ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, Солонгосын эрх зүйн боловсрол төв, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль тогтоомжийн яам, Нэгдэл ба Хойд Солонгосын Хууль Судлалын Нийгэмлэг болон Күүкмин Их Сургуулийн Хойд Солонгосын Хууль Зүйн Судалгааны Төв хамтран “Өмнөд, Хойд Солонгос болон Монгол улсын эмнэлгийн тусламж үйлчилгээний эрх зүйн чиг хандлага ба зорилт” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2024 оны 7 дугаар сарын 30-ны өдөр зохион байгууллаа.



*/Хурлын үеэр/*

Эрдэм шинжилгээний хурлын нэгдүгээр хэсгийг “БНСУ-ын Эмнэлгийн тусламж үйлчилгээний эрх зүйн чиг хандлага ба зорилт”, хоёрдугаар хэсгийг “Монгол Улсын Эмнэлгийн тусламж үйлчилгээний эрх зүйн чиг хандлага ба зорилт”, гуравдугаар хэсгийг “Хойд Солонгосын Эмнэлгийн тусламж үйлчилгээний эрх зүйн чиг хандлага ба зорилт” сэдвийн хүрээнд явуулж, хэлэлцүүлэг өрнүүллээ.





*/ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан О.Энххүслэн панелистаар оролцоо/*



*/Академич, МУИС-ийн эмерат профессор С.Нарангэрэл нээж уг хэлэв/*

## “ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМЫН ҮР ДҮНГ ЭРҮҮГИЙН БОДЛОГО ТОДОРХОЙЛОХОД АШИГЛАХ НЬ: МОНГОЛ УЛС БА ЯПОН УЛС” СЭДЭВТ ХАМТАРСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн (NLI) болон Япон Улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, судалгааны хүрээлэн (RTI) хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр МУ, УБ хотноо ХЗҮХ-ийн Хуульчдын танхимд “Гэмт хэргийн цагаан номын үр дүнг эрүүгийн бодлого тодорхойлоход ашиглах нь: Монгол Улс ба Япон Улс” сэдэвт хамтарсан эрдэм шинжилгээний хамтарсан семинар зохион байгуулагдлаа.



*/Эхний эгнээний зүүн гар талаас ГХУСА33-ийн хэлтсийн дарга Б.Одмандах, Япон улсын Хууль зүйн яамны Сургалт, судалгааны хүрээлэн (RTI)-ийн Олон улсын хамтын ажиллагааны газрын профессор Кэйсүки Гото, МӨХ-ны Ерөнхийлөгч Л.Данзанноров, ХЗҮХ-ийн захирал, доктор Х.Эрдэм-Ундрах (Dr.jur), Сургалт, судалгааны хүрээлэн (RTI)-ийн Олон улсын хамтын ажиллагааны газрын (ICD) захирал Рёота Татэмото, Гавьяат хуульч, доктор Р.Оюунбадам, доктор Ц.Мөнхбат нар бусад оролцогчдын хамт/*



Семинарыг нээж ХЗҮХ-ийн захирал, хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах (Dr. jur), Япон Улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, судалгааны хүрээлэн (RTI)-ийн Олон улсын хамтын ажиллагааны (ICD) газрын захирал Рёота Татэмото нар үг хэлэв. Сургалт, судалгааны хүрээлэнгийн (RTI) Олон улсын хамтын ажиллагааны газрын (ICD) профессор Кэйсүкэ Гото “Гэмт хэргийн цагаан номын үр дүнг эрүүгийн бодлого тодорхойлоход ашиглах нь: Япон Улс”, ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Х.Буянбат, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал нар “Монгол Улсын төрийн эрүүгийн бодлогыг тодорхойлоход гэмт хэргийн цагаан номын ач холбогдол, цаашдын чиг хандлага”, ГХУСАЗЗАА-ын хэлтсийн дарга Б.Одмандах “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс, чиг үүрэг” сэдэвт илтгэлийг тус тус илтгэл хэлэлцүүлээ.



Семинарын чиглүүлэгчээр ХЗҮХ-ийн Хүний эрх, олон улсын эрх зүйн секторын эрхлэгч Б.Энх-Амгалан, орчуулагчаар хуульч Б.Лхагважаргал нар ажиллав



Семинарт Японы талаас Сургалт, судалгааны хүрээлэнгийн Олон улсын хамтын ажиллагааны газрын ажилтан Рэй Шимажири, МУИС-ийн ХЗС-ийн багш, Кюүшүгийн их сургуулийн докторант С.Батбаяр, Монголын талаас УЕПГ-ын Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор, хууль зүйн ухааны доктор Ц.Мөнхбат, Гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор Р.Оюунбадам, Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын судлаач Г.Оюунболд болон Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Дотоод хэргийн их сургууль, Шихихутуг их сургууль зэрэг байгууллагын эрдэмтэн багш, судлаач, мэргэжилтнүүд оролцож, идэвхтэй хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.



*/ХЗҮХ-ийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur) болон Япон Улсын Хууль зүйн яамны Сургалт, судалгааны хүрээлэн (RTI)-ийн Олон улсын хамтын ажиллагааны газрын (ICD) захирал Рёота Татэмото нар/*

Энэхүү эрдэм шинжилгээний семинар нь (NLI) болон (RTI)-ийн талуудын хооронд 2021 онд байгуулагдсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд зохион байгуулагдаж буй тав дахь удаагийн семинар бөгөөд оролцогч байгууллагын тоо, цар хүрээ тэлж, үр өгөөж, ач холбогдол нэмэгдсээр байгаа билээ. ХЗҮХ-ээс талуудын хамтран зохион байгуулсан таван удаагийн эрдэм шинжилгээний семинарын илтгэлийн эмхэтгэлийг англи, монгол хос хэлээр эмхэтгэн хэвлүүлж, нийтийн хүртээл болгохоор ажиллаж байгааг дуулгахад таатай байна.

## ТЭГШ ЭРХИЙН ЗАРЧИМ БА ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 107 дугаар сургуулийн сурагчдад "Тэгш эрхийн зарчим ба ялгаварлан гадуурхалтаас ангид байх нь" сэдэвт сургалт орлоо.



*/Сургалтын үеэр/*

Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хувийн эрх зүйн секторын Эрдэм шинжилгээний ахлах ажилтан С.Нарантунгалаг ахлах ангийн 320 гаруй сурагчдыг хамруулан хичээл орлоо.

## 36 ДАХЬ УДААГИЙН ҮНДЭСНИЙ “НОМЫН БАЯР”-Т ОРОЛЦЛОО

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор жил бүр уламжлал болон зохиогддог Үндэсний 36 дахь удаагийн "Номын баяр" 2024 оны 9 сарын 13-15-ны өдрүүдэд төв талбайд зохион байгууллаа. Номын баярт Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг ном, судалгааны эмхэтгэлүүдийг танилцуулан оролцлоо.



*/Нээлийн үеэр/*

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг ном, сэтгүүл, гарын авлагуудыг иргэдэд толилуулж байна.



*/Баруун гар талаас ХЗҮХ-ийн Хүний нөөцийн мэргэжилтэн С.Номин, ХЗҮХ-ийн Тооцооны нягтлан бодогч Б.Цэрмаа нарын хамт /*








Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хуралд Монгол, Австри, Швейцарь, Япон, Солонгос, ОХУ, Колумб, Финланд, БНХАУ зэрэг 9 улсын 62 илтгэгч 32 илтгэл хэлэлцүүлж оролцлоо. Оролцогчид Монгол Улс дахь нэр томьёо судлалын түүхэн хөгжил, нэр томьёоны салбарт тулгамдаж буй асуудлыг хөндөж хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатайг онцлов.



Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасны дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэргэд хууль зүйн нэр томьёог шинжлэх ухааны үндэслэлтэй оноон тодорхойлох, жигдлэн хэвшүүлэх, нэр томьёотой холбогдсон асуудлаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хууль зүйн хэлний зөвлөл байгуулагдсан бөгөөд тус хүрээлэнгийн захирал, доктор Х.Эрдэм-Ундрах “Хууль зүйн хэлний зөвлөлийн үндсэн чиг үүрэг, нэр томьёо судлалын үйл ажиллагаа” сэдвээр илтгэл хэлэлцүүлж оролцлоо.

## “ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Хууль зүйн үндэсний хүрээлэн”-ээс 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Багахангай дүүргийн ерөнхий боловсролын Хангай цогцолбор сургуулийн сурагчдад “Цахим орчин дахь ялгаварлан гадуурхалтаас ангид байх нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад тус сургуулийн ахлах ангийн 120 гаруй сурагч хамрагдлаа.



*/ХЗҮХ-ийн Хувийн эрх зүйн секторын Эрдэм шинжилгээний ажилтан, сургагч багш Г.Болор-Эрдэнэ сургалтын үеэр/*



*/Сургалтын үеэр/*



## “ХҮНИЙ ЭРХИЙН ХАНДЛАГА ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ” СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Багахангай дүүргийн Цагдаагийн газрын нийт албан хаагчдад “Хүний эрхийн хандлага төлөвшүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Тус сургалтын сургагч багшаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Нийтийн эрх зүйн секторын Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Р.Хатансайхан ажиллалаа.



*/ХЗҮХ-ийн Нийтийн эрх зүйн секторын Эрдэм шинжилгээний ахлах ажилтан  
Р.Хатансайхан/*



*/Тус сургалтын үеэр/*

## НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА

Нээлттэй засгийн түншлэлийн Улс орныг дэмжих албаны дарга Алонсо Сердан болон Ази, Номхон далайн бүсийн ахлах зохицуулагч Деви Барнас нар Хууль зүйн үндэсний хүрээлэнд 2024 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зочиллоо.



Тус уулзалтад ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор М.Түвшинжаргал оролцож Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар харилцан мэдээлэл солилцож, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар санал солилцов.

## ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН АЛБАН ХААГЧИД “ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР ЦАХИМД БИЧВЭР БОЛОВСРУУЛАХ” СЭДЭВТ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 7 дугаар тогтоол, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн нийт албан хаагчдын 2024 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр "Үндэсний бичгээр цахимд бичвэр боловсруулах" сэдэвт сургалт зохион байгуулж нийт албан хаагч хамрагдлаа. Уг сургалтаар MNS:6395:2022 стандартын дагуу албан хэргийг хос бичгээр хөтлөх, монгол бичгийн үсгийн фонтыг хэрхэн суулгах, бичих, цахим бичвэр боловсруулах арга зүй зэрэгт суралцав.



Энэхүү сургалтыг Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Хэрлэнцэцэг, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны Эрдэм шинжилгээний ажилтан М.Гэрэлсүрэн нар орлоо.





*/Сургалтын үеэр/*

## ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН АЛБА ХААГЧИД “ГАМШИГ, ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” СЭДЭВТ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн нийт албан хаагчдын 2024 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг гамшиг, гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх зорилгоор 2024 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр "Гамшиг, гал түймрээс урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалт зохион байгуулж нийт албан хаагчид хамрагдлаа.



Тус сургалтыг Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Ангиллын сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч А.Түвшинбаатар орлоо.



## ХЗҮХ-ИЙН АЛБАН ХААГЧИД “АЖЛЫН БАЙРНЫ ЭРҮҮЛ ХЭВШИЛ” СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн нийт албан хаагчдын 2024 оны Дотоод сургалтын төлөвлөгөө болон Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хүрээнд Эрүүл аж төрөх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор нарийн мэргэжлийн эмчээс “Ажлын байрны эрүүл хэвшил, нурууны өвчлөл” сэдвээр сургалт, зөвлөгөөг 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулав.



*/Сургалтын үеэр/*



Тус сургалтыг Уламжлалт анагаах ухааны хүний их эмч Н.Баярмагнай орлоо.



## БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АВЛИГЫН ЭСРЭГ БАГЦ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦЛОО

Авлигын эсрэг багц хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн зарим гишүүд Бүгд Найрамдах Солонгос Улсын авлигын эсрэг хууль тогтоомж, түүний практик хэрэглээ, судалгааны нэгдсэн сантай танилцах зорилгоор холбогдох байгууллагуудтай 2024 оны 09 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, туршлага судлахаар ажиллаа.



*/БНСУ-ын Хууль тогтоомжын Яаманд/*

Томилолтоор ажиллах бүрэлдэхүүнд тус ажлын хэсгийн гишүүд буюу Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн болон Дотоод хэргийн хэргийн их сургуулийн төлөөлөл оролцлоо.



*/БНСУ-ын Ерөнхий прокурорын газарт/*

## “ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС БА ЭРХ ЗҮЙН ДЭЭД БОЛОВСРОЛ МОНГОЛ УЛС, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ОРОЛЦЛОО

БНХАУ-ын Өвөрмонголын их сургуулийн Хууль зүйн сургуулиас санаачлан 2024 оны 09 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотноо “Хууль дээдлэх ёс ба эрх зүйн дээд боловсрол: Монгол Улс, Оросын Холбооны Улс” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал амжилттай зохион байгууллаа.

### 当代蒙古国与俄罗斯法治理论与高等法学教育国际研讨会

International Symposium on Contemporary Rule of Law Theory and Higher Legal Education in Mongolia and Russia

中国·呼和浩特  
2024.09.20



Монгол Улсаас ХЗДХЯ-ны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн, ОХУ-аас Москвагийн Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, Владивосток дахь Алс Дорнодын их сургууль, БНХАУ-аас Хятадын Улс төр, хуулийн сургууль, Хөнань их сургууль, Тяньжиний Багшийн их сургууль, Далиэний Арбитрын хороо, Өвөрмонголын Арбитрын зөвлөл, Өвөрмонголын Нотариатчдын Зөвлөл, Өвөрмонголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэн, Өвөрмонголын их сургууль, Өвөрмонголын Санхүү, эдийн засгийн их сургууль зэрэг 30 гаруй их, дээд сургууль, хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын байгууллагын төлөөлөл 80 гаруй эрдэмтэн багш, судлаач, мэргэжилтнүүд уг хуралд оролцсон юм.

Энэхүү хурлаар Монгол Улс, Оросын Холбооны Улсын хуулийн засаглал, эрх зүйн онол, практик, эрх зүйн дээд боловсролын чиглэлээр мэдлэг, мэдээллээ харилцан солилцож, 5 таван бүлэг дэд сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүллээ





2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Өвөрмонголын их сургуулийн ХЗС-ийн “Гадаад орнуудын эдийн засгийн судалгааны төв” -ийн нээлт болж ХЗҮХ-ийн төлөөлөл оролцов.

Нээлтийн үеэр ХЗҮХ-ийн захирал, Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах, ХЗҮХ-ийн Хүний эрх, олон улсын эрх зүйн секторын эрхлэгч Б.Энх-Амгалан нар тус төвөөс зочин судлаачаар ажиллах санал тавьсныг хүлээн авсан юм.



*/Санал бичиг гардан авав/*

## **ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТӨВИЙН 2024 ОНЫ III УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГАА, ЛАВЛАГАА**

1. Авлигын эсрэг багц хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн судалгаа:
  - “Авлигын эсрэг хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” сэдэвт судалгаа;
  - “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” сэдэвт судалгаа;
  - “Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн үнэлгээ” сэдэвт судалгаа;
  - “Иргэний хуулийн үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” сэдэвт судалгаа;
  - “Төрийн аудитын тухай хуулийн зарим зохицуулалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” сэдэвт судалгаа.
2. “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” сэдэвт судалгаа.е
3. “Авлигын гэмт хэргийн эсрэг хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хөтөлбөр, хөрөнгө хураах албадлагын арга хэмжээ болон Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн зохицуулалтын сайн туршлага” сэдэвт лавлагаа.

